МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН

ХӨТӨЛБӨР

Сайжруулсан хоёр дахь хэвлэл

2019 он

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН

ХӨТӨЛБӨР

Сайжруулсан хоёр дахь хэвлэл

2019 он

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан хоёр дахь хэвлэл
/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам., Боловсролын хүрээлэн., УБ. 2019. - 168х)

Тус сургалтын хөтөлбөрийг өмчийн бүх хэлбэрийн суурь боловсролын сургалтын байгууллагууд мөрдөнө.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам.

АГУУЛГА

Дунд ангийн сургалтын төлөвлөгөө 5
Суурь боловсролын сургалтын хөтөлбөр 8
Монгол хэл, бичиг 15
Математик 31
Мэдээллийн технологи 47
Байгалийн ухаан 57
Газар зүй 81
Нийгмийн ухаан 89
Урлаг 103
Дизайн технологи 115
Биеийн тамир 125
Гадаад хэл 135
Эрүүл мэнд 159

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 01 өдөр Дугаар А/491 Улаанбаатар хот

「Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай」

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.8-3.2.17 дахь заалтууд, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сургалтын төлөвлөгөөг нэгдүгээр, дунд ангийн сургалтын төлөвлөгөөг хоёрдугаар, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг гуравдугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангид 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлсүгэй.

3. Шинэчлэн баталсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Боловсролын хүрээлэнгийн захирал /П.Лхагвасүрэн/, сургалтын төлөвлөгөөг чанартай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2018 оны А/543 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

Болов рол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын
2019 оны 08 дугаар сарын 0 –ны өдрийн
/491 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

ДУНД АНГИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

д.д	Анги / Хичээл		VI	VII	VIII	IX	Нийт цаг
1	Монгол хэл, бичиг	Монгол хэл	99	66	66	66	297
		Үндэсний бичиг	66	66	66	66	264
		Уран зохиол	66	66	66	66	264
2	Математик		165	132	132	132	561
3	Мэдээллийн технологи		33	33	33	33	132
4	Байгалийн ухаан	Физик	33	66	66	66	231
		Биологи	33	66	66	66	231
		Хими	33	66	66	66	231
5	Нийгмийн ухаан	Иргэний ёс зүйн боловсрол	66	66	66	66	264
		Газар зүй		33	33	33	99
		Түүх	33	66	66	66	231
		Нийгэм судлал		33	33	33	99
7	Урлаг	Дүрслэх урлаг	33	33	33		99
		Хөгжим	33	33	33	33	132
8	Дизайн технологи	Зураг зүй	66	66	66	66	264
		Технологи					
9	Биеийн тамир, эрүүл мэнд	Биеийн тамир	66	66	66	66	264
		Эрүүл мэнд	33	33	33	33	132
10	Гадаад хэл	Англи хэл	99	99	99	99	396
		Орос хэл		66	66	66	231
		Дүн	957	1155	1155	1155	4422
Багш зохицуулах цаг							268
		Жилийн нийт цаг					4690
		Долоо хоногийн нийт ачаалал	29	35	35	35	
		Өдрийн нийт ачаалал	5.8	7.0	7.0	7.0	

Тайлбар:

1. Хичээлийн жилд 33 долоо хоног хичээллэнэ. Ээлжит хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
2. Сургалтын төлөвлөгөөний заасан цагт багтаан орон нутаг, сургуулийн онцлог болон багшийн нөөц зэрэг хүчин зүйлст үндэслэн ээлжит хичээлийн үргэлжлэх хугацааг сургууль 80 минутаар зохион байгуулж болно.
3. “Иргэний ёс зүйн боловсрол“ хичээлийг нийгмийн ухааны багш заана.
4. хичээлийн жилд “Багш зохицуулах цаг”-аар монгол хэлний багш 18, нийгэм судлал, дүрслэх урлаг, зураг зүй, технологи, эрүүл мэндийн багш тус бүр 10, бусад хичээлийн багш нар тус бүр 15 цагт багтаан суралцагчдын хоцрогдол арилгах, давтлага өгөх, дугуйлан хичээллүүлэхээс гадна, суралцагч, эцэг эхэд “Иргэний ёс зүйн боловсрол“ хичээлээр болон ажил мэргэжлийн талаар зөвлөгөө өгнө.
5. “Багш зохицуулах цаг“-ийг хичээлийн цагт тооцно.

------oOo-----

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 01 өдөр Дугаар А/492 Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 28.1.2, 28.1.8. Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.8-3.2.17 дахь заалтууд Боловсролын хүрээлэнгийн 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 124 дүгээр албан бичиг, "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" багш нарын улсын хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдын санал, зөвлөмж, "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний хэлэлцүүлэгт оролцогчдын санал, дүгнэлт, Монголын багш нарын VII их хурлын 2019 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага боловсролын монгол хэл, математик, хүн ба орчин, хүн ба нийгэм, хүн ба байгаль, дүрслэх урлаг, технологи, хөгжим, биеийн тамир, англи хэлний сургалтын сайжруулсан хөтөлбөрийг нэгдүгээр, суурь боловсролын монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, түүх, нийгэм судлал, хөгжим, дүрслэх урлаг, дизайн технологи, биеийн тамир, англи хэл, орос хэлний сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хоёрдугаар, бүрэн дунд боловсролын заавал судлах, сонгон судлах монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, математик, мэдээллийн технологи, физик, биологи, хими, газар зүй, нийгэм судлал, англи хэл, орос хэлний болон заавал судлах монголын түүх, биеийн тамир, дизайн зураг зүй, технологи, сонгон судлах түүх, дизайн технологийн сайжруулсан хөтөлбөрийг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын нийт сургуульд 2019-2020 оны хичээлийн жилээс тус тус сургалтад хэрэгжүүлсүгэй.

3. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Т.Ням-Очир/, хөтөлбөр хэрэгжүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Боловсролын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөр, багийн бүрэлдхүүн батлах тухай” 2014 оны А/240 дүгээр тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын цөм хөтөлбөр батлах тухай” 2015 оны А/302 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр батлах тухай” 2016 оны А/277 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын хөтөлбөр чинэчлэн батлах тухай” 2015 оны А/551 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ё.БААТАРБИЛЭГ

СУУРЬ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Боловсролын тухай хуульд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”[1] гэж, Бага, дунд боловсролын тухай хуульд “Бага, дунд боловсролын зорилго нь суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино”[2] гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолоор 2015 онд баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтад “Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ”, 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалтад “Сурлагын амжилтын олон улсын чанарын үнэлгээний судалгаанд 2021 онд хамрагдана.” хэмээн тус тус тодорхойлсон.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагаас 2015 онд Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилтын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчеон хотод зохион байгуулсан “Хүн бүрт хүртээмжтэй, тэгш, насан туршдаа суралцах чанартай боловсрол” сэдэвт Дэлхийн боловсролын форумаас Инчеоны тунхаглалыг гаргасан. Тус тунхаглалд 2030 он хүртэлх Дэлхийн боловсролын алсын хараг “Нэгдсэн зорилго, хүсэл эрмэлзэлтэй, хүн бүрт хүрсэн боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулна” хэмээн тодорхойлсон. Мөн “Чанартай боловсрол нь бүтээмж болон мэдлэгийг дэмжин хөгжүүлж, бичиг үсэг, математикт суралцахтай ижил задлан шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, танин мэдэхүйн, хувь хүний хөгжил, харилцааны чадваруудыг хөгжүүлдэг”-ийг онцлон тэмдэглэжээ.

Дэлхийн улс орнууд боловсролын бодлогоо шинжлэх ухаан, технологийн хөгжил, дэвшил, нээлттэй нийгэм, ирээдүйд зохицон амьдрах чадвартай иргэнийг бэлтгэхэд чиглүүлж буй өнөө үед монгол хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, хамтран ажиллаж амьдрах, шийдвэр гаргах чадвартай, үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна.

“Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал”-д нийгмийн амьдралын таатай орчин, хэм хэмжээг бий болгох, түүнд дасан зохицож амьдрах чадвартай, иргэншсэн монгол хүнийг төлөвшүүлэх, хүүхдийн сурч боловсрох хүсэл сонирхол, хийж бүтээх тэмүүллийг боловсролын түвшин бүрт дэмжиж ажиллахыг боловсролын зорилго болгон дэвшүүлсэн.

Ийнхүү Монгол Улсын боловсролын хууль тогтоомж, төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, хүүхэд бүрийн хөгжил, төлөвшлийг дэмжих үзэл баримтлал, хандлагад үндэслэн боловсруулсан суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг 2015 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн билээ.

---

1 Монгол улсын боловсролын тухай хууль

2 Бага дунд боловсролын тухай хууль

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн үндэсний хэмжээний судалгаа, сурагчдын сурлагын амжилтын үнэлгээний үр дүн, боловсролын өнөөгийн хөгжлийн чиг хандлага болон дараах хэрэгцээ шаардлагад нийцүүлэн 2019 онд суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг сайжруулж, сургууль, багш нарт хүргэж байна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн дараагийн үе шатны хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Сургууль, багш нарын хамтын ажиллагааг дэмжих, гүнзгийрүүлэх;
- Суралцах үйл ажиллагааг сурагчийн үнэт зүйл, хандлага, төлөвшилд чиглүүлэх;
- Сургалтын хөтөлбөрийн агуулгын давхардал, хүндрэлийг арилгаж хэрэгжих нөхцөл боломжийг нэмэгдүүлэх;
- Сурагчдын сурах болон багшийн багшлах ажлын ачааллыг зохистой болгох;
- Сургуулийн хичээлд суурилсан үйл ажиллагааны менежмент, төлөвлөлтийг дэмжиж, сургуулийн хөтөлбөр, багшийн хичээл төлөвлөлтийг хөгжүүлэх зэрэг болно.

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛСАН ЗАРЧИМ

2.1. Сурагч бүрийн сурч боловсрох хүсэл сонирхол, хийж бүтээх тэмүүллийг дэмжсэн бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд тулгуурласан байх;

2.2. Агуулга нь шурган бүтцээр гүнзгийрэх, өргөсөх, залгамж холбоотой, тасралтгүй, хүүхдийн хөгжил, төлөвшлийн ахиц дэвшлийг хангахуйц байх;

2.3. Сургалтын арга зүй нь шинжлэн судлах болон сурах арга барил, бие даан бүтээлчээр суралцахад дэмжлэг болохуйц байх;

2.4. Бие даан болон хамтран суралцах, сургалтыг уян хатан төлөвлөх, зохион байгуулах сургалтын орчныг бүрдүүлсэн байх;

2.5. Үнэлгээ нь сурагч бүрт шударга хандаж, сурах үйл ажиллагаа, ахиц амжилтыг дэмжин цаашид хөгжих боломжийг хангасан байх;

2.6. Эцэг эх, олон нийт, сонирхлын бүлгийн оролцоог хангасан, бие даасан, нээлттэй сургуулийн бодлого, менежментийг дэмжсэн байх;

ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

3.1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

3.1.1. Зорилго

Сурагч бүр амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг болон сурах арга барил, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмшиж, үндэсний хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн болж төлөвшихөд оршино.

3.1.2. Зорилт

3.1.2.1. Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтыг эзэмшин, амьдрал үйлдээ хэрэглэх;

3.1.2.2. Сурах хүсэл сонирхолтой, бүтээлчээр шинжлэн судлах болон сурах арга барил, сурах үйлээ өөрөө удирдан суралцах чадвартай болох;

3.1.2.3. Үндэсний хэл, соёл, түүх, уламжлалаа хүндэтгэн, өвлөн хөгжүүлдэг, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг дээдлэн эрхэмлэдэг, хүн, байгаль, нийгэмтэй зүй зохистой харилцдаг иргэн болох.

3.1.3. Сурагчийн эзэмших чадвар

Сургалтын хөтөлбөр нь сурагчийн танин мэдэхүй; нийгэмшил, сэтгэл хөдлөл; бие бялдар, зан үйлийн хөгжлийг дэмжинэ. Сургалт, хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагаагаар дараах чадваруудыг хөгжүүлнэ. Үүнд:

- Бүтээлч сэтгэлгээний: Бүтээлчээр сэтгэх, эргэцүүлэн бодох, асуудал шийдвэрлэх, зохион бүтээх чадвар
- Нийгэмшил, сэтгэл хөдлөлийн: Харилцах, зохион байгуулах, сэтгэл хөдлөлөө хянах, удирдах, багаар болон хамтарч ажиллах, бусдыг ойлгож, хүндэтгэх чадвар
- Хувь хүний хөгжлийн: Бие даан суралцах, үүргээ ухамсарлах, хариуцлагатай байх, өөрийгөө хөгжүүлэх, хүлээцтэй, ёс суртахуунтай байх, дасан зохицох, хөдөлмөрч, хичээл зүтгэлтэй байх чадвар
- Мэдээллийн технологийн хэрэглээний: Мэдээлэл харилцааны технологиор мэдээлэл олж авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ёс суртахуунтай хэрэглэх чадвар
- Монгол ба дэлхийн иргэний: Олон талт соёлыг ойлгох, үндэсний онцлог, уламжлал болон ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, зөрчилдөөнийг шийдвэрлэх, оролцоонд тулгуурлан шийдвэр гаргах, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах чадвар

3.2. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

3.2.1. Эх хэл болон гадаад хэлний агуулга нь сурагчдын авьяас, чадварт тулгуурлан эх хэл, гадаад хэлийг сонирхон судлахад;

3.2.2. Математик, мэдээллийн технологи, байгалийн ухааны агуулга нь зохих шатны мэдлэг, чадвар, дадал, шинжлэн судлах арга барил эзэмшихэд;

3.2.3. Түүх, нийгмийн ухааны агуулга нь зохих шатны мэдлэг, чадвар, шинжлэн судлах арга барил, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахих соёлд суралцахад;

3.2.4. Урлаг, дизайн технологийн агуулга нь гоо зүй, ёс суртахууны соёл, үндэсний болон хүн төрөлхтний соёлын үнэт зүйлсэд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, бүтээлч эрэлхийллийн аргаар хөгжүүлэхэд;

3.2.5. Биеийн тамир, эрүүл мэндийн агуулга нь бие бялдар, эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болох, бусдын эрүүл мэндийн төлөө санаа тавих, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, ур чадвар эзэмшихэд тус тус чиглэсэн байх;

3.3. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

3.3.1. Сургалтын арга зүй нь сурагчдыг аливаа юмс, үзэгдлийг сонирхон эрэлхийлэх, шинжлэн судлах, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах зэрэг бүтээлч үйл ажиллагаанд суралцахад чиглэнэ.

3.3.2. Сургалтын явцад сурагчдад аливаа зүйлийг судлах сонирхол, хүсэл эрмэлзэл төрүүлэх, бүтээлчээр сэтгэх, эргэцүүлэн бодох, өөрийн бодол санаа, мэдрэмжээ илэрхийлэх, бусдад танилцуулах, түгээх боломж олгохуйц суралцахуйн онолд суурилсан идэвхтэй сургалтын аргыг төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.4. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.4.1. Сургалтын орчин гэдэгт танхимын болон танхимаас гадуурх байгаль, нийгэм, соёлын орчинг ойлгоно.

3.4.2. Сургалтын лаборатори, кабинет зэрэг зориулалтын байр, анги танхимыг ашиглана.

3.4.3. Судлагдахуун бүрийн онцлог бүхий шинжлэн судлах болон сурах арга барил эзэмшихэд чиглэсэн сургалтын хэрэглэгдэхүүн (ажлын хуудас, дасгал, даалгавар, бодлого, төсөлт ажил)-ийг олон хувилбартай боловсруулж хэрэглэнэ.

3.4.4. Сурагчдад авьяасаа хөгжүүлэх, хамтран ажиллах, харилцан суралцах, амьдралын бодит асуудлыг шийдвэрлэх боломж олгохын тулд аялал экскурс хийх, музей үзэх, номын сан зэрэг анги танхимаас гадуур хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ

3.5.1. Үнэлгээний төрөл, хэлбэр

3.5.1.1. Сурагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц дэвшил, хөгжил болон сургалтын явц, үр дүнг оношлох, явцын болон үр дүнгийн үнэлгээгээр үнэлнэ.

3.5.1.2. Оношлох үнэлгээ нь сурах үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээл, түүний шалтгааныг тодорхойлох зорилгоор хичээлийн жил, хагас жил, улирал, бүлэг сэдвийн эхэнд сурагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тандаж илрүүлэх, үр дүнг нь сургалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашиглахад чиглэнэ.

3.5.1.3. Явцын үнэлгээ нь сурагчийн ахиц, хөгжлийн талаар мэдээлэл цуглуулах, суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл сургалтын явцад тогтмол хийгдэж, багш, сурагч, эцэг эх эргэх холбоо бүхий мэдээлэл солилцоход чиглэнэ.

3.5.1.4. Явцын үнэлгээнд дараах үнэлгээний хэлбэрүүдийг хэрэглэнэ.

- Сурагчийн өөрийн үнэлгээ нь сурлагын ахиц, амжилтаа мэдэрч, бахархах, үнэлэмжээ нэмэгдүүлэх нөхцөл болно. Өөрийн үнэлгээ нь сурагч суралцах зорилгоо дэвшүүлэх, үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх зэргээр сурах үйлээ ухамсартай удирдах, арга барилаа хөгжүүлэх боломж олгоно.
- Сурагч хоорондын үнэлгээ нь бусдын сурах үйл явцыг мэдэх, дэмжин туслах, мэдээлэл хуваалцах, санал солилцох замаар хэрэгжинэ. Багаар хамтран ажиллах нь гишүүн бүрийн үүрэг, оролцоог жигд хуваарилах, хариуцлагатай байх, харилцан ойлголцох, цаашид хамтран ажиллах сонирхол, хүсэл эрмэлзлийг төрүүлэхэд чухал үүрэгтэй.
- Багшийн үнэлгээ нь сургалтын явцад сурагчийн гүйцэтгэлийн талаар аман болон бичгээр мэдээлэл цуглуулах, сурах идэвх сонирхлыг нь өрнүүлэх, дэмжихэд оршино.

3.5.1.5. Үр дүнгийн үнэлгээ нь сурагчийн тухайн хичээлийн жил, хагас жил, бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшинг тогтоох, хандлага төлөвшилд үнэлэлт, дүгнэлт өгөхөд чиглэнэ.

3.5.1.6. Бүлэг сэдвийн үнэлгээ: Бүлэг сэдвийн агуулга, сурах арга барилыг хамарсан, үнэлгээний зорилт, шалгуурт нийцсэн даалгавар боловсруулж үнэлнэ. Тухайн сурагчийн үнэлгээг бусад сурагчийн үнэлгээтэй харьцуулахгүй.

3.5.1.7. Суурь боловсролын VI-VIII ангийн анги дэвших болон IX ангийн төгсөх шалгалтаар сургалтын хөтөлбөрийн үнэлгээний зорилт, шалгуур, жинг үндэслэн үр дүнгийн үнэлгээ хийнэ.

3.5.2. Үнэлгээний зорилт, шалгуур, жин

3.5.2.1. Үнэлгээний зорилт

А. Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт;

Б. Шинжлэн судлах болон сурах арга барил, чадварын хөгжил;

В. Хандлага, төлөвшил, зан үйлд гарч буй өөрчлөлтийг илрүүлэхэд оршино.

3.5.2.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний шалгуурыг тодорхойлох нь сурагчдын хөгжил, төлөвшлийн үнэлгээг ил тод болгож, зөв оновчтой үнэлэхэд чухал ач холбогдолтой. Үнэлгээний зорилтыг дараах шалгуурыг баримтлан тодорхойлно. Үүнд:

1. Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт

Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, хэрэглээг хичээл, судлагдахууны онцлогийг харгалзан дараах шалгуурт нийцүүлэн боловсруулж үнэлнэ.

- Тодорхой шинжлэх ухааны мэдлэг, ойлголт, хууль, зарчим, онол;
- Шинжлэх ухааны үг хэллэг, нэр томьёо, тогтмол, нэгж, хэмжигдэхүүн болон олон улсын тогтсон томьёо, томьёолол
- Нийгэм, эдийн засгийн ба хүрээлэн буй орчны ойлголт бүхий шинжлэх ухаан, технологийн хэрэглээ

2. Шинжлэн судлах болон сурах арга барил, чадварын хөгжил

Суралцахуйн явцад сурагч сурах арга барилаа хөгжүүлж, эзэмших чадварыг хичээл, судлагдахууны онцлогийг харгалзан дараах шалгуурт нийцүүлэн үнэлнэ. Үүнд:

- Мэдээлэлтэй ажиллах арга барил: Мэдээлэл цуглуулах, боловсруулах, үр дүнг тохиромжтой хэлбэрээр бусдад танилцуулах, санал бодлоо солилцож, мэдээллийг хэрэглэх;
- Асуудал шийдвэрлэх арга барил: Асуудал дэвшүүлэх, асуудал шийдвэрлэх арга замыг тодорхойлох, баримт нотолгоог задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар асуудлыг шийдвэрлэх;
- Шинжлэн судлах арга барил: Таамаглал дэвшүүлэх, үйл ажиллагааг төлөвлөх, сорил туршилт хийх, хэлэлцэх, үр дүнг гаргаж танилцуулах, шинэ санаа дэвшүүлэх;
- Бүтээлч эрэлхийллийн арга барил: Асуудал, хэрэгцээг илрүүлэх, дизайны шинэ санаа, шийдэл гаргах, бүтээх, үнэлэх болон хөгжүүлэх

3. Хандлага, төлөвшил, зан үйлд гарч буй өөрчлөлт

- Сурагчийн “сонирхол” нь аливаа юмс үзэгдэл, тэдгээрийн хувирал, зүй тогтлыг судлах сонирхолтой болж, хичээл болон үйл ажиллагаанд өөрийн хүслээр бүтээлч, санаачилгатай, үр дүнтэй оролцож байгаагаар илэрнэ.
- “Идэвх зүтгэл” нь сурах үйлээ төлөвлөж, төлөвлөснөө хэрэгжүүлэхийн төлөө үр бүтээлтэй ажиллаж буй байдлаар илэрнэ.
- “Эрмэлзэл” нь өөрийн удирдлагатай, хариуцлагатай, үнэт зүйлсийг эрхэмлэдэг, хамтран ажиллах чадвартай иргэн төлөвших хандлагыг илрүүлэхэд чиглэх ба дараах шалгуураар үнэлнэ. Үүнд:
    - Эх орон, түүх, соёл, хэл, байгаль, өв уламжлал, үндэсний үнэт зүйлээрээ бахархаж, тэдгээрийг хайрлан хөгжүүлэхийг эрмэлзэж буй байдал;
    - Хийх, бүтээх, туурвих зэрэгт бүтээлч, санаачилгатай хандаж буй байдал;
    - Аливаа зүйлийг хийж бүтээх, оролцох хүсэл эрмэлзлэлтэй болж буй байдал;

3.5.2.3. Үнэлгээний жин

Үр дүнгийн үнэлгээний даалгаврыг боловсруулахдаа сургалтын хөтөлбөрт тусгасан үнэлгээний зорилт тус бүрийг илрүүлэх шалгуур, даалгаврын эзлэх хувийн жинг баримтална.

Үнэлгээний зорилт, шалгуур, жингийн талаар сургуулийн удирдлага, багш, сурагч, эцэг эх нэгдсэн ойлголттой байх нь үнэлгээг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх, шалгуурыг үнэн зөв тогтоох, үнэлгээ шударга, бодитой, үр дүнтэй байхад нөлөөлнө.

3.5.3. Үнэлгээний арга, хэрэгсэл

3.5.3.1. Сурагчийг үнэлэхдээ ажиглах, сурагчтай ярилцлага хийх, шалгалт авах зэрэг арга хэлбэрээс хамгийн үр дүнтэй, оновчтойг сонгох нь чухал. Бичгийн шалгалт нь үнэлгээний үр дүнтэй аргын нэг боловч бусад аргатай хослуулан хэрэглэвэл үнэлгээний зорилт бүрэн хангагдах болно. Үнэлгээ нь үнэлгээний зорилтыг хэмжиж болохуйц мэдээлэл буюу баримт, нотолгоонд үндэслэсэн байна.

3.5.3.2. Сурагчийн шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, суралцах чадварын хөгжил, хандлага төлөвшилд гарч байгаа өөрчлөлтийг үнэлэхэд хичээлийн дэвтэр, ажлын хуудас, бүтээлийн сан, ажиглалтын тэмдэглэл зэрэг үнэлгээний хэрэгслийг боловсруулан ашиглана.

3.5.3.3. Ажлын хуудас, бүтээлийн сангаар сурагчийн гүйцэтгэлийг үнэлэх нь (асуултад хариулах, хариултыг сонгох, мэдээлэл цуглуулсан, боловсруулсан үр дүнгээ тэмдэглэх г.м) зөвхөн мэдлэг, ойлголтыг төдийгүй “мэдээлэл боловсруулах”, “асуудал шийдвэрлэх” чадварыг үнэлэх, “сонирхол”, “идэвх зүтгэл”, “оролцоо” зэргийг илрүүлэх баримт, нотолгоо болно.

3.5.3.4. Багш үнэлгээг ажиглалтын аргаар хийх бол ажиглалтын тэмдэглэл хөтөлж, ашиглана.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ

4.1.1. Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг БСШУС-ын сайдын тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Шинжлэн судлах болон сурах арга барил, эзэмших чадварыг VI-VII, VIII-IX анги гэсэн хоёр шатлалтайгаар хөгжүүлнэ.

4.1.2. Сургалтын хөтөлбөр нь хичээл болон хичээлээс гадуурх сургалтын ажлаар хэрэгжинэ.

4.1.3. Ерөнхий боловсролын сургууль нь орон нутаг болон сургуулийн онцлог, хүний нөөцийг тооцон сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйг уян хатан, нээлттэй байхаар төлөвлөн, хичээлд суурилсан үйл ажиллагаа, сургуулийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.1.4. Ерөнхий боловсролын сургууль нь батлагдсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн, сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлнэ.

4.2. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЛЭЭ БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжих нөхцлийг бүрдүүлэхэд сургуулийн удирдлага, багш, ажилтнууд манлайлан эцэг, эх, олон нийт, сонирхлын бүлгүүдтэй хамтран ажиллана. Үүнд:

4.2.1. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага нь сургуулийн зорилго, зорилтоо тодорхойлох, үйл ажиллагаагаа төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг үнэлэхэд

сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээг баримжаалан ажиллана.

4.2.2. Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтнууд хичээл сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, зохион байгуулах, өөрийн үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх, сургалтын чанарыг дээшлүүлэхэд ашиглана.

4.2.3. Сурагч сурах арга барилаа хөгжүүлж, бүтээлчээр эрэлхийлэх, шинжлэн судлах, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, бусадтай харилцах, хамтран ажиллах чадвар эзэмших, сурлагын амжилтаа ахиулахад сургалтын хөтөлбөрийг баримтлана.

4.2.4. Сурагчийн эцэг эх, асран хамгаалагчид өөрсдийн хүүхдийнхээ сурлагын ахиц, амжилт, хөгжил, төлөвшлийн талаар мэдээлэл авч, тэдний хөгжилд дэмжлэг үзүүлэхийн тулд сургууль, боловсролын байгууллага, бусад хүмүүстэй хамтран ажиллахад гарын авлага болно.

4.2.5. Боловсролын төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллага сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар үнэлгээ хийх, сургуулийн удирдлага, багш, ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэхэд үндсэн баримт бичиг болно.

4.2.6. Олон нийт болон сонирхлын бүлгүүдэд боловсрол эзэмших үйл ажиллагааны явц, үр дүнг хянах, тооцох, дэмжин хамтран ажиллахад мэдээлэл болно.

4.3. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ гэдэгт сурагчийн сурлагын амжилтын буюу боловсролын чанарын үнэлгээ, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааг багтаан ойлгоно.

4.3.1. Орон нутаг, сургууль сурагчдын сурлагын амжилтыг жил бүр үнэлж, үр дүнг сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхэд хэрэглэнэ. Үүнд:

- Сургуулийн жилийн ажлыг төлөвлөхөд дотоодын болон хөндлөнгийн үнэлгээний хугацаа, үнэлгээний арга хэлбэрийг заавал тусгана.
- Сургуулийн удирдлага, багш, сурагч, эцэг эх, асран хамгаалагч нар үнэлгээний нэгдсэн үзэл, ойлголттой болох нь сурагчийн хөгжил, төлөвшлийг дэмжихэд нөлөөлнө.
- Багш бүрийн заах арга, ур чадвар, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор үнэлгээний үйл явц, үр дүнг сургууль, хамт олноороо хэлэлцэж, зохион байгуулалттай, төлөвлөгөөтэй үйл ажиллагааг явуулна.
- Ямар шалгуурт суурилсан даалгавраар хэзээ, хэрхэн, яаж, ямар аргаар үнэлсэн тухай мэдээллийг эцэг эх, асран хамгаалагч болон сурагчдад ойлгогдохоор мэдээлэл, тайлбарыг тогтмол өгч ажиллана.

4.3.2. Суурь боловсролын чанарын үнэлгээ нь сурагчийн мэдлэг, чадварын түвшинг тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.

4.3.3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгааг 5 жил тутамд хийж, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх үндэслэлийг тодорхойлно.

4.3.4. Дээрх үнэлгээ, судалгаанууд нь үнэлгээний зорилго, үнэлж буй субъект болон арга, хэлбэрээр ялгаатай байна.

МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ

“Монгол хэл, бичиг”-ийн сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч:	Ш.Оюунцэцэг, БМДИ-ийн Хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургалтын албаны дарга

Монгол хэл

Б.Оюунцэцэг	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
Ө.Цэндсүрэн	Нийслэлийн Боловсролын газрын ахлах мэргэжилтэн
М.Базаррагчаа	Монгол Улсын Их сургууль, НХС-ийн багш проф. Sc.D
Ц.Өнөрбаян	Монгол Улсын Боловсролын Их Мургууль, МоСС-ийн профессор багш, Sc.D
Ц.Туул	“Шинэ эрин” лаборатори сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
Б.Цасанчимэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Ш.Баттөгс	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн тэнхимийн эрхлэгч, Ph.D
Д.Эрдэнэсан	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн багш, Ph.D

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Ө.Цэндсүрэн	Singapore School of Mongolia сургуулийн захирал, магистр
Ш.Оюунцэцэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Сургалтын албаны дарга, магистр
Д.Эрдэнэсан	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн багш, Ph.D
Б.Цасанчимэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Г.Нандинбилиг	Монгол Улсын Их Сургууль, ХШУС-ийн багш, Ph.D
П.Одсүрэн	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, Ph.D
Ц.Туул	“Шинэ эрин” лаборатори сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
А.Энхнаран	“Байгаль эх” лицей сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр
Ж.Гэрэлмаа	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Уран зохиол

Г.Галбаяр	Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, соёлын сургуулийн тэнхимийн эрхлэгч, Ph.D
С.Энхбаяр	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн уран зохиолын тэнхимийн эрхлэгч,Sc.D
Г.Нандинбилиг	Монгол Улсын Их Сургууль, Монгол хэл, соёлын сургуулийн багш, Ph.D
П.Одсүрэн	“Гурван-Эрдэнэ” БДС-ийн багш
Д.Туяа	“Шинэ эхлэл” лаборатори сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Ө.Цэндсүрэн	Singapore School of Mongolia сургуулийн захирал, магистр
Ш.Оюунцэцэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Сургалтын албаны дарга, магистр
Д.Эрдэнэсан	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн багш, Ph.D
Б.Цасанчимэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Г.Нандинбилэг	Монгол Улсын Их Сургууль, ХШУС-ийн багш, Ph.D
П.Одсүрэн	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, Ph.D
Ц.Туул	“Шинэ эрин” лаборатори сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
А.Энхнаран	“Байгаль эх” лицей сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр
Ж.Гэрэлмаа	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Монгол бичиг

Ү.Ариунболд	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн багш, Ph.D
Д.Баттогтох	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Ph.D
Д.Заяабаатар	Монгол Улсын Их Сургууль, МХСС-ийн багш, Ph.D
Б.Батчимэг	Нийслэлийн 23 дугаар сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
Н.Мөнхцэцэг	Нийслэлийн 39 дүгээр сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Ө.Цэндсүрэн	Singapore School of Mongolia сургуулийн захирал, магистр
Ш.Оюунцэцэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Сургалтын албаны дарга, магистр
Д.Эрдэнэсан	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, НХС-ийн багш, Ph.D
Б.Цасанчимэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Г.Нандинбилэг	Монгол Улсын Их Сургууль, ХШУС-ийн багш, Ph.D
П.Одсүрэн	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, Ph.D
Ц.Туул	“Шинэ эрин” лаборатори сургуулийн монгол хэл, уран зохиолын багш
А.Энхнаран	“Байгаль эх” лицей сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Цэдэнсодном	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр
Ж.Гэрэлмаа	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Эх хэлний зохих шатны мэдлэгтэй, нийгмийн харилцааны тодорхой орчинд аман болон бичгийн хэлээр чадварлаг харилцдаг, хэлний мэдрэмжтэй, соёлын ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Хэл зүйн болон үгийн сангийн зохих шатны мэдлэг, ойлголт эзэмшиж хэрэглэх чадвартай болох;

1.2.2. Унших, бичих, ярих-сонсох харилцааны чадвараа хөгжүүлэх, мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хэрэглэх чадвар эзэмших;

2.3. Эх хэлний баялаг санг судлан эзэмших, бичиг соёлоо хамгаалах, хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж соёлын ялгаатай байдлыг ойлгож, хүндэтгэлтэй хандах хүсэл эрмэлзлэлтэй болох.

ХОЁР. АГУУЛГА

МОНГОЛ ХЭЛ

VI АНГИ

6.1. УНШИХ

6.1а. Алдартай хүмүүсийн захидал, намтар, өдрийн тэмдэглэл, үйл явдлын мэдээ зэрэг эхийн орон, цагийн дараалал, учир шалтгааны уялдаа холбоо, бүтцийг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таних

6.1б. Богино өгүүллэг, үлгэр зэрэг эхийн бүтэц, учир шалтгааны уялдаа холбоо, орон цагийн дараалыг задлан шинжилж, хүүрнэсэн эхийн үндсэн шинжийг ялган таних

6.1в. Хүүрнэсэн эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн уялдаа холбоог тогтоож, эхийн сэдэв, гол санааг тодорхойлох

6.1г. Уншсан эхээс орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчныг тодорхойлох

6.1д. Уншсан эхийн доторх харилцан ярианы үүргийг тодорхойлох

6.1е. Уншсан эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлсэн хэсгийг ялгаж, зохиогчийн сэтгэлийн өнгө аясыг тайлбарлах

6.1ж. Уншсан эхээс чухал хэсгийг олж, бичигчийн санааг тайлбарлах

6.1з. Үйл явдлын мэдээ мэдээллийг нэгтгэн дүгнэж унших

6.1и. Уншсан эхэд жинхэнэ нэр, нэрийн тийн ялгал, биед ба эзэнд хамаатуулах нөхцөл, олон тооны дагаврыг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох

6.1к. Уншсан эхэд үйлийн цагаар төгсгөх болон биеэр төгсгөх, тодотгон холбох болон нөхцөлдүүлэн холбох нөхцөлийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох

6.1л. Уншсан эхэд орон цагийн нэрийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын үүргийг тодорхойлох

6.1м. Өгүүлбэрийг гишүүдээр хурааж, дэлгэрүүлж найруулах

6.2. БИЧИХ

6.2а. Захидал, намтар, өдрийн тэмдэглэл, тохиолдсон явдал, үйл явдлын мэдээг орон, цагийн дараалаар өрнүүлэн учир шалтгааны уялдаа холбоотой бичих

6.2б. Үлгэр, өгүүллэг зохиохдоо орон, цаг, дараалаар өрнүүлэн, сэдэв, агуулгыг учир шалтгааны уялдаа холбоотой бичих

6.2в. Өгсөн сэдэв, гол санаанд тохируулан үйл явдлыг сонгож бичих

6.2г. Эхэд өөрийн санаа, харилцан яриа оруулан дэлгэрүүлж бичих

6.2д. Хэлц ашиглан мэдрэмж сэтгэгдлээ дүрслэн бичих

6.2е. Товч мэдээллийг баримтаар дэлгэрүүлэх

6.2ж. Үйл явдлыг хэн?, хаана?, юу? яагаад?, хэрхэн? яав? гэсэн асуултын дагуу мэдээлж бичих

6.2з. Өөрийн болон бусдын зохиосон эхийн найруулгыг судалж, үг илүүдсэн, давтсан зэрэг алдааг таньж, сайжруулах

6.2и. Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих

6.3. СОНСОХ-ЯРИХ

6.3а. Тодорхой сэдвээр ярилцахдаа гол асуудлыг ойлгон, асуулт асууж тодруулах

6.3б. Санаа бодлоо бусдынхтай холбож, харилцан ярих

VII АНГИ

7.1. УНШИХ

7.1а. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал зэрэг хүн, юм, үзэгдлийн гадаад дотоод шинж, үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлсэн эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних

7.1б. Товч танилцуулга, илтгэх хуудас зэрэг тоочсон эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних

7.1в. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал, товч танилцуулга, илтгэх хуудас зэрэг эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох

7.1г. Аян замын тэмдэглэл, хөрөг найруулал зэрэг эхээс содон сонин үг хэллэг, уран дүрслэл (адилтгал, ихэсгэл, багасгал, амьдчилал), хэлцийн утга, үүргийг тодруулж, тоочин дүрслэх арга хэрэглүүрийг ялган таних

7.1д. Эхээс чухал хэсгийг олж, үндэслэлийг нь тайлбарлах

7.1е. Эхэд тооны нэр, тэмдэг нэр, дуурайх үгийг хэрэглэсэн учрыг тайлбарлаж, хэл зүйн шинж, найруулгын утга, үүргийг тодорхойлох

7.1ж. Хэлэх аялга, зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл нь зэрэгцүүлэн холбоход чухал үүрэгтэй байгааг эхийн жишээгээр тодруулан, зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийн найруулгын үүргийг тайлбарлах

7.1з. Эхэд эсрэг ба ойролцоо утгатай зэрэгцсэн нийлмэл үгийг сонгосон учрыг тайлбарлаж, найруулгын утга, үүргийг тодорхойлох

7.2. БИЧИХ

7.2а. Сонин содон үг хэллэг, тэмдэг нэр, мэдрэмж сэтгэгдэл оруулан, гадаад дотоод шинжийг тоочин дүрсэлж хөрөг бичих

7.2б. Хэлц, уран дүрслэл, дүрслэх ба дуурайх үг ашиглан үйлийн хувирал өөрчлөлтийг тоочин дүрсэлж аян замын тэмдэглэл бичих

7.2в. Тооны нэр, баримт нотолгоо, жишээ ашиглан танилцуулга, илтгэх хуудсыг тоочин бичих

7.2г. Өөрийн болон бусдын зохиосон эхийн найруулгыг судалж, үг буруу хэлбэржүүлсэн, оновчгүй сонгосон зэрэг алдааг таньж, сайжруулах

7.2д. Үгийн бүтцийг задлан ялгаж, бүтээврийн нийлцийг зөв бичих

7.3. СОНСОХ - ЯРИХ

7.3а. Сургууль, анги хамт олны өмнө тулгамдсан асуудлаас сонгон, баримт мэдээллийг судалж, чухлыг сонгон, санаа бодлоо илэрхийлж ярих

7.3б. Тулгамдсан асуудлын хүрээнд хэлэлцүүлэг хийхдээ баталж нотолж, дэмжиж, үгүйсгэж ярих

VIII АНГИ

8.1. УНШИХ

8.1а. Шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдвээр тоочин тайлбарласан, учир шалтааныг тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних

8.1б. Учир шалтааныг тайлбарласан, дүрслэн тайлбарласан, тоочин тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох

8.1в. Уншсан эхээс зохиогчийн мэдрэмж, сэтгэгдлийг ялган, учрыг тайлбарлах

8.1г. Өргөдөл, хүсэлт, заавар зөвлөгөө зэрэг албан бичгийн эхийн бүтэц, үгийн санг задлан шинжилж, найруулгын онцлогийг тодорхойлох

8.1д. Эхээс баримт мэдээллийг ялгаж, бүтэц, дараалалтай холбон, дүгнэх

8.1е. Уншсан эхэд дэвшүүлсэн асуудлын шалтгаан, үр дагаврын холбоо хамаарлыг тодорхойлж, загварчлах

8.1ж. Уншсан эхэд зохиогчийн ашигласан баримт, мэдээллийг ялгаж, дүгнэлт гаргах

8.1з. Шалтгааны утгатай угсарсан нийлмэл өгүүлбэрийн бүтсэн аргыг тодорхойлох

8.1и. Нутгийн аялгууны үг, гадаад үг хэллэгийн найруулгын үүргийг тодорхойлох

8.1к. Угсарсан нийлмэл үгийг ялган таньж, эх өгүүлбэрт гүйцэтгэсэн найруулгын үүргийг тодорхойлох

8.2. БИЧИХ

8.2а. Жишээ баримтаар баталж, уялдаа холбоотой тоочин тайлбарлаж бичих

8.2б. Хэлц, уран дүрслэл ашиглан мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо тусган найруулж бичих

8.2в. Өргөдөл, зөвлөгөөг албан бичгийн тогтсон бүтэц, загварын дагуу учир шалтгаан, холбоо хамааралтай бичих

8.2г. Угсруулан холбох үг, нөхцөлүүдийг ашиглан учир шалтгааныг тайлбарласан эх зохиож бичих

8.2д. Жишээ баримт ашиглан дүрслэн тайлбарласан эх зохиож бичих

8.2.е Өөрийн болон бусдын зохиосон эхийг хянан шинжилж, найруулгыг засан сайжруулах

8.1ж. Зохион найруулсан эхээс баримтын учир зүйн холбох үгийг буруу хэрэглэсэн алдааг таньж, найруулгыг сайжруулах

8.3. СОНСОХ - ЯРИХ

8.3а. Сонсогчоо мэдэрч, оновчтой баримт, мэдээлэл ашиглан илтгэх

8.3б. Тогтвортой хөгжлийн сэдвийн хүрээнд асуудал дэвшүүлэн, баталж нотолж тайлбарлан ярих

IX АНГИ

9.1. УНШИХ

9.1а. Уншигчийн захидал, шүүмж зэрэг асуудал дэвшүүлэн тайлбарласан, учир шалтгааныг тайлбарласан, таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхийн бүтэц, агуулгын уялдаа холбоог задлан шинжилж, үндсэн шинжийг ялган таних

9.1б. Учир шалтгааныг тайлбарласан, таамаглал дэвшүүлэн тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох

9.1в. Зохиогчийн үзэл бодол, мэдрэмж сэтгэгдэл, бичлэгийн өнгө аясыг дэвшүүлсэн асуудал, дүгнэлт өгүүлбэрийн уялдаа холбоо, баймж нэгжүүдээр тодорхойлж тайлбарлах

9.1г. Тайлбарласан эхийн агуулгыг баримт - үзэл бодол, шалтгаан - үр дагавар, таамаглал баталгаа нотолгооны холбоо хамаарлаар ялган тодруулах

9.1д. Баталсан, таамагласан, үгүйсгэсэн утгат баймж нэгжүүд, угсруулан ба зэрэгцүүлэн холбох үг, нөхцөл болон орон, цаг, зорилго, шалтгааны утгат угсруулан холбох үг бүтээврээр зохиогчийн хэлний онцлогийг тайлбарлах, тодорхойлох

9.1е. Өөр өөр цаг үед бичсэн ижил сэдэвтэй эхийн үгийн санг харьцуулан дүгнэх

9.2. БИЧИХ

9.2а. Асуудал дэвшүүлэн таамаглаж бичихдээ баталж нотолж, үгүйсгэж бичих

9.2б. Байгаль, нийгэм, эдийн засгийн сэдвээр асуудал дэвшүүлэн, шалтгаан үр дагаврын холбоог гаргаж бичих

9.2в. Асуудал дэвшүүлэн тайлбар, үзэл бодол, дүгнэлтийг уялдаа холбоотой илэрхийлж бичих

9.2г. Ойролцоо, эсрэг ойлголтыг жишиж харьцуулан дүгнэх, учир шалтгааныг тайлбарлан бичихдээ тохирох холбоосоор холбон найруулах

9.2д. Орон, цаг, зорилго, шалтгааны утгатай холбох, үг, нөхцөл ашиглан угсарсан нийлмэл өгүүлбэрийг зохион найруулж бичих

9.2е. Баримтад үндэслэн тайлбарлан бичих

9.2ж. Тайлбарласан эх, өгүүлбэрээс үг илүүдсэн, дутсан, буруу сонгосон, буруу хэлбэржүүлсэн, үг, өгүүлбэрийг буруу холбосон, буруу байрлуулсан зэрэг алдааг таньж, найруулгыг сайжруулах

9.2з. Цэг цэглэлийг хэрэглэх

9.3. СОНСОХ - ЯРИХ

9.3а. Нийгмийн хүрээнд тулгамдсан асуудлаар баримтад үндэслэн, баталж, нотолж, үгүйсгэн үзэл бодлоо илэрхийлж мэтгэлцэх

ҮНДЭСНИЙ БИЧИГ

VI АНГИ

6.1. УНШИХ

6.1а. Дуудлага бичлэг тохирдог үгийг шударга унших

6.1б. Дармал, бичмэл бүхий үг, холбоо үг, хялбар үгтэй өгүүлбэрийг унших

6.2. БИЧИХ

6.2а. Үндэсний бичгийн үндсэн зурлагыг харьцуулах аргаар ялган таних, хичээнгүй бичих

6.2б. Эгшгийн эхэн, дунд, адагт ордог хэлбэрээр гийгүүлэгчийг амилуулан зөв бичих

6.2в. Үе, үг, холбоо үг, өгүүлбэрийг хичээнгүй хуулж бичих

6.2г. Галигаас үндэсний бичгээр зөв бичих

6.2д. Сурах бичгийн хүрээн дэх дуудлага бичлэг зөрүүтэй үгийг галигаас үндэсний бичгээр бичих

6.3. ХЭЛ ЗҮЙ

6.3а. Нэр үгийг олон тооны дагавар, тийн ялгал, хамаатуулах, нөхцлөөр, зөв хувилган бичих

VII АНГИ

7.1. УНШИХ

7.1а. Дармал, бичмэл эхийг харьцуулж унших

7.1б. Гадаад үг, өгүүлбэрийг шударга унших

7.1в. Сурах бичгийн хүрээнд дуудлага бичлэг зөрүүтэй үгсийн хэлбэр, утгыг харьцуулан унших

7.2. БИЧИХ

7.2а. Бичмэл эхийг хичээнгүй хуулж бичих

7.2б. Дармал эхийг бичмэлээр хичээнгүй хуулж бичих

7.2в. Галиглан бичсэн өгүүлбэр, бичил эхийг үндэсний бичигт хөрвүүлэх

7.2г. Урт, хос эгшигтэй үгийг зөв бичих

7.2д. Үйл үгийн язгуур үндсийг цагаар төгсгөх нөхцлөөр зөв ялган бичих

7.3. ХЭЛ ЗҮЙ

7.3а. Урт, хос эгшгийг тэмдэглэх ёсыг таних

7.3б. Холбох эгшгийн дүрмийг таньж, цагаар төгсгөх нөхцлөөр хувилган бичих

7.3в. Холбох эгшгийн дүрмийг таньж үйл үгийг зөв хувилган бичих

VIII АНГИ

8.1. УНШИХ

8.1а. Дармал, бичмэл эхийг галигаар болон орчин цагийн дуудлагаар хослуулан унших аргаар эхийг шууд унших

8.1б. Үндэсний зан заншил, сэтгэлгээний онцлог бүхий эх, сургаалын зохиолыг шударга унших

8.1в. Бийрийн хичээнгүй бичгээс зөв унших

8.2. БИЧИХ

8.2а. Үсгийн бичмэл тигээр өгүүлбэр, эхийг хичээнгүй бичих

8.2б. Дармалаас бичмэл тигээр хичээнгүй бичих

8.2в. Сурах бичгийн хүрээний дуудлага бичлэг зөрүүтэй үгсийг кириллээс үндэсний бичигт хөрвүүлэх

8.2г. Галигаас үндэсний бичгээр бичих

8.3. ХЭЛ ЗҮЙ

8.3а. Нэр, үйл язгуур, үндсийг харьцуулах аргаар ялган таних

8.3б. Хувилгагч, эс хувилгагч залгаврын бүтэц, хэлбэрийг хурьцуулан судалж, холбох ёсны дагуу зөв хувилган бичих

8.3в. Үйл үгийн хэв, байдлын дагавар, холбох, төгсгөх нөхцөлийг зөв бичих

IX АНГИ

9.1. УНШИХ

9.1а. Дармал, бичмэл, бийрээр бичсэн эхийг хурдан, шударга уншиж ойлгох

9.1б. Уншсан эхээс түүхэн үг, хэллэгийн утгыг тольчлон тайлбарлах

9.1в. Түүх, соёл, өв уламжлал бүхий монгол бичгийн хичээнгүй, дармал, хулсан үзэг, бийрийн хэлбэрээр бичсэн түүхэн зохиол судар бичгээс сонгон унших

9.2. БИЧИХ

9.2а. Бийрийн бичмэл хэлбэрийг дуурайн бичих

9.2б. Түүх, соёл, өв уламжлалын сэдэв бүхий дармал болон бийрээр бичсэн эхийг хичээнгүй тигээр бичих

9.2в. Сурах бичгийн хүрээн дэх дуудлага бичлэг зөрүүтэй үгсийг толь бичиг ашиглан зөв бичих

9.3. ХЭЛ ЗҮЙ

9.3а. Нэр, үйл үг бүтээх хувилгагч дагаврыг холбох ёсны дагуу зөв залган бичих

УРАН ЗОХИОЛ

VI АНГИ

6.1. УНШИХ

6.1а. Монгол аман яруу найргийн богино хэлбэрүүд, домог, үлгэр, сургаалын яруу найраг, өгүүллэг, дэлхий дахины шилдэг үлгэр, өгүүллэгээс уншиж, соёлын хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авах

6.1б. Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл (амьдчилал, адилтгал) -ийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах

6.1в. Зохиолын өгүүлэгдэхүүнийг үйл явдлын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллаар ялган таних

6.1г. Зохиолын сэдэв, гол санааг тайлбарлах

6.1д. Зохиолын орчныг орон ба цагийн дүрслэлээр ялган таних

6.1е. Зохиолын дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох

6.1ж. Шүлэглэсэн зохиолын шад, холбоцыг таних

6.2. БИЧИХ

6.2а. Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих

6.2б. Уншсан зохиолын гол санааг алдагдуулахгүй үйл явдлыг товчилж бичих

6.2в. Шүлгийн хэлбэрийг дуурайн зохиох

6.3. СОНСОХ - ЯРИХ

6.3а. Уншсан зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярих

6.3б. Шүлэг зохиолоос сонгон цээжилж, дуу хоолойн өнгө, айзам, хэмнэлийг тохируулан уран унших

VII АНГИ

7.1. УНШИХ

7.1а. Монгол ерөөл, магтаал, түүх домог, уянгын ба туульсын яруу найраг, туурь, өгүүллэг, өрнө дорнын шилдэг зохиолоос уншиж, соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авах

7.1б. Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл (адилтгал, амьдчилал, хэтрүүлэл) -ийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах

7.1в. Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц хэсгүүдийн холбоо хамаарлыг тодорхойлох

7.1г. Зохиолын сэдэв, гол санааг тодорхойлох

7.1д. Зохиолын орчин, нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлах

7.1е. Зохиолын дүрийн шууд ба шууд бус тодорхойлолт (үг, үйлдэл, бодол санаа)-оос дүрийн зан төрхийг тодорхойлж, үнэлэх

7.1ж. Шүлэглэсэн зохиолын шад, холбоцыг тайлбарлах

7.2. БИЧИХ

7.2а. Уншсан зохиолын сэдэв, утга санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичих

7.2б. Уншсан зохиолд дүр, орчин нэмэх, харилцан яриа оруулах зэргээр үйл явдлыг дэлгэрүүлж бичих

7.2в. Ерөөл, магтаалын шүлэглэлийн туршлага, уран дүрслэл (адилтгал, зүйрлэл)-ийн аргаас суралцан, шүлэг зохиох

7.3. СОНСОХ - ЯРИХ

7.3а. Зохиолын үйл явдлыг ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэлээс эшлэл авч, сонирхол татаж сэтгэлд хүрэхээр ярих

7.3б. Зохиолын дүрийн үг үйлдлээр зан төрхийг харуулж, дүрд тоглох

VIII АНГИ

8.1. УНШИХ

8.1а. Монгол баатарлаг туульс, иргэний яруу найраг, өгүүллэг, туурь, тууж, хошин жүжиг, өрнө дорнын шилдэг зохиолоос уншиж, соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авах

8.1б. Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл (ёгтлол, егөөдөл) -ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлах

8.1в. Зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц ба үйл явдлын дараалыг хүүрнэлийн учир холбогдлоор тайлбарлах

8.1г. Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдвийг хэрхэн хөгжүүлснийг задлан шинжлэх

8.1д. Зохиолын орчин, нөхцөл байдал нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг тайлбарлах

8.1е. Зохиолын дүрүүдийн хоорондын холбоо хамаарлаар гол ба туслах дүр, сөрөг дүрийг тодорхойлох

8.1ж. Шүлэглэсэн зохиолын шад, холбоц, айзам хэмнэлийг тайлбарлах

8.2. БИЧИХ

8.2а. Уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих

8.2б. Уншсан зохиолын дүр, дүрслэлийг тайлбарлах

8.2в. Уншсан зохиолын дүр, орчныг өөрчлөх буюу ёгтлол, егөөдөл ашиглан, үйл явдлыг өрнүүлэн богино өгүүллэг зохиох

8.3. СОНСОХ - ЯРИХ

8.3а. Шүлэглэсэн зохиолын айзам хэмнэлийг илрүүлэн уран унших

8.3б. Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэн хэлэлцэх

IX АНГИ

9.1. УНШИХ

9.1а. Монголын эртний тууж, түүхэн сурвалжаар уламжилсан яруу найраг, туурь, бэсрэг роман, жүжгийн зохиолоос сонгон уншиж, соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авах

9.1б. Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл (бэлгэдэл) -ийн учир холбогдлоор далд утгыг тайлан тайлбарлах

9.1в. Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, үйл явдпын өнгөрснийг дурсах, ирээдүйг зөгнөх аргын нөлөөг тайлбарлах

9.1г. Зохиолын утга санааг бүрдүүлэхийн тулд сэдэв, хам сэдвийг хэрхэн хөгжүүлснийг дүгнэх

9.1д. Зохиолын орчин, нөхцөл байдал нь сэдэв утгыг тодруулахад нөлөөлж буйг шинжлэх

9.1е. Зохиолын дүрийн зорилго, зан төрх, холбоо хамаарлаас дүрийн өсөлтийг дүгнэх

9.1ж. Шүлэглэсэн зохиолын шад, холбоц, бадаглалын туршлагыг шинжлэх

9.2. БИЧИХ

9.2а. Уншсан зохиолын сэдэв, утга санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичих

9.2б. Уншсан зохиолын сэдэв, утга санаа, дүр, дүрслэлээс сонгон, баримт жишээ ашиглан үнэлж дүгнэх

9.2в. Дүр, орчныг хувирган, үйл явдлыг төгсгөн, богино өгүүллэг зохиох

9.3. СОНСОХ - ЯРИХ

9.3а. Бие даан уншсан зохиолыг бусдад унших хүсэл төрөхүйц, сонирхолтой арга хэлбэрээр танилцуулан илтгэх

9.3б. Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцэх

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Мэдээлэлтэй ажиллах арга барил

Мэдээлэл хүлээн авах: Энэ шатанд унших ба сонсох чадвар чухал үүрэгтэй. Үүний тулд хурдтай багцлан унших замаар уншиж ойлгох, ойлгосон мэдлэг мэдээллээ нэгтгэн дүгнэх, сонголт хийхэд бэлэн болгох явдал юм.

Уншиж байгаа мэдээллийн хэмжээг нэмэгдүүлэн, тэдгээрээс чухал ба чухал бусыг ялгаж салган мэдээллийн чанарыг сайжруулах чадвартай болно.

Мэдээлэл боловсруулах: Энэ шатанд уншсан эхийг задлан шинжилж, гол ба гол бус шинжийг ялгах, харьцуулах, олон талаас харах, утгачлан тогтоох, нэгтгэн дүгнэх, үнэлгээ өгөх зэргээр судална. Гол ба гол бус гэдэгт уншигчийн байр суууринаас биш бичсэн хүний байр суууринаас хандах хэрэгтэйг ойлгоно. Аливаа зохиол бүтээлийг уншихдаа түүнд нуугдаж байгаа далд санааг олж зохиолчийн уран сайхны мэдрэмж ба сэтгэгдлийг тунгаан бодох замаар гол агуулгыг ойлгон,түүнд үндэслэн өөрийн бодол санаа ба мэдрэмжийг тогтооно.Энэ нь мэдээлэл дотор байгаа эерэг санааг сонгон авч,өөрийн бодол санаа, мэдрэмжтэй уялдуулах явц юм.

Илэрхийлэх: Энэ нь өмнөх шатуудад бий болгосон мэдлэг чадвартаа үндэслэн шинэ сэдэв, санаа олох, ярьж бичихийн тулд холбогдох мэдээлэл эрж хайх, ангилж бүлэглэх, төлөвлөх, бичиж боловсруулах, түүнийгээ амаар болон бичгээр илэрхийлнэ.Товчоор хэлбэл, тодорхой “бүтээгдэхүүн” гаргахад бэлтгэх болон түүнийгээ танилцуулах үйл явцыг хамтад нь ойлгоно.

Унших чадварын зорилго нь төрөл бүрийн найруулгаар бичсэн эхийн учир утга санааг ойлгож, өргөн хүрээнд холбох, улмаар учир утгатай хэрэглэж сурахад оршино. Тухайлбал,

- Мэдээлэл авах
- Баримт нотолгоо олох
- Үзэл бодлоо өргөжүүлэх,өөрчлөх
- Үнэт зүйл,соёлын агуулгыг ойлгох зэргээр өргөн хүрээнд холбох чадвар эзэмших юм.

Сонсох ба унших чадвар нь бусдын ярьж, бичсэнээс суралцахад гол үүрэгтэй бол ярих ба зохиож бичих нь юмс үзэгдлийг хэрхэн ойлгож байгаагаа өөрийн үзэл бодлоор илэрхийлэхтэй холбогддог. Энэ нь сурагчаас харьцангуй бүтээлч үйл шаардана. Өөрөөр хэлбэл, суурь боловсролын түвшинд унших ба сонсох, ярих ба бичих энгийн үйлдлийг “ухаарч ярих”, “ухаарч сонсох”, “ухаарч бичих”, “ухаарч унших” чадвар оюуны гүн үйлдэл болгоно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, гадаад яриаг дотоод яриа болгох, дотоод яриаг оюуны үйлдэл болгож, түүнийгээ өөрийн болгон ярьж, бичиж сургах нь чухал бөгөөд энэ нь суралцахуйн үйл ажиллагааны онолд тулгуурлана. Эдгээрийг сургалтын хөтөлбөрт “зорилготой ярьж, бичих”, “эргэцүүлэн бодох” гэж томьёолсон.

“Хэлний зүй,уран зохиолын мэдлэг, ойлголт, ур чадвар” гэдгийн дор сурагчид хэл шинжлэл, уран зохиол шинжлэлийн ухагдахуун, ойлголт, хууль, дүрэм, тодорхойлолт, зүй тогтол, нэр томьёог хөтөлбөрийн хүрээнд ойлгож, хэлний хэрэглээнд хэрэглэх чадварыг ойлгоно.

“Эх хэлээ хэрэглэх хүсэл эрмэлзэл, оролцоо” гэдгийн дор өдөр тутмын харилцаанд зөв, ойлгомжтой ярьж,бичихийг эрмэлзэх, өдөр тутмын амьдрал, нийгмийн орчны хэл ярианы хэрэглээг сонирхон судлах, асуудал дэвшүүлэх, эрэл хайлт хийх, бичиж боловсруулах, илтгэж танилцуулах, үндэсний хэл бичгийн мөн чанар үнэ цэнийг тодорхойлох, хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа байдал, идэвх санаачилга, хандлагыг ойлгоно.

3.2. Хичээлийн онцлог

- Монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг хичээлүүд нь соёл сэтгэлгээний онцлогийг хөгжүүлэх, хадгалахад сургах онцлогтой. Эх хэлний хичээлээр нийгэм, соёлын янз бүрийн орчинд эх хэлээрээ бүтээлчээр харилцах, хэлний мэдлэг ойлголтоо ашиглан мэдрэмж, үзэл бодлоо аман болон бичгийн хэлээр (сонсох, ярих, унших, бичих) баримт

нотолгоо, эш үндэслэлтэйгээр илэрхийлж сурах нь чухал.

- Монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг хичээл нь уран зохиолын ба уран зохиолын бус эхэд суурилан эхийг агуулга, бүтэц, хэл зүйгээр задлан шинжлэх явцдаа судлан шинжлэх арга барил эзэмшиж янз бүрийн мэдээллийг боловсруулан ярих, бичих үйлдээ бүтээлчээр хэрэглэх чадварт сургах юм.
- Нийгмийн тодорхой асуудлаар өөрийн өвөрмөц байр суурь, үзэл бодол, чөлөөт сэтгэлгээгээ илэрхийлэх, жишээ баримт ашиглах, үндэслэл нотолгоотой бичих ур чадварт сургахдаа
    - Тодорхой асуудал буюу сэдвээ тодорхойлох
    - Сэдвийн хүрээний мэдээлэл, баримт, жишээ цуглуулах
    - Өөрийн үзэл бодлоо цэгцлэн боловсруулах
    - Эхийг хэрхэн бичихээ төлөвлөх, шийдэл гаргах
    - Эхийг бичиж боловсруулах, сайжруулах гэсэн тодорхой алхамт арга барилыг эзэмшүүлнэ.

3.3. Сургалтын хэрэглэгдэхүүн

Уран зохиолын бус эхийг сонгох нь:

- Тухайн ангийн агуулгад байгаа онцлогийг сайн гаргахуйц эхийг сонгох
- Мэдээллийг бичсэн хүний бодол санаа, илэрхийлсэн өнгө аясын ойролцоо ба ялгаатай байдал, зорилго, жишээ, эшлэл, үнэлэмж, баримт, жишээ агуулгын уялдаа холбоог тогтоохуйц эх бичвэрүүдийг сонгох
- Тулгамдсан асуудал дэвшүүлсэн, үзэл бодол, шалтгаан - үр дагавар, таамаглал бүхий эх сонгоход анхаарах
- Мэдээлэн тайлбарласан, дүрслэн тайлбарласан, асуудал дэвшүүлсэн эхийн (шинжлэх ухаан, танин мэдэхүйн болон байгаль хамгаалах сэдэвтэй) сонголтыг чухалчлах
- Ятгах стратегийг сайн гаргасан зар сурталчилгаа, болон төсөөлөх чадварыг сайн харуулах эх хэрэглэгдэхүүнийг сонгох
- Монгол ахуй соёл, үндэсний соёл сэтгэлгээ, уламжлал, зан заншлыг харуулсан уран дүрслэл , өвөрмөц, сонин содон үг хэллэг бүхий эхийг сонгож хэрэглэх
- Монголын сургаалын зохиолууд болон тогтвортой хөгжлийн 17 зорилгоос ядуурлыг устгах, эрүүл мэндийг дэмжих, чанартай боловсролыг дэмжих, тэгш бус байдлыг бууруулах, хариуцлагатай хэрэглээг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах гэх мэт сэдвүүдийн хүрээнд сонгож хэрэглэх.
- Мэдээллийг хүлээж авахын тулд гол агуулга нь юу болох, “чухал зүйл“ болон “маш чухал зүйл“-д анхаарлаа хандуулан уншиж, сонсож байгаа хүний байр сууринаас үзэх төдийгүй түүнийг бичигчийн байр сууринаас хандаж ойлгох эргэцүүлэн тунгаан бодох, эргэлзэн тээнэгэлзэх сэтгэлгээний арга барилд сургах эхийг сонгох
- Хүний сэтгэл хөдлөлийн олон янз байдлыг үзүүлсэн зохиолоос гадна түүх, нийгэм, соёлын хам сэдэв бүхий зохиол бүтээл сонгох

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт, шалгуур

А. Үгийн сан, хэл зүй, уран зохиолын мэдлэг ойлголт

Б. Унших, бичих, сонсох-ярих чадвар, мэдээлэлтэй ажиллах чадвар

В. Эх хэлээ сонирхон судлах хүсэл эрмэлзэл, өөрийн болон бусдын хэл, соёлыг хүндэтгэх хандлага

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
Үгийн сан, хэл зүй, уран зохиолын мэдлэг ойлголт	1. Үг зүй, өгүүлбэр зүй, үгийн сангийн ойлголт, нэр томьёо 2. Уран зохиолын онолын ойлголт 3. Үндэсний бичгийн зөв бичих дүрэм
Унших, бичих, сонсох-ярих чадвар, мэдээлэлтэй ажиллах чадвар	Унших, сонсох А1. Эхийн агуулга, гол санааг ойлгосноо харуулах А2. Эхийн шууд ба далд утга, өнгө аясыг ойлгосноо харуулах А3. Эхийн агуулгын бүтэц, дараалал (орон цаг, учир шалтгаан, чухал чухал бус), уялдаа холбоог задлан шинжлэх, дүгнэх А4. Эхэд хэрэглэсэн баримт, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодол задлан шинжлэх, үнэлж дүгнэх А5. Зохиолын хэл найруулга, түүний арга хэрэглүүр, үг хэллэгийн үр нөлөө, хэрэглэсэн зорилгыг тайлбарлах, үнэлж дүгнэх
	Бичих, ярих Б1. Сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодол, төсөөллөө үр дүнтэй илэрхийлэх Б2. Уншигч, сонсогчдод сонирхол төрүүлэхээр баримт мэдээлэл, сэтгэгдэл мэдрэмж, үзэл бодлоо дараалалд оруулж илэрхийлэх Б3. Зорилго, нөхцөл байдалд тохируулан санаагаа эш үндэстэй тодорхой илэрхийлэх Б4. Харилцан ярилцах үед бусдыг анхааралтай сонсож, хариулт өгөх, тодруулан асуух
Эх хэлээ сонирхон судлах хүсэл эрмэлзэл, өөрийн болон бусдын хэл, соёлыг хүндэтгэх хандлага	1. Монгол хэл бичиг, үндэсний соёл, ахуй, ёс заншлыг сонирхон судлах 2. Хэл соёлын ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэх, хамтран ажиллах

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	**Эзлэх хувийн жин**
Мэдлэг ойлголт	30%
Унших чадвар	30%
Бичих чадвар	40%
Хандлага	

МАТЕМАТИК

“Математик”-ийн сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч: М.Итгэл, Монгол Улсын Их Сургууль, ШУС-ийн дидактикийн багш, Ph.D

Багийн гишүүд

Д.Мөнхжаргал	Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирал, проф, Ph.D
Т.Ганбаатар	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, МБУС-ийн Хөтөлбөрийн албаны дарга
Д.Түвшинжаргал	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр
Э.Чойсүрэн	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, МБУС-ийн дидактикийн багш
Ж.Буянт	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Д.Даваасүрэн	“Байгаль эх” лицей сургуулийн математикийн багш
Б.Энхболд	“Шинэ эхлэл” сургуулийн математикийн багш
Н.Цогзолмаа	Нийслэлийн 14 дүгээр сургуулийн математикийн багш
Б.Эрдэнэсувд	Нийслэлийн Ирээдүй цогцолбор сургуулийн математикийн багш
Б.Ариунтунгалаг	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Б.Баяржаргал	МУИС, ШУС-ийн Математикийн тэнхимийн багш, Ph.D
Д.Түвшинжаргал	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр
Н.Цогзолмаа	Нийслэлийн 14 дүгээр сургуулийн математикийн багш
Ш.Амарсанаа	Нийслэлийн 14 дүгээр сургуулийн математикийн багш
О.Үүрцайх	Нийслэлийн 24 дүгээр сургуулийн математикийн багш

Хянан тохиолдуулсан (2019)

Д.Түвшинжаргал	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь тоо, хувьсагч, дүрс, хэмжигдэхүүн, өгөгдөлтэй ажиллах, асуудал шийдвэрлэх арга барилд суралцан, математикийн мэдлэг, чадвараа амьдрал, ахуйд хэрэглэснээр хэл, сэтгэлгээ, танин мэдэх чадвараа хөгжүүлж, математикийг сонирхон судлах хүсэл, тэмүүлэлтэй болно.

1.2. Зорилт

2.1. Математикийн нэр, томьёо, ойлголт, хууль, дүрэм, чанар, зүй тогтлыг танин мэдэх, тэдгээрийн учир шалтгааныг ойлгох, тайлбарлах;

2.2. Математикийн мэдлэг, чадвараа хэрэглэн асуудлыг загварчлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, математик арга, сэтгэлгээгээр асуудалд хандах, оновчтой арга, хувилбарыг сонгож шийдвэрлэх арга барил эзэмших;

2.3. Юмс, үзэгдлийн учир шалтгааныг эргэцүүлэн бодох, үндэслэх, эмх цэгцтэй, учир зүйтэй сэтгэн бодох, өөрийгөө илэрхийлэх үйл ажиллагаанд суралцах;

2.4. Математикт суралцахуйн ач холбогдлыг ойлгон, математикийг сонирхон судлах хүсэл, тэмүүлэлтэй болох.

Математикийн хичээлээр асуудал шийдвэрлэх арга барилд суралцана. Асуудал шийдвэрлэх арга барилыг танин мэдэхүйн үйл явцтай холбон VI - VII анги, VIII - IX анги гэсэн хоёр түвшинд 4 үе шаттай тодорхойлсон болно.

Асуудал шийдвэрлэх арга барил		
Үе шат	**VI-VII анги**	**VIII-IX анги**
Асуудлыг олж харах, томьёолох	- Өдөр тутмын амьдрал дахь математикийн асуудлыг олж харах, ойлгох, өөрийн үгээр болон зураг, схемээр томьёолох	- Нийгэм, ахуй амьдрал дахь математикийн асуудлыг олж харах, ойлгох, математик нэр томьёо, ойлголтоо ашиглан томьёолох
Асуудлыг математик загварт оруулах, төлөвлөгөө боловсруулах	- Шаардлагатай мэдээлэл цуглуулах - Өмнөх туршлагатайгаа харьцуулах, жишээ олох - Таамаглал дэвшүүлэх - Асуудлыг математикийн хэл рүү хөрвүүлэх - Төлөвлөгөө боловсруулах, алгоритм хэрэглэх	- Шаардлагатай мэдээлэл, статистик тоо, баримт цуглуулах, хэрэгцээгүй мэдээлэл байгаа эсэхийг тогтоох - Өмнөх туршлагатайгаа харьцуулах, ижил төстэй болон эсрэг жишээ олох; - Тодорхой үндэслэлтэй таамаглал дэвшүүлэх - Асуудлыг математикийн аргаар загварчлах - Хувилбарт төлөвлөгөө боловсруулах, алгоритм зохиох
Төлөвлөгөөг хэрэгжүүлэх	- Төлөвлөгөөний алхам бүрийг гүйцэтгэх, хийж буй үйлдлээ алдаагүй, үнэн зөв бичиж тэмдэглэх - Тооцоолол хийх, боломжуудыг тооцох, тухайн тохиолдлуудыг шалгах - Диаграмм, график, байгуулалтыг ойлгомжтой байдлаар өгсөн нарийвчлалтай зурах, дүрслэх, тайлбарлах	- Төлөвлөгөөний алхам бүрийг гүйцэтгэх, хянах, хийж буй үйлдлээ алдаагүй, үнэн зөв бичиж тэмдэглэх - Тооцоолол хийх, боломжуудыг тооцох, үнэлэх, онцгой болон эсрэг тохиолдлуудыг шалгах - Диаграмм, график, байгуулалтыг тохирох нарийвчлалыг сонгон, өөртөө болон бусдад ойлгомжтой байдлаар зурах, дүрслэх, үндэслэлтэй тайлбарлах

Дүгнэлт гаргах, үр дүнг тайлбарлах	- Дүгнэлтээ математик тэмдэглэгээ, нэр томьёо ашиглан тайлбарлах - Дүгнэлтээ бусадтайгаа хэлэлцсэний үндсэн дээр сайжруулах - Асуудлыг шийдвэрлэх өөр арга зам байгаа эсэхийг тодорхойлох - Шийдсэн асуудалтай холбоотой өөр бодлого, асуудал дэвшүүлэх	- Дүгнэлтээ математик нэр томьёо, тэмдэглэгээ, ойлголтоо ашиглан тодорхой үндэслэлтэй тайлбарлах - Дүгнэлт нь асуудалд бүрэн хариулт өгч байгаа эсэхийг тооцох, дүгнэлтийг бусадтайгаа хэлэлцсэний үндсэн дээр сайжруулах - Асуудлыг шийдвэрлэх өөр арга зам байгаа эсэхийг тодорхойлох - Шийдсэн асуудалтай холбоотой илүү өргөн, ерөнхий эсвэл явцуу асуудлыг дэвшүүлэх

ХОЁР. АГУУЛГА

Математикийн хөтөлбөрийн агуулгыг анги тус бүрээр Тоо тоолол, Алгебр, Геометр, Хэмжигдэхүүн, Магадлал, статистик гэсэн агуулгын бүрэлдэхүүн хэсгээр тодорхойлсон.

VI АНГИ

ТОО ТООЛОЛ

6.1. БҮХЭЛ ТООН ОЛОНЛОГ, ЗЭРЭГ, ЯЗГУУР

6.1а. Эерэг, сөрөг тоог ахуй амьдралд хэрэглэх, тоон шулуун хэрэглэн бүхэл тоонуудыг жиших, нэмэх, хасах, хялбар бүхэл тоонуудыг үржүүлэх, хуваах

6.1б. Тооны хуваагдах шинжийг хэрэглэн өгсөн тоо 2, 3, 4, 5, 6, 8, 9, 10, 100-д хуваагдах эсэхийг тогтоох, ерөнхий хуваагч, ерөнхий хуваагдагч, анхны ба зохиомол тоог таних, нэг ба хоёр оронтой тоонуудын ХИЕХ, ХБЕХ-ийг олох, хэрэглэх

6.1в. Бүхэл тооны квадрат зэргийг олох, түүний урвуу үйлдлийг ойлгох, квадрат язгуур нь -20-оос +20 хүртэлх бүхэл тоо байх тоог таних, цээжээр олох, тэмдэглэх

6.1г. Хэллэг, олонлогийн талаар анхны ойлголттой болох, тоон олонлогийн нэгдэл, огтлолцлыг олох, дүрслэх, тэмдэглэгээг хэрэглэх

6.2. ТООНЫ ОРНЫ УТГА, ТООГ ЖИШИХ, ТОЙМЛОХ

6.2а. Тооны бичлэг дэх цифрийн байршлын утгыг тайлбарлах, бүхэл тоо ба аравтын бутархайг 0.1, 0.01, 0.001-ээр үржүүлэх, хуваах

6.2б. Урт, хүнд, хугацааны хэмжээг ижил нэгжид шилжүүлэх замаар аравтын бутархайг жиших, эрэмбэлэх

6.2в. Олон оронтой тоог 10-т, 100-т, 1000-т, 10000-таар тоймлох, аравтын бутархайг бүхлээр болон аравны, зууны, мянганы хэсгээр тоймлох, хэрэглэх

6.3. ЭНГИЙН БА АРАВТЫН БУТАРХАЙ, ПРОЦЕНТ

6.3а. Бүхэл ба бутархай хэсгийн орны тоо нь ялгаатай байх аравтын бутархайнуудыг нэмэх, хасах,

6.3б. Аравтын бутархайг нэг ба хоёр оронтой бүхэл тоогоор болон аравтын бутархайгаар үржүүлэх, хуваах

6.3в. Аравтын бутархай оролцсон илэрхийлэлд үйлдлийн дараалын дүрэм, үйлдлийн чанарыг хэрэглэх, үйлдлийн дүнг урвуу үйлдлээр шалгах, хялбар аргаар тооцоолох

6.3г. Энгийн бутархайн үндсэн чанарыг хэрэглэн бутархайг хураах, тэнцүү бутархайнуудыг таних, засагдах бутархайг холимог бутархай, холимог бутархайг засагдах бутархай болгох

6.3д. Энгийн бутархайнуудыг ижил хуваарьтай болгох эсвэл тоон шулуун дээр тэмдэглэх замаар жиших, эрэмбэлэх

6.3е. Ижил биш хуваарьтай энгийн бутархайнуудыг нэмэх, хасах

6.3ж. Энгийн бутархайг үржүүлэх, өгсөн тооны тодорхой хэсэгт ногдох тоог олох, энгийн бутархайг бүхэл тоонд хуваах, бүхэл тоог энгийн бутархайд хуваах

6.3з. Төгсгөлөг аравтын бутархайг энгийн бутархайгаар илэрхийлэх, хуваах үйлдэл ашиглан энгийн бутархайг аравтын бутархайгаар илэрхийлэх

6.3и. Тоо, хэмжээний зууны нэг хэсэг нь процент гэдгийг хэрэглэн дүрс, тоо, хэмжээний хэсгийг энгийн бутархай, процент, аравтын бутархайгаар илэрхийлэх, эдгээрийг харилцан шилжүүлэх

6.3к. Тоо, хэмжээний өгсөн процентод ногдох тоог олох, бага тоог их тооны хэсэг, процентоор илэрхийлэх, асуудал шийдвэрлэх

6.4. ХАРЬЦАА, ПРОПОРЦ

6.4а. Харьцааг ойлгох, тэмдэглэх, тоо, хэмжээг өгсөн харьцаагаар хоёр ба гурван хэсэгт хуваах, тоо, хэмжээг харьцуулах, жишихэд процентийг хэрэглэх

6.4б. Пропорцын үндсэн чанар, түүнийг асуудал шийдвэрлэхэд хэрэглэх

6.4в. Шууд пропорционал хамаарлыг таних, пропорционалийн коэффициентийг олох, хялбар асуудал шийдвэрлэх

АЛГЕБР

6.5. АЛГЕБРЫН ИЛЭРХИЙЛЭЛ, ТЭГШИТГЭЛ

6.5а. Хувьсагч эсвэл тодорхойгүй тоог үсэг хэрэглэн бичих, алгебрын шугаман илэрхийлэл зохиох, төсөөтэй гишүүдийг эмхэтгэх

6.5б. Бүхэл тоон коэффициенттэй алгебрын шугаман илэрхийллийг хувиргах, хялбарчлах, хувьсагчийн оронд тоон утга орлуулан илэрхийллийн утгыг олох (хаалт дотор байгаа илэрхийллийг тогтмол тоогоор үржүүлэх, ерөнхий үржигдэхүүнийг хаалтнаас гаргах)

6.5в. Хувьсагч нь тэнцүүгийн тэмдгийн зөвхөн нэг талд нь байх бүхэл тоон коэффициенттэй шугаман тэгшитгэл зохиох, бодох

6.6. ДАРААЛАЛ, ФУНКЦ

6.6а. Дүрсэн дараалын зүй тогтлыг олох, үргэлжлүүлэх, дараалал зохиох

6.6б. Дараалын гишүүдийн зүй тогтлыг олох, үргэлжлүүлэх, тоон дараалал байгуулах

6.6в. Шугаман функцийн харгалзааны дүрмийг үгээр болон оролт, гаралтын схем хэрэглэн тодорхойлох

6.6г. Тэгш өнцөгт координатын хавтгайг тодорхойлох, цэгийн координатыг унших, бичих

6.6д. у нь х –ээр илэрхийлэгдсэн шугаман тэгшитгэлийг үнэн байлгах (х, у) хосуудыг олох, шууд пропорционал хамаарлын график байгуулах (I мөчид)

ГЕОМЕТР

6.7. ӨНЦӨГ, ДҮРС, БИЕТ

6.7а. Цэг, шулуун, хэрчим, цацраг, өнцгийг зурах, тэмдэглэх

6.7б. Перпендикуляр, параллел шулууны талаар ойлголттой болох, огтлолцсон шулуунуудын хоорондох өнцгийн чанар, хамар өнцгүүдийн нийлбэр (180°)-ийн чанарыг мэдэх, хэрэглэх, гүйцэд өнцгийг (360°) хэрэглэн тооцоолох

6.7в. Гурвалжны дотоод өнцгүүдийн нийлбэр 180° байдгийг хэрэглэн гүдгэр 4, 5, 6 өнцөгтийн дотоод өнцгүүдийн нийлбэрийг олох

6.7г. Гурвалжны тэнцэтгэл бишийг мэдэх, хэрэглэх

6.7д. Гүдгэр ба гүдгэр биш олон өнцөгтийг таних, ангилах, дөрвөн өнцөгтүүдийг (квадрат, тэгш өнцөгт, ромбо, параллелограмм) зурах, тэмдэглэх, тал, өнцгийн чанарыг тодорхойлох

6.7е. Тойрог, дугуй дүрсийг таних, нэрлэх, гортиг ашиглан тойрог, дугуй байгуулах

6.7ж. Призм, пирамидын орой, ирмэг, талсын тоог олох, цилиндр, конус, бөмбөрцгийг таних, нэрлэх, эдгээр биетүүдийг тодорхойлох, ангилах

6.7з. Гурвалжин шугам, транспортир хэрэглэн хэмжих, зурах:

- Хэрчмийг миллиметрийн нарийвчлалтай хэмжих, зурах
- Хурц, мохоо, тэгш өнцөг болон 180° –аас их хэмжээтэй өнцгүүдийг градусаар хэмжих, зурах
- Гурвалжныг өгсөн тал, өнцгөөр нь зурах

6.8. БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨН

6.8а. Координатын хавтгайд бүхэл тоон координаттай цэгийг тэмдэглэх, хялбар дүрс байгуулах

6.8б. Дүрсийн (гурвалжин, 4 өнцөгт, зөв 5, 6, 8 өнцөгт гэх мэт) тэгш хэмийн тэнхлэг (төв)-ийг таних, зурах

6.8в. Хавтгайн цэг ба дүрсийг хувиргах, хувиргалтыг таних

- Өгсөн шулууны хувьд тэгш хэмтэй байгуулах
- Өгсөн цэгийн хувьд тэгш хэмтэй байгуулах
- Параллел зөөлтөөр шилжүүлэх

6.8г. Тэнцүү дүрсийг таних, тэгш хэм, параллель зөөлт хувиргалтуудаар дүрсүүд тэнцүү дүрсэд шилждэг болохыг ойлгох, хэрэглэх

6.9. ХЭМЖИГДЭХҮҮН

6.9а. Хэмжих нэгжийг оновчтой сонгох, урт, хүнд, багтаамжийг хэмжих нэгжүүдийн хоорондын холбоо хамаарлыг мэдэх, нэгж шилжүүлэх

6.9б. Хугацааг хэмжих, хугацааны нэгжүүдийн хамаарлыг мэдэх, нэгж шилжүүлэх, 12 ба 24 цагийн систем, цагийн хуваарийг унших, хэрэглэх, үйл явдлын үргэлжлэх болон завсарлах хугацааг тооцоолох

6.9в. Аналоги ба дижитал хэмжих багажийн хуваарийг унших, хэрэглэх

6.9г. Талбайг хэмжих нэгжүүд, тэдгээрийг харилцан шилжүүлэх

6.9д. Тэгш өнцөгтийн периметр, талбайг олох томьёог гаргах, хэрэглэх, бүх өнцөг нь тэгш өнцөг байх нийлмэл дүрсийн талбай, периметрийг тооцоолох, асуудал шийдвэрлэх

6.9е. Тэгш өнцөгтийн аль нэг хэмжээсийг тодорхой тоо дахин ихэсгэхэд (багасгахад) талбай нь хэрхэн өөрчлөгдөхийг мэдэх, асуудал шийдвэрлэх

6.9ж. Тэгш өнцөгт параллелепипедийн дэлгээсийг таних, зурах, гадаргуун талбайг олох

6.9з. Тэгш өнцөгт параллелепипедийн эзлэхүүн олох томьёог гаргах, хэрэглэх

МАГАДЛАЛ, СТАТИСТИК

6.10. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ

6.10а. Өгөгдөл цуглуулах, бүртгэх, давтамжийн хүснэгт зохиох

6.10б. Өгөгдлийг диаграммаар дүрслэх

- Баганан диаграмм, пиктограмм байгуулах
- Өгсөн загвар дээр хялбар дугуй диаграмм байгуулах
- Шугаман график унших, тайлбарлах

6.10в. Дунджууд ба далайцыг олох, давтамжийн хүснэгт ашиглан арифметик дунджийг олох

6.10г. Хүснэгт, диаграмм, графикийг унших, тайлбарлах, дүгнэлт гаргах

6.10д. Баганан диаграммуудыг далайц, моод, медиан, арифметик дунджаар нь харьцуулах, дүгнэлт гаргах

6.11. МАГАДЛАЛ

6.11а. Боломжийг тоолох, нийлбэр, үржвэрийн зарчим хэрэглэх

6.11б. Тэнцүү боломжтой үр дүн бүхий үзэгдлийн магадлалыг олох, магадлалын хэмжээ 0-ээс 1-ийн хооронд байдгийг ойлгох

6.11в. Магадлалыг олж, тоон шулуун дээр тэмдэглэх, магадлалын хэл хэрэглэн тайлбарлах (гарцаагүй үзэгдэл, боломжгүй үзэгдэл, тэгш боломжтой үзэгдэл гэх мэт)

VII АНГИ

ТОО ТООЛОЛ

7.1. БҮХЭЛ ТООН ОЛОНЛОГ, ЗЭРЭГ, ЯЗГУУР

7.1а. Тооны модулийн талаар ойлголттой болох, бүхэл тооны 4 үйлдэл гүйцэтгэх

7.1б. Бүхэл тооны куб зэргийг олох, түүний урвуу үйлдлийг ойлгох, куб язгуур нь бүхэл тоо байх тоог олох, тэмдэглэх, хэрэглэх

7.1в. Тоог анхны тоон үржигдэхүүнд задлах аргаар ХИЕХ, ХБЕХ-ийг олох, асуудал шийдвэрлэх

7.2. ТООГ ЖИШИХ, ТОЙМЛОХ

7.2а. 10-ын натурал илтгэгчтэй зэргийг унших, бичих

7.2б. Хэмжээг ижил нэгжид шилжүүлэх замаар аравтын бутархайг жиших, эрэмбэлэх (урт, хүнд, багтаамж)

7.2в. Аравтын бутархайг тоймлох, асуудал шийдвэрлэх

7.3. ЭНГИЙН БА АРАВТЫН БУТАРХАЙ, ПРОЦЕНТ

7.3а. Энгийн бутархайн хүртвэр, хуваарийн ХИЕХ-ийг олж, хураах замаар бутархайг үл хураагдах бутархай болгох

7.3б. Энгийн бутархайнуудыг ижил хуваарьтай болгох эсвэл аравтын бутархайгаар илэрхийлэх замаар жиших, эрэмбэлэх

7.3в. Энгийн бутархайн нэмэх, хасах үйлдлийг гүйцэтгэх

7.3г. Энгийн бутархайн үржүүлэх, хуваах үйлдэл гүйцэтгэх, өгсөн тооны тодорхой хэсэгт ногдох тоог олох, тооны тодорхой хэсэгт ногдох тоогоор нь өгсөн тоог олох

7.3д. Аравтын бутархайн үйлдэл гүйцэтгэх

7.3е. Энгийн ба аравтын бутархай оролцсон илэрхийлэлд үйлдлийн дараалын дүрэм хэрэглэх, үйлдлийн дүнг урвуу үйлдлээр шалгах, хялбар аргаар тооцоолох

7.3ж. Энгийн ба аравтын бутархай, процентийг харилцан шилжүүлэх

7.3з. Тоо, хэмжээний өгсөн процентод ногдох тоог олох, нэг тоог нөгөө тооны хэсэг, процентоор илэрхийлэх, процентийн өсөлт, бууралт бүхий асуудал шийдвэрлэх

7.3и. Өгүүлбэртэй бодлого бодох (зөрүү, бүтэн ба бүхлийн хэсэг, процентоор тооцоолох гэх мэт)

7.4. ХАРЬЦАА, ПРОПОРЦ

7.4а. Тоо, хэмжээг өгсөн харьцаагаар хуваах, тоо, хэмжээг харьцуулах, жишихэд энгийн, аравтын бутархай, процентийн харилцан хамаарлыг хэрэглэх

7.4б. Харьцаа, пропорцыг хэрэглэх, ялгаатай нэгжээр илэрхийлэгдсэн харьцааг хялбар хэлбэрт бичих

7.4в. Шууд пропорционал хамаарлыг хэрэглэх, асуудал шийдвэрлэх

АЛГЕБР

7.5. АЛГЕБРЫН ИЛЭРХИЙЛЭЛ, ТЭГШИТГЭЛ

7.5а. Алгебрын илэрхийлэл зохиох, төсөөтэй гишүүдийг эмхэтгэх

7.5б. Натурал илтгэгчтэй зэргийн чанаруудыг мэдэх, хэрэглэх

7.5в. Нэг гишүүнт ба олон гишүүнтийг таних, нэг гишүүнтүүдийг үржүүлэх, хуваах

7.5г. Бүхэл тоон коэфициенттэй алгебрын илэрхийллийг хувиргах, хялбарчлах (Нэг гишүүнтээр олон гишүүнтийг үржүүлэх, нэг гишүүнтийг хаалтаас гаргах)

7.5д. Шугаман тэгшитгэл зохиох, бодох

7.6. ДАРААЛАЛ, ФУНКЦ

7.6а. Тоон болон дүрсэн дараалын зүй тогтол, ерөнхий гишүүний дүрмийг олох

7.6б. Арифметик прогрессийн n дүгээр гишүүний томьёог бичих, хэрэглэх

7.7в. Шууд пропорционал хамаарлын график байгуулах, координатын эхийг дайрсан шулууны тэгшитгэл бичих

7.6г. $y = mx + c$ хэлбэрийн шугаман функцийн утгын хүснэгт зохиож, координатын хавтгайд шулуун байгуулах

7.6д. Координатын тэнхлэгүүдтэй параллель шулуун байгуулах, шулууны тэгшитгэл бичих

ГЕОМЕТР

7.7. ӨНЦӨГ, ДҮРС, БАЙГУУЛАЛТ

7.7а. Параллел шулуунуудыг гурав дахь шулуунаар огтлоход үүсэх өнцгүүдийн чанарыг мэдэх, хэрэглэх

7.7б. Баталгааг ойлгох, хэрэглэх:

- Гурвалжны дотоод өнцгийн нийлбэр 180°, дөрвөн өнцөгтийн дотоод өнцгийн нийлбэр 360° байна
- Гурвалжны гадаад өнцөг нь өөртэйгөө хамар биш дотоод хоёр өнцгийн нийлбэртэй тэнцүү байна

7.7в. Дөрвөн өнцөгтүүдийг ижил болон ялгаатай шинжээр нь ангилах

7.7г. Гортиг, шугам ашиглан үндсэн байгуулалт хийх:

- Өгсөн хэрчимтэй тэнцүү хэрчим байгуулах
- Өгсөн өнцөгтэй тэнцүү өнцөг байгуулах
- Хэрчмийг таллан хуваах
- Хэрчмийн дундаж цэгийг дайруулан перпендикуляр шулуун байгуулах, өгсөн цэгээс шулуунд перпендикуляр татах
- Өнцгийн биссектрисс байгуулах
- Шулууны гадна орших цэгийг дайруулан параллел шулуун байгуулах

7.7д. Гортиг, шугам ашиглан гурвалжин байгуулах:

- Гурвалжныг түүний хоёр тал, хоорондох өнцөг (ТӨТ), нэг тал түүнд налсан хоёр өнцөг (ӨТӨ), гурван талаар нь байгуулах (ТТТ)
- Тэгш өнцөгт гурвалжин байгуулах

7.7е. Тэнцүү гурвалжныг таних, гурвалжны тэнцүүгийн шинжийг мэдэх, хэрэглэх

7.8. БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨН

7.8а. Тэгш өнцөгт координатын хавтгайд бүхэл тоон координаттай цэгүүдээр дүрс байгуулах, хэрчмийн дундаж цэгийн координатыг олох, хэрэглэх

7.8б. Дүрсийг өгсөн цэг дээр төвтэй цагийн зүүний дагуу болон эсрэг чиглэлд 90°, 180° -аар эргүүлэлтээр хувиргах, хувиргалтыг таних

7.8в. Эргэлтийн тэгш хэмтэй дүрсийг таних, зохиох, тэгш хэмийн эрэмбийг тогтоох

7.8г. Дүрсийн тэгш хэмт чанарыг (төвийн болон тэнхлэгийн тэгш хэмтэй, эргэлтийн тэгш хэмтэй дүрс, параллелограмм, тойрог гэх мэт) тогтоох

6.8д. Координатын хавтгайд өгсөн дүрсийг нэг төрлийн хувиргалтуудаар дараалуулан хувиргах (параллель зөөлт, эргүүлэлт)

7.9. ХЭМЖИГДЭХҮҮН

7.9а. Монголын уламжлалт хэмжих нэгжүүдийг мэдэх, хэрэглэх

7.9б. Талбай, эзлэхүүний нэгж шилжүүлэх, асуудал шийдвэрлэх

7.9в. Гурвалжин, параллелограмм, трапецийн талбайг олох томьёог гаргах, хэрэглэх, эдгээр дүрсийн периметрийг олох

7.9г. Тэгш өнцөгт параллелепипедийн дэлгээсийг зурах, гадаргуун талбайг олох, нийлмэл биетийн (тэгш өнцөгт параллелепипедээс тогтох) эзлэхүүн, гадаргуун талбайг олох

7.9д. Тэгш өнцөгт параллелепипедийн аль нэг хэмжээсийг тодорхой тоо дахин ихэсгэхэд (багасгахад) эзлэхүүн нь хэрхэн өөрчлөгдөхийг мэдэх, асуудал шийдвэрлэх

7.9е. π тооны ойролцоо утгыг олох, тойргийн урт, дугуйн талбайн томьёог гаргах, хэрэглэх

7.9ж. Призм, зөв 4 өнцөгт пирамид, тетраэдрын дэлгээсийг таних, зурах, дэлгээсээр нь эдгээр биетийг бүтээх, гадаргуун талбайг олох

МАГАДЛАЛ, СТАТИСТИК

7.10. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ

7.10а. Дискрет ба тасралтгүй өгөгдлийг таних, ялгааг мэдэх

7.10б. Өгөгдөл цуглуулах арга, хэмжигдэхүүний утгын нарийвчлалыг сонгох, түүврийн хэмжээг тогтоох

7.10в. Өгөгдлийг тэнцүү завсарт бүлэглэж, давтамжийн хүснэгт зохиох

7.10г. Өгөгдлийг график, диаграммаар дүрслэх

- Баганан диаграмм, пиктограмм байгуулах
- Дугуй диаграмм байгуулах
- Шугаман график тайлбарлах, байгуулах

7.10д. Дунджууд ба далайцыг тооцоолох, эдгээрийг хэзээ хэрэглэхээ мэдэх, бүлэглэсэн өгөгдлийн хувьд моод бүлгийг олох

7.10е. Дискрет ба тасралтгүй өгөгдлийн диаграмм, графикийг унших, тайлбарлах, дүгнэлт гаргах

7.10ж. Дугуй диаграммуудыг далайц, моод, медиан, арифметик дунджаар нь харьцуулах, дүгнэлт гаргах

7.11. МАГАДЛАЛ

7.11а. Үзэгдлийн илрэх магадлал нь p бол эсрэг үзэгдлийн магадлал нь (1–p) байдгийг ойлгох, хэрэглэх, нийлмэл үзэгдлийн бүх үр дүнг олох, тоочин бичих

7.11б. Харьцангуй давтамж ба магадлалыг үнэлэх, харьцуулах:

- Туршилтыг давтаж хийхэд өөр өөр үр дүнгүүд гардаг
- Туршилтын тоог ихэсгэхэд магадлалын үнэлгээ сайжирдаг гэдгийг ойлгох, хэрэглэх

VIII АНГИ

ТОО ТООЛОЛ

8.1. РАЦИОНАЛ ТООН ОЛОНЛОГ, ЗЭРЭГ, ЯЗГУУР

8.1а. Рационал тоог тоон шулуун дээр тэмдэглэх, жиших, төгсгөлгүй, үет аравтын бутархайг энгийн бутархайд шилжүүлэх

8.1б. Рационал тооны зэргүүдийг үржүүлэх, хуваахад натурал илтгэгчтэй зэргийн чанар хэрэглэх

8.1в. Рационал тооны нэмэх, хасах, үржүүлэх, хуваах, зэрэг дэвшүүлэх, язгуур гаргах үйлдлүүдийг гүйцэтгэн тоон илэрхийллийн утгыг олох

8.1г. Олонлог, түүн дээр үйлдэл (олонлогийн нэгдэл, огтлолцол, гүйцээлт) гүйцэтгэх, Эйлер- Веннийн диаграммаар загварчлах

8.2. ТООГ ТОЙМЛОХ

8.2а. $0.1=\frac{1}{10}=10^{(-1)}$ болохыг мэдэх, бүхэл тоо болон аравтын бутархайг 10-ын бүхэл илтгэгчтэй зэргээр үржүүлэх, хуваах

8.2б. Тоо, хэмжээг орны нэгжээр тоймлох болон тэмдэгтийн тоогоор тоймлох, асуудал шийдвэрлэх

8.2в. Тоо, хэмжээ болон бодлогын агуулгад тохирсон нарийвчлалыг сонгох, тооцооллын үр дүнг шалгах, тооны машин хэрэглэх

8.3. ПРОЦЕНТ, ХАРЬЦАА, ПРОПОРЦ

8.3а. Хүү, хямдрал, ашиг, алдагдал, татвар зэрэг хувь хүн, өрхийн санхүүгийн тооцоолол, процентийн өөрчлөлт оролцсон асуудал шийдвэрлэх

8.3б. Хольцын хялбар бодлогууд бодох

8.3в. Масштабыг ойлгох, тайлбарлах, газрын зураг ашиглан зай олох, асуудал шийдвэрлэх

8.3г. Урвуу пропорционал хамаарлыг таних, шууд ба урвуу пропорционал хамаарлын ялгааг ойлгох, хэрэглэх, асуудал шийдвэрлэх;

АЛГЕБР

8.4. АЛГЕБРЫН ИЛЭРХИЙЛЭЛ, ТЭГШИТГЭЛ, ТЭНЦЭТГЭЛ БИШ

8.4а. Нэг гишүүнтүүдийг үржүүлж, хуваахад зэргийн чанар хэрэглэх

8.4б. Нэг гишүүнтээр олон гишүүнтийг үржүүлэх, нэг гишүүнтийг хаалтнаас гаргах

8.4в. Олон гишүүнтийг олон гишүүнтээр үржүүлэх

8.4г. Олон гишүүнтийг үржигдэхүүн болгон задлах,(бүлэглэх, нийлбэр, ялгаврын квадрат, квадратуудын ялгаврын томьёог хэрэглэх)

8.4д. Алгебрын хялбар бутархайг нэмэх, хасах

8.4е. Шугаман тэгшитгэл рүү шилжих хялбар рационал тэгшитгэл зохиох, бодох, өгүүлбэртэй бодлогыг тэгшитгэл зохиох аргаар бодох, шийдийг олох

8.4ж. Томьёог хувиргаж, томьёоны аль нэг хувьсагчийг бусдаар нь илэрхийлэх

8.4з. Шугаман тэгшитгэлийн систем зохиох, бодох (нэмэх арга)

8.4и. Тэмдгүүдийг (<, >, ≤,≥, ∪,∩) ойлгох, хэрэглэх, нэг хувьсагчтай шугаман тэнцэтгэл биш зохиох, бодох, тоон шулуун дээр шийдийг дүрслэх

8.5. ДАРААЛАЛ, ФУНКЦ

8.5а. Арифметик прогрессийн n дүгээр гишүүнийг олох томьёоны гаргалгаа хийх, дараалсан гурван гишүүний чанарыг гаргах, хэрэглэх

8.5б. Ах + Ву = С хэлбэрийн шугаман тэгшитгэлийн график байгуулах, $y = mx + c$ хэлбэрт шилжүүлэх;

8.5в. Шугаман функцийн график өгсөн үед шулууны тэгшитгэл бичих, шулууны налалт (өнцгийн коэффициент) -ыг олох

8.5г. Шугаман функцийн график хэрэглэн тэгшитгэлийн системийн шийдийг ойролцоогоор олох, хэрэглэх (зам – хугацааны график)

8.5д. Урвуу пропорционал хамаарлын график байгуулах

8.5е. $y=ax^2$ функцийн графикийг таних, утгын хүснэгт ашиглан байгуулах

ГЕОМЕТР

8.6. ӨНЦӨГ, ДҮРС, БАЙГУУЛАЛТ

8.6а. Гүдгэр олон өнцөгтийн дотоод өнцгийн нийлбэрийг олох томьёо гаргах, гадаад өнцгийн нийлбэрийг олох, хэрэглэх

8.6б. Тойргийг тэнцүү хуваах аргаар зөв олон өнцөгт байгуулах

8.6в. Гортиг, шугам ашиглан байгуулалт хийж, гурвалжны дундаж шугам, медиан, биссектрисийн чанарыг тодорхойлох

- Гурвалжны дундаж шугам, медиан байгуулах
- Гурвалжны биссектрис байгуулах
- Гурвалжны өндөр байгуулах

8.6г. Пифагорын теоремыг мэдэх, тэгш өнцөгт гурвалжны бодлого бодоход хэрэглэх

8.6д. Гурвалжны төсөөгийн шинжийг мэдэх, хэрэглэх, төсөөтэй гурвалжнуудын өндөр, медиан, биссектриссийн харьцааг дадлага ажлаар олох

8.6е. Тойрог ба шулууны харилцан байршлыг тодорхойлох

8.6ж. Төв өнцөг, тойрогт багтсан өнцгийг таних, чанарыг мэдэх, хэрэглэх

8.6з. Параллел, огтлолцсон шулуунуудаар үүсэх өнцгийн чанар хэрэглэн асуудал шийдвэрлэх

8.7. БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨН, ХУВИРГАЛТ

8.7а. Дүрсийг өгсөн цэгт төвтэй натурал тоон коэффициенттэй гомотетээр хувиргах, хувиргалтыг таних

8.7б. Гомотетоор үүссэн дүр нь анхны дүрстэй төсөөтэй байдгийг мэдэх, төсөөтэй дүрсүүдийн харгалзах өнцгүүд тэнцүү, талууд нь пропорционал байдгийг хэрэглэх

8.7в. Дүрсийг тэгш хэм, паралель зөөлт, эргүүлэлтээр хувиргах, эдгээр хувиргалтаар дүрс тэнцүү дүрсэд буудаг бөгөөд өнцөг ба хэрчмийн урт хадгалагддаг гэсэн дүгнэлт гаргах

8.7г. Координатын хавтгайд өгсөн дүрсийг (тэнхлэгийн тэгш хэм, гомотет) нэг төрлийн хувиргалтаар дараалуулан хувиргах

8.7д. Хоёр цэгийн хоорондох зайг олох,тэгш хэм, эргүүлэлт, параллел зөөлт, гомотет оролцсон асуудал шийдвэрлэхэд координатын систем хэрэглэх

8.7е. Биетийн (призм, цилиндр, пирамид, конус, бөмбөрцөг) тэгш хэмт чанарыг тогтоох, тэгш хэмийн хавтгайг таних, зурах

8.7ж. Хойд зүгтэй үүсгэх өнцгийн талаар ойлголттой болох, зай, чиглэлийг ойлгох, тодорхойлоход хэрэглэх

8.8. ХЭМЖИГДЭХҮҮН

8.8а. Хэмжигдэхүүн оролцсон агуулгатай асуудал шийдвэрлэх (урт, хүнд, талбай, эзлэхүүний нэгж шилжүүлэх)

8.8б. Нийлмэл нэгжийг хэрэглэх, тогтмол хурд, дундаж хурд, тэдгээрийн ялгааг мэдэх, хурдны нэгж шилжүүлэх, зам-хугацааны графикийг унших, дүгнэлт гаргах, асуудал шийдвэрлэх

8.8в. Тойргийн урт, дугуйн талбайн томьёог хэрэглэн асуудал шийдвэрлэх, тооны машин хэрэглэх

8.8г. Призм, цилиндрийн гадаргуун талбайг дэлгээс ашиглан тооцоолох, эзлэхүүний хэмжээг олох

8.8д. Төсөөтэй дүрсүүдийн талбайн харьцааг олох, хэрэглэх

МАГАДЛАЛ, СТАТИСТИК

8.9. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ

8.9а. Өгөгдлийн анхдагч болон хоёрдогч эх үүсвэрийг тодорхойлох, өгөгдөл цуглуулах хүснэгтийг зохиомжлох

8.9б. Статистик арга хэрэглэн судалгаа хийхийн тулд түүврийн хэмжээг тогтоох, хэмжигдэхүүний нарийвчлал, өгөгдөл цуглуулах аргаа (ярилцлага хийх буюу санал асуулгын хуудас боловсруулах) сонгох

8.9в. Тохиромжтой тэнцүү завсруудыг сонгох замаар дискрет болон тасралтгүй өгөгдлийг цуглуулах, бүртгэх

8.9г. Өгөгдлийг график, диаграмм сонгон дүрслэх

- Дугуй диаграмм
- Гистограмм
- Хугацаанаас хамаарсан шугаман график
- Иш навчны диаграмм

8.9д. Бүлэглэсэн өгөгдлийн арифметик дунджийг олох

8.9е. Тухайн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай статистик үзүүлэлтүүдийг (дунджууд ба далайц, хамгийн их ба хамгийн бага утга) тооцоолох, тэднээс хамгийн оновчтойг нь сонгох

8.9ж. Хүснэгт, график, диаграммыг тайлбарлах, тохирох статистик үзүүлэлт хэрэглэн түүврүүдийг харьцуулах, дүгнэлт гаргах

8.10. МАГАДЛАЛ

8.10а. Нийцтэй ба нийцгүй үзэгдлүүдийг таних

8.10б. Үзэгдлийн магадлал нь тухайн үзэгдэлд харьяалагдах бүх эгэл үзэгдлийн магадлалын нийлбэртэй тэнцүү байдгийг мэдэх, хэрэглэх

8.10в. Нийцгүй үзэгдлүүдийн нэгдлийн магадлалыг олох, хэрэглэх

8.10г. Харьцангуй давтамж нь магадлалын үнэлгээ болохыг ойлгох, туршилтын үр дүнг харьцуулах

IX АНГИ

ТОО ТООЛОЛ

9.1. БОДИТ ТООН ОЛОНЛОГ, ЗЭРЭГ, ЯЗГУУР

9.1а. Иррационал тоог таних, тоон шулуун дээр тэмдэглэх, иррационал тооны ойролцоо утгыг өгсөн нарийвчлалтай олох

9.1б. Үржвэр, ногдвороос язгуур гаргах дүрмийг хэрэглэх, квадрат язгуур агуулсан илэрхийллийг хялбарчлах;

9.2. ТООНЫ СТАНДАРТ ДҮРС, ТООГ ЖИШИХ, ТОЙМЛОХ

9.2а. Тоог стандарт дүрсэд шилжүүлэх $A \times 10^n$ (энд n нь бүхэл тоо, $1 \leq A < 10$)

9.2б. Тоог тохиромжтой аргаар тоймлох, тооцооллыг үнэлэх, асуудал шийдвэрлэх

9.3. ПРОЦЕНТ, ХАРЬЦАА, ПРОПОРЦ

9.3а. Өсөлт ба бууралтыг процентоор илэрхийлэх, ашиг ба алдагдал, татвар, энгийн ба нийлмэл хүүг тооцоолох, асуудал шийдвэрлэх

9.3б. Процентын бодлогууд бодох, асуудал шийдвэрлэх

9.3в. Харьцаа, пропорц, урвуу пропорционал хамаарлыг хэрэглэн төрөл бүрийн асуудал шийдвэрлэх;

АЛГЕБР

9.4. АЛГЕБРЫН ИЛЭРХИЙЛЭЛ, ТЭГШИТГЭЛ, ТЭНЦЭТГЭЛ БИШ

9.4а. Хялбар олон гишүүнтийг үржигдэхүүн болгон задлах

9.4б. Алгебрын хялбар бутархайнуудыг (хүртвэр, хуваарь нь нэг гишүүнт байх) үржүүлэх, хуваах

9.4в. Хоёр хувьсагчтай шугаман тэгшитгэлийн систем зохиох, бодох (нэмэх, орлуулах арга)

9.4г. Нэг хувьсагчтай шугаман тэнцэтгэл биш зохиох, бодох, шугаман тэнцэтгэл бишийн систем бодох

9.4д. Квадрат тэгшитгэлийг үржигдэхүүн болгон задлах аргаар бодох

9.4е. Шугаман болон квадрат тэгшитгэл рүү шилжих хялбар рационал тэгшитгэл бодох, асуудал шийдвэрлэх

9.4ж. Хялбар илтгэгч тэгшитгэл бодох (ижил суурьтай болгох аргаар)

9.5. ДАРААЛАЛ, ФУНКЦ

9.5а. Дараалын ерөнхий гишүүний томьёо, рекуррент томьёо гаргах, хэрэглэх

9.5б. Шугаман функцийн урвуу функцийг олох, урвуу функцийн тэмдэглэгээг ойлгох, хэрэглэх, шулууны налалт (өнцгийн коэффициент) -ыг олох, хэрэглэх

9.5в. Шугаман тэгшитгэлийн системийн шийдийг график хэрэглэн олох

9.5г. Квадрат функцийн графикийг утгын хүснэгт ашиглан байгуулах, хэрэглэх (максимум, минимум утгыг олох, тэгшитгэлийн шийдийг график хэрэглэн олох)

ГЕОМЕТР

9.6. ӨНЦӨГ, ДҮРС, БАЙГУУЛАЛТ

9.6а. Гурвалжны биссектрисс, медианы чанаруудыг хэрэглэх

9.6б. Гортиг, шугам ашиглан байгуулалт хийх:

- Гурвалжныг багтаасан тойрог байгуулах
- Гурвалжинд багтсан тойрог байгуулах

9.6в. Тэгш өнцөгт гурвалжны өнцөг болон талыг олоход Пифагорын теорем, хурц өнцгийн тригонометр харьцаа бичих, хэрэглэх, асуудал шийдвэрлэх

9.6г. Тойргийн тэгш хэмт чанаруудыг тогтоох, хэрэглэх:

- Тэнцүү урттай хөвчүүд тойргийн төвөөс ижил зайд байдаг
- Хөвчийн дунджид татсан перпендикуляр нь тойргийн төвийг дайрдаг
- Тойргийн гадна орших цэгээс тойрогт татсан шүргэгчүүд тэнцүү байдаг

9.6д. Тойргийн хөвч, шүргэгч, огтлогчийн чанаруудыг мэдэх, хэрэглэх

9.6е. Тойрогт багтсан өнцгийн чанарыг хэрэглэх, тойргийн гадна оройтой өнцгийн чанарыг мэдэх, хэрэглэх

9.7. БАЙРШИЛ, ХӨДӨЛГӨӨН, ХУВИРГАЛТ

9.7а. Параллел зөөлт, тэнхлэгийн тэгш хэм, эргүүлэлт, гомотетийг таних, байгуулах, хувиргалтыг координатаар илэрхийлэх (Жишээ нь, (x, y)→(2x, 2y) нь координатын эх дээр төвтэй, k=2 коэффициенттэй гомотет)

9.7б. Тэгш хэм, эргүүлэлт, параллел зөөлт, гомотетийг бүрэн тодорхойлоход юу шаардлагатайг ойлгох, хэрэглэх

9.7в. Хоёр өөр төрлийн (параллел зөөлт, тэнхлэгийн тэгш хэм, эргүүлэлт, гомотет) хувиргалтаар дүрсийг дараалуулан хувиргах

9.7г. Координатын аргаар бодлого бодох

9.7д. Векторын талаар ойлголттой болох, тэмдэглэх, хавтгайд дүрслэх

9.7е. Координатын хавтгайд векторуудыг нэмэх, хасах, тоогоор үржүүлэх

9.7ж. Векторын уртыг томьёогоор олох, хэрэглэх

9.7з. Хойд зүгтэй үүсгэх өнцгийг хэмжих, тооцоолох, түүнийг асуудал шийдвэрлэхэд хэрэглэх

9.8. ХЭМЖИГДЭХҮҮН

9.8а. Хэмжигдэхүүн оролцсон төрөл бүрийн агуулгатай асуудал шийдвэрлэх

9.8б. Дэлхийн цагийн бүсийг хэрэглэн асуудал шийдвэрлэх

9.8в. Графикаар дүрслэгдэх ахуй амьдралын жишээ гаргах, (хурд-хугацааны графикийг унших, байгуулах, дүгнэлт гаргах, валют шилжүүлэх) асуудал шийдвэрлэх

9.8г. Тэгш өнцөгт, гурвалжин, параллелограмм, трапец, зөв 6, 8 өнцөгт, нийлмэл дүрсийн периметр, талбайг олох

9.8д. Тойргийн урт, дугуйн талбай, нийлмэл дүрсийн талбай олох, асуудал шийдвэрлэх

9.8е. Дугуйн секторын талбай, нумын уртыг хялбар аргаар тооцоолох, асуудал шийдвэрлэх

9.8ж. Цилиндр, призмийн, гадаргуун талбай, эзлэхүүнийг олох, асуудал шийдвэрлэх

9.8з. Конусын гадаргуун талбайг дэлгээсээр нь олох, томьёо хэрэглэх

9.8и. Цилиндр, зөв 4 өнцөгт пирамид, конусын тэнхлэг огтлол, тэгш өнцөгт параллелепипедийн диагонал огтлол байгуулах, огтлолын талбайг олох

9.8к. Төсөөтэй биетүүдийн гадаргуун талбай, эзлэхүүний харьцааг олох, хэрэглэх

МАГАДЛАЛ, СТАТИСТИК

9.9. ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ

9.9а. Статистик өгөгдөл цуглуулах

9.9б. Статистик диаграмм байгуулах (баганан диаграмм, дугуй диаграмм, гистограмм шугаман график)

9.9в. Хуримтлагдсан давтамжийн график унших, байгуулах

9.9г. Цэгэн диаграмм, түүний хандлагын шулууныг баримжаалан зурах, эерэг, сөрөг, тэг корреляцыг таних

9.9д. Өгөгдлийн далайц, дундаж, медиан, моодыг олох, хэрэглэх, тэдгээрийг хэрэглэгдэж байгаа зорилгоос хамааруулж ялгаж тооцоолох

9.9е. Статистик диаграммуудыг харьцуулах, диаграмм, график, хүснэгтэн мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргах

9.10. МАГАДЛАЛ

9.10а. Үл хамаарах үзэгдлүүдийн огтлолцлын магадлалыг олох, модны схем хэрэглэн нийлмэл үзэгдлийн магадлалыг олох

9.10б. Туршилтын үр дүн, харьцангуй давтамжийг хэрэглэн асуудал шийдвэрлэх

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Суурь боловсролын математикийн сургалтын хөтөлбөрийн агуулга нь сурагчдын эзэмших мэдлэг, чадвар буюу суралцахуйн зорилтуудаар тодорхойлогдсон бөгөөд өдөр тутмын амьдралд өргөн хэрэглэгддэг төрөл бүрийн тооцоолол хийх, тоо, хэмжээг жиших, тоймлох, дүрс, биет, хэмжигдэхүүнтэй ажиллах, өгөгдөл, мэдээлэл цуглуулах, хүснэгт, диаграмм, графикаар илэрхийлэх, боломж, зүй тогтол, магадлалыг тооцох гэх мэт математикийн суурь мэдлэг, чадварууд болон асуудал шийдвэрлэх арга барил эзэмшихэд сургалтын арга зүй чухал ач холбогдолтой. Дахин давтагдаж буй агуулгын хувьд анги дээшлэх тутам агуулгын өргөсөл, гүнзгийрэл дээр төвлөрөн судлах бөгөөд даалгавар болон шийдвэрлэх асуудлаар нь гүнзгийрүүлэн судлах стратегийг барьж ажиллах нь чухал.

Математикийн агуулгыг сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, асуудал шийдвэрлэх арга барилтай холбон хэрэгжүүлнэ. Математикийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багшлахуй, суралцахуйн дараах стратегийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Математикийн хичээлийг танин мэдэх, эргэцүүлэн бодох, асуудал шийдвэрлэх үйл ажиллагаан дээр тулгуурлан явуулах;
- Асуудал шийдвэрлэх үйл явцад сурагчдын юмс үзэгдлийг ойлгох, танин мэдэх, эрэгцүүлэн бодох, эрэл хайгуул хийх, эмх цэгцтэй, учир зүйтэй сэтгэн бодох, тайлбарлах, үндэслэх, дүгнэлт гаргах чадварыг хөгжүүлэх;
- Сурагчдын хүсэл, сонирхол, идэвх, оролцоог нэмэгдүүлэхийн тулд сургалтын идэвхтэй, бүтээлч аргуудыг хэрэглэх;
- Математикийг нийгэм, ахуй амьдралтай холбох, сурагчдын бүтээлч сэтгэлгээ, МХТ хэрэглэх чадварыг хөгжүүлэх;
- Сурагчдын ялгаатай байдлыг харгалзан сургалтын арга, хэлбэрээ сонгох;
- Явцын үнэлгээний тохиромжтой аргуудыг хэрэглэх;
- Хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгох, цахим хэрэглэгдэхүүн, интернэт, бусад эх сурвалжийг ашиглах;
- Сургалтын таатай орчин бүрдүүлэх, сурагчдад өөрийгөө илэрхийлэх боломж олгох;
- Сурагчдын бие даан ажиллах болон багаар ажиллах чадварыг хөгжүүлэх
- Тодорхой асуудлын хүрээнд мэдээлэл, статистикийн тоо, баримт цуглуулах, боловсруулах, график диаграммаар дүрслэх, дүгнэлт гаргах, бусдадаа танилцуулах гэх мэт мэдээлэлтэй ажиллах чадваруудыг хөгжүүлж, төсөлт ажил хэлбэрээр хичээл, сургалтыг зохион байгуулах боломжтой.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

Математик сургалтын үр дүнг сайжруулахад сургалтын орчин, нөхцөл, хэрэглэгдэхүүн чухал үүрэг гүйцэтгэнэ. Сургалтын орчин, нөхцөлийн хувьд хот, хөдөө, аймгийн төв, сумын төв, улсын болон хувийн хэвшлийн сургууль гэх мэт сургууль, орон нутгийн онцлогтой уялдан харилцан адилгүй боловч, боломж, нөхцөлөө ашиглан сургалтын таатай орчинг бүрдүүлэх нь сурагчдын ахиц, амжилтад эерэгээр нөлөөлнө. Хэрэглэгдэхүүний хувьд дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:

- Хэмжих, зурах, байгуулалт хийх багаж, хэрэгсэл, шугам, гортиг, транспортир, термометр, миллитрийн хэмжээстэй сав, аналог болон дижитал цаг, компас гэх мэт шаардлагатай багаж, хэрэгсэл ашиглах;
- Тооны машиныг шаардлагатай тохиолдолд хэрэглэх, их болон маш бага тоон дээр үйлдэл гүйцэтгэх, хариугаа шалгахад зарим үед тооны машин ашиглах нь үр дүнтэй байдаг, гэхдээ тухайн ангийн агуулгатай холбогдон ихэвчлэн VIII-IX ангид голчлон

хэрэглэнэ. Арифметикийн үйлдлүүдээс гадна зэрэг дэвшүүлэх, квадрат язгуурыг олох, тоо, хэмжээг өгсөн нарийвчлалаар тоймлох, процентийн өсөлт, бууралтыг олоход тооны машин өргөн хэрэглэгддэг.

- Зарим хичээл, сэдвээр сурагчийн ажлын хуудсыг интернет, бусад эх сурвалж хэрэглэн бэлтгэх;

Сурагчдын сонирхлыг татсан жишээ, баримт, математик сэтгэлгээг хөгжүүлэх төрөл бүрийн тоглоом, бодит байдлыг харуулсан видео бичлэг, цахим хэрэглэгдэхүүн хэрэглэх нь үр дүнтэй.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

А. Математикийн мэдлэг, ойлголт

Б. Хэрэглээ, асуудал шийдвэрлэх чадвар

В*. Хандлага

* Сурагчдын хандлагыг асуулга, ажиглалт, ярилцлага зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Математикийн мэдлэг, ойлголт	А1. Математикийн нэр, томьёо, ойлголт А2. Чанар, хууль, дүрэм А3. Зүй тогтол, харилцан хамаарлын ойлголт
Б. Хэрэглээ, асуудал шийдвэрлэх чадвар	Б1. Математикийн мэдлэг, ойлголтоо сэдэв, хичээлд хэрэглэх Б2. Математикийн мэдлэг, ойлголтоо ахуй амьдралд хэрэглэх Б3. Асуудлыг ойлгон томьёолох Б4. Асуудал шийдвэрлэх оновчтой аргыг сонгон, төлөвлөх Б5. Төлөвлөгөөг хэрэгжүүлж, математик арга, техникийг хэрэглэх Б6. Дүгнэлт гарган, үр дүнгээ үндэслэлтэй тайлбарлах
В. Хандлага	В1. Хичээлд оролцож буй байдал (Багаар болон бие даан ажиллах чадвар) В2. Юмс үзэгдлийг сонирхон судалж, бүтээлчээр хандаж буй байдал

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголт	40% - 50%
Б. Хэрэглээ, асуудал шийдвэрлэх	50% - 60%

Үнэлгээг хийхэд:

Юуны тулд үнэлэх вэ? (Хүүхдийн хөгжлийг дэмжих, ахицыг тодорхойлох)

Юуг үнэлэх вэ? (Мэдлэг ойлголт, хэрэглээ, асуудал шийдвэрлэх арга барил, хандлага)

Хэрхэн үнэлэх вэ? (үнэлгээний арга, хэлбэр, хэрэгслээ сонгох) гэдгээ тодорхойлох нь чухал.

Үнэлгээний даалгаврын төрөл нь сонгох, нөхөх, харгалзуулах, богино хариулттай, задгай хариулттай гэх мэт тестийн аргуудаас гадна эссэ бичих, график, диаграммаар илэрхийлэх, зураг, загвар зохиох гэх мэт олон төрөл байж болно. Мөн дадлага ажил, асуулт, хариулт, ярилцлага, хэлэлцүүлэг хийх аргаар болон онлайн хэлбэрээр үнэлж боломжтой. Хичээлийн явцад сурагчдыг асуудал шийдвэрлэх үйл ажиллагаанд чиглүүлэх, сурагчдын мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд сурагчийн ажлын хуудас нь чухал хэрэгсэл болно.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

“Мэдээллийн технологи”-ийн сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч:	Д.Цэдэвсүрэн, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Мэдээлэл зүйн тэнхимийн эрхлэгч проф, Ph.D

Багийн гишүүд

Л. Мөнхтуяа	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Мэдээлэл зүйн тэнхимийн багш, Ph.D
Б.Ариунтунгалаг	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
С. Уянга	Монгол Улсын Их Сургууль, Мэдээлэл, компьютерын ухааны тэнхимийн багш дэд проф, Ph.D
Н.Булгантамир	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
С. Энхцэцэг	Нийслэлийн 18 дугаар сургуулийн мэдээлэл зүйн багш
Б. Эрдэнэчимэг	Монгол-Энэтхэгийн сургуулийн мэдээлэл зүйн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Цэдэвсүрэн	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Мэдээлэл зүйн тэнхимийн эрхлэгч проф, Ph.D
Л. Мөнхтуяа	Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн албаны дарга, дэд проф, Ph.D
Э.Оюунбилэг	Нийслэлийн 73 дугаар сургуулийн мэдээллийн технологийн багш

Хянан тохиолдуулсан (2019)

Д.Цэдэвсүрэн	Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Мэдээлэл зүйн тэнхимийн эрхлэгч проф, Ph.D

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилт

Сурагч нь мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэхэд мэдээлэл, харилцаа холбооны технологийг бүтээлчээр ёс зүйтэй хэрэглэдэг, мэдээлэлжсэн нийгэмд соёлтой амьдарч, хамтран ажиллах суурь чадвартай иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Мэдээлэл, харилцаа холбооны технологиор мэдээлэл боловсруулах үндсэн зарчмыг ойлгож, мэдээллийн технологийн хэлд суралцах;

1.2.2. Мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглан сургалт, ахуй амьдралд тулгарсан асуудлыг шийдвэрлэх, өөрийгөө хөгжүүлэх болон бусадтай хамтран хөгжих хэрэгсэл болгон бүтээлчээр хэрэглэх;

1.2.3. Цахим орчинд бусадтай хүндэтгэлтэй хандаж, ёс зүйтэй, соёлтой харилцах.

Мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид VI-VII, VIII-IX ангид мэдээлэл, харилцаа холбооны технологийг хэрэглэн мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх арга барилд суралцаж, дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VI-VII анги	VIII-IX анги
МХХТ, мэдээллийг таньж тодорхойлох	- Мэдээллийг тодорхойлох, өөрийн үгээр тайлбарлах - Мэдээллийг шинж чанар, ач холбогдлоор нь ялган ангилах - Хэрэгцээндээ тохирсон мэдээллийг цуглуулах - МХХТ-ийн хэрэгслийг таньж мэдэх, ажиллагааны зарчмыг ойлгох	- Бусад хичээл, ахуй амьдралд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг боломжит эх сурвалжийг ашиглан сонгох - Мэдээллийн бодитой, хэрэгцээтэй, үр ашигтай байдалд дүн шинжилгээ хийх - Нийгэмд мэдээлэл, МХХТ-ийн гүйцэтгэх үүргийг ойлгох
Мэдээлэл боловсруулах ажлыг төлөвлөх, арга аргачлал гаргах	- Мэдээлэл боловсруулах хялбар аргуудыг тайлбарлах - Ахуй амьдрал, бусад хичээлийн мэдээллийг боловсруулах үйлдлийн дараалыг төлөвлөх - Мэдээллийн шинж чанар, онцлогоос хамааруулан түүний хялбар загварыг төлөвлөх	- Бусад хичээл, ахуй амьдралд тулгарсан асуудлыг шийдвэрлэх боломжит арга замуудыг сонгох - Боломжит арга замуудаас оновчтойг нь сонгон тайлбарлах - Мэдээлэл боловсруулж шийдвэрлэх алхам, үйлдлийн дараалыг оновчтой төлөвлөх
Технологи сонгон мэдээллээ боловсруулах	- Боловсруулах мэдээллийн онцлогоос хамааруулан технологийг сонгон боловсруулах - Мэдээллийн эх үүсвэрээс хичээлд болон ахуй амьдралд хэрэгцээт мэдээллийг олж цуглуулах, шинжлэх, ашиглах	- Бусад хичээл, ахуй амьдралд түгээмэл тохиолдох юмс үзэгдлийн нийтлэг шинж чанарт үндэслэн түүний загварыг байгуулах - Мэдээллийн шинж чанар, онцлогоос хамааран тохиромжтой арга зам, технологийг сонгон боловсруулах

Мэдээлэл, МХХТ-ийг хэрэглэх, үнэлэх, түгээх, хамтран эзэмших	- Мэдээллийг ашиглах, түгээх, хуваалцах, сайжруулан боловсруулахдаа МХХТ-ийг оновчтой хэрэглэх - МХХТ-ийн хэрэглээний болон хамтран эзэмших соёл, ёс зүйд суралцах	- Боловсруулсан мэдээллийг түгээх, хуваалцах, хамтран ашиглах - МХХТ-ийн хэрэглээний соёл, ёс зүйн хэм хэмжээг мөрдөх

ХОЁР. АГУУЛГА

VI АНГИ

МХХТ-ИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

6.1. МЭДЭЭЛЭЛ

6.1а. Мэдээ, мэдээллийн шинж чанарт үндэслэн мэдээллийг бичвэр, тоо, график хэлбэрээр дүрслэх

6.1б. Өгсөн объектын шинж чанарт үндэслэн объектын үзүүлэлтийг тодорхойлох

6.1в. Зорилгодоо нийцсэн мэдээллэн болон материаллаг загвар бүтээж, тайлбарлах

6.2. КОМПЬЮТЕР

6.2а. Компьютерын гар, хулгана, дэлгэц, системийн блок зэрэг үндсэн төхөөрөмжийн үүрэг, зориулалтыг тайлбарлах

6.2б. Компьютерийн хэрэглээ, эрүүл ахуйн энгийн дүрмийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх

6.2в. Тооны машин, дуу хөгжим, видео тоглуулагч зэрэг программын ашиглалтын үндсэн дээр график интерфэйсийн нийтлэг элемент болон компьютероор мэдээлэл боловсруулах ажлын үндсийг таньж тодорхойлох

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ

6.3. БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

6.3а. Бичвэр мэдээллийг бүрэлдүүлэгч хэсгүүдийг таньж, компьютерт догол мөр, том үсэг, сул зай, цэг, таслалаар ялган оруулах

6.3б. Баримт бичиг боловсруулах программ ашиглан гарын хурууны зөв байрлалаар бичих технологиор бичвэр мэдээллийг компьютерт оруулах

6.3в. Баримт бичигт тавигдах шаардлагад нийцүүлэн үсгийн хэлбэр, хэмжээ, өнгө, мөр зэрэгцүүлэх командаар бичвэрийг хэлбэржүүлэх, мөр зэрэгцүүлэх

6.4. ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

6.4а. Зургийн программын орчин, хэрэгслийг таньж мэдсэний үндсэн дээр тодорхой агуулгаар зургийн бүтээлийг зохиомжлон боловсруулах

6.5. ЦАХИМ ХАРИЛЦАА, ИНТЕРНЭТ ТЕХНОЛОГИ

6.5а. Интернэтийн орчинд ажиллах үндсэн хэм хэмжээ, нийтлэг үйлчилгээний талаар таньж тодорхойлсны үндсэн дээр хэрэгцээндээ нийцсэн мэдээллийг сонгон ашиглах

VII АНГИ

МХХТ-ИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

7.1. МЭДЭЭЛЭЛ

7.1а. Төрөл бүрийн мэдээллээс хэрэгцээт мэдээллийг хүлээн авах, боловсруулах, хадгалах үйл ажиллагааг жишээлэн харуулах

7.1б. Мэдээллийг кодчилох аргуудыг жишээгээр тайлбарлах

7.1в. Мэдээлэл хадгалах төхөөрөмжийн хэрэглээнд тулгуурлан мэдээллийг хэмжих нэгжийг таньж тодорхойлох

7.2. КОМПЬЮТЕР

7.2а. Мэдээллийг дүрслэх хэлбэрийг таньж мэдсэний үндсэн дээр мэдээллийн хоёртын дүрслэлийн жишээнд үндэслэн компьютер дэх мэдээллийн дүрслэлийг зураглах

7.2б. Файл, хавтастай ажиллах хэрэгцээндээ тулгуурлан файл удирдах системийг ашиглах

7.2в. Компьютерын санах ой, хатуу диск, хуруу диск, зөөврийн диск зэрэг мэдээлэл хадгалах өргөн хэрэглээний төхөөрөмжийн хэмжээ, хэрэглээний шинж чанарыг тодруулах

7.2г. Вирус, хөнөөлт программаас компьютерыг хамгаалах нийтлэг программыг зүй зохистой ашиглах

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ

7.3. БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

7.3а. Баримт бичиг боловсруулах программ ашиглан боловсруулж буй мэдээллийн онцлогт нийцэж байхаар хуудасны тохиргоо хийх

7.3б. Баримтын агуулга, зохиомжид нийцүүлэн зураг, бэлэн дүрс, хүснэгт оруулж боловсруулах

7.4. ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

7.4а. Зургийн программ (Paint.net)-ын ажлын хуудас, зургийн хэмжээ болон давхарга зэрэг нийтлэг командыг ашиглан сонгосон сэдвээр зураг зохиомжлон боловсруулах

7.5. ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭХ ТЕХНОЛОГИ

7.5а. Танилцуулга бэлтгэх программ ашиглан тавигдсан зорилго, өгөгдсөн сэдвийн хүрээнд зураг, диаграмм, бүдүүвч, хөдөлгөөн, хөдөлгөөний эффект, зураг, бичвэр төрлийн мэдээлэл бүхий танилцуулга боловсруулах

7.6. ЦАХИМ ХАРИЛЦАА, ИНТЕРНЭТ ТЕХНОЛОГИ

7.6а. Интернэт, үүрэн холбоонд суурилсан цахим харилцааны технологийн хэрэглээний ёс зүй, зарчим, дүрмийг өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх

7.6б. Хайлтын системийн хэрэглээний давуу талыг ойлгосны үндсэн дээр интернэтийн ахуйн болон сургалтын талаарх хэрэгцээт мэдээллийг ёс зүйтэйгээр ашиглах

VIII АНГИ

МХХТ-ИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

8.1. МЭДЭЭЛЭЛ, ЗАГВАР, ЗАГВАРЧЛАЛ

8.1а. Загвар байгуулах үе шатын дагуу мэдээллэн болон математик загварыг гол үзүүлэлтэд тулгуурлан байгуулах

8.2. КОМПЬЮТЕР

8.2а. Компьютерийн үндсэн болон нийтлэг төхөөрөмжийн гол үзүүлэлтэд үндэслэн хэрэгцээндээ нийцүүлэн сонгох

8.2б. Бичвэр, тоон, хүснэгтэн мэдээлэл болон танилцуулга боловсруулах зэрэг хэрэглээний программуудын хооронд мэдээлэл солилцох хэрэгцээнд тулгуурлан олон программын орчны талаар таньж мэдэх

8.2в. Компьютерын хэрэглээний нийтлэг асуудлыг зохицуулахад файл шахах задлах, үйлдлийн систем болон төхөөрөмжийн мэдээллийг харах зэрэг тохиромжтой программыг зүй зохистойгоор сонгон ашиглах

8.3. ҮЙЛДЛИЙН ДАРААЛАЛ

8.3а. Үйлдлийн дараллын шугаман болон салаалсан бүтцийг үгээр дүрслэх аргыг дүрс зурах, талбай олох, тооны тэгш эсвэл сондгойг тодорхойлох зэрэг хялбар жишээн дээр үзүүлж тайлбарлах

8.3б. Хялбар үйлдлийн дараллын үр дүнг оролтын тодорхой өгөгдөл дээр тооцоолж тайлбарлах

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ

8.4. БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

8.4а. Өгсөн мэдээллийн шинж чанар, онцлогт нийцүүлж бэлэн загвар ашиглан баримтыг үүсгэн боловсруулах

8.4б. Мэдээллийн агуулга, зохиомжид нийцүүлж бичгийн талбар, гоёмсог бичиг, бүдүүвч, график, толгой үсэг зэргийг баримтад ашиглах

8.5. ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

8.5а. Байгаль болон бусад сэдвийн хүрээнд зургийг зохиомжлон зурахдаа зургийн программын давхарга, өнгө тооцоологч, эффект оруулагч болон бусад хэрэгслийн боломжид тулгуурлан боловсруулж хадгалах

8.6. ТАНИЛЦУУЛГА БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

8.6а. Танилцуулга бэлтгэх программ ашиглан тавигдсан зорилго, өгөгдсөн сэдвийн хүрээнд мастер хуудас, холбоос, дуу, дүрсний эффект, аудио, видео болон бусад төрлийн мэдээлэл бүхий танилцуулга боловсруулах

8.7. ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

8.7а. Цахим хүснэгтийн ажлын хуудас, нүд, нүдний хаяг, муж, хүрээ шугам, өгөгдөл, түүний төрөл, хэлбэр зэргийг таньж мэдсэний үндсэн дээр тооцоолол бүхий хүснэгтэн мэдээлэл боловсруулах

8.7б. Тоон мэдээллийг хүснэгтээр загварчлан боловсруулахад томьёо, хялбар функцийг ашиглах

8.8. ЦАХИМ ХАРИЛЦАА, ИНТЕРНЭТ ТЕХНОЛОГИ

8.8а. Хичээл болон ахуй амьдралд шаардлагатай мэдээллийг МХХТ ашиглан хамтран ашиглах

8.8б. Өөрийн болон бусдын нийгмийн сүлжээний хэрэглээнд шүүмжлэлтэй хандаж, ёс зүйтэй, аюулгүй, соёлтой хэрэглээг хэрэгжүүлэх

IX АНГИ

МХХТ-ИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

9.1. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИ

9.1а. МХХТ-ийн нийгэмд үзүүлж буй үр нөлөөг ойлгосны үндсэн дээр түүний мэдээллийн нийгмийн онцлогийг зураглах

9.1б. Мэдээллийн нийгмийн ёс зүйн хэм хэмжээг даган мөрдөх

9.1в. Мэдээллэн загвар байгуулах үе шатад тулгуурлан физикийн хялбар загвар бүтээх

9.2. КОМПЬЮТЕР

9.2а. Компьютерын сүлжээний нийтлэг төхөөрөмжийн үүрэг зориулалт, сүлжээний зохион байгуулалт, ажиллагааны зарчим, хэрэглээг жишээгээр тайлбарлах

9.2б. Paint .NET, audacity, chrome зэрэг өргөн хэрэглэгддэг программаар жишээлэн чөлөөт нээлттэй эхийн программ хангамжийг зорилгодоо нийцүүлэн ашиглах

9.3. ҮЙЛДЛИЙН ДАРААЛАЛ

9.3а. Алгоритм нь оролтын мэдээлэлд боловсруулалт хийж, үр дүн гарган авах үйл ажиллагааг жишээлэн харуулах

9.3б. Үйлдлийн дараалын ижил үйлдлийг хэд хэдэн удаа давтан гүйцэтгэх үед давталт ашигладаг болохыг тоонуудын нийлбэр, үржвэр олох зэрэг жишээгээр тайлбарлах

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ

9.4. БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

9.4а. Хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баримтад автомат гарчиг, хөл, толгойн мэдээлэл, тусгай тэмдэгт, томьёо, эшлэл, зүүлт, тайлбар болон нүүр хуудас зэргийг оруулан боловсруулах

9.5. ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

9.5а. Зургийн дүрслэл, хэмжээ зэрэг шинж чанарыг таньж мэдсэнээр бэлэн зургийг чанарыг алдагдуулалгүйгээр засварлан боловсруулах

9.5б. Бэлэн зураг, дүрсийг ёс зүйтэйгээр ашиглан зургийн бүтээл зохиомжлон боловсруулах

9.6. ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

9.6а. Хүснэгтэн мэдээллийн загвар, боловсруулалтын онцлогт нийцүүлэн томьёо, функц ашиглах

9.6б. Хүснэгтийн нэг эсвэл хэд хэдэн талбараар эрэмбэлэх, шүүх, хайх зэргээр боловсруулах

9.6в. Хүснэгтийн хэд хэдэн өгөгдлийн хамаарлыг зохимжтойгоор илэрхийлсэн график, диаграмм боловсруулах

9.7. ЦАХИМ ХАРИЛЦАА, ИНТЕРНЭТ ТЕХНОЛОГИ

9.7а. Хайлтын системийн онцлог, хэрэглээний талаар таньж тодорхойлсоны үндсэн дээр түлхүүр үгийг оновчтой хэрэглэн хэрэгцээт мэдээллээ зохиогчийн эрхийг харгалзан шилж сонгох

9.7б. Үүрэн холбооны технологи болон цахим үйлчилгээний хэрэглээний талаар судалсны үндсэн дээр өнөөгийн нийгэм дэх МХХТ-ийн хэрэглээг эргэцүүлэх

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зарчим:

- МХХТ-ийн үндсэн ойлголт, ажиллагааны зарчим, түүний амьдрал, нийгэм дэх хэрэглээг ойлгон ухаарах, өргөн хэрэглээний технологийг мэдээллийн технологи болон бусад хичээл, ахуй амьдралын асуудлыг шийдвэрлэх практик жишээгээр баяжуулан зохион байгуулна.
- Мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд МХХТ-ийг хэрэглэн асуудал шийдвэрлэх арга барил эзэмших, хэл харилцаанд суралцах, хичээл хоорондын агуулга, арга зүйн уялдаа холбоог тооцох, хийсэн ажлынхаа үр дүнг танилцуулах үйл ажиллагаа нь хугацаа их шаардагдах тул долоо хоногт хоёр цагаар, хоёр улирал заахаар төлөвлөх боломжийг авч үзнэ.

- Сургалтыг зохион байгуулахдаа тодорхой зорилготойгоор, суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхүйц, үр дүнд хүрэхүйц үйл ажиллагааг төлөвлөх, түүнийг гүйцэд хэрэгжүүлэх, хийсэн зүйлээ эргэцүүлэн бодох, алдаа оноогоо хэлэлцэхэд чиглэсэн багийн болон бие даасан үйл ажиллагаагаар зохион байгуулна.
- Сурагчид сэтгэн бодох, асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах, харилцан ярилцах, нэг нэгнээсээ туршлага солилцох, хийсэн ажлаа тайлагнах, тайлбарлах, эдгээр үйл ажиллагаандаа МХХТ-ийг ашиглах нөхцөл боломжоор хангахад анхаарна.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

Суурь боловсролын мэдээллийн технологийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэгцээт суурь программ хангамж (үйлдлийн систем, оффисын багц программ, веб хөгжүүлэх, программ бичих, системийн үйлчилгээний гэх мэт)-тай, зохих үзүүлэлттэй (P4,Dual Core болон түүнээс дээш процессортой), хүрэлцээтэй тооны компьютер бүхий лаборатори шаардлагатай. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд программ хангамжийн орчин чухал бөгөөд сургалтад хэрэглэх программ хангамж нь хөтөлбөрт тавигдсан шаардлагыг хангаж байхаас гадна зохиогчийн эрхийн зөрчилгүй, албан ёсны лицензтэй байх шаардлагатай. Энэ үүднээс мэдээлэл зүйн багш нь сурагчийн нас сэтгэхүйн онцлог, хэрэглээний шаардлагын хангахуйц чөлөөт нээлттэй эхийн программ (Free and Open Source Software, FOSS) ашиглан хэрэгжүүлэх боломжийг бүтээлчээр эрэлхийлж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглах боломжийг харгалзан үзвэл зохино. Лабораторийн нэг компьютерт нэг сурагч ногдож байх нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг олгоно. Нэг компьютерийг хоёр болон түүнээс дээш тооны сурагч ногдож байгаа үед хөтөлбөрийн хэрэглээний чадвар эзэмшүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх учраас сургуулийн удирдлага болон мэдээллийн технологийн багш хамтран сургалтын орчин, хичээлийн зохион байгуулалт (бүлгээр хичээллэх, блокоор зохион байгуулах)-ын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Сургалтад ашиглах программ, технологи (бичиг баримт, үзүүлэн, зураг боловсруулах, дуу хөгжмийн программ, үгийн алдаа шалгагч, компьютерын үйлчилгээний программ гэх мэт)-ийг сонгохдоо зохиогчийн эрхийн зөрчилгүй, сургалт, ахуй амьдралын бодит хэрэглээтэй, хэрэглэхэд хялбар байдал, найдвартай ажиллагааг хангасан байна. Хичээлийг явуулахдаа онлайн номын сан, виртуаль музей, цахим хичээл зэрэг сурагчийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон агуулгыг ашиглах, орчин үеийн мэдээллийн технологийн дэвшилтэт шийдлийг ашиглаж, интернэтийн орчинд соёлтой, аюулгүй ажиллагааг хэвшил болгоход чиглүүлэн зохион байгуулна.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

А. МХХТ-ийн суурь мэдлэг, ойлголт

Б. Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх

В*. Хандлага

* Сурагчдын хандлагыг асуулга, ажиглалт, ярилцлага зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

ᠬᠣᠯᠪᠣᠭᠠᠯᠠᠬᠤ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠮᠡᠷᠭᠡᠵᠢᠯᠡᠬᠦ᠒᠐᠐᠐

БАЙГАЛИЙН УХААН

“Байгалийн ухаан”-ы сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч:	Г. Баярмаа Монгол Улсын Боловсролын их сургууль, Боловсрол судлалын тэнхимийн эрхлэгч, Ph.D

Хими

Н. Оюунцэцэг	Монгол Улсын их сургууль, ШУС-ийн дидактикийн багш
Д. Сарангэрэл	Монгол Улсын их сургууль, ШУС-ийн химийн тэнхимийн багш
Н. Наранцогт	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС-ийн химийн тэнхимийн багш
Д.Оюунбилэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, БУСА-ны дарга
Ц. Отгонбаяр	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Сарангэрэл	Монгол Улсын их сургууль, ШУС-ийн Химийн тэнхимийн профессор, Ph.D
Ч.Энхжаргал	Нийслэлийн 92-р сургуулийн химийн багш, магистр

Хянан тохиолдуулсан (2019)

Н.Оюунцэцэг	Боловсролын хүрээлэн, Боловсролын хөтөлбөрийн судалгааны секторын зөвлөх, Ph.D, дэд профессор

Биологи

А.Энхтогтох	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан, магистр
М.Оюунчимэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
М.Мөнхбаатар	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС-ийн биологийн тэнхимийн эрхлэгч, Ph.D
Ц.Хонгорзул	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС-ийн биологийн тэнхимийн багш, Ph.D
Ш.Оюунгэрэл	Монгол Улсын их сургууль, ШУС-ийн Биологийн тэнхимийн багш, Ph.D
Д.Мөнхтуяа	“Шинэ эрин” сургуулийн биологийн багш, магистр
О.Мөнхжаргал	“Монгол тэмүүлэл” сургуулийн биологийн багш, магистр
Э.Мөнгөнтулга	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС-ийн биологийн тэнхимийн багш, магистр

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

М.Оюунчимэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн сургалтын хөтөлбөр, үнэлгээ хариуцсан арга зүйч
Д.Мөнхтуяа	“Шинэ эрин” сургуулийн биологийн багш
О.Мөнхжаргал	“Орхон Хасү”сургуулийн биологийн багш

Хянан тохиолдуулсан (2019)

А.Энхтогтох	Боловсролын хүрээлэн, Боловсролын хөтөлбөрийн судалгааны секторын эрхлэгч

Физик

М. Ганбат	Монгол Улсын их сургууль, ШУС-ийн физикийн тэнхимийн багш
С. Гэндэнжамц	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан
Н. Сайнбаяр	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Х. Батболд	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС-ийн физикийн тэнхимийн багш
Ж. Дөлгөөн	Монгол Улсын их сургууль, ШУС-ийн физикийн тэнхимийн багш
Б. Бадам	“Шинэ эрин” сургуулийн физикийн багш
Н. Болормаа	Нийслэлийн 20 дугаар сургуулийн физикийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

М.Ганбат	Монгол Улсын Их сургууль, ШУС-ийн физикийн тэнхимийн багш, дэд профессор
С.Анхзаяа	МУБИС-ийн харьяа ерөнхий боловсролын сургууль, физикийн багш

Хянан тохиолдуулсан (2019)

О.Мөнхжин	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан, магистр

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь байгалийн ухааны суурь мэдлэг, байгалийн юмс, үзэгдлийг шинжлэн судлах арга барилаа хөгжүүлж, хүрээлэн буй орчиндоо ээлтэй, түүнийг хайрлан хамгаалахад хувь нэмрээ оруулдаг иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Байгалийн ухааны суурь мэдлэг ойлголт эзэмших;

1.2.2. Өдөр тутмын амьдралд тохиолдох түгээмэл үзэгдлийг тайлбарлахад байгалийн ухаан, математик болон орчин үеийн техник, технологийн мэдлэг чадвараа хэрэглэж, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварт суралцах;

1.2.3. Байгалийн юмс үзэгдлийн талаар таамаглал дэвшүүлэх, зорилготойгоор ажиглалт, туршилт хийх, үр дүнг нэгтгэх, боловсруулах, бусдад илэрхийлэх замаар шинжлэн судлах арга барилаа хөгжүүлэх;

1.2.4. Байгаль, нийгмийн харилцан хамаарлыг ойлгож, байгалийн ухаанд суралцах сонирхол, хүсэл эрмэлзэлтэй болох, байгаль орчноо хайрлан хамгаалах үүрэг, хариуцлагаа ухамсарлах, үйл ажиллагаанд бие даан болон хамтран оролцох хандлагатай болох.

Байгалийн ухааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид VI-VII, VIII-IX ангид шинжлэн судлах арга барилд суралцаж, дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VI-VII	VIII-IX
Шинжлэх ухааны санаа гаргах, асуудал, таамаглал дэвшүүлэх	- Өмнөх туршлага, ажиглалтад тулгуурлан асуулт асуух - Өмнөх мэдлэг ойлголт, ажиглалт, зарим баримт нотолгоонд тулгуурлан таамаглал дэвшүүлэх	- Асуулт баримт нотолгоог тайлбарлахад түүхэн болон орчин үеийн жишээ ашиглахын ач холбогдлыг эрэлхийлсэн асуулт асуух - Шинжлэх ухааны мэдлэг ойлголтод үндэслэн судлаачдын сорил, туршилт, судалгааны арга, түүний үр дүнгийн талаар таамаглал, шинэ санаа дэвшүүлэх
Сорил, туршилт, шинжлэн судлах ажлыг төлөвлөх	- Хянах, өөрчлөх, ажиглах хэмжигдэхүүнийг тодорхойлон сорил, туршилт, төлөвлөх - Шинэ санаа, таамаглалыг баримт нотолгоотой харьцуулж нягтлах, шалгах - Сорил туршилт, шинжлэн судлах ажлын хүрээнд чухал хэмжигдэхүүнийг ялган тогтоох, хувьсах хэмжигдэхүүнийг сонгох - Тохиромжтой багаж төхөөрөмжүүдийг зөв сонгох, эрүүл мэндэд аюулгүйгээр хэрэглэх	- Шаардлагатай нөхцөлд тохирсон түүвэр хийх аргыг хэрэглэх, аргаа тодорхойлох - Сорил туршилт, шинжлэн судлах ажил явуулах шийдэл гаргахдаа өмнө хийгдсэн ажлуудын санааг ашиглаж ажлын төлөвлөгөө гаргах - Сорил туршилт, шинжлэн судлах ажлын хүрээнд хувьсах, үл хувьсах хэмжигдэхүүний холбоо хамаарлыг тогтоох - Шаардлагатай үед дээж авах арга техникийг хэрэглэх, лаборатори болон ажлын байранд учирч болох аюул эрсдлийг хянах, аюулаас сэргийлэх
Баримт нотолгоо гаргах, илэрхийлэх	- Хэмжигдэхүүнийг ашиглан хэмжилт, ажиглалтыг нягт нямбай хийх - Үр дүнгээ бичвэр, зураг, хүснэгт, баганан ба дугуй диаграмм, шугаман графикаар илэрхийлэх - Анхдагч эх сурвалжаас мэдээллийг ашиглах, илэрхийлэх	- Алдааг багасгахын тулд ажиглалт, хэмжилтийг хангалттай давтан хийх, илүү найдвартай, нарийвчлалтай үр дүнг гаргах - Үр дүнгээ зураг, бичвэр, бүдүүвч, хүснэгт, баганан ба дугуй диаграмм, шугаман ба шугаман бус график, математик статистик аргаар илэрхийлэх - Баримт нотолгоог анхдагч болон хоёрдогч эх сурвалжаас хэрэглэх, илэрхийлэх

Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, тайлбарлах	- Сорил туршилтын үр дүнгээс дүгнэлт гаргахдаа шинжлэх ухааны суурь мэдлэг, ойлголт, үг хэллэгийг хэрэглэх, хялбар тооцоо хийх - Зураг, бичвэр, баганан диаграмм, бүдүүвч, хүснэгт, график хэлбэрээр өгөгдсөн судалгаанаас цуглуулсан өгөгдөл, мэдээллээс дүгнэлт гаргах - Сорил туршилт, шинжлэн судлах ажлын үр дүнд үндэслэн таамаглалдаа тайлбар хийх - Сорил, туршилтын үр дүнг шинжлэх ухааны мэдлэг ойлголтоо ашиглан бусдад тайлбарлах - Алдаатай үр дүнг тогтоож, туршилтыг сайжруулах санаа дэвшүүлэх	- Үр дүнд ажиглагдсан зүй тогтол, хамаарлыг шинжлэх ухааны мэдлэг, ойлголтоо ашиглан жишиж тайлбарлах, бусдынхтай харьцуулан үнэлэх - Зураг, бичвэр, бүдүүвч, хүснэгт, баганан ба дугуй диаграмм, шугаман графикийн зүй тогтлоос гажсан үр дүнг тогтоох, математик аргаар цуглуулсан өгөгдлөөс дүгнэлт гаргах - Мэдээллээс түүвэр хийж, хэрэглэсэн аргаа үнэлж, бусдад ойлгомжтойгоор тайлбарлах - Сорил, туршилтын үр дүнгийн тодорхой зүй тогтлыг хэлэлцэн, ялгаатай арга замуудыг үнэлэх, оновчтойг сонгох - Өгөгдлийн зүй тогтол, тооцооллоос гажсан үр дүнг тогтоож, туршилт судалгааг сайжруулах арга замыг хэлэлцэх

ХОЁР. АГУУЛГА

2.1. Шинжлэн судлах арга барил

VI АНГИ

Ш6.1. Шинжлэх ухааны санаа гаргах, асуудал, таамаглал дэвшүүлэх

а) Өмнөх туршлага, ажиглалтад тулгуурлан асуулт асуух, баримт нотолгоо, тайлбарын ач холбогдлын тухай ярих чадвартай байх

б) Юу болох талаар бодож, өмнөх мэдлэг ойлголт, зарим баримт нотолгоонд тулгуурлан таамаглах

в) Шинжлэн судалж болох бодит асуудлыг дэвшүүлэх

Ш6.2. Сорил, туршилт, шинжлэн судлах ажлыг төлөвлөх

а) Шалгаж болох шинэ санаа, таамаглал дэвшүүлж, түүнийг баримт нотолгоотой харьцуулж нягтлах

б) Хянах, өөрчлөх, ажиглах хэмжигдэхүүнийг тодорхойлон сорил, туршилт, судалгаа шинжилгээний ажлаа төлөвлөх

в) Өмнөх шинжлэх ухааны мэдлэг, ойлголтдоо үндэслэн таамаглалаа сайжруулах, хэрэгцээтэй мэдээллийн эх сурвалжуудыг сонгож, хэрхэн хэрэглэхээ шийдэх

г) Цуглуулах шаардлагатай баримт нотолгоог тогтоох, оновчтой арга, тохиромжтой багаж төхөөрөмжүүдийг зөв сонгох, зөв, бусдын эрүүл мэндэд аюулгүйгээр хэрэглэх

Ш6.3. Баримт нотолгоо гаргах, илэрхийлэх

а) Хэмжигдэхүүнийг ашиглан хэмжилт, ажиглалтыг нягт нямбай хийх

б) Үр дүнгээ бичвэр, зураг, хүснэгт, баганан диаграммаар илэрхийлэх

в) Анхдагч эх сурвалжаас мэдээллийг ашиглах, илэрхийлэх

Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, тайлбарлах

а) Сорил туршилт, шинжлэн судлах ажлын үр дүнд үндэслэн таамаглалдаа тайлбар хийх, дүгнэлт гаргах

б) Зураг, бичвэр, баганан диаграмм, бүдүүвч, хүснэгт зэрэг өгөгдлийн зүй тогтлоос, алдаатай үр дүнг ялган таних

в) Зураг, бичвэр, баганан диаграмм, бүдүүвч, хүснэгт хэлбэрээр өгөгдсөн болон судалгаанаас цуглуулсан өгөгдөл, мэдээллээс дүгнэлт гаргах

г) Гарсан дүгнэлтийг янз бүрийн аргаар илэрхийлэн үзүүлэх, бусдад тайлбарлах, цаашид сайжруулах талаар эргэцүүлэх

VII АНГИ

Ш7.1. Шинжлэх ухааны санаа гаргах, асуудал, таамаглал дэвшүүлэх

а) Баримт нотолгоо цуглуулах, шинжлэх ухааны тайлбарыг хөгжүүлэхэд бүтээлч сэтгэлгээг ашиглахын чухлыг хэлэлцэх

б) Зарим судлаачдын сорил, туршилт, судалгааны арга, түүний үр дүнгийн талаар хэлэлцэж таамаглал дэвшүүлэх

в) Сорих, турших, шалгах боломжтой шинэ санаа дэвшүүлэх, таамаглалаа баримт нотолгоотой харьцуулах

Ш7.2. Ажиглалт, туршилт, шинжлэн судлах ажлыг төлөвлөх

а) Өөрийн дэвшүүлсэн таамаглал болон тохирох шинэ санааг сонгон, нотолж болох хэлбэрт шилжүүлэх, цуглуулсан баримт нотолгоондоо үндэслэн таамаглалаа шалгах

б) Таамаглал, шинэ санааг шалгах туршилтыг төлөвлөх, ажиглах, өөрчлөх, хянах боломжтой хувьсагчийг харгалзан шинжлэн судлах аргыг сонгох, хүрээг тогтоох

в) Чухал хэмжигдэхүүнийг ялган тогтоох, өөрчлөх, хянах, ажиглах боломжтой хувьсах хэмжигдэхүүнийг сонгох

г) Шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмжийг тогтоох, өөрт болон бусдад учирч болох аливаа эрсдлийн талаар хэлэлцэх, түүнийг хянах

Ш7.3. Баримт нотолгоо гаргах, илэрхийлэх

а) Хэмжилт, ажиглалтыг нягт нямбай хийж, тохирох үр дүнг гаргах

б) Үр дүнгээ бичвэр, зураг, хүснэгт, баганан ба дугуй диаграмм, шугаман графикаар илэрхийлэх

в) Өөрсдөдөө болон бусдадаа учирч болох аюул эрсдлийг хэлэлцэх, хянах

Ш7.4. Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, тайлбарлах

а) Таамаглалыг үр дүнтэй холбон тайлбарлахад шинжлэх ухааны мэдлэг, ойлголт, үг хэллэгийг хэрэглэх, хялбар тооцоо хийх

б) Зураг, бичвэр, бүдүүвч, хүснэгт, баганан ба дугуй диаграмм, шугаман графикийн өгөгдлийн зүй тогтлоос алдаатай үр дүнг ялган таних, үр дүнгийн өөрчлөгдөх хандлага, зүй тогтлыг илрүүлэх

в) Зураг, бичвэр, бүдүүвч, хүснэгт, баганан ба дугуй диаграмм, график хэлбэрээр өгөгдсөн болон судалгаанаас цуглуулсан өгөгдөл, мэдээллээс дүгнэлт гаргах, таамаглалаа үр дүнтэйгээ харьцуулах

г) Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтыг ашиглан үр дүнг бусдад ойлгомжтойгоор, тохирох замыг ашиглан тайлбарлах

д) Гажсан үр дүнг тогтоож, судалгаа шинжилгээг сайжруулах санаа дэвшүүлэх, нэмэлт эх сурвалжийг ашиглан чанарын хувьд үр дүнгийн учир шалтгааныг буулган тайлбарлах

VIII АНГИ

Ш8.1. Шинжлэх ухааны санаа ба асуудал, таамаглал дэвшүүлэх

а) Шинжлэх ухааны мэдлэг ойлголтод үндэслэн таамаглал дэвшүүлэх, таамаглалаа турших шалгах, түүнийгээ баримт нотолгоог үнэлэх

б) Асуулт баримт нотолгоог тайлбарлахад түүхэн болон орчин үеийн жишээ ашиглахын ач холбогдлыг хэлэлцэх

в) Өнөөгийн болон өнгөрсөн үеийн судлаачдын туршилт хийдэг, баримт нотолгоо гаргадаг, бүтээлчээр сэтгэдэг арга барилыг хэлэлцэх

Ш8.2. Сорил, туршилт, шинжлэн судлах ажлыг төлөвлөх

а) Шинэ санаа санаа дэвшүүлэх, сонгох, өмнөх мэдлэг, ойлголт, судалгаандаа үндэслэн туршилтын төлөвлөгөө гаргах

б) Сорил туршилт, шинжлэн судлах ажил явуулах шийдэл гаргахдаа өмнө хийгдсэн ажлуудын санааг ашиглаж ажлын төлөвлөгөө гаргах

в) Сорил туршилт, шинжлэн судлах ажлын хүрээнд хувьсах, үл хувьсах хэмжигдэхүүнийг ялгах, хэмжилт хийх арга ба шаардлагатай багаж хэрэгслийг сонгох

г) Шаардлагатай үед дээж авах арга техникийг хэрэглэх, лаборатори болон ажлын байранд учирч болох аюул эрсдлийг хянах

Ш8.3. Баримт нотолгоо гаргах, илэрхийлэх

а) Алдааг багасгахын тулд ажиглалт, хэмжилтийг хангалттай давтан хийх, илүү найдвартай, бодитой үр дүнг гаргах

б) Боломжит материал, багаж төхөөрөмжийг хэрэглэх, эрсдлийг хянах

в) Үр дүнгээ зураг, бичвэр, хүснэгт, баганан ба дугуй диаграмм, шугаман графикаар илэрхийлэх, үр дүнгээ тайлагнах, хамгийн тохирох арга замыг сонгох

Ш8.4. Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, тайлбарлах

а) Үр дүнд ажиглагдсан зүй тогтол, хамаарлыг тодорхойлох, судалгааны арга, үр дүн, дүгнэлтийг шинжлэх ухааны мэдлэг, ойлголт ашиглан жишиж тайлбарлах

б) Хоёрдогч эх сурвалжийн үр дүнг шүүмжлэлтэйгээр судлах

в) Зураг, бичвэр, хүснэгт, баганан ба дугуй диаграмм, шугаман графикийн зүй тогтлоос гажсан үр дүнг тогтоох, хэрэглэсэн аргаа үнэлж судалгааг сайжруулах арга замыг санал болгох

г) Үр дүнгийн тодорхой зүй тогтлыг хэлэлцэн бусдад ойлгомжтойгоор харуулж, тайлбарлах

IX АНГИ

Ш9.1. Шинэ санаа гаргах, асуудал, таамаглал дэвшүүлэх

а) Шинжлэх ухааны мэдлэг, ойлголт, баримтад үндэслэн таамаглал дэвшүүлэх

б) Баримт нотолгоог анхдагч болон хоёрдогч эх сурвалжийн алинаас нь хэрэглэхээ шийдэх

в) Шинжлэх ухааны ололт нээлтийг ашиглах талаар дэлхий нийтээс суралцах, нэр томьёог зөв оновчтой хэрэглэх

Ш9.2. Сорил, туршилт, шинжлэн судлах ажлыг төлөвлөх

а) Таамаглал, тайлбараас баримт нотолгоог олох ажлаа төлөвлөх

б) Шаардлагатай нөхцөлд тохирсон түүвэр хийх аргыг хэрэглэх аргаа тодорхойлох

в) Шинжлэн судлах ажлыг төлөвлөх

г) Хувьсах ба үл хувьсах хэмжигдэхүүний холбоо хамаарлыг тогтоох, түүнийг илрүүлэхэд шаардлагатай арга, хэрэгслийг сонгох

д) Нийтлэг хэрэглэгддэг материал, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, лабораторид болон судалгаа шинжилгээний явцад тохиолдож болох эрсдэл, аюулаас сэргийлэх

Ш9.3. Баримт нотолгоо гаргах, илэрхийлэх

а) Хэмжилт ажиглалтаас тохирох нарийвчлалтай үр дүнг гаргах

б) Ажиглалт, хэмжилтийн үр дүнг зураг, бичвэр, бүдүүвч, хүснэгт, статистик диаграмм, математик аргаар илэрхийлэх, танилцуулах

Ш9.4. Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, тайлбарлах

а) Судалгаа шинжилгээний арга, үр дүн, дүгнэлтийг бусдынхтай харьцуулан, үнэлэж тайлбарлах

б) Зураг, бичвэр, бүдүүвч, хүснэгт зэрэг өгөгдлийн зүй тогтол, тооцооллоос гажсан үр дүнг тогтоож, шинжилгээ судалгааг сайжруулах арга замыг хэлэлцэх

в) Зураг, бичвэр, бүдүүвч, хүснэгт, статистик диаграмм, математик аргаар цуглуулсан өгөгдөл, мэдээллээс түүвэр хийж, мэдээллээс үр дүн, дүгнэлт гаргах

г) Үр дүн, дүгнэлтийг танилцуулах ялгаатай арга замуудыг үнэлэх, оновчтойг сонгох

2.2. Судлагдахуун тус бүрийн агуулга

ФИЗИК

VI АНГИ

Ф6.1. БИДНИЙ ЭРГЭН ТОЙРОН ДАХЬ ЭНЕРГИ

Ф6.1а. Биеийг хөдөлгөөд байгаа шалтгааныг таамаглах, үндэслэх

Ф6.1б. Бидний эргэн тойронд тохиолдож буй үзэгдэл дэх энергийн хэлбэр, хувирлыг жишээгээр харуулах

Ф6.1в. Цахилгаан хэрэгслийн жишээгээр энергийн хэлбэр болон хувирлыг ялган таних

Ф6.2. ХҮЧ БА ХАРИЛЦАН ҮЙЛЧЛЭЛ

Ф6.2а. Харилцан үйлчлэлийн үр дүнд биед ямар өөрчлөлт гарч байгааг харуулах, дүрслэх

Ф6.2б. Дэлхийд бие татагддаг болохыг тодорхойлох

Ф6.2в. Агаарын эсэргүүцэл ба үрэлтийг оролцуулан хөдөлгөөнд хүчний үзүүлэх нөлөөг дүрслэх

Ф6.3. ГЭРЭЛ

Ф6.3а. Гэрэл шулуун тархдаг гэдгийг ашиглаж сүүдэр үүсэх үзэгдлийг тайлбарлах

Ф6.3б. Хавтгай толинд гэрэл ойх зарчмыг дүрслэх, толин ойлтын хуулийг илэрхийлэх

Ф6.3в. Агаар шил ба агаар усны заагт гэрлийн тарах чиглэл өөрчлөгдөхийг туршилтаар жишээлэн тайлбарлах

Ф6.3г. Цагаан гэрэл олон өнгийн гэрлийн нийлбэр болохыг призм юм уу дифракцийн тор ашиглан задалж үзүүлэх

Ф6.3д. Үндсэн гурван өнгө (улаан, ногоон, хөх) ашиглаж завсрын өнгө гаргаж үзүүлэх, бие өнгөтэй байдаг учрыг тайлбарлах

Ф6.4. БИДНИЙ ЭРГЭН ТОЙРОН ДАХЬ ФИЗИК

Ф6.4а. Энерги хангамжийн асуудлаар өөрийн үзэл бодлыг илэрхийлж, хүрээлэн буй орчин дахь хүний нөлөө, түүний үр дагаварт үнэлгээ өгөх

VII АНГИ

Ф7.1. БИЕИЙН ЕРӨНХИЙ ШИНЖ ЧАНАР

Ф7.1а. Өгсөн биетийн уртыг шугам болон утас ашиглан хэмжих

Ф7.1б. Штангенциркуль, микрометр ашиглан өгсөн биетийн уртыг нарийвчлалтай хэмжих

Ф7.1в. Масс нь жин биш гэсэн ойлголтыг жинлүүр, дэнс ашиглан тодорхойлох

Ф7.1г. Үзэгдлийн үргэлжлэх хугацааны завсрыг хэмжих

Ф7.1д. Түрэгдсэн шингэний эзлэхүүнийг хэмжих туршилтыг гүйцэтгэх, тооцоолол хийх

Ф7.1е. Хатуу, шингэн биеийн нягтыг тодорхойлох, хялбар тооцоолол хийх

Ф7.1ж. Хий ба шингэнд бие хөвөх, живэх нөхцөлийг тодорхойлох

Ф7.1з. Температурыг биеийн халалтаар тодорхойлох, шингэний температурыг термометрээр хэмжих аргачлалыг тайлбарлах

Ф7.1и. Биеийн хөдөлгөөний хурдыг тодорхойлох

Ф7.2. СОРОНЗОН

Ф7.2а. Тогтмол соронзны туйлуудын зайнаас харилцан үйлчлэх үйлчлэлийг илэрхийлэх

Ф7.2б. Тогтмол соронзны орчим дахь төмрийн үртэсний төрхийг туршилтаар харуулах

Ф7.3. ДУУ

Ф7.3а. Биеийн чичирхийлэлээр дуу авиа үүсдэг болохыг харуулах

Ф7.3б. Осциллоскоп ашиглан дууны чанга сул ба далайц, өндөр нам ба давтамжийн холбоог тодорхойлох

Ф7.3в. Дууны долгион тарахад орчин хэрэгтэй гэдгийг тайлбарлах, хатуу, шингэн, хийд дуу тарах хурдны хэмжээг эрэмбэлэх

Ф7.3г. Дууны ойлтоор цуурай хэрхэн үүсэхийг дүрслэх

Ф7.4. БИДНИЙ ЭРГЭН ТОЙРОН ДАХЬ ФИЗИК

Ф7.4а. Дэлхий нарыг тойрох, сарны дэлхийг тойрох хөдөлгөөнийг дүрслэн тайлбарлах

Ф7.4б. Тэнгэрийн хойд зүгийн одны ордны хоногийн ба сарын эргэлтийг зураг дээр тайлбарлах

VIII АНГИ

Ф8.1. ХҮЧ БА ХАРИЛЦАН ҮЙЛЧЛЭЛ

Ф8.1а. Хатуу биеийн даралтыг тодорхойлох жишээ гаргах, хялбар тооцоолол хийх

Ф8.1б. Тохиромжтой жишээ ашиглан хүч ба талбайг даралттай холбон тайлбарлах (тооцоо хийхгүй)

Ф8.1в. Шингэнд даралт дамжих үзэгдлийг тайлбарлах (зөвхөн чанарын хувьд)

Ф8.1г. Шингэний гүний даралтыг гүн ба нягттай холбох, манометрийг хэрэглэх, хэрхэн ашиглах талаар илэрхийлэх

Ф8.1д. Хийн даралтыг тайлбарлах (зөвхөн чанарын хувьд), энгийн мөнгөн уст барометрийн ажиллах зарчимтай танилцаж, агаарын даралт хэмжихэд ашиглах

Ф8.1е. Хүч нь биеийн хэлбэр хэмжээг өөрчлөх шалтгаан нөхцөл болохыг тайлбарлах

Ф8.1ж. Хөшүүргийн дүрмийг ахуй амьдрал дахь жишээнд хэрэглэх

Ф8.1к. Хүчний момент эргүүлэх үйлчлэлийн хэмжүүр болохыг илэрхийлэх

Ф8.2. ШУГАМАН ХУРД, ХУРД, ХУРДАТГАЛ, ЭНЕРГИ, АЖИЛ, ЧАДАЛ

Ф8.2а. Шугаман хурд, шугаман хурдатгалыг тэргэнцэрийн хөдөлгөөнөөр тодорхойлох

Ф8.2б. Тогтмол хурдатгалтай шулуун хөдөлгөөнийг таних, шугаман хурдатгалыг тооцоолох

Ф8.2в. Биеийн хөдөлгөөн, байрлалын энергийн хувирлыг харуулах

Ф8.2г. Ажлыг хүч ба явсан замаас хамаарахыг тодорхойлох (тооцоо хийхгүй)

Ф8.2д. Ажил ба чадлын илэрхийллийг тохиромжтой жишээгээр тайлбарлах

Ф8.3. ЦАХИЛГААН, СОРОНЗОН

Ф8.3а. Цахилгаанжих, цахилгаан цэнэгийн харилцан үйлчлэлийг туршилтаар жишээлэн тайлбарлах

Ф8.3б. Энгийн цуваа, зэрэгцээ хэлхээ угсрах, амперметрээр гүйдлийн хүчийг хэмжих, гүйдлийн хуваарилалтыг тайлбарлах

Ф8.3в. Батарей, зай болон хэлхээний янз бүрийн элементүүдийг схемээр дүрслэх, цахилгаан гүйдлийг загварчлах, тайлбарлах

Ф8.3г. Амперметрээр гүйдлийн хүчийг, вольтметрээр хүчдэлийг (тоон мультиметр ашиглаж болно) хэмжих, хүчдэлийг загварчлах

Ф8.3д. Гүйдэлтэй дамжуулагчийн орчимд соронзон орон үүсдэг болохыг туршилтаар жишээлэн тайлбарлах

Ф8.4. ЭНЕРГИЙН ХЯМРАЛ БА ХҮНИЙ НӨЛӨӨ

Ф8.4а. Хүн төрөлхтөний тулгамдсан асуудлууд, дэлхийн энергийн хэрэглээний талаар үзэл бодлоо илэрхийлэх

Ф8.4б. Хүрээлэн буй орчин дахь хүний нөлөө, түүний үр дагаврыг тайлбарлах

Ф8.4в. Сэргээгдэх ба үл сэргээгдэх энергийн эх үүсвэрүүдийн мэдлэгийг ашиглах, бусад мэдээллийн эх сурвалжийг ашиглан дэлхийн энергийн хэрэгцээг тодорхойлох

Ф8.4г. Дулааны энерги зөөгдөх процесс /дамжуулал, конвекц, цацаргалт/-ыг ялгах, эдийн засагтай холбон тайлбарлах

IX АНГИ

Ф9.1. ДУЛААНЫ ФИЗИК

Ф9.1а. Хийн даралт, температурыг бөөмөн загвараар томьёолох

Ф9.1б. Хатуу, шингэн, хийн дулаан тэлэлтийг чанарын хувьд илэрхийлэх, тэлэлтийн хэмжээг харьцуулах, дулаан тэлэлтийн өдөр тутмын хэрэглээ, үр дагаврыг тодорхойлох

Ф9.1в. Хийн даралт тогтмол үед эзлэхүүн температураас хамаарах хамаарлыг чанарын хувьд илэрхийлэх, бөөмөн загвар ашиглан тайлбарлах

Ф9.1г. Температурын хуваарь хийхэд тогтвортой цэгүүдийн (ус буцлах, хөлдөх температур г.м) ач холбогдлыг ялган таних

Ф9.1д. Дотоод энергийг бөөмөн загварын үүднээс, дулаан багтаамжийг энергийн үүднээс тодорхойлох, тэдгээрийн хэрэглээг жишээлэн тайлбарлах

Ф9.1е. Хайлах, буцлах үзэгдлийн үед температурын өөрчлөлтгүйгээр энерги авдгийг илэрхийлэх

Ф9.1ж. Буцлах ба ууршиx үзэгдлийг ялгах, ууршихын дулааныг энергийн үүднээс тодорхойлж мэдлэгээ хэрэглэх

Ф9.1з. Бодисын дулаан дамжуулах ба тусгаарлах шинжийг үзүүлэх туршилтыг илэрхийлэх, дулаан дамжууллыг бөөмөн загварын үүднээс тайлбарлах

Ф9.1и. Конвекцыг үзүүлэх туршилт болон конвекцын үзэгдлийг бөөмөн загварын үүднээс тайлбарлах

Ф9.1к. Цацаргагч гадаргын өнгө өөрчлөгдөх үзэгдлийг тайлбарлах, цацаргагч болон шингээгчийн шинжийг илэрхийлэх

Ф9.2. ЦАХИЛГААН, СОРОНЗОН

Ф9.2а. Гүйдэлтэй ороомог хэрэглэж нөлөөгөөр соронзлогдохыг харуулах. Ферро ба ферро бус материалыг туршилтаар илрүүлэх

Ф9.2б. Шулуун соронзон ба гүйдэлтэй дамжуулагчийн үүсгэх соронзон орны шугамын төрхийг харуулах туршилтыг тайлбарлах, соронзон орныг шугамаар загварчлах

Ф9.2в. Гүйдэлтэй шулуун дамжуулагч утас ба соленоидын соронзон орны чиг, хэмжээг гүйдлийн чиглэл ба хэмжээнээс харгалзуулан дүрслэх

Ф9.2г. Цахилгаан соронзон ба тогтмол соронзны ялгааг тогтоох

Ф9.2д. Цахилгаанжих үзэгдлийг туршилтаар үзүүлж, атомын бүтэцтэй холбон тайлбарлах, хэрэглээг үндэслэх

Ф9.2е. Цахилгаан цэнэгийн орчимд цахилгаан орон оршин байгааг туршилтаар харуулах. Цахилгаан орныг хүчний шугамын тусламжтай дүрслэх

Ф9.3. ЦАХИЛГААН ХЭЛХЭЭ

Ф9.3а. Гүйдэл нь цэнэгийн урсгалын хурд гэсэн ойлголтыг харуулах, I=Q/t томьёог хэрэглэх, электронуудын урсах чиг ба гүйдлийн чигийн хоорондох ялгааг тогтоох

Ф9.3б. Үүсгэгчийн цахилгаан хөдөлгөгч хүч нь вольтоор хэмжигдэх үйлдвэрлэсэн цахилгаан энерги гэдгийг илэрхийлэх

Ф9.3в. Хэлхээний хэсэг дээр унах хүчдэлийг (потенциалын ялгавар) вольтметрээр хэмжих хэрэглэсэн цахилгаан энерги гэдгийг илэрхийлэх

Ф9.3г. Ерөнхий хүчдэл нь цуваа холболтын үед элемент бүр дээр унах хүчдэлүүдийн нийлбэртэй тэнцүү, зэрэгцээ холболтын үед салаа бүрийн хүчдэл ижил болохыг илэрхийлэх

Ф9.3д. Вольтметр, амперметр ашиглан резисторын эсэргүүцлийг тодорхойлох туршилтыг дүрслэх. Хэлхээний цахилгаан хөдөлгөгч хүч ба эсэргүүцлийг өөрчилж гүйдэлд хэрхэн нөлөөлөхийг чанарын хувьд илэрхийлэх

Ф9.3е. Дамжуулагч утасны эсэргүүцэл түүний уртаас шууд, хөндлөн огтлолын талбайгаас урвуу хамаардгийг тайлбарлах, ашиглах жишээ гаргах

Ф9.3ж. Цуваа холбогдсон резисторуудын ерөнхий эсэргүүцэл нь резистор тус бүрийн эсэргүүцлийн нийлбэртэй тэнцүү болохыг илэрхийлэх

Ф9.3з. Зэрэгцээ холбогдсон эсэргүүцлүүдийн ерөнхий эсэргүүцэл нь салаа тус бүрийн эсэргүүцлээс бага гэдгийг үндэслэх, потенциометр нь хэлхээнд хүчдэл хуваарилах үүрэгтэй болохыг үзүүлэх

Ф9.3и. Цахилгаан чадал нь нэгж хугацаанд хувирч байгаа цахилгаан энерги болохыг илэрхийлэх, цахилгаан хэрэгслүүдийн хэрэглэх цахилгаан энергийг үнэлэх

Ф9.3к. Тэжээл үүсгэгч, түлхүүр, эсэргүүцэл (тогтмол ба хувьсах), чийдэн, амперметр, вольтметр, ороомог, трансформатор, цахилгаан хонх, гал хамгаалагч, реле бүхий хэлхээний схем зурах, тайлбарлах

Ф9.3л. Цахилгааны аюулыг үндэслэх. Үүнд:

- Тусгаарлагч бүрээс гэмтэх - кабель утас шалбарсан байх
- Чийгтэй нөхцөл
- Хэлхээнд гал хамгаалагч, автомат таслуурыг ашиглах тухай

Ф9.4. ГЭРЭЛ

Ф9.4а. Гэрэл нэгэн төрлийн орчинд шулуун замаар, тодорхой хурдтай тархдагийг үндэслэн байгалийн үзэгдлүүдийг тайлбарлах

Ф9.4б. Тэгш хэмийн чанарыг ашиглан хавтгай толинд дүрс байгуулах

Ф9.4в. Гүдгэр, хүнхэр толинд дүрс байгуулах, шинж төрхийг тайлбарлах

Ф9.4г. Гэрлийн хугарлын хуулийг шалгах туршилтыг таниулах, дотоод бүрэн ойлтын үзэгдлийг үндэслэх

Ф9.4д. Үндсэн цацраг ашиглан нимгэн линзэд дүрс байгуулах, дүрсийн шинж төрхийг тайлбарлах

Ф9.4е. Нимгэн линзийн томьёог хэрэглэх, оптик хүч гэсэн ойлголтыг хэрэглэх жишээ гаргах

БИОЛОГИ

VI АНГИ

Б6.1. АМЬД БИЕИЙН ҮНДСЭН ШИНЖ, АНГИЛАЛ

Б6.1а. Амьд биеийн 7 үндсэн шинжид үндэслэн амьдралын үйл ажиллагааг тайлбарлах

Б6.1б. Амьд биеийн үндсэн шинжид үндэслэн орон нутгийнхаа ургамал, амьтдыг тодорхой шинжүүдээр нь ялгах

Б6.2. АМЬД БИЕИЙН БҮТЭЦ, АМЬДРАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Б6.2а. Амьд биеийн бүтцийн түвшин (бие махбод-эрхтэн тогтолцоо-эрхтэн-эд-эс)-г дүрслэн үзүүлэх

Б6.2б. Хүний биеийн тодорхой нэгэн үйл ажиллагааг хамтран гүйцэтгэдэг эрхтэнүүдийг эрхтэн тогтолцоонд хамааруулахын учрыг тайлбарлах

Б6.2в. Ургамлын эрхтэнүүдийг ургал ба үржлийн эрхтэн тогтолцоо гэж ялган нэрлэх болсон учир шалтгааныг батлах

Б6.2г. Гэрлийн микроскоп ашиглан ургамал, амьтны эсийн үндсэн бүтэц (бүрхүүл, бөөм, сийвэн)-ийг ялган таних

Б6.2д. Бичил биетэн амьд бие болохыг туршилтын үр дүнгээр нотлох

Б6.2е. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, өвчин үүсгэх зэрэгт бичил биетний гүйцэтгэх үүргийг баримт нотолгоогоор жишээлэн тайлбарлах

Б6.2ж. Бичил биетэн задлагч амьд бие болохыг учирлан тайлбарлаж, тэдгээрийн үүргийг бүдүүвчээр дүрслэх

Б6.3. АМЬД БИЕИЙН ҮРЖИЛ, ХӨГЖИЛ

Б6.3а. Шилжилтийн насны охид хөвгүүдийн бие махбод ба сэтгэл санаанд гарах өөрчлөлтийг ялган тодорхойлох

Б6.3б. Ургамлын үр соёолох, ургамал ургахад нөлөөлөх хүчин зүйлийг туршилтын үр дүнгээс нотлон тайлбарлах

Б6.4. АМЬД БИЕ ХООРОНДЫН БОЛОН ОРЧНЫ ХАРИЛЦАН ХОЛБОО

Б6.4а. Орон нутгийнхаа амьтдын гадаад бүтэц, амьдрах орчны ялгаатай байдлыг ажиглан, амьдрах орчиндоо дасан зохицсон болохыг жишээгээр тайлбарлах

Б6.4б. Биологийн системийн энергийн анхдагч эх үүсвэр болох нар болон бүтээгч, хэрэглэгч, задлагч амьд биеийг оролцуулсан идэш тэжээлийн хэлхээний 3-5 гишүүнтэй загвар бүтээх

VII АНГИ

Б7.1. АМЬД БИЕИЙН ҮНДСЭН ШИНЖ, АНГИЛАЛ

Б7.1а. Амьд биеийн үндсэн шинжийг Монгол орны болон орон нутгийнхаа амьд биеэр жишээлэн тайлбарлах

Б7.1б. Ангилал зүйн нэгжийг нэрлэх, амьд биеийн 5 аймаг ба тэдгээрийн зарим төлөөлөгчдийг онцлог шинж, гадаад бүтцэд нь үндэслэн ялган таних бүдүүвч зохиох

Б7.1в. Гэрлийн микроскоп ашиглан нэг эстний бүтцийг ажиглах, нэг эстэн, вирус ялгаатай амьд бие болохыг тайлбарлах

Б7.2. АМЬД БИЕИЙН БҮТЭЦ, АМЬДРАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Б7.2а. Ургамал, амьтны эсийн бүтцийн ялгааг (вакуоль, хлоропласт, эсийн бүрхүүл, хана) микроскопын бэлдмэл ашиглан харьцуулах

Б7.2б. Эсүүдийн хэлбэр нь түүний гүйцэтгэх үүрэгтэй зохилдсон болохыг зарим онцлог эсээр жишээлэн тайлбарлах

Б7.2в. Хүний хоол боловсруулах эрхтнүүдийн байрлал, гадаад бүтцийг ялган таних

Б7.2г. Хүн ба амьтны амьсгалын эрхтний ялгаа, хүний амьсгалын эрхтэн тогтолцооны эрхтэнүүдийн байрлал, гадаад бүтцийг ялган таних

Б7.2д. Хүний цусны эргэлтийн эрхтэн тогтолцоо, зүрх судасны байрлал, гадаад бүтцийг ялган таних

Б7.2е. Хүний зүрх цусыг шахдаг, судас нь цусыг дамжуулдаг болохыг зүрх, судасны цохилт тоолох туршилтаар тодорхойлох

Б7.2ж. Цусны эсийн зураг болон байнгын бэлдмэлийг микроскопоор харж, цусны эсүүдийн хэлбэр, онцлог, үүргийг ялган таних

Б7.2з. Навчны бүтэц, үүргийг ялган таньж, навчинд фотосинтез явагддаг болохыг туршилтаар илрүүлэх

Б7.3. АМЬД БИЕИЙН ҮРЖИЛ, ХӨГЖИЛ

Б7.3а. Биений юмны мөчлөг, хуанли хөтлөхийн учрыг тайлбарлах

Б7.3б. Бэлгийн бус үржлийг төмс, мөөг бактерийн үржлээр жишээлэн тайлбарлах

Б7.3в. Ургамлын үржлийн эрхтэн болох цэцгийн бүтцийн хэсгүүдийг өсгөгч шил ашиглан ялган таних

Б7.3г. Цэцгийн шадар эрхтний бүтцэд үндэслэн цэцгийн хэлбэрийг тодорхойлж, баг цэцгийг ялган таних

Б7.3д. Цэцгийн үндсэн эрхтэн болох дохиур, үр боловсрох орны бүтэц, онцлогийг ялган таних

Б7.4. АМЬД БИЕ ХООРОНДЫН БОЛОН ОРЧНЫ ХАРИЛЦАН ХОЛБОО

Б7.4а. Идэш тэжээлийн хэлхээ, сүлжээ гэсэн ухагдахуунуудыг ялган, тэдгээрийн хоорондын хамаарлыг тодорхойлох

Б7.4б. Идэш тэжээлийн хэлхээний зүй тогтол алдагдахад хүний үйл ажиллагаа нөлөөлхийг жишээгээр тайлбарлах

VIII АНГИ

Б8.1. АМЬД БИЕИЙН ҮНДСЭН ШИНЖ, АНГИЛАЛ

Б8.1а. Ангилал зүйн том нэгжийн нийтлэг шинжид үндэслэсэн түлхүүр бичгийг хэрэглэж, амьтны аймгийн зарим хүрээ, ангийг ялган таних

Б8.1б. Ангилал зүйн том нэгжийн нийтлэг шинжид үндэслэсэн түлхүүр бичгийг хэрэглэж, ургамлын аймгийн зарим хүрээ, ангийг ялган таних

Б8.2. АМЬД БИЕИЙН БҮТЭЦ, АМЬДРАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Б8.2а. Эсийн хромосом нь удамшлын мэдээлэл генийг хадгалан, митоз хуваагдлаар төл эсэд дамждаг болохыг тоймлон тайлбарлах

Б8.2б. Хоол боловсруулах эрхтнүүдийн үүргийг тодорхойлох

Б8.2в. Хоол тэжээлээр авсан шим бодисын задрах, нийлэгжих явцыг загварчлах

Б8.2г. Шим ба шим бус бодисуудын биологийн ач холбогдлыг зарим витамин, эрдэс бодисын дутагдлаар жишээлэн тайлбарлах

Б8.2д. Хүний амьсгал авах, гаргах үеийн хийн солилцоог загвар, туршилтаар илрүүлж тайлбарлах

Б8.2е. Зүрх, судасны дотоод бүтцийг туршилтын үр дүнд үндэслэн тайлбарлах

Б8.2ж. Артери, вен, хялгасан судас нь гүйцэтгэх үүрэгтэйгээ зохилдсон болохыг ялган таних

Б8.2з. Хүний цусны их, бага эргэлтийг загварчлан тайлбарлах

Б8.2и. Ногоон ургамалд фотосинтез явагдах процессийг туршилтаар баталж, үгэн тэгшитгэлээр илэрхийлэх

Б8.2к. Үндэсний бүтэц, үүргийг ялган таньж үндсээр ус, эрдэс бодис дамждаг болохыг туршилтаар илрүүлэх

Б8.2л. Ишний бүтэц, үүргийг ялган таньж, флоэм, ксилемээр бодис дамждаг болохыг туршилтаар илрүүлэх

Б8.3. АМЬД БИЕИЙН ҮРЖИЛ, ХӨГЖИЛ

Б8.3а. Бэлгийн бус ба бэлгийн үржлийн ялгааг тодорхойлох

Б8.3б. Хүний нөхөн үржихүйн тогтолцооны эрхтнүүдийг нэрлэж, үүргийг тайлбарлах, эр, эм бэлгийн эсийн бүтцийг харьцуулах

Б8.3в. Ургамлын тоос хүртэлтийг загварчилж, шавжаар болон салхиар тоос хүртдэг ургамлын ялгааг харьцуулан тодорхойлох

Б8.3г. Ургамалд үр, жимс үүсэх үйл явцыг цэцэгт ургамлын давхар үр тогтолтоор жишээлэн тайлбарлах

Б8.3д. Ургамлын үр, жимсний бүтцийг харьцуулан, үрийн тархалтын хэлбэрүүдийг тодорхойлох

Б8.3е. Ургамлын амьдралын эргэлтийг далд ба нүцгэн үрт ургамлаар жишээлэн тайлбарлах

Б8.3ж. Шинж тэмдгүүд эцэг эхээс үр төлд дамжин удамшдаг болохыг жишээгээр тайлбарлах

Б8.3з. Ашигтай шинж тэмдэг бүхий шинэ үүлдэр, сорт, омог гарган авахын ач холбогдлыг жишээгээр тайлбарлах

Б8.3и. Амьд бие орчиндоо дасан зохилдож, мэнд үлддэг болохыг Дарвины онол, жишээгээр нотлох

Б8.4. АМЬД БИЕ ХООРОНДЫН БОЛОН ОРЧНЫ ХАРИЛЦАН ХОЛБОО

Б8.4а. Идэш тэжээлийн хэлхээнд амьд биеийн эзлэх түвшинг тоон ба биомассын суврагаар илэрхийлж, учрыг тайлбарлах

Б8.4б. Идэш тэжээлийн гинжин хэлхээ 5-аас цөөн түвшинтэй байдгийг энергийн алдагдалд үндэслэн тайлбарлах

IX АНГИ

Б9.1. АМЬД БИЕИЙН ҮНДСЭН ШИНЖ, АНГИЛАЛ

Б9.1а. Ангилал зүйн бага нэгжийн онцлог шинжид үндэслэсэн түлхүүр бичгийг хэрэглэж, амьтны аймгийн зарим баг, овог, төрөл зүйлийг тодорхойлох

Б9.1б. Ангилал зүйн бага нэгжийн онцлог шинжид үндэслэсэн түлхүүр бичгийг хэрэглэж, ургамлын аймгийн зарим баг, овог, төрөл зүйлийг тодорхойлох

Б9.1в. Ангилал зүйн бага нэгж болох зүйлийг хос нэршлээр нэрлэх болсон түүх, учир шалтгааныг тайлбарлах

Б9.2. АМЬД БИЕИЙН БҮТЭЦ, АМЬДРАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Б9.2а. Эс түүний эрхтэнцрүүдийн хэмжээг мм-ээр илэрхийлэх, өсгөлтийг тооцох

Б9.2б. Мейоз хуваагдлын дүнд бэлгийн эсийн хромосомын тоо цөөрдөг болохыг бүдүүвчээр тайлбарлах

Б9.2в. Хүний хоол боловсруулах эрхтэн тус бүрийн бүтцийг гүйцэтгэх үүрэгтэй нь холбон тайлбарлах

Б9.2г. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах шим бодисыг туршилтаар илрүүлж, амьд биед гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг тодруулах

Б9.2д. Хоол боловсруулахад энзим биохурдасгуурын үүрэгтэй оролцдог болохыг шүлсний амилазагийн цардуул задлах туршилтаар жишээлэн тайлбарлах

Б9.2е. Дэлхийн хүн амын хүнс тэжээлийн хүрэлцээ хангамж, хомсдолыг ган гачиг, үер усны аюул, хүн амын тоо хэт ихсэх зэрэг асуудлуудтай холбон шүүн хэлэлцэх

Б9.2ж. Хүний амьсгалын ач холбогдолыг аэроб амьсгалаар жишээлэн тайлбарлаж, аэроб амьсгалыг үгэн тэгшитгэлээр илэрхийлэх

Б9.2з. Зүрхний бүтцийн хэсгүүд нь үйл ажиллагаатайгаа нарийн зохилдсоныг загварчлан шинжилж, цусны эргэлтийн хурдад дасгал хөдөлгөөн хэрхэн нөлөөлөхийг туршиж, нотлох

Б9.2и. Зүрхний титэм судас нарийсах өвчний шалтгааныг тодруулан ойлгож, түүнээс урьдчилан сэргийлэх боломжуудыг таамаглан хэлэлцэх

Б9.2к. Цусны зөөвөрлөх үүргийг нарийвчлан задлан шинжлэх

Б9.2л. Хоол боловсруулах, амьсгалах, цусны эргэлтийн эрхтэн тогтолцооны хамаарлыг бүдүүвчээр илэрхийлж тайлбарлах

Б9.2м. Мэдрэл- шингэний зохицуулгыг загварчлан тайлбарлах

Б9.2н. Арьсны бүтцийг харьцуулан, арьсны хялгасан судасны хана өргөсөх болон нарийсах замаар дулаан зохицуулагддаг болохыг таньж тодорхойлох

Б9.2о. Глюкагон ба инсулин нь цусанд агуулагдах глюкозын хэмжээг зохицуулахад оролцдог болохыг учирлан тайлбарлах

Б9.2ө. Фотосинтезийг урвалын тэгшитгэлээр илэрхийлэн бичиж, ургамалд шим бодис зөөвөрлөгдөхийг нотлох

Б9.2п. Фотосинтезийн эрчимд гэрлийн өөрчлөлт ба нүүрсхүчлийн хийн концентраци нөлөөлөхийг туршилтын үр дүнгээс илрүүлэх

Б9.2р. Навчийн бүтэц фотосинтез болон хийн солилцоо явуулахад зохицсон болохыг туршилтаар тодорхойлох

Б9.2с. Ургамлаас ус ууршиx болон ус дутагдах үзэгдлийн шалтгааныг харьцуулан тайлбарлаж, ууршилтын эрчимд чийг, температур, гэрлийн эрчим нөлөөлөхийг туршилтаар илрүүлэх

Б9.2т. Шим бодис флоэмээр зөөвөрлөгдөх, ургамлын эрхтнүүдэд хуримтлагдахыг туршилтын үр дүнд үндэслэн задлан шинжлэх

Б9.2у. Ургамал нь гэрэл ба хүндийн хүчний үйлчлэлд хариу үйлдэл үзүүлдэг болохыг хэлэлцэх, туршилтаар илрүүлэх

Б9.3. АМЬД БИЕИЙН ҮРЖИЛ, ХӨГЖИЛ

Б9.3а. Хүний эр, эм бэлгийн эсийн хөгжлийн үе шатыг харьцуулан тайлбарлах

Б9.3б. Хүний үр тогтолт болон хөврөлийн хөгжлийн үе шатыг зураг, бичлэгээс ажиглаж тайлбарлах

Б9.4. АМЬД БИЕ ХООРОНДЫН БОЛОН ОРЧНЫ ХАРИЛЦАН ХОЛБОО

Б9.4а. Экосистем, түүний үндсэн үйл ажиллагааг бүрэлдэхүүн хэсгүүдийн хооронд явагдах бодис, энергийн урсгалыг тайлбарлах

VI АНГИ

Х6.1. ХАТУУ, ШИНГЭН, ХИЙ

Х6.1а. Хатуу, шингэн, хийн төлөвт орших бодисын шинж чанарыг бодисын жижиг хэсгийн онолоор тайлбарлах

Х6.1б. Бодисын төлвийн өөрчлөлтийг бодисын жижиг хэсгийн онолоор тайлбарлах

Х.6.2. МАТЕРИАЛЫН ШИНЖ

Х6.2а. Өдөр тутмын материал, тэдгээрийн шинж чанарыг тодорхойлох

Х6.2б. Металл ба металл биш шинжтэй материалын ялгааг тогтоох

Х.6.3. ХҮЧИЛ БА СУУРЬ

Х6.3а. Индикатор ашиглан материалыг хүчиллэг, суурилаг шинжээр нь ангилах

Х6.3б. Саармагжих үзэгдэл, түүний зарим хэрэглээг бодит амьдралын жишээгээр тайлбарлах

Х.6.4. ХИМИ БА АМЬДРАЛ

Х6.4а. Хүчиллэг шинжтэй бодис, материалын байгаль, орчинд үзүүлэх нөлөөг тодорхойлох

Х6.4б. Усны бохирдол, түүний шалтгааныг тодорхойлох

VII АНГИ

Х.7.1. ХИМИЙН ЭЛЕМЕНТ, НЭГДЭЛ, ХОЛИМОГ

Х7.1а. Хатуу, шингэн, хий байдалтай бодисын шинж чанар, төлвийн өөрчлөлт, хийн даралт, диффузийн үзэгдлийг бодисын жижиг хэсгийн онолоор тайлбарлах

Х7.1б. Химийн элемент нэгэн төрлийн атом болон хэд хэдэн атомаас үүссэн молекулаас тогтдогийг тодорхойлох

Х7.1в. Үелэх хүснэгтийн эхний 20 элементийн химийн тэмдгийг чээжлэх

Х7.1г. Физикийн шинж чанарт үндэслэн химийн элемент, химийн нэгдэл, холимгийг ялгах

Х.7.2. МЕТАЛЛ, МЕТАЛЛ БИШ ЭЛЕМЕНТ

Х7.2а. Металл ба металл биш элементийн ялгааг тайлбарлах

Х7.2б. Оксид, гидроксид, хлорид, сульфат, карбонат зэрэг түгээмэл химийн нэгдлийг нэрлэх

Х.7.3. ХИМИЙН УРВАЛ

Х7.3а. Химийн урвалыг үгэн тэгшитгэлээр илэрхийлэх

Х7.3б. Химийн урвал явагдсаныг индикатор ашиглан илрүүлэх

Х7.3в. Практикийн ач холбогдолгүй химийн урвалыг тодорхойлох

Х.7.4. ХИМИ БА АМЬДРАЛ

Х7.4а. Хөрсний шинж чанарыг тодорхойлох

Х7.4б. Хүний үйл ажиллагаа хүрээлэн буй орчин (хөрсний бохирдол)-д хэрхэн нөлөөлдгийг тодорхойлох

VIII АНГИ

Х8.1. АТОМЫН БҮТЭЦ, ҮЕЛЭХ ТОГТОЛЦОО

Х8.1а. Резерфордын болон Борын загварт үндэслэн атомын бүтцийг тодорхойлох

Х8.1б. Үелэх хүснэгтийн эхний 20 элементийн атомын бүтцийг харьцуулах

Х8.1в. Үелэх хүснэгтийн үе, бүлгийн дагуух шинж чанарын өөрчлөлтийн хандлагыг тодорхойлох

Х8.2. ТУРШИЛТЫН ТЕХНИК, ХЭМЖИЛТ

Х8.2а. Хугацаа, температур, масс, эзэлхүүнийг хэмжих, бюретка, пипетка, хэмжээст цилиндр зэрэг багаж хэрэгслийг нэрлэх

Х8.3. ДАВС ГАРГАН АВАХ АРГА

Х8.3а. Металл ба металлын карбонатаас давс гарган авах урвалыг үгэн тэгшитгэлээр бичих

Х8.3б. Металл эсвэл металлын карбонатын хүчилтэй үйлчлэх урвалаар зарим энгийн давсыг гарган авах аргыг тайлбарлах

Х8.4. ХИМИЙН ЭНЕРГИ

Х8.4а. Эндотермийн урвал, экзотермийн урвалыг температурын өөрчлөлтөд үндэслэн тайлбарлах

Х8.5. УРВАЛД ОРОХ ИДЭВХ. УРВАЛЫН ХУРД

Х8.5а. Металлын хүчилтөрөгч, ус, сулруулсан хүчилтэй урвалд орох идэвхийг тодорхойлох

Х8.5б. Туршилтын үр дүнгээр металлын идэвхийн эгнээг бүтээх

Х8.5в. Идэвхийн эгнээнд үндэслэн халах урвалын жишээ гаргах

Х8.5г. Урвалын хурдад концентрац, бодисын хэмжээ, температур, катализаторын үзүүлэх нөлөөг мөргөлдөлтийн онолоор тайлбарлах

Х8.6. ХИМИ БА АМЬДРАЛ

Х8.6а. Эрдэмтдийн хийсэн туршилт, нээлтийг судлаачийн байр сууринаас нягтлах

Х8.6б. Ус, агаарын бохирдолд хүний үзүүлж буй нөлөөг тайлбарлах

Х8.6в. Ус, агаарын бохирдлоос сэргийлэх арга замыг тодорхойлох

IX АНГИ

Х9.1. БОДИСЫН ТӨЛӨВ, ДИФФУЗИ

Х9.1а. Бодисын төлвийг кинетик онолд тулгуурлан тодорхойлох, төлвийн шилжилтийг тайлбарлах

Х9.1б. Диффузи, түүнд нөлөөлөх хүчин зүйл (молекул масс, температур)-ийг тайлбарлах

Х9.2. ТУРШИЛТЫН ТЕХНИК

Х9.2а. Нэрэх (хэсэгчилсэн нэрлэгийг багтаан), талсжуулах, тохирох уусгагчийг ашиглан цэвэрлэх аргуудыг тодорхойлох

Х9.3. АТОМ

Х9.3а. Протон, электрон, нейтроны харьцангуй цэнэг, харьцангуй массыг томьёолох

Х9.3б. Протон (атомын)-ы тоо, нуклон (масс)-ын тоог тодорхойлох

Х9.3в. Протоны тоо, атомын бүтцийг ашиглан үелэх хүснэгтийн үндсийг тайлбарлах (протоны тоо нь 1-20 хүртэлх элементүүдийн хувьд)

Х9.3г. Цацраг идэвхт, цацраг идэвхт биш изотопуудыг тодорхойлох

Х9.3д. Цацраг идэвхт изотопын хэрэглээг анагаах ухаан, үйлдвэрлэл, энергийн үүсгүүрээр жишээлэн тайлбарлах

Х9.3е. Харьцангуй атом массыг томьёолох

Х9.3ж. Энергийн түвшнээр электроныг хуваарилах, инертийн хийн электронт бүтэц ба валентын электроны ач холбогдлыг ойлгох (s ба p орбитал дахь электроны тархалтын санаа болон d элементийн тухай орохгүй)

Х9.4. ҮЕЛЭХ ХҮСНЭГТ

Х9.4а. Элементийг ангилах, тэдгээрийн шинж чанарыг урьдчилан таамаглахад үелэх хүснэгтийг хэрхэн ашиглахыг тодорхойлох

Х9.4б. Үелэх хүснэгтийн үеийн дагуу элементийн шинж чанар нь металлаас металл биш болж өөрчлөгдөхийг тодорхойлох

Х9.4в. Зөөлөн металл болох I бүлгийн лити, натри, калийн хайлах, буцлах цэг, нягт, устай харилцан үйлчлэх урвалын өөрчлөгдөх зүй тогтлыг тайлбарлах

Х9.4г. VII бүлгийн хлор, бром, иодын өнгө, төлөв, бусад галидын ионтой харилцан үйлчлэх урвалын өөрчлөгдөх зүй тогтлыг тайлбарлах

Х9.4д. Инертийн хий урвалын идэвх муутай болохыг тодорхойлж, тэдгээрийн хэрэглээг тайлбарлах

Х9.4е. Шилжилтийн элементүүд нь нягт ихтэй, өндөр температурт хайлдаг, өнгөт нэгдэл үүсгэдэг бөгөөд элемент болон түүний нэгдлүүдийг нь катализатор болгон ашигладаг металл болохыг тодорхойлох

Х9.5. ХИМИЙН ХОЛБОО. БОДИСЫН БҮТЭЦ

Х9.5а. Химийн элемент, холимог бодис (хайлшийг багтаан), химийн нэгдлүүдийн болон металл, металл бишийн хоорондын ялгааг тодорхойлох

Х9.5б. Ион үүсэх зарчимд үндэслэн металл ба металл биш элементүүдийн хооронд ионы холбоо үүсэхийг тодорхойлох

Х9.5в. Инетрийн хийн электронт бүтэц үүсгэн электрон хосоо дундаа эзэмших H_2, Cl_2, H_2O, CH_4, HCl зэрэг молекулд дан ковалентын холбоо үүсэхийг тайлбарлах

Х9.5г. Ионт болон ковалентын холбоотой нэгдлүүдийн хоорондох дэгдэмхий чанар, уусах чанар, цахилгаан дамжуулах чанарын ялгааг тайлбарлах

Х9.5д. Элементийн химийн тэмдгийг ашиглах, түгээмэл нэгдлүүдийн байгууллын томьёог бичих

Х9.5е. Зарим органик молекулын жишээн дээр атомуудын харьцангуй тооноос түгээмэл нэгдлийн томьёог гаргах

Х9.5ж. Молекулын загвар болон зураглалаас түгээмэл нэгдлийн томьёог бичих

Х9.5з. Ионы цэнэгээс нь ионт нэгдлийн томьёог зохиох

Х9.5и. Бал чулуу, алмазын ковалент холбоо болон бүтцэд үндэслэн хэрэглээ (бал чулууг тосолгоонд, алмазыг шил зүсэхэд)-г тайлбарлах

Х9.5к. Алмаз ба цахиур (IV)-ын оксидын төсөөтэй шинж чанарыг тэдгээрийн бүтцэд үндэслэн тайлбарлах

Х9.5л. Металлын талст оронт тор (металлын ион, чөлөөт электрон)-ыг дүрсэлж, металлын холбоог тодорхойлох

Х9.5м. Өгсөн химийн урвалын тэгшитгэлийг бичих

Х9.6. ХИМИЙН ЭНЕРГИ

Х9.6а. Экзотерм, эндотермийн урвалыг тодорхойлох

Х9.6б. Түлш (нүүрс, спирт, устөрөгч зэрэг)-ний шаталтаар дулааны энерги үүсэхийг тайлбарлах

Х9.7. ХҮЧИЛ, СУУРЬ БА ДАВС

Х9.7а. Металл, суурь, карбонатын хүчилтэй харилцан үйлчлэх урвалын өвөрмөц шинж болон лакмусын цаасанд үзүүлэх нөлөөг тодорхойлох

Х9.7б. Саармаг, харьцангуй хүчиллэг, суурилаг чанарыг pH-ийн үндсэн дээр тайлбарлах (зөвхөн бүхэл тоогоор, универсал индикаторын цаас ашиглан)

Х9.7в. Оксидыг металл, металл бишийн төрхөөр нь хүчлийн болон суурийн оксид гэж ангилах

Х9.8. АГААР БА УС

Х9.8а. Үйлдвэр болон гэр ахуйн хэрэглээний усыг цэвэрлэх (шүүх, хлоржуулах) аргыг тайлбарлах

Х9.8б. Цэвэр агаар нь ойролцоогоор 79% азот, 20% хүчилтөрөгч ба инертийн хий, усны уур, нүүрсхүчлийн хийнээс тогтдогийг тайлбарлах

Х9.8в. Бохирдуулагчдын эх үүсвэрийг тайлбарлах:

- Нүүрстөрөгч агуулсан бодисын шаталтаар үүсэх нүүрстөрөгчийн монооксид
- Хүхрийн нэгдэл агуулсан шатамхай түлшний шаталтаас үүсэх хүхрийн диоксид (хүчиллэг бороо үүсгэдэг)
- Машины яндангаас гарах азотын оксидууд

Х9.8г. Машины яндангаас гарах азотын оксидууд, тэдгээрийг катализаторын оролцоотойгоор зайлуулах аргыг тайлбарлах

Х9.8д. Хүний эрүүл мэнд, барилга байгууламжид химийн бодисын үзүүлэх сөрөг нөлөөг тайлбарлах

Х9.8е. Нүүрсхүчлийн хий, метаныг хүлэмжийн хий гэж нэрлэдэг, хүлэмжийн хийн цаг агаарын өөрчлөлтөд үзүүлэх нөлөөг тайлбарлах

Х9.8ж. Нүүрсхүчлийн хийн эх үүсвэр [амьсгалах, химийн урвал (шатах, халах, задрах)], метаны эх үүсвэр (амьтны ялгадас, ургамлын задралаар үүсэх хий)-ийг тайлбарлах

Х9.9. ОРГАНИК ХИМИ 1

Х9.9а. Молекулдаа 4 хүртэл тооны нүүрстөрөгчийн атом агуулсан салбарлаагүй алкан, алкен (цис-, транс- изомер орохгүй), спирт, хүчлийн бүтцийг зурж, нэрлэх

Х9.9б. ан, -ен, -ол, -ы хүчил гэсэн төгсгөлтэй нэршил, молекулын бүтцээс нь нэгдлүүдийн төрлийг тодорхойлох

Х9.9в. Ижил функциональ бүлэгтэй нэгдлүүд болох гомологийн эгнээний дагуу шинж чанар өөрчлөгдөх зүй тогтлыг тайлбарлах

Х9.9г. Байгууллын изомерийг тодорхойлох

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Байгалийн ухааны хичээл хоорондын уялдаа холбоог ханган, сурагч аливаа асуудалд шинжлэх ухаанчаар ханддаг, эрэл хайгуул хийдэг, байгалийн юмс үзэгдлийг зорилготойгоор судалдаг болоход сургалтыг чиглүүлнэ. Суурь боловсролын байгалийн ухааны сургалтаар сурагчид мэдээлэлд боловсруулалт хийх, асуудал шийдвэрлэх, сорил туршилт хийх шинжлэн судлах арга барил эзэмшинэ.

Мэдээлэлтэй ажиллах арга барил

Сурагчид мэдээллийн анхдагч ба хоёрдогч эх үүсвэрээс авсан аман ба бичвэр мэдээлэл, шууд ба шууд бус мэдээлэлд боловсруулалт хийж, шинжлэх ухааны үнэн бодит мэдлэг, ойлголт болон цуу яриа аль нь болохыг ялган таних шаардлага тулгардаг. Иймээс байгалийн ухааны сургалтаар дараах үе шат бүхий үйл ажиллагааг төлөвлөж мэдээлэлтэй ажиллах арга барил эзэмшихэд анхаарна. Үүнд:

- Мэдээлэл цуглуулах аргаа сонгох (ажиглалт хийх, асуулт асуух, ярилцлага хийх)
- Мэдээлэл цуглуулах (төлөвлөлт хийх, ажлын хуудас бэлтгэх, тэмдэглэл хөтлөх, бичлэг хийх)
- Мэдээлэл боловсруулах (чанарын ба тоо анализ хийх, үр дүнг зураг, бичвэр, хүснэгт, диаграмм, графикаар илэрхийлж бусдад танилцуулах)
- Мэдээллийг хэрэглэх (эш татах, жишээ гаргах, мэдээллийг тайлбарлах)

Асуудал шийдвэрлэх сургалтын загвар

Асуудал шийдвэрлэх сургалт нь сурагчийн бие даасан бүтээлч үйл ажиллагаанд суурилна. Сурагчид дараах үе шат бүхий үйл ажиллагаагаар дамжуулан өөрт тулгарсан болон хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чадварт суралцана. Үүнд:

- Асуулт гаргаж, анхаарал татсан асуудлыг тодруулах
- Асуудал үүсэх учир шалтгааныг илрүүлэх
- Шийдвэр гаргаж хэрэгжүүлэх
- Асуудал дэвшүүлэх, үр дүнг үнэлэх

Шинжлэн судлах арга барил

Шинжлэх ухааны ухагдахууныг ойлгоход хамгийн үр дүнтэй, эргэн тойрон дахь юмс үзэгдлийг системтэй судлах арга юм. Сурагчид судлах зүйлийнхээ талаар асуулт асуух, таамаглал дэвшүүлэх, туршилтыг төлөвлөх, сорил туршилтыг гүйцэтгэх, юмс үзэгдлийн зүй тогтол, харилцан хамаарлын учир шалтгаан, сорил туршилтын үр дүнг илэрхийлэх, үнэлэх, үр дүнгээс дүгнэлт гаргах суралцахуйн цогц үйл ажиллагааг хэлнэ.

3.2. Сургалтын орчин

Байгалийн ухааны хичээлийг сурагчид бие даан болон хамтран олон талт ажиглалт, туршилт, судалгаа хийж болохуйц материаллаг, үйлийн болон сэтгэлзүйн шаардлагыг хангасан зориулалтын лабораторид хичээллэх орчин, нөхцлийг бүрдүүлж, сурагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд анхаарал хандуулна.

3.3. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээлийн хэрэглэгдэхүүн нь танин мэдэхүйн хэрэгцээ шаардлагыг хангасан, сурагчдад хүртээмжтэй, харагдахуйц, сонирхол сэдэл тэмүүллийг төрүүлэхүйц, энгийн ойлгомжтой, эрүүл ахуй, аюулгүйн шаардлагыг хангасан байна.

- Сорил туршилтын үед өөрийн болон бусдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны удирдамжийг хэрэглэнэ.
- Гарын доорх материал ашиглан бодитоор харах, хүртэх, судлах боломжийг бүрдүүлнэ.
- Багаж, тоног төхөөрөмжийг технологийн горимын дагуу хэрэглэх дүрэм, аюулгүй ажиллагааны зааварчилгааг баримтална.
- Орчин үеийн техник, технологийн дэвшлийг сургалтад нэвтрүүлэх оновчтой ажлын хуудас, хэвлэмэл болон бодит үзүүлэн, цахим хэрэглэгдэхүүнийг боловсруулж хэрэглэнэ.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

А. Мэдлэг, ойлголт
Б. Мэдээллийг хүлээн авах, асуудлыг шийдвэрлэх
В. Туршилт ба судалгааны арга
Г*. Хандлага
* Сурагчдын хандлагыг асуулга, ажиглалт, ярилцлага зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт (Сурагчид хөтөлбөрийн хүрээний ухагдахуун ойлголтын талаар мэддэг байна.)	Дараах мэдлэг, ойлголтыг үнэлнэ: А1. Шинжлэх ухааны үзэгдэл, баримт, хууль, тодорхойлолт, шинэ санаа ба онол А2. Шинжлэх ухааны үг хэллэг, нэр томьёо, тогтмол, нэгж, хэмжигдэхүүн болон олон улсын тогтсон томьёо, томьёолол А3. Шинжлэх ухааны багаж тоног төхөөрөмж, арга техник, аюулгүй ажиллагаа А4. Нийгэм, эдийн засгийн ба хүрээлэн буй орчны ойлголт бүхий шинжлэх ухаан, технологийн хэрэглээ
Б. Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадвар (Сурагч дараах зүйлсийг хийх чадвартай байх)	Сурагч дараах чадварыг тэмдэг, график, тоон өгөгдөл, тэмдэглээг ашиглан үгээр юмуу, бичгээр илэрхийлэн гүйцэтгэнэ: Б1. Төрөл бүрийн эх сурвалжаас өгөгдөл, мэдээллийг цуглуулж, бүртгэх, сонгох, цэгцлэх Б2. Мэдээллийг нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт хөрвүүлэх Б3. Дүгнэлт гаргахад өгөгдөл, мэдээллийг хэрэглэх Б4. Зүй тогтол, харилцан хамаарлын учир шалтгааныг тайлбарлах Б5. Үзэгдэл, загвар, үйл явцын холбоо хамаарлыг олж илрүүлэх Б6. Урьдчилан таамаг, таамаглал дэвшүүлэх зэргээр учир шалтгааныг тайлбарлах аргыг оновчтой сонгох Б7. Мэдлэг, мэдээллээ шинэ нөхцөлд хэрэглэн, асуудлыг шийдвэрлэх Б8. Үр дүнг үнэлэх, асуудалд байгалийн ухааны мэдлэг, онол, загварын хэрэглэгдэх хязгаарыг ялган таних
В. Туршилт ба судалгааны чадвар (Сурагчид нь дараах зүйлсийг хийх чадвартай байх)	Сурагч дараах чадвараа харуулна: В1. Техник, багаж төхөөрөмж, бусад материал (тохирох газарт нь заавар журмыг ашиглахыг оруулаад)-ыг аюулгүй сонгон, хэрэглэх В2. Туршилт, судлан шинжлэх ажлыг төлөвлөх В3. Ажиглалт, хэмжилт хийх, тэмдэглэх В4. Ажиглалт, туршилтын үр дүнг тооцоолох, тайлагнах, үр дүнг үнэлэх, дүгнэх В5. Туршилт, судалгааны аргыг үнэлэх, түүнийг сайжруулах боломж (техник, тоног төхөөрөмж, материалын сонголтыг багтаан)-ийг санал болгох
Г. Хандлага (сурагчдад дараах хандлага төлөвшсөн байх)	Сурагчдад дараах хандлага төлөвшсөн байна: Г1. Сонирхол Г2. Идэвхтэй оролцоо Г3. Бүтээлч байдал Г4. Нягт нямбай байдал Г5. Аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах

Үнэлгээний зорилтыг хэрэгжүүлэхдээ багш зөвхөн сурагчийг үнэлж, дүн тавихаар хязгаарлах бус сурагчдын сонирхол, хүсэл эрмэлзэлийг өдөөх, оролцоог нэмэгдүүлэх, илүү ихийг хийх, бүтээхэд чиглүүлэх нь чухал юм.

1. Мэдлэг, ойлголтыг үнэлэхэд сурагч мэдээллийг сэргээн санах, тайлбарлах түвшний даалгаврыг гүйцэтгэнэ. Мөн танил бус нөхцөлд мэдлэгээ хэрэглэх, эзэмшсэн мэдлэгээ шинэ сэдэвтэйгээ холбон ойлгох зэрэг үнэлэх асуултууд орж болно. Энэ үнэлгээний зорилтын даалгаврыг боловсруулахдаа гол төлөв тогтоох, тодорхойлох, дурдах, илэрхийлэх, дүрслэх, тайлбарлах (ойлгосноо) зэрэг үйл үгсийн аль нэгийг хэрэглэнэ.
2. Мэдээлэл боловсруулах чадвар гэдэгт мэдээллийг цуглуулах аргаа сонгох, мэдээллийг бүртгэн тэмдэглэх, нэгтгэн дүгнэх, задлан шинжилгээ хийх, мэдээллийг хэрэглэх зэргийг багтаан ойлгоно.

   Асуудал шийдвэрлэх чадвар гэдэгт асуудлыг тодруулах, асуудал үүсэх нөхцөл буюу тохироог илрүүлэх, асуудлыг шийдвэрлэх, өөрийн санаа бодлоо дэвшүүлэх зэргийг багтаан ойлгоно.

   Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварыг үнэлэхдээ ойлголт, ухагдахуун, зарчмыг шинэ нөхцөлд бүтээлчээр хэрэглэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх түвшний даалгавар боловсруулна. Энэхүү үнэлгээний зорилтын даалгаврыг боловсруулахдаа гол төлөв таамаглах, санал болгох, тооцоолох, тодорхойлох зэрэг үйл үгсийн аль нэгийг хэрэглэнэ.
3. Сорил туршилт хийх чадвар гэдэгт байгалийн юмс, үзэгдлийн мөн чанар, учир шалтгааны талаар таамаглал дэвшүүлэх, түүнийг батлахын тулд төлөвлөгөөтэйгээр ажиглалт, туршилт хийх, үр дүнг нэгтгэх, боловсруулах, бусдад илэрхийлэх цогц үйл ажиллагааг ойлгоно. Энэхүү үнэлгээний зорилтын даалгавар нь тухайн анги тус бүрийн агуулга, шинжлэн судлах арга барилд тохирох сорил туршилтын өгөгдөл бүхий үйлийн алхамтай байна.

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголт	50% (20%-аас ихгүй сэргээн санах түвшний даалгавар)
Б. Мэдээлэл хүлээн авах болон асуудал шийдвэрлэх чадвар	30%
В. Туршилт ба судалгааны чадвар	20%

ГАЗАР ЗҮЙ

“Газар зүй”-н сургалтын цөм хөтөлбөр (2015)

Е.Батчулуун	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС-ийн газар зүйн тэнхимийн профессор, Ph.D
Г.Уранчимэг	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС-ийн дидактикийн тэнхимийн багш
П.Энхжаргал	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС, газар зүйн тэнхимийн багш
Х.Цогбадрал	Монгол Улсын Боловсролын их сургууль, МБУС, газар зүйн тэнхимийн эрхлэгч
Г.Юмчмаа	Монгол Улсын их сургууль, ШУС-ийн газар зүйн тэнхимийн багш, Ph.D
Х.Билигсайхан	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Е.Батчулуун	МУБИС, МБУС-ийн Газар зүйн тэнхимийн багш, PhD., Профессор
Ц.Цэндсүрэн	МУИС, ШУС-ийн Газар зүйн тэнхимийн багш, магистр

Хянан тохиолдуулсан (2019)

Б.Алтансүх	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан, магистр

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь байгалийн нөхцөл ба нийгмийн үйл ажиллагааны хоорондох холбоо хамаарлыг орон зайн утгаар нь янз бүрийн нутаг дэвсгэр (орон нутаг, улс, тив, бүс нутаг, дэлхийн хэмжээнд г.м)-ийн хүрээнд ойлгож, байгаль, нийгмийн юмс, үзэгдлийг шинжлэн судлах арга барилаа хөгжүүлж, хүрээлэн буй орчиндоо ээлтэй, түүнийг хайрлан хамгаалахад хувь нэмрээ оруулдаг иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Газар зүйн үндсэн-суурь мэдлэг ойлголт эзэмших;

1.2.2. Өдөр тутмын амьдралд тохиолдох түгээмэл үзэгдлийг тайлбарлахад байгалийн ухаан, математик болон орчин үеийн техник, технологийн мэдлэг чадвараа хэрэглэж, мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварт суралцах;

1.2.3. Байгалийн нөхцөл ба нийгмийн үйл ажиллагааны холбоо хамаарлын талаар таамаглал дэвшүүлэх, зорилготойгоор ажиглалт, туршилт хийх, үр дүнг нэгтгэх. боловсруулах, бусдад илэрхийлэх замаар шинжлэн судлах арга барилаа хөгжүүлэх;

1.2.4. Байгаль, нийгмийн харилцан хамаарлыг ойлгож, газар зүйн боловсролд суралцах сонирхол, хүсэл эрмэлзэлтэй болох, байгаль орчноо хайрлан хамгаалах үүрэг, хариуцлагаа ухамсарлах, үйл ажиллагаанд бие даан болон хамтран оролцох хандлагатай болох.

Газар зүйн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид VII, VIII-IX ангид шинжлэн судлах арга барилд суралцаж, дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VII анги	VIII-IX анги
Асуудал, таамаглал дэвшүүлэх	- Өмнөх төсөөлөл болон ажиглалтад суурилан байгаль нийгмийн юмс, үзэгдэл, түүний өөрчлөлтийн талаар асуулт асуух, таамаглах - Тулгарч буй асуудлын талаар санал бодлоо илэрхийлэх	- Баримт нотолгоо, шинжлэх ухааны мэдлэгт суурилан байгаль нийгмийн юмс үзэгдлийн учир шалтгаан, зүй тогтлыг эрэлхийлсэн асуулт асуух, таамаглал дэвшүүлэх - Зайлшгүй шийдвэрлэх асуудлыг томьёолон хэрэгцээг тодорхойлох
Сорил, туршилт, шинжлэн судлах ажлыг төлөвлөх	- Асуудлаа шийдвэрлэх, таамаглалаа батлах ажлын дараалыг багштайгаа хамтран төлөвлөх - Ажиглалт, туршилтын үед өөрчлөгдөх хэмжигдэхүүнийг ялган таних - Хэрэглэх багаж хэрэгслийг нэрлэж сонгох - Аюулгүй ажиллагааны талаар эргэцүүлэн бодох	- Асуудлаа шийдэх, таамаглалаа шалгах ажлын төлөвлөгөө гаргах - Сорил туршилтын үед тогтмол болон хувьсах хэмжигдэхүүнийг сонгох - Ашиглах тохиромжтой багаж төхөөрөмжийг сонгож үндэслэлээ тайлбарлах - Туршилтын явцад тохиолдож болох эрсдлийг тооцох, үнэлэх
Баримт нотолгоо гаргах, илэрхийлэх	- Ажиглалт, туршилт, хэмжилтийг нягт нямбай хийх - Ажиглалт, тэмдэглэл, хэмжилтийн үр дүнг бичвэр, зураг, хүснэгт, баганан диаграмм, шугаман графикаар илэрхийлэх	- Ажиглалт, туршилт, хэмжилтийг зөв хийж хянах, шаардлагатай тохиолдолд давтан хийх - Ажиглалт, тэмдэглэл, хэмжилтийн үр дүнг бичвэр, зураг, хүснэгт, математик статистик диаграммаар илэрхийлэх

Баримт нотолгоо ба үр дүнг нягтлах, тайлбарлах	- Ажиглалт, туршилт, мэдээлэл боловсруулах явцыг таамаглалтай тохирч буй эсэхийг нягтлах - Өөрийн алдааг олж, түүнийг засах санаа дэвшүүлэх - Үр дүнгээс дүгнэлт гаргах - Ажиглалт, туршилтыг сайжруулах санаа дэвшүүлэх	- Ажиглалт, туршилт, мэдээлэл боловсруулах явцыг газарзүйн хэл ашиглан танилцуулж, таамаглалтай тохирч буй эсэхийг тодорхойлж үнэлэх - Өөрийн болон бусдын алдааг олж засах - Ажиглалт, туршилтыг сайжруулах шинэ санаа, хувилбарыг дэвшүүлэх

ХОЁР. АГУУЛГА

VII АНГИ

ГЗ7.1. ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

ГЗ7.1а. Глобус ба газар зүйн зургийн ялгааг дүрслэлийн бусад төрлүүдтэй харьцуулан тодорхойлох

ГЗ7.1б. Газар зүйн төрөл бүрийн зураг унших замаар таних тэмдэг ба масштабын ялгааг тодорхойлох

ГЗ7.1в. Газар зүйн солбицол ашиглан тухайн газар (цэг)-ын байрлалыг тодорхойлох

ГЗ7.1г. Хотын план ба сансрын зураг дээр зүг чиг олж, байрлал тодорхойлох

ГЗ7.1д. Таних тэмдэг ба масштаб ашиглан тодорхой талбайн тойм зураглал үйлдэх

ГЗ7.2. ДЭЛХИЙ БИДНИЙ ОРОН ГЭР

ГЗ7.2а. Нарны аймгийн бүдүүвч дээр гарагуудын байрлал ба хэмжээг харьцуулах

ГЗ7.2б. Цагийн ялгаа хэрхэн үүсэхийг туршилтаар тайлбарлах

ГЗ7.3. ХҮН АМ БА СУУРЬШИЛ

ГЗ7.3а. Таних тэмдэг ашиглан газар зүйн зураг дээр дэлхийн томоохон хотуудын байрлалын онцлогийг тодорхойлох

ГЗ7.3б. Дэлхийн янз бүрийн орны хүмүүсийн төрх байдал, эрхлэх аж ахуйн ялгаатай байдалд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох

ГЗ7.3в. Тив тивийн хүмүүсийн ялгаа ба амьдралын төрх байдлыг төрөл бүрийн эх сурвалж ашиглан харьцуулах

ГЗ7.4. БАЙГАЛЬ НИЙГМИЙН ОРЧИН

ГЗ7.4а. Физик газар зүйн зураг ашиглан дэлхийн гадаргын ялгаатай байдал ба хэлбэрийг харьцуулах

ГЗ7.4б. Гадаргын хэлбэр бүрэлдэн тогтоход нөлөөлөх хүчин зүйлсийн ялгааг туршилтаар үзүүлж шалтгааныг тайлбарлах

ГЗ7.4в. Цаг агаарын ажиглалт, хэмжилт хийж урьдчилсан мэдээ цуглуулан харьцуулах

ГЗ7.4г. Уур амьсгалын зураг, диаграмм, бусад мэдээлэл ашиглан газар нутгуудын уур амьсгалын ялгааг харьцуулах

ГЗ7.4д. Газар зүйн зураг ашиглан тухайн газар орны уур амьсгалын ерөнхий төрх байдлыг тодорхойлох

ГЗ7.4е. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулахад хувь нэмэр оруулах жишээ гаргах

ГЗ7.4ж. Усны эргэлтийн бүрэлдэхүүн хэсгүүд тэдгээрийн зохистой харьцааг жишээгээр тайлбарлах

ГЗ7.4з. Дэлхийн далай, түүний хэсгүүдийг ялгах

ГЗ7.4и. Далайн ус ба цэнгэг усны шинж чанарыг харьцуулан дүгнэлт хийх

Г37.4к. Далайн урсгал ба шинж чанар байгаль, нийгэмд хэрхэн нөлөөлдгийг тайлбарлах

Г37.4л. Гол мөрөн, нуур, мөстлөг зэрэг усны бусад төрлүүдийн тархалт ба хүмүүсийн амьдралд нөлөөлж буйг жишээгээр тайлбарлах

Г37.5. БАЙГАЛЬ НИЙМГИЙН ХАМААРАЛ БҮС НУТАГ

Г37.5а. Хөрс, ургамал, амьтан бүсээр ялгаран тархахад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох

Г37.5б. Байгалийн бүс, бүслүүрийг ялган тодорхойлох

VIII АНГИ

Г38.1. ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

Г38.1а. Монгол орны газар зүйн зургийн тусгагийн онцлогийг тайлбарлах

Г38.1б. Газар зүйн зургийг масштабаар нь ялган, онцлогийг тодорхойлох

Г38.1в. Газар орны үнэмлэхүй ба харьцангуй байрлалыг тодорхойлон харьцуулах

Г38.2. ДЭЛХИЙ БИДНИЙ ОРОН ГЭР

Г38.2а. Нарны тусгалын өнцөг, өдрийн үргэлжлэх хугацааны өргөргийн хамаарлыг тооцох

Г38.2б. Янз бүрийн газар орны цагийн ялгааг тодорхойлж, шалтгаан ба үр дагаврыг тайлбарлах

Г38.3. ХҮН АМ БА СУУРЬШИЛ

Г38.3а. Хүн амын тоон өөрчлөлтийг төрөл бүрийн аргаар дүрсэлж, шалтгааныг тайлбарлах

Г38.3б. Угсаатны онцлог ба газар зүйн тархалтыг ялган тодорхойлох

Г38.4. БАЙГАЛЬ НИЙГМИЙН ОРЧИН

Г38.4а. Монгол орны гадаргын хэв шинжийн ялгааг тодорхойлох

Г38.4б. Газар зүйн зураг ашиглан хотгор гүдгэрийн зүсэлт байгуулах

Г38.4в. Монгол орны ашигт малтмалын тархалтыг геологийн хөгжлийн түүхтэй холбон тайлбарлах

Г38.4г. Орон нутагтаа байгаа ашигт малтмал, газрын нөөцийн ашиглалтын талаар дүгнэх

Г38.4д. Цаг агаарын зургийн таних тэмдэг ашиглан, төлөв байдлыг илэрхийлэх

Г38.4е. Уур амьсгалын элементүүдийн газар зүйн хуваарилалтыг улирлын ялгаагаар тайлбарлах

Г38.4ж. Монгол орны усны нөөцөд нөлөөлсөн хүчин зүйлийг томоохон гол мөрөн нуурын жишээн дээр тодорхойлох

Г38.4з. Монгол орны мөстлөг, цэвдэг ба газар доорх усны тархалт, өөрчлөлтийг тодорхойлон шалтгааныг тайлбарлах

Г38.4и. Монгол орны хөрсний тархалтын зураг ашиглан голлох хэв шинжийн тархалт ба бүтцийг ялгах

Г38.5. БАЙГАЛЬ НИЙГМИЙН ХАМААРАЛ БҮС НУТАГ

Г38.5а. Монгол орны голлох ургамал, амьтдын тархалтыг байгалийн бүс, бүслүүрээр ялгах

Г38.5б. Орон нутагтаа тулгараад байгаа байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг дэвшүүлэх

IX АНГИ

ГЗ9.1. ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

ГЗ9.1а. Юмс үзэгдлийн шинж чанарыг илэрхийлэх, дүрслэх, хэмжих, тооцох дүгнэхдээ сэдэвчилсэн газарзүйн зураг ашиглах

ГЗ9.1б. Сэдэвчилсэн зургуудыг сонгон давхцуулах замаар байгаль нийгмийн юмс үзэгдлийн холбоо хамаарал, төлөв байдалд үнэлгээ өгөх

ГЗ9.2. ДЭЛХИЙ БИДНИЙ ОРОН ГЭР

ГЗ9.2а. Нар, сар, дэлхийн харилцан байрлалын үр дагаврыг туршилтаар нотолж, аргын ба билгийн тооллын учрыг тайлбарлах

ГЗ9.2б. Нарны тусгал, өдрийн үргэлжлэх хугацаа нь нийгмийн амьдралд хэрхэн нөлөөлж байгааг жишээгээр тайлбарлах

ГЗ9.3. ХҮН АМ БА СУУРЬШИЛ

ГЗ9.3а. Монгол орны хүн амын шилжих хөдөлгөөн, өөрчлөлтийн шалтгааныг байгалийн болон нийгмийн хүчин зүйлтэй холбон тайлбарлах

ГЗ9.3б. Аймаг сумын хүн амын статистик ашиглан хүн амын нас хүйсийн суварга байгуулах, уншиж ашиглах дүгнэлт гаргах

ГЗ9.3в. Монгол орны хот хөдөөгийн хүн амын бүтцийг диаграммаар дүрслэх

ГЗ9.3г. Хотын ангилал, хотжилтыг ялган таних

ГЗ9.4. БАЙГАЛЬ НИЙГМИЙН ОРЧИН

ГЗ9.4а. Байгалийн нөхцөл, нөөц Монгол орны эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах

ГЗ9.4б. Монгол орны газрын нэгдмэл сан, газар ашиглалтын төрлүүдийг графикаар дүрслэх

ГЗ9.4в. Монгол орны үйлдвэрийн хэв шинжийг ангилж, ялгаатай байгаагийн учрыг тайлбарлах

ГЗ9.4г. Мэдээллийн эх сурвалж ашиглан ХАА-н үйлдвэрлэлийн бүтэц, байршилд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох

ГЗ9.4д. Статистик мэдээлэлд үндэслэн Монгол орны дэд бүтцийн онцлогийг дүрслэлийн аргаар илэрхийлж, дүгнэлт гаргах

ГЗ9.5. БАЙГАЛЬ НИЙГМИЙН ХАМААРАЛ БҮС НУТАГ

ГЗ9.5а. Монгол орны эдийн засгийн бүсүүдийг байгалийн ба нийгэм эдийн засгийн онцлогоор нь харьцуулах

ГЗ9.5б. Эдийн засгийн тодорхой бүс нутгийг сонгон, газарзүйн байрлал, хүн ам, аж үйлдвэр, онцлогийг тодорхойлох

ГЗ9.5в. Тогтвортой хөгжлийн тулгуур ухагдахууныг судалж, нийгэмд тулгамдсан асуудлыг тодорхойлох

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1.Арга зүйн онцлог

- Газар зүйн хичээлийн агуулга хоорондын уялдаа холбоог ханган, сурагч аливаа асуудалд шинжлэх ухаанчаар ханддаг, эрэл хайгуул хийдэг, байгаль нийгмийн юмс үзэгдлийг зорилготойгоор судалдаг болоход сургалтыг чиглүүлнэ.
- Газар зүйн сургалт нь асуудал дэвшүүлэх, таамаглах, хийх үйл ажиллагаагаа төлөвлөх, гүйцэтгэх, үр дүнг боловсруулах, үнэлж дүгнэх, танилцуулах, сайжруулах алхмын дагуу явагдана.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

- Байгаль ахуй амьдралд ойр бодит орчинд ажиглалт, судалгаа хийх боломжоор хангахыг хичээнэ. Сурагчид бие даан болон хамтран олон талт ажиглалт, туршилт, судалгаа хийж болохуйц материаллаг, үйлийн болон сэтгэл зүйн шаардлага хангасан бүтээлчээр суралцах орчинг бүрдүүлэхэд анхаарна.
- Хичээлийн хэрэглэгдэхүүн нь танин мэдэхүйн хэрэгцээ шаардлагыг хангасан, оновчтой, сурагчдад хүртээмжтэй, харагдахуйц, сонирхол сэдэл тэмүүллийг төрүүлэхүйц, энгийн ойлгомжтой, эрүүл ахуй, аюулгүйн шаардлагыг хангасан байна.
- Ажиглалт, туршилт гүйцэтгэх явцдаа өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалдаг, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг баримталдаг, орчин үеийн техник, технологийн дэвшлийг ойлгодог, хэрэглэдэг, байгаль орчноо хамгаалах, хайрлах сэтгэлгээтэй болохыг чухалчилна.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

Үнэлгээнд дараах үнэлгээний зорилт, шалгуур, жинг баримтална.

4.1. Үнэлгээний зорилт

А. Мэдлэг, ойлголт

Б. Мэдээллийг хүлээн авах, асуудлыг шийдвэрлэх

В. Туршилт ба судалгааны арга

Г*. Хандлага

* Сурагчдын хандлагыг асуулга, ажиглалт, ярилцлага зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт (Сурагчид хөтөлбөрийн хүрээний ухагдахуун ойлголтын талаар мэддэг байна.)	Дараах мэдлэг, ойлголтыг үнэлнэ: А1. Шинжлэх ухааны үзэгдэл, баримт, хууль, тодорхойлолт, шинэ санаа ба онол А2. Шинжлэх ухааны үг хэллэг, нэр томьёо, тогтмол, нэгж, хэмжигдэхүүн болон олон улсын тогтсон томьёо, томьёолол А3. Газар зүйн хэмжилтийн багаж тоног төхөөрөмж, арга техник, аюулгүй ажиллагаа А4. Нийгэм, эдийн засгийн ба хүрээлэн буй орчны ойлголт бүхий шинжлэх ухаан ба технологийн хэрэглээ
Б.Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадвар (Сурагч дараах зүйлсийг хийх чадвартай байх)	Сурагч дараах чадварыг тэмдэг, график, тоон өгөгдөл, тэмдэглээг ашиглан үгээр юмуу, бичгээр илэрхийлэн гүйцэтгэнэ: Б1. Төрөл бүрийн эх сурвалжаас өгөгдөл, мэдээллийг цуглуулж, бүртгэх, сонгох, цэгцлэх Б2. Мэдээллийг нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт хөрвүүлэх Б3. Дүгнэлт гаргахад өгөгдөл, мэдээллийг хэрэглэх Б4. Зүй тогтол, харилцан хамаарлын учир шалтгааныг тайлбарлах Б5. Үзэгдэл, үйл явцын холбоо хамаарлыг олж илрүүлэх Б6. Урьдчилан таамаг, таамаглал дэвшүүлэх зэргээр учир шалтгааныг тайлбарлах аргыг оновчтой сонгох Б7. Мэдлэг, мэдээллээ шинэ нөхцөлд хэрэглэн, асуудлыг шийдвэрлэх Б8. Үр дүнг үнэлэх, асуудалд газарзүйн мэдлэг, онол, хэрэглэгдэх хязгаарыг ялган таних

В.Туршилт ба судалгааны чадвар (Сурагчид нь дараах зүйлсийг хийх чадвартай байх)	Сурагч дараах чадвараа харуулна: В1. Газар зүйн багаж төхөөрөмж, бусад материал (тохирох газарт нь заавар журмыг ашиглахыг оруулаад)-ыг аюулгүй сонгон, хэрэглэх В2. Туршилт, судлан шинжлэх ажлыг төлөвлөх В3. Ажиглалт, хэмжилт хийх, тэмдэглэх В4. Ажиглалт, туршилтын үр дүнг тооцоолох, тайлагнах, үр дүнг үнэлэх, дүгнэх В5. Туршилт, судалгааны аргыг үнэлэх, түүнийг сайжруулах боломж (техник, тоног төхөөрөмж, материалын сонголтыг багтаан)-ийг санал болгох
Г. Хандлага (сурагчдад дараах хандлага төлөвшсөн байх)	Сурагчдад дараах хандлага төлөвшсөн байна: Г1. Сонирхол Г2. Идэвхтэй оролцоо Г3. Бүтээлч байдал Г4. Нягт нямбай байдал Г5. Аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандах

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилтыг хэрэгжүүлэхдээ багш зөвхөн сурагчийг үнэлж, дүн тавихаар хязгаарлах бус сурагчдын сонирхол, хүсэл эрмэлзэлийг өдөөх, оролцоог нэмэгдүүлэх, илүү ихийг хийх, бүтээхэд чиглүүлэх нь чухал юм.

1. Мэдлэг, ойлголтыг үнэлэхэд сурагч мэдээллийг сэргээн санах, тайлбарлах түвшний даалгаврыг гүйцэтгэнэ. Мөн танил бус нөхцөлд мэдлэгээ хэрэглэх, эзэмшсэн мэдлэгээ шинэ сэдэвтэйгээ холбон ойлгох зэрэг үнэлэх асуултууд орж болно. Энэ үнэлгээний зорилтын даалгаврыг боловсруулахдаа гол төлөв тогтоох, тодорхойлох, дурдах, илэрхийлэх, дүрслэх, тайлбарлах (ойлгосноо) зэрэг үйл үгсийн аль нэгийг хэрэглэнэ.
2. Мэдээлэл боловсруулах чадвар гэдэгт мэдээллийг цуглуулах аргаа сонгох, мэдээллийг бүртгэн тэмдэглэх, нэгтгэн дүгнэх, задлан шинжилгээ хийх, мэдээллийг хэрэглэх зэргийг багтаан ойлгоно.

   Асуудал шийдвэрлэх чадвар гэдэгт асуудлыг тодруулах, асуудал үүсэх нөхцөл буюу тохироог илрүүлэх, асуудлыг шийдвэрлэх, өөрийн санаа бодлоо дэвшүүлэх зэргийг багтаан ойлгоно.

   Мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх чадварыг үнэлэхдээ ойлголт, ухагдахуун, зарчмыг шинэ нөхцөлд бүтээлчээр хэрэглэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх түвшний даалгавар боловсруулна. Энэхүү үнэлгээний зорилтын даалгаврыг боловсруулахдаа гол төлөв таамаглах, санал болгох, тооцоолох, тодорхойлох зэрэг үйл үгсийн аль нэгийг хэрэглэнэ.
3. Сорил туршилт хийх чадвар гэдэгт байгаль нийгмийн юмс үзэгдлийн мөн чанар, холбоо хамаарал, учир шалтгааны талаар таамаглал дэвшүүлэх, түүнийг батлахын тулд төлөвлөгөөтэйгээр ажиглалт, туршилт хийх, үр дүнг нэгтгэх, боловсруулах, бусдад илэрхийлэх цогц үйл ажиллагааг ойлгоно. Энэхүү үнэлгээний зорилтын даалгавар нь тухайн анги тус бүрийн агуулга, шинжлэн судлах арга барилд тохирох сорил туршилтын өгөгдөл бүхий үйлийн алхамтай байна.

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголт	50% (20%-аас ихгүй сэргээн санах түвшний даалгавар)
Б. Мэдээлэл хүлээн авах болон асуудал шийдвэрлэх чадвар	30%
В. Туршилт ба судалгааны чадвар	20%

НИЙГМИЙН УХААН

Нийгмийн ухааны сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч: У.Туяа Боловсролын хүрээлэн, секторийн эрхлэгч, Ph.D

Түүх

Б.Нацагдорж	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Ж.Гэрэлбадрах	Монгол Улсын Боловсролын их сургууль, түүхийн тэнхимийн эрхлэгч, Ph.D
П.Дэлгэржаргал	Монгол Улсын их сургууль, түүхийн тэнхимийн эрхлэгч, Ph.D
Ц.Гантулга	Монгол Улсын Боловсролын их сургууль, түүхийн багш, Ph.D
О.Батсайхан	Шинжлэх ухааны академи,ОУС хүрээлэнгийн салбарын эрхлэгч, Sc.D
З.Лонжид	Монгол Улсын их сургууль, түүхийн багш, Ph.D
З.Баасанжав	Монгол Улсын их сургууль, түүхийн багш, Ph.D
Х.Баярмаа	Монгол Улсын Боловсролын их сургууль, түүхийн дидактикийн багш
Б.Пунсалдулам	Шинжлэх ухааны академи, Түүхийн хүрээлэн, түүхч, Ph.D
Д.Янжинжав	Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн
Д.Нансалмаа	Нийслэлийн 117 дугаар сургуулийн түүх, нийгмийн ухааны багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

У.Туяа	Боловсролын хүрээлэн, Секторын эрхлэгч, доктор Ph.D
Ц.Гантулга	МУБИС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор Ph.D, профессор
Р.Содномцэрэн	Төмөр замын дээд сургуулийн багш, доктор Ph.D
Х.Эрдэнэтулга	“Шинэ эрин” сургуулийн түүхийн багш

Хянан тохиолдуулсан (2019)

О.Пүрэв Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Sc.D, профессор, МУ-ын гавьяат багш

Нийгэм судлал

О.Пүрэв	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Sc.D
С.Түмэндэлгэр	Монгол Улсын Боловсролын их сургууль, социологч багш, Ph.D
Ч.Гажиддулам	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, магистр
Р.Дарьхүү	Монгол Улсын их сургууль, философийн багш, Ph.D
Н.Мягмарцоож	Монгол Улсын Боловсролын их сургууль, улс төр судлалын багш, Ph.D
Ц.Сэлэнгэ	Монгол Улсын Боловсролын их сургууль, эдийн засгийн багш, Ph.D
Б.Батсүх	Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн
А.Баярбаатар	Хэрэгжилтийн багийн гишүүн

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

О.Пүрэв	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Sc.D, профессор
С.Түмэндэлгэр	МУБИС-ийн багш, Ph.D., дэд профессор
Д.Пунцагсүрэн	Боловсролын хүрээлэн, сурах бичгийн секторын эрхлэгч, магистр
Ч.Гажиддулам	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч, магистр

Хянан тохиолдуулсан (2019)

О.Пүрэв	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Sc.D, профессор, МУ-ын гавьяат багш

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь түүх, нийгмийн үйл явдал, үзэгдлийг танин мэдэх арга барилтай, үндэсний бахархал, соёл, уламжлалаа дээдлэн өвлөж, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг хүндэтгэдэг иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Түүх, нийгмийн үйл явдал, үзэгдлийг мэдэх, ойлгох;

1.2.2. Түүх, нийгмийн үйл явдал, үзэгдлийг шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, түүхийг тайлбарлах, үзэл бодлоо хөгжүүлэх замаар сурах арга барил эзэмших;

1.2.3. Монгол үндэсний нийтлэг адилсал болох эх хэл, урлаг, соёл, зан заншил, уламжлал, байгаль орчинтойгоо зохицон амьдрах мэдлэг ухаан шингэсэн нүүдлийн иргэншлийн үнэт зүйлээ өвлөх, хөгжүүлэх арга ухаанд суралцах;

1.2.4. Ардчиллын үнэт зүйлсийг эрхэмлэх, ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах.

Түүх, нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлснээр сурагч VI-VII, VIII-IX ангид шинжлэн судлах арга барилд суралцаж, дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VI-VII анги	VIII-IX анги
Асуулт тавих, асуудал, таамаглал дэвшүүлэх	- Хэзээ, хаана, юу, хэрхэн, яагаад болсон зэрэг асуух үгсийг ашиглан нийгэм, түүхийн үйл явдлын учир шалтгаан, адил болон ялгаатай талыг тодруулах асуулт, асуудлыг багшийн дэмжлэг, чиглүүлгийн дагуу тавих, дэвшүүлэх	- Түүх, нийгмийн үйл явдал, үзэгдлийн шалтгаан, явц, үр дагавар болон холбоо, хамаарал, нөлөөлөл, өөрчлөлтийг илрүүлэхийн тулд бие даан асуулт гаргах, асуудал, таамаглал дэвшүүлэх
Үйлийг төлөвлөх, мэдээлэл цуглуулах	- Тавьсан асуултад хариулах, дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэхийн тулд хэрхэн, юу хийхээ төлөвлөх, шаардагдах баримт мэдээллийг эрж хайх, цуглуулах, тэдгээрийг ангилах үйлийг багшийн тусламжтайгаар гүйцэтгэх	- Дэвшүүлсэн асуудал, таамаглалаа шийдвэрлэхийн тулд хийж гүйцэтгэх үйл, үйл ажиллагааг төлөвлөх, шаардагдах мэдээллийг холбогдох эх сурвалжаас эрж хайх, цуглуулах
Мэдээлэл боловсруулах	- Багшийн зааж, зөвлөсөн аргын дагуу мэдээллийг задлах, нэгтгэх, дүгнэх замаар боловсруулах	- Цуглуулсан мэдээллийг өөрийн сонгож авсан арга хэрэгслийг ашиглан ангилж, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх замаар дэвшүүлсэн асуудал, таамаглалаа нотлох, няцаах
Үр дүнг хэлэлцэх, шинэ санаа гаргах	- Шинжилгээний үр дүнг гаргах, танилцуулах, бусдын саналыг сонсох, шинэ асуулт гаргах, асуудал дэвшүүлэх үйлийг багшийн зааврын дагуу гүйцэтгэх	- Шинжилгээний үр дүнг гаргах, хэлэлцүүлэх, танилцуулах, шинэ санаа, асуудал, таамаглал дэвшүүлэх, түүнийгээ тайлбарлах

ХОЁР. АГУУЛГА

ТҮҮХ

VI АНГИ

6.1. ТҮҮХИЙГ ОЙЛГОХ (СУДЛАХ) АРГА

6.1а. Түүхийн асуулт асуух, зохиох

6.1б. Түүхийн он тоолол, түүхэн газар зүйн зургийн талаар мэдэх, хэрэглэх

6.1в. Түүхийн эх сурвалжийг нэрлэх, ангилах, эх сурвалжтай ажиллах зарим аргыг хэрэглэх

МОНГОЛ БА ЭРТНИЙ ДЭЛХИЙ: НЭН ЭРТНЭЭС ЧИНГИСИЙН ӨМНӨХ ҮЕ ХҮРТЭЛ

6.2. ӨВӨГ ТҮҮХИЙН ҮЕ

6.2а. Түүхийн олдвор болон газрын зураг ашиглан хүний үүсэл, тархалтыг дүрслэн харуулах

6.2б. Эртний хүмүүсийн аж ахуй (олзворлох, түүвэрлэх), багаж зэвсгийн (чулуун зэвсэг) талаар мэдэх, тэдний аж амьдралыг дүрслэн харуулах, танилцуулах

6.2в. Эртний хүмүүсийн аж ахуй (газар тариалан, мал аж ахуй)-н хөгжил, тэдний амьдралд гарсан өөрчлөлтийг зураглан харуулах

6.3. ЭРТНИЙ ИРГЭНШИЛ

6.3а. Эртний хот тосгодын олдвор, газар зүйн зураг зэргийг ашиглан суурин иргэншил хэрхэн, хаана, яагаад үүссэнийг тайлбарлах

6.3б. Багаж зэвсгийн (төмөр зэвсэг) болон бичиг үсгийн үүсэл, хөгжил иргэншлийн хөгжилд хэрхэн нөлөөлснийг тайлбарлах

6.3в. Монгол нутаг дахь хадны зураг, түүвэр олдвор зэрэгт тулгуурлан эртний нүүдэлчдийн аж амьдралыг дүрслэж, онцлогийг нь тодорхойлох

6.3г. Нүүдэлчид байгальтайгаа хэрхэн зохицон амьдардгийг жишээгээр тайлбарлах, байгалийг хайрлаж, хамгаалахыг эрмэлзэх

6.3д. Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн дурсгалыг мэдэж нэрлэх, тэдгээрийг хамгаалахыг эрмэлзэх

6.4. ДЭЛХИЙН ЭРТНИЙ УЛСУУД

6.4.а. Хоёр мөрний болон Египетчүүдийн аж амьдралыг дүрслэх, тэдний бүтээсэн соёлын өв, түүхэн дурсгалуудыг нэрлэх, танилцуулах

6.4.б. Грек, Ромчуудын аж амьдралыг дүрслэн илэрхийлэх, өнөө үед үлдсэн соёлын түүхэн өв, дурсгалуудыг нэрлэх, танилцуулах

6.4.в. Эртний Хятад болон Энэтхэгчүүдийн аж амьдралыг дүрслэх, тэдний бүтээсэн соёлын өв, дурсгалуудыг нэрлэх, танилцуулах

6.5. МОНГОЛЫН ЭРТНИЙ УЛСУУД

6.5.а. Монголын эртний улсуудыг нэрлэх, түүхийн асуулт тавих, хариулах замаар тухайн улсын түүхийг танилцуулах

6.5.б. Түүхийн дурсгал, олдвор, домгийг ашиглан Монголын эртний улсуудын үеийн соёлтой танилцах, соёлын өвийг хайрлан хамгаалахыг эрмэлзэх

6.5.в. Түүхийн дурсгал, олдворыг ашиглан Монголын эртний улсуудын аж ахуй, хүмүүсийн амьдралыг дүрслэн тайлбарлах

VII АНГИ

7.1. ДУНДАД ЗУУНЫ ТҮҮХИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

7.1а. Дундад зууны түүхийн он тооллыг оноор болон зуунаар тооцоолох, хэрэглэх

7.1б. Дундад зууны түүхэнд холбогдох баримт, эх сурвалжуудыг ангилах, эх сурвалжтай ажиллах үйл ажиллагааг төлөвлөж, хэрэглэх

7.2. ЧИНГИСИЙН ӨМНӨХ ҮЕИЙН МОНГОЛ (VI-XII ЗУУН)

7.2а. Түүхийн эх сурвалжтай (Судрын чуулган, Эргүнэ гүнгийн домог г.м) ажиллаж, монголчуудын угсаа гарлыг тодруулах

7.2б. VI-XII зууны үеийн нэр бүхий монгол аймаг, улсын түүхийн мэдээллийг шинжилж, тэдгээрийн байгуулагдсан болон оршин тогтносон цаг хугацааг тооцоолох, танилцуулах

7.2в. Эх сурвалжид тулгуурлан VI-XII зууны үеийн Монголчуудын эрхлэх аж ахуй, нийгэм, соёлын амьдралыг дүрслэн харуулах, танилцуулах

7.3. ИХ МОНГОЛ УЛС

7.3а. Монголын нууц товчоо зэрэг эх сурвалжийг ашиглан Чингис хааны намтрыг бүтээх, түүний түүхэн гавьяа, зүтгэлээр бахархах

7.3б. Их Монгол улс байгуулагдсан түүхийг он дараалын дагуу бүтээх, ач холбогдлыг дүгнэх, үнэлэх

7.3в. Их Монгол улсын төр, засаг захиргааны зохион байгуулалт, аж ахуй, соёлыг судалж, эдүгээ хүртэл өвлөгдөж ирсэн соёл, уламжлалыг тодруулах, үнэлэх

7.3г. Чингис хаан болон түүнийг залгамжлагч хаадын үеийн гадаад бодлого, байлдан дагууллыг мэдэх, түүний шалтгаан, үр дагаврыг тодорхойлох

7.4. МОНГОЛЫН АГУУ ГҮРЭН БА ЭЗЭНТ УЛСУУД

7.4а. Их Юань улсын газар нутаг, төр, нийгмийн зохион байгуулалт, аж ахуй, соёлыг тайлбарлах, Их Юань улс нь монголын эзэнт гүрэн болохыг ойлгох

7.4б. Алтан ордны улсын газар нутаг, аж ахуй, соёлыг тодорхойлох, монголчуудын байгуулсан улс болохыг тайлбарлах

7.4в. Цагадайн улсын газар нутаг, аж ахуй, соёлыг тодорхойлох, монголчуудын байгуулсан улс болохыг баримтаар нотлох

7.4г. Ил хаадын улсын газар нутаг, аж ахуй, соёлыг тодорхойлох, монголчуудын байгуулсан улс болохыг үндэслэн тайлбарлах

7.5. МОНГОЛЫН АГУУ ЭЗЭНТ ГҮРНИЙ ҮЕИЙН БУСАД УЛС (XIII-XV ЗУУН)

7.5а. Дундад зууны Хятад, Энэтхэг, Япончуудын төр, нийгэм болон аж ахуй, шашин, соёлын онцлогийг тодорхойлох

7.5б. Америк тивийн уугуул иргэдийн төр, нийгэм, ахуй амьдрал, соёлын онцлогийг мэдэх, танилцуулах

7.5в. Арабчуудын ахуй амьдрал, лалын шашин, Арабын халифт улсын талаар мэдэх, соёл, боловсролын онцлогийг тодорхойлох

7.5г. Баруун Европын феодалын нийгмийн онцлог, хотын хүн ам, тэдний эрхлэх аж ахуй, шашны талаар судалж, танилцуулах

7.5д. Зүүн Европын зарим нэр бүхий улсын түүхийн талаар мэдэх, танилцуулах

7.5е. Дундад зууны европын сүм хийдийн талаар мэдэх, загалмайтны аян дайны шалтгаан, үр дагавар, сургамжийг тодорхойлох

7.5ж. Баруун Европын улс орнуудын соёлтой танилцах, онцлог, нийтлэг шинжийг ялгах, танилцуулах

VIII АНГИ

8.1. МОНГОЛ УЛС БА ДЭЛХИЙН ШИНЭ ҮЕИЙН ТҮҮХИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

8.1а. Шинэ үеийн түүхийн он цаг, үечлэл, эх сурвалж, газар нутаг, түүхэн зүтгэлтэн зэргийг нэрлэх, энэ үеийн онцлогийг тодорхойлох

8.1б. Шинэ үеийн монголын болон дэлхийн зарим түүхэн үйл явдлыг зэрэгцүүлэн шинжлэх (уялдаа холбоо, нийтлэг болон ялгаатай байдлыг тодорхойлох) аргыг хэрэглэх

8.2. МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ДАРААХ МОНГОЛ БА ДЭЛХИЙ ДАХИН (XV-XVIII ЗУУНЫ ДУНД ҮЕ)

8.2а. XV-XVIII зууны дунд үед Монгол Улс Халх, Өвөр, Ойрад Монгол хэмээн хуваагдаж, нэгдмэл байдлаа алдсан шалтгаан, түүхэн сургамжийг сурвалж, баримт ашиглан тайлбарлах

8.2б. Монгол Улс тусгаар тогтнолоо алдахад хүрсэн шалтгаан, түүхэн сургамжийг баримт, эх сурвалжид тулгуурлан тодорхойлох

8.2в. Дэлхийн түүхэн дэх газар зүйн их нээлт, колоничлолын талаар мэдэх, эдгээр үйл явдлын түүхэн үүрэг, үр дагаврыг илрүүлэх

8.2г. Шашны шинэтгэх хөдөлгөөн, сэргэн мандалт, соён гэгээрлийн үзэл санаатай танилцаж, тэр үеийн түүхэн зүтгэлтнүүдийн үйл хэргийг дүгнэх, дэлхийн түүхэнд оруулсан хувь нэмрийг тодорхойлох

8.2д. XV-XVIII зууны дунд үеийн Англи, Франц зэрэг улсуудын түүхийг судлах замаар дэлхийн түүхийн шинэ үед гарсан гол өөрчлөлтийг харьцуулах, дүгнэлт хийх

8.2е. Манж Чин гүрэн, Могол, Япон, Солонгос зэрэг Азийн улсуудын мэдээллийг ашиглан тухайн үеийн дорно дахины түүхэн байдлыг дүрслэх, танилцуулах

8.2ж. XV-XVIII зууны дунд үеийн монголчуудын болон дэлхийн улс түмний аж амьдрал, соёлын ялгааг эх сурвалж, баримтад тулгуурлан тодорхойлох, харьцуулах, дүгнэх

8.3. XVIII-XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ БА ДЭЛХИЙ ДАХИН

8.3а. Амарсанаа, Чингүнжав нарын тэргүүлсэн монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл болон Монгол Манжид эзлэгдсэн түүхийг судалж, түүхэнд бие хүний гүйцэтгэх үүргийг тодорхойлох

8.3б. Манж чин улсын Монголыг захирсан бодлого, түүний шалтгааныг тодорхойлох, үр дагавар, сургамжийг илрүүлэх

8.3в. Монголд бурхны шашин дэлгэрсэн шалтгаан, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох, өнөөдөртэй холбон тайлбарлах, дүгнэх

8.3г. Мэдээлэл, эх сурвалжийг ашиглан XVIII-XX зууны эхэн үеийн монголчуудын аж амьдрал, соёл, урлагийг дүрслэх, өнөөдөртэй холбон тайлбарлах, үнэлэх

8.3д. Монголын талаарх Манж Чин гүрний бодлогод гарсан өөрчлөлт, түүний учир шалтгааныг эх сурвалж, үйл явдалд үндэслэн тодорхойлох, үр дагаврыг илрүүлэх

8.3е. Аж үйлдвэрийн анхдугаар хувьсгалын үйл явц, өрнөлтийг тайлбарлах, үр дүн, ач холбогдлыг тодорхойлох

8.3ж. Шинэ үеийн сүүлчээр гарсан шинжлэх ухааны нээлтүүдийг нэрлэх, тэдгээрийн ач холбогдлыг өнөө үетэй холбон тайлбарлах

8.3з. Шинэ бүрэлдэн тогтсон улс гүрнүүдийн түүхийг хувьсгалтай холбон тайлбарлах, үйл явдлуудын нийтлэг, ялгаатай талыг тодорхойлох

8.3к. Наполеон Бонапарт ба Францын эзэнт гүрний явуулсан бодлого, үр дагаврыг нээн харуулах

8.3л. XVIII-XX эхэн үеийн дорно дахины нийгэм, улс төрийн байдал, онцлогийг баримт, нотолгоонд үндэслэн тайлбарлах, үнэлэх

8.3м. Эзэнт гүрнүүдийн дорно дахиныг колончлох бодлогын учир шалтгаан, үр дагаврыг шинжлэн дүгнэх

8.3н. XVIII-XX зууны эхэн үеийн өрнө дахины улс түмний амьдрал, соёлтой танилцах, танилцуулах

8.3о. XVIII-XX эхэн үеийн дорно дахины улс орнуудын хүн ардын аж амьдрал, соёлын онцлогийг харьцуулах, дүрслэх

IX АНГИ

9.1. ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛЫН ТҮҮХИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

9.1а. Ойрх үеийн түүхтэй холбоотой гол, гол үйл явдал, он цаг, түүхэн зүтгэлтнийг ялгах, тодорхойлох, энэ үеийн онцлогийг тодруулах

9.1б. Ойрх үеийн түүхэнд холбогдох гар бичмэл, гэрээ, хууль тогтоомж зэрэг эх сурвалж, судалгааны бүтээлийг нэрлэх, ангилах, ашиглах

9.2. МОНГОЛЫН ТӨРИЙН СЭРГЭЛТ БА ДЭЛХИЙ ДАХИН (1911-1924 ОН)

9.2а. 1911 оны Монголын үндэсний хувьсгалын үр дүнг түүхийн баримтад тулгуурлан нэгтгэн дүгнэх, ач холбогдлыг тодорхойлох

9.2б. Монголын тусгаар тогтнолын түүх, тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч түүхэн хүмүүсийн үйл хэрэг, түүхэнд эзлэх байр суурийг баримтад тулгуурлан үнэлэх, бахархах

9.2в. Дэлхийн I дайны шалтаг, шалтгаан, гол үйл явдал, үр дагавар, сургамжийг тодорхойлж, танилцуулах

9.2г. 1917 онд Орост болсон "Октябрийн эргэлт"-ийн үр дагавар, уг үйл явдлын Монголын болон дэлхийн түүхэнд үзүүлсэн нөлөөг судалж, дүгнэх

9.2д. 1921 оны хувьсгалын шалтгаан, өрнөлийг он цаг, үйл явдлаар нь харуулах, үр дагавар, сургамжийг тодорхойлох

9.2е. XX зууны эхэн үеийн монголчуудын аж байдлыг зураглах, түүхийн үеүдэд хүмүүсийн аж байдал хэрхэн өөрчлөгдөж буйг харьцуулах

9.3. СОЦИАЛИЗМЫН ҮЕИЙН МОНГОЛ БА ДЭЛХИЙ ДАХИН (1924-1990 ОН)

9.3а. ЗХУ-аас Монгол улсад нөлөөгөө тогтоохын тулд явуулсан бодлого, үйл ажиллагаа, түүхэн сургамжийг тодорхойлох, дүгнэх

9.3б. БНМАУ байгуулагдсан үйл явц болон анхны Үндсэн хуулийн үзэл санааг тайлбарлах

9.3в. Монгол Улсын засаг захиргаанд гарсан өөрчлөлтийг харьцуулан тодорхойлох

9.3г. БНМАУ-ын эдийн засгийн байдлыг зураглан, өнөө үетэй харьцуулж, тайлбарлах

9.3д. Социализмын үеийн Монгол дахь соёл, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын ололт амжилт, алдаа дутагдлыг тодорхойлох

9.3е. Социализмын жилүүдэд шашны талаар явуулсан бодлого, түүний сургамжийг тодорхойлох, үнэлэх

9.3ж. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн шалтгаан, үйл явц, үр дагавар, сургамжийг судалж илрүүлэх, дүгнэх

9.3з. Социализмыг эсэргүүцсэн ард түмний тэмцэл, хөдөлгөөнийг танилцуулах, учир шалтгааныг тайлбарлах

9.3и. Дэлхийн II дайны шалтаг, шалтгаан, гол үйл явдал, үр дагавар, сургамжийг тодорхойлох, уг дайн дэлхийн түүхэнд хэрхэн нөлөөлснийг танилцуулах

9.3к. НҮБ байгуулагдсаны учир, түүний ач холбогдлыг тайлбарлах

9.3л. Капиталист, социалист хэмээх 2 системийн түүхэн байдлыг харьцуулах, дүгнэх

9.3м. Колонийн систем задарсан шалтгаан, үйл явцыг тодорхойлох, ач холбогдлыг дүгнэх

9.4. АРДЧИЛСАН МОНГОЛ БА ӨНӨӨГИЙН ДЭЛХИЙ (1990-ЭЭД ОНООС ОДООГ ХҮРТЭЛ)

9.4а. ЗХУ, социалист системийн задралын шалтгаан, үйл явц, үр дагавар, сургамжийг илрүүлэх, дэлхийн түүхэнд хэрхэн нөлөөлснийг тодорхойлох

9.4б. Энэ үеийн түүхэн зүтгэлтнүүдийн намтрыг бүтээх, тэдний үйл ажиллагааг сурвалжлах

9.4в. 1990 оны хувьсгалын үр дүнг Монголын улс төр, нийгмийн байдалд гарсан өөрчлөлтөөр зураглан харуулах

9.4г. Энэ үед Монголын эдийн засагт гарсан өөрчлөлтүүдийг нэрлэх, өмнөх үетэй нь харьцуулах, дүгнэх

9.4д. 1990-ээд оноос хойш монголчуудын оюун санааны амьдралд гарсан өөрчлөлтийг нэрлэх, өмнөх үетэй нь харьцуулах, дүгнэх

9.4е. Монгол улсын гадаад харилцаа, түүний бодлогын өөрчлөлтийг ойлгох, ач холбогдлыг тайлбарлах

НИЙГЭМ СУДЛАЛ

VII АНГИ

7.1. ХУВЬ ХҮН БА НИЙГЭМ

7.1а. Сурагч анхдагч бүлгийн гишүүн гэдгийн үндэслэлийг баримтаар тайлбарлах

7.1б. Байгууллагыг судлах замаар хоёрдогч бүлгийн тухай мэдэж, өөрт нь ямар нөлөө үзүүлж байгааг жишээгээр танилцуулах

7.1в. Анхдагч, хоёрдогч бүлгийн орчинд зөрчил юунаас үүсдэг болох, зөрчлийг зохистойгоор шийдвэрлэх аргуудыг нэрлэх

7.2. ХУВЬ ХҮН БА СОЁЛ

7.2а. Өөрийгөө соёлыг бүтээгч хийгээд соёлын нөлөөнд амьдардаг болохыг тайлбарлах

7.2б. Бүлгийн түвшинд бусдын соёлыг ойлгодог, хүндэтгэдэг эрмэлзэлтэй болохоо жишээгээр илэрхийлэх

7.3. ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

7.3а. Өрхийн түвшинд судлан, хэрэгцээ хязгааргүй, нөөц хязгаарлагдмал болохыг тайлбарлах

7.3б. Өрхийн хөдөлмөрийн хуваарь дахь өөрийн оролцоог жишээгээр тодорхойлох

7.3в. Сургуулийн жишээгээр зардлыг ангилж, тооцоолол хийх, зардлыг хэмнэх санаачилгаа үнэлэх

7.4. ХУВЬ ХҮН БА ХУУЛЬ

7.4а. Хүүхдэд чиглэсэн хайр халамж, тусламж, үйлчилгээг нэрлэх, хүүхдийн эрхийн тухай ойлголтыг тодорхойлох

7.4б. Хүүхдийн эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэхгүй байхын сөрөг үр дагаврыг тодорхойлж, өөрийн эрх, үүргийн хэрэгжилтийг үнэлэх

7.4в. Сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар судалж, дүрэм, журам, хууль нь хүний эрхийг хамгаалах арга, хэрэгсэл болохыг тайлбарлах

7.5. ХУВЬ ХҮН БА НИЙТИЙН УДИРДЛАГА

7.5а. Анги, хамт олны шийдвэрийг судлан, хамтын удирдлага, шийдвэр, оролцооны тухай ойлгох

7.5б. Сургуулийнхаа сурагчдын өөрөө удирдах байгууллагын талаар судалж, уг байгууллагын зорилго, үүргийг тайлбарлах

VIII АНГИ

8.1. ХУВЬ ХҮН БА НИЙГЭМ

8.1а. Орон нутгийн байгууллагууд, бусад бүлгүүдийн уялдаа холбоог зураглаж, хувь хүний амьдралд үзүүлж буй нөлөөллийг жишээгээр тайлбарлах

8.1б. Орон нутгийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, тэдгээр нь хүмүүсийн байр суурь, үүрэг, соёлын ялгаанаас хэрхэн хамаарч байгааг тодорхойлох

8.1в. Зөрчил нь байр суурь, соёлын ялгаанаас үүдэлтэй болохыг мэдэж, зөрчлийн эерэг, сөрөг талыг тодорхойлох, үл ойлголцол, зөрчлөөс сэргийлэх арга замуудыг нэрлэх

8.2. ХУВЬ ХҮН БА СОЁЛ

8.2а. Орон нутгийнхаа өв соёлын тухай мэдээлэлд тулгуурлан өвөрмөц байдлыг нь танилцуулж, бахархах эрмэлзлээ жишээгээр илэрхийлэх

8.2б. Хүн бусдын соёлыг ойлгох, хүндэтгэхийг илтгэх үйлдлийн төрлүүдийг нэрлэх, тайлбарлах

8.2в. Орон нутаг дахь соёлын хожимдлын асуудлыг судалж, асуудлыг шийдэхэд оруулах өөрийн хувь нэмрийг тодорхойлох

8.3. ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

8.3а. Орон нутгийнхаа ААН-ийн үйл ажиллагаатай танилцах, үр дүнг илтгэх

8.3б. Орон нутгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг судалж, зах зээлийн талаар ойлголттой болох

8.3в. Жижиг бизнесийн төслийн санаа гаргах, танилцуулах

8.4. ХУВЬ ХҮН БА ХУУЛЬ

8.4а. Хүний эрх, эрх чөлөөний түүхэн хөгжлийн эх сурвалжийг судлан, хүний эрхийн заяагдмал мөн чанарын үндэслэлүүдийг тайлбарлах

8.4б. Хүний эрхийн зарчмууд, иргэн, байгууллага, төр нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах талаар хариуцлага хүлээдгийг тодорхойлох

8.4в. Орон нутгийн жишээгээр хүний эрхийн зөрчлийг ялган таньж, дүрэм журам, хуулийн хүрээнд хүний эрхийг хэрхэн хамгаалах талаар дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах

8.5. НИЙТИЙН УДИРДЛАГА

8.5а. Орон нутгийн түвшинд бодлого, шийдвэр хэрхэн гардаг, түүнийг хэрхэн хэрэгжүүлэхийг судалж, нийтийн удирдлага гэж юу болохыг тодорхойлох

8.5б. Орон нутагт хүүхдийн талаар гаргасан шийдвэрийг судлан, шийдвэрт тусгах санал боловсруулах

IX АНГИ

9.1. ХУВЬ ХҮН БА НИЙГЭМ

9.1а. Харилцан үйлдэл дэх бэлгэ тэмдгийн (утгын) тогтолцоо хэрхэн бүрэлдэх, өөрчлөгдөхийг хүмүүс хоорондын харилцан үйлдлийн жишээгээр тайлбарлах

9.1б. Хүмүүс хоорондын үгэн болон үгэн бус харилцаанд субъектийн байр суурь, үүргийн ялгаа хэрхэн илэрч байгаа талаар дүгнэх, бусадтай үр дүнтэй харилцах арга замуудыг танилцуулах

9.1в. Хүмүүсийн хоорондын үл ойлголцол, маргааны шалтгаан, үр дагаврыг тодорхойлох, шийдвэрлэх аргуудын талаар зөвлөмж боловсруулах

9.2. ХУВЬ ХҮН БА СОЁЛ

9.2а. Өөрийн улс орон, үндэстний соёлын өвөрмөц байдал, ижилслийг (адилсал) бусад улс орон, үндэстний соёлын өвөрмөц байдалтай харьцуулах, танилцуулах

9.2б. Соёл үнэт зүйлсийн тогтолцоо болохыг жишээ, эх сурвалжид тулгуурлан тодорхойлж, соёлын үүргийн ач холбогдлыг танилцуулах

9.3. ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

9.3а. Хөдөлмөрийн зах зээл, цалин хөлс, ажил мэргэжлийн эрэлтийн талаарх мэдээллийг шинжлэх, тэдгээрийн уялдаа холбоог тодорхойлох, нөлөөлөгч хүчин зүйлсийг тайлбарлах

9.3б. Ирээдүйд эзэмших мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлж, зорилго дэвшүүлэн, түүндээ хүрэх арга замыг төлөвлөх

9.3в. Мөнгө, банкны нийгэмд гүйцэтгэх үүрэг, мөнгөний худалдан авах чадварын талаар судлах, хуримтлалын ач холбогдол, арвижуулах арга замуудыг танилцуулах

9.4. ХУВЬ ХҮН БА ХУУЛЬ

9.4а. Хүний эрхийн төрөл, хэлбэр, ангиллыг судлах, иргэний болон улс төрийн эрх ардчиллын үнэт зүйлс болохыг тайлбарлах

9.4б. Иргэн эрхээ эдлэх, үүрэг, хариуцлагаа биелүүлэх нь зайлшгүй болохыг жишээ, тохиолдол шинжлэн, тодорхойлох

9.4в. Хуулиар хүний эрхийг хамгаалах үндэслэлийг нэрлэх, эрхээ хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээхийн тулд хийх үйлдлийн хувилбаруудыг дэвшүүлэх

9.5. НИЙТИЙН УДИРДЛАГА

9.5а. УИХ, Засгийн газар, шүүхийн байгууллагын эрх хэмжээ, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны онцлог, уялдаа холбоог судлах, эрх мэдэл хуваарилалт гэж юу болохыг тодорхойлох

9.5б. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд иргэдийн оролцох боломжуудыг судлах, оролцох шаардлагын үндэслэл дэвшүүлэх

9.5в. Улс төрийн дэглэмүүд дэх иргэний үнэт зүйлс, итгэл үнэмшлийн ялгааг харьцуулан судалж, ардчилалд иргэдийн оролцоо ямар ач холбогдолтойг тайлбарлах

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Түүх, нийгмийн ухааны сургалтад уламжлалт аргын зэрэгцээ дараах сурагч “төв”-тэй аргуудыг заавал хэрэглэнэ. Үүнд:

- асуудал шийдвэрлэх арга
- шинжлэн судлах арга
- тохиолдол шинжлэх арга
- мэдээлэл боловсруулах арга
- түүхийг тайлбарлан судлах арга (интерпретац) гэх мэт.

Сургалтын эдгээр арга нь сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгатай нийцсэн байна.

3.2. Сургалтын орчин

Түүх, нийгмийн ухааны хичээлийн гол онцлог болсон итгэл үнэмшил, үнэт зүйлсийг сурагчдад эзэмшүүлэхэд анхаарч сургалтын орчинг бүрдүүлнэ. Сурагчид өнгөрсөн үед болон өнөөгийн нийгэмд болж буй үйл явдал, үзэгдлийн талаар бодол, үнэлэлт, дүгнэлтээ баримт, нотолгоотойгоор илэрхийлэх нээлттэй, аюулгүй, таатай орчинг бүрдүүлсэн байна. Хичээлийн анги танхим нь хамтаараа ажиллах, хэлэлцэх боломжтой байрлалаар зохион байгуулагдсан байхад анхаарна.

3.3. Сургалтын хэрэглэгдэхүүн

- Түүх, нийгмийн ухааны мэдээлэл бүхий түүхийн анхдагч болон хоёрдогч эх сурвалж
- Нийгэмд болж буй үйл явдлыг харуулсан тохиолдол, жишээ, дүрс бичлэг, киноны хэсэглэл
- Түүхийн газрын зураг
- Түүх, нийгмийн сэдэвт уран зохиол, урлагийн бүтээлүүд
- Мэдээлэл харилцааны технологи зэрэг болно.

Сурагчид өөрсдөө мэдээлэл цуглуулах, тэдгээрийг ангилах, кодлох замаар хэрэглэгдэхүүний санг бий болгож ашиглана. Сурагчдын мэдээлэл цуглуулах, ашиглахад мэдээллийн ёс зүй, зохиогчийн эрхтэй холбоотой анхаарах зүйлсийг багш сануулан, баримталж хэвшихэд анхаарна.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

А. Мэдлэг, ойлголт

Б. Шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх чадвар

В. Хандлага

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг, ойлголт (Түүхэнд болж өнгөрсөн болон өнөөгийн нийгэмд болж буй үйл явдал, үзэгдлийг танин мэдэх явцад ашигласан шинжлэх ухааны үг хэллэг, нэр томьёо, ойлголтын тайлбар, тодорхойлолт)	А1. Монголын болон дэлхийн түүхийн үечлэл, тэдгээрийн онцлог, үе тус бүрийн гол үйл явдал А2. Түүхэн эх сурвалж, он тоолол, орон зай, гол үйл явдал зэрэг түүхийн болон социологи, эдийн засаг, соёл, улс төрийн холбогдолтой нийгмийн ухааны нэр томьёо, ойлголтын тайлбар, тодорхойлолт А3. Мэдлэгийн хэрэглээ
Б. Шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх чадвар (Түүх, нийгмийн үйл явдал, үзэгдлийг шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, нотлох, түүхэн тайлбар хийх чадвар)	Б1. Түүх, нийгмийн ухааны баримт, тохиолдол, мэдээлэл цуглуулах, ялгах, ангилах, үнэлэх, мэдээллийг нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт хөрвүүлэх, шилжүүлэх Б2. Түүхийн төрөл бүрийн эх сурвалж болон нийгмийн ухааны баримт, тохиолдлоос мэдээлэл олох, асуудал дэвшүүлэх, шийдвэрлэх Б3. Үзэгдэл, үйл явцын холбоо хамаарлыг учир шалтгааны үүднээс тайлбарлах, бүдүүвч, хүснэгт, зураглал, график ашиглан амаар, бичгээр мэдээлэх

В. Хандлага (Түүх, нийгмийн үзэгдэл, үйл явдлыг сонирхож, судлах, оролцох идэвх зүтгэл, эрмэлзэл*)	В1. Нийгэм, түүхийн үйл явдал, тэдгээрийн үр дагавар, сургамж, өнөөтэй холбогдох байдлыг сонирхож буйгаа илэрхийлэх В2. Шинжлэн судлах хүсэл, эрмэлзэл В3. Эх түүх болон өнөөгийн нийгмийн талаарх эргэцүүлэл

Түүх, нийгмийн үзэгдэл, үйл явдлыг сонирхох сонирхол, идэвх зүтгэл, эрмэлзэл*:

- “Сонирхол, эрмэлзлэл” гэдэг нь сурагчдын хичээлийн болон хичээлээс гадуурх түүх, нийгмийн ухааны чиглэлийн үйл ажиллагаанд өөрийн сонирхлоор оролцож, эх түүх, амьдран буй нийгмээрээ бахархаж, түүний өв соёлыг хайрлан хамгаалахыг эрмэлзэж буй байдлаар илэрнэ.
- Түүхийн үйл явдлыг өнөөдөртэй холбон асуух, өөрийн санал дүгнэлтийг илэрхийлэх, түүхийн эх сурвалжийг өөрийн санаачилгаар хайж олохын төлөө санаачилга гаргах зэрэг нь сурагч сонирхож буйгийн илэрхийлэл гэж ойлгож болно. Мөн сурагчийн гайхах, эргэлзэх, өрөвдөх, дургүйцэх зэрэг сэтгэл хөдлөл, мэдрэмж нь сонирхол, эрмэлзэлтэй байгааг илтгэнэ.
- Сурагчийн "идэвх зүтгэл"-ийг илрүүлэхдээ түүний сурах үйлээ төлөвлөж, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн төлөө ажиллаж буй үйл ажиллагааг үнэлнэ.
- Хариуцлагатай, үнэт зүйлсийг эрхэмлэдэг иргэн төлөвшихтэй холбоотой зорилтын хэрэгжилтийг илрүүлэхэд чиглэнэ.
- Нийгмийн шинжтэй анги хамт олны болон сургуулийн ажилд оролцох, тэдгээрт өөрийн хувь нэмрийг оруулахын төлөөх санал, санаачилга, хандлагыг энэ үнэлгээнд хамааруулна.

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголт	30%
Б. Шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх чадвар	40%
В. Хандлага	30%

УРЛАГ

“Урлаг”-ийн сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч:	Х.Энхжаргал Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Хөгжим

Ч.Оюунбилэг	Соёл, урлагийн их сургууль, ХУС-ийн хөгжмийн дидактикийн багш
С.Баасандулам	Соёл, урлагийн их сургууль, СС-ийн багш
Т.Олоннэмэх	Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн
У.Саруул	“Шинэ эхлэл” сургуулийн хөгжмийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Ч.Оюунбилэг	Соёл, урлагийн их сургууль, ХУС-ийн багш, магистр
У.Ууганцэцэг	Нийслэлийн 84-р сургуулийн хөгжмийн багш

Хянан тохиолдуулсан (2019)

Х.Энхжаргал	Боловсролын хүрээлэн, БХСС-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Дүрслэх урлаг

С. Батцоож	Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш
Д.Цэдэн-Иш	Монгол Улсын Боловсролын их сургууль, БС-ийн багш, Ph.D дэд профессор
З.Баярмагнай	Монгол Улсын Боловсролын их сургууль, БС-ийн багш, Ph.D дэд профессор
А. Ариунболд	Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш
Б. Галбадрах	Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Хөхөө	МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш Ph.D, дэд профессор
А.Ариунболд	МУБИС-ийн ДУТС-ийн багш, Ph.D, дэд профессор
П. Болдбаатар	Нийслэлийн 20 дугаар сургуулийн багш

Хянан тохиолдуулсан (2019)

С.Отгонтуяа	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан, магистр

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилт

Сурагч нь аливаа юмс, үзэгдэл, урлагийн бүтээлийг судлах бүтээлч эрэлхийллийн арга барилтай, өөрийн авьяас, гоо сайхны мэдрэмжээ илэрхийлж, хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй, урлаг соёлыг эрхэмлэдэг иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Урлагийн бүтээлийг сонирхон судалснаар урлагийн хэл, нэр томьёог ойлгож хэрэглэх;

1.2.2. Урлагийн бүтээлийг мэдэрч ойлгох, сонирхон судлах, бүтээх хөгжүүлэх, илэрхийлэх, үнэлэх замаар бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцах;

1.2.3. Гүйцэтгэлийн ур чадвараа хөгжүүлэх явцдаа урлагийн сайхныг мэдэрч, гоо зүйн мэдрэмжээ хөгжүүлэх, илэрхийлэх;

1.2.4. Үндэсний болон хүн төрөлхтний урлагийн баялаг өв сан, үнэт зүйлсийг хүндэтгэн бахархаж, хамгаалдаг болно.

Урлагийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцаж, дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VI-VII	VIII -IX
Мэдэрч ойлгох	- Урлагийн бүтээлийн сайхныг мэдэрч, ойлгох, тэдгээрийн талаар эргэцүүлж, асуулт асуух - Бүтээлийн санаа, үүрэг зорилгыг тодорхойлох - Бүтээлийн дүр, дүрслэлийн талаар таамаглах, асуулт асуух, асуултад хариулах, дүрслэн бодох	- Урлагийн бүтээлийн төрөл хэлбэр, хэв маягийн талаар эргэцүүлэн бодох, асуудал дэвшүүлэх - Урлагийн илэрхийллийн арга, хэрэглэгдэхүүн, бүтээлийн санаа, үүрэг зориулалт, эрэлт хэрэгцээг тодорхойлох - Бүтээлийн онцлог, ач холбогдол, үр нөлөөг илрүүлэх асуулт асуух, асуудал дэвшүүлэх
Сонирхон судлах	- Шинэ бүтээлийн санаа олохын тулд хүрээлэн буй орчин, урлагийн бүтээлийн талаар мэдээлэл цуглуулах, ангилах, уншиж судлах - Санаагаа илэрхийлэх арга замыг багштайгаа хамтран төлөвлөх, хэрэглэгдэхүүнээ сонгох - Олсон санаагаа бодитойгоор зохиомжлон дүрслэх, найруулах - Бүтээлийн арга, хэрэглэгдэхүүнийг харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх	- Бүтээлийн шинэ санаа эрж хайх явцдаа урлагийн бүтээлийн агуулга, арга барилын талаар мэдээлэл цуглуулах, ангилах, материал хэрэгслийг судлах - Санаагаа илэрхийлэх арга замыг бие даан төлөвлөх, хэрэглэгдэхүүнээ сонгох олсон санаагаа бодитойгоор зохиомжлон дүрслэх, мэдрэмж, сэтгэгдлээ бүтээлдээ тусгах - Бүтээлийн хэв маяг, төрөл, илэрхийлэх аргуудыг харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх
Бүтээх, хөгжүүлэх	- Уран бүтээлийн дүр, дүрслэл, агуулгыг мэдэрч гүйцэтгэх, гүйцэтгэлийн талаар санаа бодлоо хуваалцах; - Гүйцэтгэлийн чадвартаа тулгуурлан төрөл бүрийн хэрэглэгдэхүүн ашиглан жижиг хэлбэрийн бүтээл хийх, зохион найруулах; - Бүтээлийн санаагаа сайжруулах, хувилбар боловсруулах;	- Урлагийн илэрхийллийн сайхныг мэдэрч, бүтээлийн санаагаа янз бүрийн аргаар илэрхийлэх, зохиомжлох, найруулах зэргээр гүйцэтгэх чадвараа хөгжүүлэх - Бүтээлийн санаагаа илэрхийлэхийн тулд өөрийн чадвар, техник, технологийг ашиглан найруулах, зохион бүтээх - Хийсэн бүтээлээ сайжруулах, шинэ хувилбар боловсруулах, хамтын бүтээл хийх

Илэрхийлэх, үнэлэх	- Бүтээлийн санаа, арга барил, хэрэглэгдэхүүний талаар илтгэх, туршлагаа хуваалцах, үнэлэх - Хамтарч хийсэн бүтээлийн агуулга, дүр, хэрэглэгдэхүүний талаар бусдад танилцуулах, үнэлэх	- Бүтээлийн илэрхийллийн арга болон үйл явцад шүүмжлэлтэй хандаж, санал бодлоо хуваалцах, үнэлж, дүгнэх - Хамтарч болон бие даан хийсэн бүтээлийн үр дүн, ач холбогдлыг бусдад танилцуулах, үнэлэх - Бусдын болон өөрийн бүтээлийг үнэлэх, дүгнэх

ХОЁР. АГУУЛГА

ХӨГЖИМ

VI АНГИ

УРЛАГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

6.1. УРЛАГИЙН ТӨРЛҮҮД

6.1а. Урлагийн бүтээлийн агуулга, дүр, үүрэг зорилго, илэрхийллийн арга барилыг сонсож тодорхойлох, тайлбарлах

6.1б. Дүрслэх урлаг, уран зохиолын төрлөөр туурвисан бүтээлийг хөгжмийн хэлний хэрэглүүрээр (хөг эгшиглэгээ, аялгууны шинж төрх, өнгө аяс, айзам хэмнэл, хурд, хүч, зэмсэгжилт г.м) дүрслэн илэрхийлэх, таамаглах

6.1в. Урлагийн төрлүүдэд ижил сэдвээр туурвигдсан бүтээлийг харьцуулан жишээгээр тайлбарлах

6.1г. Хөгжмийн зохиол, урлагийн бусад төрлөөр туурвигдсан бүтээл хоорондын уялдаа холбоо, ялгааг илрүүлэх

6.1д. Өөрийн сонирхсон урлагийн төрлөөр онцлох бүтээлийг сонгон жишээгээр тайлбарлах

6.1е. Урлагийн төрлүүдийн харилцан нөлөөллийг (дүрслэх урлаг-хөгжим, уран зохиол-хөгжим, бүжиг-хөгжим, кино-хөгжим, театр-хөгжим) тайлбарлаж жишээгээр харуулах

6.2. ХӨГЖМИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

6.2а. Дуу, романс, кантат, оратори, реквием, дуурь зэрэг дуулаачийн төрлүүдийг сонсож, тэдгээрийн онцлог ялгаа, бүтэц хэлбэр, илэрхийллийн аргыг тодорхойлох

6.2б. Аяз, этюд, прелюди, серенада, сонат, концерт зэрэг дан хөгжмийн зохиолын төрлүүдийг сонсож, тэдгээрийн онцлог ялгаа, бүтэц хэлбэр, илэрхийллийн арга хэлбэрүүдийг тодорхойлох

6.2в. Хөгжмийн зохиолыг сонсоод давталт, ялгарамж, зэмсэгжилтийг тодорхойлох

6.2.г. Хөгжмөө сонсоод зохиолын гол сэдэв аялгууны ноотонд задлал хийж, цараа, хурд, хүчний өөрчлөлт, аялгууны хөдөлгөөн, шинж төрх, айзам хэмжээ, хэмнэлийн зураглал, эгшиглэгээний онцлогоор агуулга дүрийг таамаглах, жишээгээр тайлбарлах

6.2.д. Гоцлол, цөөхүүл, найрал хэлбэрээр дуулахдаа хоолой тус бүрийн үүргийг ялган таних, тайлбарлах, ая, шүлэг, мэдрэмжид тулгуурлан утга санааг илэрхийлэх

6.2.е. Бишгүүрээр болон өөрийн сонирхсон хөгжмийн зэмсгээр хөгжимдөх арга барил эзэмшсэнээ гоцлол, цөөхүүл, найрал хэлбэрээр гүйцэтгэх, зэмсгийнхээ үүрэг, онцлогийг тодорхойлж, илэрхийлэх аргаа боловсруулах

VII АНГИ

МОНГОЛ АРДЫН УРЛАГ

7.1. МОНГОЛ АРДЫН ДУУ ХӨГЖМИЙН ТӨРЛҮҮД

7.1а. Монгол ардын дуу хөгжмийн төрөл зүйл, илэрхийллийн арга барил, онцлог, ялгааг тодорхойлох, тайлбарлах

7.1б. Өгүүлэх эрхтний шүтэлцээт урлаг хөөмийн төрлүүдийг (исгэрээ, шахаа, хархираа) сонсож таних, тодорхойлох

7.1в. Хөгжимт аман зохиолын төрлүүдийг сонсож таних, сурснаа жишээгээр харуулах, монголчуудын ахуй, аж байдалтай холбон тайлбарлах

7.1г. Монгол ардын дууны төрөл, дуулах хэв маяг, арга барил, онцлогийг бусад үндэстний дуутай харьцуулах, дуулж үзүүлэх

7.1д. Монгол ардын дууны уран бүтээлээс дуулахдаа хоолойн цараа, амьсгааны техник, айзмын өөрчлөлт, аялгууны үсрэлтийг мэдэрч, дуулж харуулах

7.1е. Монгол үндэсний хөгжмийн зэмсгүүдийн төрөл, эгшиглэгээ, хөгжимдөх арга барил, онцлогийг тайлбарлах, сонсож таних

7.1ж. Үндэсний хөгжимд зориулсан бүтээлийг сонсоод агуулга дүр, хэлбэр бүтэц, зэмсэгжилтийг тодорхойлох, сэдэв аялгууг ноотоор аялах

7.1з. Монгол ардын бүжиглэх урлаг, язгуур бий биелгээний төрөл, онцлогийг монголчуудын амьдрал ахуйтай холбон жишээгээр тайлбрлах

7.1и. Язгуур бий биелгээний дөрвөн зохицолт хөдөлгөөн (гар хөлийн байрлал, үндсэн суудал, мөр цээжний хөдөлгөөн)- ийг эзэмшсэнээ харуулах

7.2. МОНГОЛ ХӨГЖМИЙН УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛ

7.2а. Орчин цагийн мэргэжлийн хөгжмийн бүтээл дэх уламжлалт төрлүүдийг сонсож тодорхойлох

7.2б. Этник хамтлагуудын уран бүтээлээс сонгон хөгжимдөх арга маяг, зэмсгүүдийн өнгө дуурьсал, уран бүтээлдээ авч ашигласан ардын дуу хөгжмийг тодорхойлох, тайлбарлах

7.2в. Монгол ардын дууны уран бүтээлээс сонголт хийж, бишгүүрээр болон өөрийн сонгосон хөгжмийн зэмсгээр тэмдэг тэмдэглэгээг зөв илэрхийлж, ноотоор хөгжимдөж илэрхийлэх

VIII АНГИ

СОНГОДОГ УРЛАГ

8.1. ДУУРЬ

8.1а. Сонгодог хөгжмийн төрлүүд, илэрхийллийн арга хэлбэр, онцлогийг тодорхойлох

8.1б. Дуурийн үүсэл хөгжил, төрөл хэлбэр, бүтэц, онцлогийг тайлбарлах

8.1в. Дуурь дах дуулаачийн төрлүүдийг сонсоод, ялган таних, үүргийг тайлбарлах

8.1г. Урлагийн төрлүүдийн харилцан уялдаа холбоог бүтээлийн жишээгээр харуулах

8.1д. Дуурийн уран бүтээлийн шилдэг үзүүлбэрээс сонсож тодорхойлох, тайлбарлах

8.1е. Аялгууны шинж төрх, хөгжмийн хэл, сэтгэл хөдлөлийн илрэлийг хөдөлгөөнөөр хэрхэн илэрхийлснийг шилдэг бүтээлийн жишээн дээр тайлбарлах

8.2. СИМФОНИ

8.2а. Симфони хөгжмийн үүсэл хөгжил, төрөл хэлбэр, бүтэц онцлогийг тайлбарлах

8.2б. Суут хөгжмийн зохиолчдын шилдэг бүтээлээс сонсоод хөгжмийн зэмсгүүдийг төрөл ангилал, гүйцэтгэх үүргээр нь ялган тодорхойлох, ардын хөгжмийн зэмсгүүдтэй харьцуулах

8.2в. Өөрийн сонсох дуртай сонгодог хөгжмийн бүтээлд сонсголын ажиглалт хийж, сэтгэгдлээ илэрхийлэх, онцолсон зүйлээ тэмдэглэх, тайлбарлах

8.3. БҮЖГЭН ЖҮЖИГ

8.3а. Бүжгэн жүжгийн үүсэл хөгжил, илэрхийллийн арга хэлбэр, бүжигт хөгжмийн гүйцэтгэх үүргийн талаар тайлбарлах

8.3б. Цэнгээнт болон чөлөөт бүжгийн энгийн элементүүдэд тулгуурлан өөрийн бүтээлийг хийж харуулах

8.3в. Бүжгийн урлагийн дүрслэл илэрхийллийн өвөрмөц арга, утга агуулга, дүр дүрслэлийг хөдөлгөөнтэй холбон тайлбарлах, бүжгийн хөгжмийн аялгууны шинж төрх, хурд, хүчийг тодорхойлох

IX АНГИ

ОРЧИН ҮЕИЙН УРЛАГ

9.1. ОРЧИН ҮЕИЙН ХӨГЖМИЙН УРЛАГ

9.1а. Орчин үеийн хөгжмийн урсгал чиглэлүүд, тэдгээрийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрүүдийг ялган таних, тайлбарлах

9.1б. Импрессионист, экспрессионист урсгалын онцлогийг хөгжим-уран зураг-уран зохиолын бүтээлийн жишээн дээр харьцуулан тайлбарлах, сонсож таних, тодорхойлох

9.1в. Авангард урлаг, бүтээлч илэрхийллийн арга барилууд, тэдгээрийн онцлогийг тайлбарлах, жишээгээр харуулах

9.1г. Найрал хөгжмийн зэмсгийн дуурьслын хүч, хэмнэл, аялгууны шинж төрхийг сонсож тодорхойлох

9.1д. Орчин үеийн хөгжмийн урлагийн төрөл, хэлбэр, илэрхийллийн арга барилд гарсан шинэчлэлт өөрчлөлт, тэдгээрийн холбоо хамаарлыг жишээгээр тайлбарлах, харуулах

9.1е. Зураг болон хөгжим, шүлгээс төрсөн сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэх, хөгжмийн илэрхийлэмжийг өөрийн санаагаар баяжуулах, тайлбарлах

9.2. МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ХӨГЖИМ

9.2а. Монголын орчин үеийн хөгжмийн үүсэл хөгжил, гол төлөөлөгчид, шилдэг бүтээлийн талаар жишээгээр тайлбарлах

9.2б. Монголын орчин үеийн симфони, дан хөгжмийн бүтээлээс сонсоод хөгжмийн зэмсэг, хэмнэлийн илэрхийлэл, дуурьсал тэдгээрт гарсан өөрчлөлт, эгшиглэх онцлогийг тайлбарлах

9.2в. Монголын орчин үеийн хөгжмийн театрын бүтээлийн санаа, илэрхийллийн арга барил, онцлогийг тайлбарлах, жишээгээр харуулах

9.3. ЭСТРАД ХӨГЖИМ

9.3а. Эстрад (джаз, рок, поп,) урлагийн онцлог, илэрхийллийн арга хэлбэрийг сонсож тодорхойлох, тайлбарлах

9.3б. Эстрад хөгжмийн бүтээлийг сонсоод хэмнэл, дуурьсал, зэмсгүүдийн гүйцэтгэх үүргийг тайлбарлах

9.3в. Эстрад хөгжмийн урлагт гарсан шинэчлэлт өөрчлөлтийг жишээгээр тайлбарлах, үзүүлэх

ДҮРСЛЭХ УРЛАГ

VI АНГИ

6.1. ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ХЭЛ

6.1а. Уламжлалт болон улс үндэстний өнгийн бэлгэдлийг харьцуулах

6.1б. Өнгийн дагнаас, зохицол, эрс тэс чанарыг урлагийн бүтээлийн жишээ гарган тайлбарлах

6.1в. Шулуун тахир нуман зураасны онцлогийг танин мэдэж тосон харандаа усан будаг ашиглан зураасны чөлөөт зохиомж хийн турших

6.1г. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзэлхүүнийг нэг цэгийн алслалтын аргаар дүрслэн харуулах

6.1д. Биеийн ерөнхий хэмжээ, харьцааг баримжаалан дүрслэх аргаар амьтан зурах

6.2. УРЛАН БҮТЭЭХ

6.2а. Уран сайхны үсгийн хэлбэр, онцлогийг таньж тодорхойлох

6.2б. Өөрийн бодол төсөөллийг шог хошин зургийн аргаар илэрхийлэх

6.2в. Өөрийн бодол төсөөллөө уран зургийн аргаар илэрхийлэх

6.2г. Цоолборлох аргаар амьтны дүрсийн гаралтай хээ, угалзыг давтамжтайгаар дүрслэх

6.3. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ

6.3а. Ардын гар урлалын төрлүүдийг бүтээлийн жишээн дээр тайлбарлах

6.3б. Хүй нэгдлийн үеэс -XIV зууны үеийг хүртлэх монголын дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох

6.3в. Дэлхийн эртний улсуудын дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох

VII АНГИ

7.1. ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ХЭЛ

7.1а. Ахромат, хромат өнгө, өнгийн тон, ханалт, хоршил, харшил зонхилох өнгийг ялгах

7.1б. Тосон харандааны хүнд хөнгөн даралтыг нягт сийрэг байдлаар зурааслах

7.1в. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзэлхүүнийг хоёр цэгийн алслалтын болон урвуу алслалтын аргаар дүрслэх

7.1в. Биет өөрийн болон биет хоорондын хэмжээ, харьцааг жишиж харьцуулах аргыг зураг дүрслэлдээ ашиглах

7.2. УРЛАН БҮТЭЭХ

7.2а. Геометр биетийн гэрэл, сүүдрийг зурааслах аргаар илэрхийлэх

7.2б. Гротеск төрлийн үсгийг хэв ашиглан бичих, бичлэгийн онцлогийгтайлбарлах

7.2в. Таталбар, судалбар зургийн аргаар хүн ба амьтныг дүрслэх

7.2г. Байгалийн өнгө төрх, үзэгдлийг судалбар зургийн аргаар өнгөөр дүрслэх

7.2д. Ардын зураг ба шүтээн зургийн ялгаа, онцлогийг таньж тодорхойлох

7.2е. Монгол зургийн зурааслах техникүүдийг зураг дүрслэлд ашиглах

7.3. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ

7.3а. Зүмбэрлэх болон шуумал хийх аргыг туршин хэрэглэх

7.3б. XIV-XVII зууны үеийн Монголын дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох

7.3в. Дундад зууны болон дэлхийн зарим улс үндэстний дүрслэх урлагийн зарим бүтээлийн онцлогийг таньж тодорхойлох

VIII АНГИ

8.1. ДҮРСЛЭХ УРЛАГИЙН ХЭЛ

8.1а. Дулаан, хүйтэн, ойролцоо өнгийн зохицол үүсгэн зохиомжлох, зураг дүрслэлдхэрхэн нөлөөлөхийг ашиглах

8.1б. Цэг, толбо зураасыг хослуулан хүн амьтан, эд юмсыг чөлөөт зохиомжоор дүрслэх

8.1в. Юмсын хол, ойр байршил ба биетийн эзэлхүүнийг хоёр ба гурван цэгийн алслалтын аргаар дүрслэн харуулах

8.1г. Хүүхэд болон том хүнийг зурахдаа хүний биеийн ерөнхий харьцааг дүрслэх аргыг ашиглах

8.2. УРЛАН БҮТЭЭХ

8.2а. Натюрмортын гэрэл, сүүдрийг зурааслах аргаар илэрхийлэх

8.2б. Антиква үсгийн уран бичлэгийн онцлогийг тайлбарлах

8.2в. Өөрийн бодол төсөөллийг бар зургийн аргаар илэрхийлэх

8.2г. Натюрмортын гэрэл, сүүдрийг өнгөөр илэрхийлэх

8.2д. Монгол зургийн зохиомж, өнгө, арга ажиллагаа уран бүтээлийн жишээн дээр тайлбарлах

8.2е. Монгол зургийн аргаар өгөгдсөн сэдвээр бүтээл хийх

8.3. СОЁЛЫН ҮНЭТ ЗҮЙЛ

8.3а. Монголын дүрслэх урлагийн төлөөлөгчдийн бүтээлийг таньж тодорхойлох /1921 оноос өнөөг хүртлэх үе/

8.3б. Сэргэн мандалтын үеийн дүрслэх урлагийн зарим бүтээлийг таньж тодорхойлох

8.3в. Дүрслэх урлагийн зарим чиг хандлагуудыг бүтээлийн жишээн тайлбарлах

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Урлагийн сургалтын арга зүй нь энэхүү хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байхаар төлөвлөгдөнө.

3.1. Арга зүйн онцлог

Сурагчийн сурах арга барилын эзэмшилт болон авьяас чадварыг хөгжүүлэхтэй холбогдуулж, арга зүйн хувьд дараах зүйлийг анхаарч ажиллана. Үүнд:

- Хичээл тус бүрийн агуулга нь мэдэрч ойлгох, сонирхон судлах, бүтээх, илэрхийлэхтэй холбоотой чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд үйл ажиллагааг бүх сурагчдад хүртээмжтэй байхаар зохион байгуулна.
- Урлагийн олон талт үйл ажиллагаанд бие даан болон хамтарсан хэлбэрээр оролцох, сонсох, дуулах, хөгжимдөх, бүжиглэх, зурах үйлийг тодорхой аргачлалын дагуу хийж гүйцэтгэх арга зүйд суурилна.
- Сурагчдын эрэлт хэрэгцээ сонирхлыг харгалзан театр музей, галерей, үзэсгэлэн үзүүлж, монгол ардын болон сонгодог, орчин үеийн урлагийн бүтээлүүдтэй танилцах боломжийг бүрдүүлнэ.

3.2. Сургалтын орчин

Хөгжим, дүрслэх урлагийн хичээлийг зориулалтын анги, кабинетад зохион байгуулна.

Сурагч бүрийн авьяасыг хөгжүүлэхийн тулд чөлөөтэй дуулж, хөгжимдөх, бүжиглэх боломжтойгоор анги танхимыг тохижуулна. Тухайлбал, зурагт, дэлгэц, проектор, систем хөгжим, магнитофон г.м

3.3. Сургалтын хэрэглэгдэхүүн

Мэдээллийн технологийн дэвшилд суурилан, өөрийн болон бусад улс орны дүрслэх урлагийн бүтээл, дуу хөгжмөөс хичээлийн зорилготойгоо уялдуулан сурагчдад ойлгоход дөхөм, сонирхол, эрэлт хэрэгцээнд нь нийцсэн урын сангийн сонголтыг оновчтой хийж, аудио болон видеог ашиглах боломжийг бүрдүүлнэ.

Сурагчдад мэдэрч ойлгох, мэдрэмжээ хөгжүүлэх, илэрхийлэхэд нь чиглэсэн дасгал, даалгаврыг боловсруулна.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

А. Урлагийн мэдлэг, ойлголт
Б. Бүтээлчээр хөгжих чадвар
В. Гүйцэтгэх чадварын ахиц
Г*. Урлагийн бүтээлийг судлах хүсэл, сонирхол, хандлага
* Сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А.Урлагийн мэдлэг, ойлголт	А1. Урлагийн хэл, нэр томьёо, тэмдэг, тэмдэглэгээ А2. Хөгжмийн зэмсэг, зургийн хэрэгсэл, тоног төхөөрөмж А3. Нийгэм болон хүрээлэн буй орчин дахь урлагийн хэрэгцээ
Б.Бүтээлчээр хөгжих чадвар	Б1. Санаагаа илэрхийлэх аргаа төлөвлөх Б2. Өөрийн бүтээлээ оновчтой арга, хэрэглэгдэхүүн сонгон илэрхийлэх Б3. Ажиглалт, мэдээлэл, гүйцэтгэлийн үр дүнг бичвэр, зураг, хүснэгт, диаграммаар илэрхийлэх Б4. Хамтарч болон бие даан хийсэн бүтээлийн алдааг олж засах, сайжруулах шинэ санаа, хувилбарыг боловсруулах Б5. Мэдээллийн технологи хэрэглэн бүтээлийнхээ агуулга, дүр, хэрэглэгдэхүүний талаар бусдад танилцуулах Б6. Олсон санаагаа зохиомжлон дүрсэлж, найруулан, үндэслэлээ тайлбарлах
В.Гүйцэтгэлийн чадварын ахиц	В1. Бүтээлээ илэрхийлэхийн тулд дуулах, хөгжимдөх, зохион найруулах, зурах, дүрслэх, барих, наах, чимэглэх, зохиомжлох В2. Шаардлагатай тохиолдолд давтан хийж, сайжруулах В3. Дуулах, хөгжимдөх, зурах, дүрслэх үйлийг гүйцэтгэх В4. Гүйцэтгэхдээ сэтгэл хөдлөл, мэдрэмжээ илэрхийлэх

Г.Урлагийн бүтээлийг судлах хүсэл, сонирхол, хандлага	Г1. Аливаа юмс үзэгдэл, урлагийн бүтээлийг өдөр тутмын амьдралтай холбон ойлгож, урлагт хандах хандлага, сонирхол нь нэмэгдэж буй байдал Г2. Бие даан болон хамтран хичээллэх идэвх, оролцоо нэмэгдэж буй байдал Г3. Урлагийн төрөл, илэрхийлэл, дүр дүрслэлийн талаар төсөөлөн, ургуулан бодож, эргэцүүлж, асуудал дэвшүүлж буй байдал Г4. Бүтээлийн үүрэг, зорилго, ач холбогдол, үр нөлөөг илрүүлэх асуулт зохиож, асууж буй байдал Г5. Шинэ бүтээлийн санаа олохын тулд мэдээлэл цуглуулж, түүнийгээ ангилан, боловсруулж буй байдал Г6. Урлаг, соёлын үйл ажиллагаанд оролцож буй байдал

4.2. Үнэлгээний шалгуур

Урлагийн хичээлээр сурагчдын авьяас чадварыг үнэлэх тохиромжтой аргыг сонгохдоо илэрхийлэх болон гүйцэтгэлийн чадварыг илрүүлэн хөгжүүлэхэд анхаарч илтгэл, төсөл бичих, бүтээлийн үзэсгэлэн, тайлан тоглолт зэргээр үнэлж болно.

Үнэлгээг хэт олон янзаар ойр ойрхон хийх нь мэдээлэл цуглуулах сайн талтай ч хичээл, сургалтын чанарт нөлөөлөх муу тал байгааг анхаарна. Багш бүр өөрийн сургуулийн онцлог, ажлын туршлага, бусад багш нарын дэвшилтэт арга барилыг үндэс болгож, богино хугацаанд, оновчтой байдлаар сурагчдыг үнэлэх үнэлгээний арга техникийг боловсруулж ашиглана.

“Урлагийн мэдлэг, ойлголт”-ыг үнэлэхдээ сургалтын явцад эзэмшсэн урлагийн суурь мэдлэг ойлголт, нэр томьёо, ухагдахуун болон тэдгээрийн үүрэг зориулалт, тэмдэг тэмдэглэгээг амьдрал, үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэглэх чадварыг багтаан үнэлнэ.

“Бүтээлчээр хөгжих чадвар”-ыг үнэлэхдээ бие даан болон хамтран бүтээлийн сэдэв, агуулга, дүр дүрслэлийг ойлгож мэдрэхийн тулд өөрийн хувилбарыг боловсруулах, туршилт хийх, бусдад илэрхийлэх, тайлагнах нэгдмэл үйл ажиллагааг ойлгох бөгөөд урлагт хандах хандлага, урлаг, соёлын үйл ажиллагаанд оролцох идэвх оролцоо, санаачлагыг чухалчилна.

“Гүйцэтгэлийн чадварын ахиц”-ыг үнэлэхдээ зурах, дүрслэх, барих, наах, чимэглэх, дуулах, хөгжимдөх, зохион найруулах, чадварыг эзэмшиж, бүтээлчээр хандаж байгаа болон өөрийн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлж байгааг үнэлэн, гүйцэтгэлийг нь хянаж, зөвлөн тусалж, чиглүүлнэ.

“Урлагийн бүтээлийг судлах хүсэл, сонирхол, суралцах чадварын хөгжил сурагчдын ахиц амжилт”-ыг үнэлэхдээ урлагийн төрлүүдийг сонирхон судалж, эргэцүүлэх түүнийгээ өдөр тутмын амьдралтай холбон ойлгож, илэрхийлэх чадвар, тэдгээрийн хөгжлийг үнэлнэ.

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголт	40%
Б. Мэдлэгээ хэрэглэх (бүтээлч эрэлхийллийн арга барил)	60%

ДИЗАЙН ТЕХНОЛОГИ

“Дизайн технологи”-ийн сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч:	Г.Чулуунаа Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш Ph.D, дэд профессор,
Багийн гишүүд	
С.Отгонтуяа	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан
Х.Тамир	Монгол Улсын Боловсролын их сургуулийн дэд захирал Ph.D, дэд профессор
Д.Сэрээтэрдорж	Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш Ph.D, дэд профессор
Р.Гоцбаяр	Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш Ph.D, дэд профессор
Г.Амарсанаа	Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн
Х.Гэрэлтуяа	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч
Д.Алтанцэцэг	Төслийн мэргэжилтэн
М.Баасанбаяр	Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш
У.Лхагвадорж	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн багш
С.Цолмон	Нийслэлийн “Шинэ эхлэл” сургуулийн технологийн багш
Т.Ариунаа	Нийслэлийн 33 дугаар сургуулийн технологийн багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Д.Хөхөө	МУБИС-ийн ДУТС-ийн зөвлөх багш, Ph.D, дэд профессор
Д.Сэрээтэрдорж	МУБИС-ийн ДУТС-ийн тэнхимийн эрхлэгч, Ph.D, дэд профессор
Р.Гоцбаяр	МУБИС-ийн ДУТС-ийнтэнхимийн эрхлэгч, Ph.D, дэд профессор
Г.Чулуунаа	МУБИС-ийн ДУТС-ийн багш, Ph.D, дэд профессор

Хянан тохиолдуулсан (2019)

С.Отгонтуяа	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан, магистр

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь дизайн, техник, технологийн үйл явцыг танин мэдэх бүтээлч сэтгэлгээ, арга барилаа хөгжүүлж, дизайны шийдэл гаргах, бүтээх, үнэлэх чадвар эзэмшин, байгаль, үндэсний соёлоо дээдэлдэг иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Дизайн, техник, технологийн үйл явцын талаарх мэдлэг ойлголт, түүнийг хэрэглэх, мэдээлэл харилцааны технологийг ашиглах;

1.2.2. Дизайны шийдэл гаргах, бүтээх, үнэлэх замаар бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцах;

1.2.3. Ахуй амьдрал, нийгэмд чиглэсэн дизайн технологийн асуудлыг шийдвэрлэхдээ уламжлалт болон орчин үеийн технологийн сонгон хэрэглэх, байгаль орчинд аюулгүйн талаас нь авч үзэх хандлагатай болно.

Дизайн, технологийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагчид YI-YII, YIII-IX ангид бүтээлч эрэлхийллийн арга барилд суралцаж дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VI-VII анги	VIII-IX анги
Асуудал болон хэрэгцээг илрүүлэх	- Өөрийн, өрх гэрийн, хамт олны хүрээн дэх дизайн технологийн асуудлаас хэрэгцээг илрүүлж, учир шалтгааныг хэлэлцэх, эргэцүүлэн бодож зорилгоо тодорхойлох, анхны санаа гаргах	- Сургууль болон орон нутгийн хүрээн дэх дизайн технологийн асуудлыг судалж хэрэгцээг илрүүлэх, тэдгээрийн учир шалтгааныг тайлбарлах, үндэслэлтэйгээр зорилгоо тодорхойлж, анхны санааг хувилбартайгаар гаргах
Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх	- Асуудлыг шийдвэрлэхдээ шаардлагатай мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх - Эдлэл, бүтээгдэхүүний дизайнд хийсэн дүн шинжилгээний үр дүнг тэмдэглэл, бичвэр, зураг, хүснэгт, диаграм, шугаман графикаар илэрхийлэх	- Олон эх сурвалжаас зорилготойгоор мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх - Эдлэл, бүтээгдэхүүний дизайнд хийсэн дүн шинжилгээний үр дүнг тэмдэглэл, бичвэр, зураг, хүснэгт, диаграм, шугаман графикаар илэрхийлэхдээ МХТ ашиглах
Дизайны шинэ санаа, шийдэл гаргах	- Өмнөх мэдлэг ойлголт, судалгаандаа үндэслэн анхны санаагаа сайжруулж, дизайны шинэ шийдэл гаргах	- Өмнөх туршлага, судалгаа болон шинжлэх ухааны баримтад үндэслэн дизайны оновчтой шийдлүүдийг гаргах, тэдгээрээс сонголт хийх
Бүтээх, хөгжүүлэх	- Дизайны санаагаа хэрэгжүүлэхдээ материал, багаж хэрэглэгдэхүүнийг сонгон, ажлын технологи дараалыг төлөвлөх; - Эдлэлийн ажлын болон эсгүүрийн зураг зурах, технологи ажилбарыг зааврын дагуу гүйцэтгэх	- Дизайны санаа шийдлийг хэрэгжүүлэхдээ материал, багаж тоног төхөөрөмж, ажлын технологи дараалал болон бусад нөөцийг тусган төлөвлөх - Төлөвлөлтийн дагуу эдлэл, бүтээгдэхүүний ажлын зургийг дүрэм стандартын дагуу зурах, технологи ажилбарыг гүйцэтгэх
Үнэлэх, үр дүнгээ танилцуулах	- Баримт нотолгоонд үндэслэн дизайны санаа, үйл явц, шийдэлд үнэлэлт өгөх, үр дүнгээ танилцуулах	- Дизайны санаа, үйл явц, шийдлийг шалгуур боловсруулан үнэлэх, технологийн эерэг сөрөг нөлөөнд үнэлгээ өгөх, санал дэвшүүлэх

ХОЁР. АГУУЛГА

VI АНГИ

6.1. ДИЗАЙН, ЗУРАГ ЗҮЙ (А,Б групп)

6.1а. Хэрчим тойргийг тэнцүү хэсэгт хуваах аргаар геометр байгуулалт хийх

6.1б. Өгсөн эд зүйлсийн загварыг хоёр хэмжээст дүрсээр төлөвлөн зурах

6.1в. Чимэглэлийн зохиомжийг амьтан, ургамлын дүрс ашиглан бүтээх

6.1г. Өгсөн эд зүйлсийн онцлогийг судлах замаар хэлбэр, хэмжээ, өнгө, чимэглэлийг тодорхойлох

6.2. БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

А групп

6.2а. Хэрэглээний жишээн дээр энгийн болон чимэглэлийн гар оёдлын төрлийн тухай ойлголттой болох, хийх жижиг эдлэлийн хэрэгцээг тодорхойлох

6.2б. Ширхэглэгийг тайлбарлах, турших аргаар байгалийн, ургамлын, химийн гаралтай материалын хэрэглээг судлах, ялгаж таних, сонгож хэрэглэх

6.2в. Гар оёдлын багаж хэрэглэгдэхүүнийг зориулалтаар нь зөв сонгох, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлан ажиллах

6.2г. Оёх аргачлал, хэрэглээгээр нь энгийн болон чимэглэлийн гар оёдлын төрлийг ангиллах, жижиг эдлэл эсгэх, оёж, чимэглэх

6.2д. Хэрэглээний жишээн дээр уран зангилаа, шүрэн урлалын төрлийг мэдэх, зааварчилга, схем тэмдэглэгээ ашиглан хэлхэх, зангидах аргаар бүтээл хийж чимэглэх

6.2е. Хагас боловсруулсан бүтээгдэхүүнээр төрөл бүрийн хүйтэн зууш бэлтгэх

6.2ж. Хүнсний эрүүл ахуйн талаар жишээ гарган тайлбарлах

Б групп

6.2з. Модны төрөл, хэрэглээг ахуйн модон эдлэлийн жишээгээр тайлбарлах

6.2и. Модны өнгө, хээ зураглал, гялалзалт, нягт зэргийг харуулдах, зүлгэх өнгөлөх аргаар физик шинж чанарыг тодорхойлох

6.2к. Энгийн гар багаж ашиглан модыг хөндлөн тайрах, тууш зүсэх, харуулдах, холбох, зүлгэх чимэглэх аргаар тоглоом, эд зүйлс зохион бүтээх

6.2л. Аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг баримтлан гар багажаар ажиллаж байгаагаа харуулах

6.2м. Металлын төрөл, хэрэглээг ердийн хэрэгцээний зориулалттай эд зүйлс, гоёл чимэглэлийн зориулалттай эд зүйлсийн жишээгээр тайлбарлах

6.2н. Хуудсан металлыг хайчлах, нугалах, эмхэрдэх, зүлгэж өнгөлөх аргаар тоглоом, ахуйн зориулалттай эд зүйлс хийх

6.2о. Төмөр утсыг таслах, матах, мушгих, эрчлэх, чимэглэх аргаар тоглоом, эд зүйлс зохион бүтээх

6.3. ТЕХНИК (А, Б групп)

6.3а. Техникийн (унадаг дугуйны) хөгжлийн товч түүхийг зураг дүрслэл ашиглан тайлбарлах

6.3б. Техникийн эд ангийн бүтэц, холболтын төрлүүдийг жишээ авч дүрслэн тайлбарлах

6.3в. Энерги, хүчний эх үүсвэрийн төрөл, хэрэглээг жишээгээр тайлбарлах

6.3г. Хялбар хийцтэй хөдөлгөөнт бүтээл зохион бүтээх

VII АНГИ

7.1. ДИЗАЙН, ЗУРАГ ЗҮЙ (А,Б групп)

7.1а. Цэг, шулуун, хавтгайг 3 хэмжээст байдлаар зохиомжийн дэвсгэртэд тохируулан төлөвлөн зурах

7.1б. Өгсөн эд зүйлсийн загварыг дизайн шаардлагын дагуу төлөвлөн зурах, бүтээх

7.1в. Хэмжээ заах аргыг эд зүйлсийн зураг, дүрслэлд хэрэглэх

7.1г. Тойргийн нум, шулууныг дөлгөөн холболтын байгуулалтаар зурах

7.1д. Эд зүйлсийн тойм зургийг гараар баримжаалан зурах

7.1е. Дэлгээс байгуулах арга хэрэглэн геометр биетийн загвар бүтээх

7.2. БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

А групп

7.2а. Энгийн, сарж, сатин нэхээсний гадаад байдал, өнгө дотрын ялгаа, суналтыг ажиглан бүтцийг тодорхойлох

7.2б. Оёдлын багаж хэрэгслийг зориулалтаар нь хэрэглэх, бүртгэх, зориулалтын саванд хадгалах аргаар аюулгүй ажиллагааны дүрмийг (ААД) баримтлан ажиллахаа харуулах

7.2в. Энгийн ба чимэглэлийн гар оёдлын төрлүүдийг хослуулан жижиг эдлэл хийх

7.2г. Дэгээ зүүний сүлжмэлийн тойргоор сүлжих, хавтгай сүлжих аргаар, схемийн дагуу эдлэл хийх

7.2д. Амин дэмээр баялаг зууш, ундаа бэлтгэх, эрүүл, зөв хооллохын ашиг тусыг жишээгээр тайлбарлах

Б групп

7.2е. Модны бүтцийг хөндлөн ба дагуу огтлолоор тодорхойлох зохион бүтээх ажилдаа зөв сонгох

7.2ж. Брус банзны хээллэг байдлаар голч, шахагч голч ба шахагч огтлолыг тодорхойлох

7.2з. Гар ба энгийн цахилгаан багаж, туслах төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны дүрмийг (ААД) баримтлан хэрхэн ажиллахаа харуулах

7.2и. Брусыг харуулдах, тайрах, холбох, зүлгэж чимэглэх аргаар ахуйн зориулалттай эд зүйлс зохион бүтээх

7.2к. Гар ба суурь машинаар цилиндр биет боловсруулах

7.2л. Металлын технологийн шинж чанарыг нугалах, хугалах, хайчлах, хуурайдах, хөрөөдөх, хасуурдах аргаар тодорхойлох

7.2м. Хайчлах, мушгих, эрчлэх, нугалах, эмхэрдэх, зүлгэх, өнгөлөх аргаар хуудсан металл эдлэл зохион бүтээх

7.3. ТЕХНИК (А,Б групп)

7.3а. Техникийн (автомашины хөгжлийн түүх г.м.) хөгжлийн түүхийг дүрслэл ашиглан тайлбарлах

7.3б. Механик дамжуулгуудын бүтэц, эд анги, ажиллах зарчмыг хэрэглээгээр нь харьцуулах

7.3в. Электроникийн эд ангиудыг тэмдэг, тэмдэглэгээний дагуу угсрах

7.3г. Хялбар механизм, электроникийн энгийн хэлхээ ашигласан хялбар техникийн бүтээл зохион бүтээх

VIII АНГИ

8.1. ДИЗАЙН, ЗУРАГ ЗҮЙ /А,Б групп/

8.1а. Өгсөн юмсын биет загварыг төлөвлөн зурах, уран сайхны боловсруулалт хийх

8.1б. Эд зүйлсийн дизайн шийдлийг төлөвлөн зурах, дизайнд дүн шинжилгээ хийх,эдлэлийн загвар бүтээх

8.1в. Деталийг ортогональ проекцоор дүрслэх

8.1г. Өгсөн эдлэлийг ортогональ проекцоор төлөвлөн зурах

8.1д. Геометр биетийг аксонометр проекцоор дүрслэх

8.1е. Параболын муруйг F фокус цэгийн аргаар зурах, загварын зурагт хэрэглэх

8.2. БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

А групп

8.2а. Нэхмэл материалын үндсэн шинж чанарыг /физик, механик, технологийн/ суналт, үрчийлт, сэмрэлт, хэлбэрээ алдах, тоос татах байдал зэрэг шинж чанараар тодорхойлох, зохион бүтээх ажилдаа сонгох

8.2б. Машины энгийн оёдлын төрлүүдийг ашиглаж жижиг эдлэл хийх

8.2в. Шулуун ба наран юбканы эсгүүр байгуулах, загварчилгаа хийх

8.2г. Эдлэл хийхэд шаардлагатай материал, багаж хэрэгсэл болон технологи дараалыг төлөвлөх

8.2д. Технологийн төлөвлөлтийн дагуу юбка эсгэх, оёх, чимэглэх

8.2е. Хос зүүний сүлжмэлийн ар, өнгө сүлжих, хээ үүсгэн сүлжих аргаар, схемийн дагуу эдлэл хийх

8.2ж. Тодорхой зориулалтын ширээ засалтанд зориулсан зууш, ундаа амттан бэлтгэх

8.2з. Хооллох соёл, зарчмыг жишээн дээр тайлбарлах

Б групп

8.2и. Модны механик шинж чанарыг зорох, хугалах аргаар тодорхойлох, зохион бүтээх ажилдаа сонгох

8.2к. Амьтдаас санаа авах аргаар модон тоглоомын хэлбэрийн дизайны шийдэл гаргах

8.2л. Мод боловсруулах цахилгаан багаж хэрэгслийн бүтэц, хэрэглээ, ажиллах зарчмыг зураг, схем ашиглан тайлбарлах

8.2м. Зүсмэл модон материалыг тайрах, харуулдах, цүүцдэх, нүхлэх, зүлгэх, өнгөлөх аргаар модон тоглоом зохион бүтээх

8.2н. Зохион бүтээсэн модон тоглоомын жишээн дээр холболтын төрлийг тайлбарлах

8.2о. Нугалах, мушгих, таслах, матах аргаар металлын механик шинж чанарыг тодорхойлох, зохион бүтээх ажилдаа механик шинж чанарыг харгалзан үзэх

8.2ө. Ахуйн хэрэгцээнд ашигладаг хуванцрын жишээн дээр аль нь реактопластын ба термопластын хуванцар болохыг тодорхойлох, зохион бүтээх ажилдаа зөв сонгох

8.3. ТЕХНИК (А,Б групп)

8.3а. Техникийн хөгжил, зохион бүтээлтийн түүхийг (нисэх онгоцны хөгжлийн түүх г.м.) товч зураглал ашиглан тайлбарлах

8.3б. Механизмын бүтэц, ажиллах зарчмыг харьцуулах

8.3в. Электроникийн бүрдэл хэсгүүдийн төрөл ангилал, бүтэц, үүрэг зориулалт, ажиллах зарчмыг тодорхой жишээн дээр дүрслэн тайлбарлах

8.3г. Механик дамжуулгаар ажиллах, электроникийн энгийн хэлхээ ашигласан хялбар техникийн бүтээл зохион бүтээх

IX АНГИ

9.1. ДИЗАЙН, ЗУРАГ ЗҮЙ (А,Б групп)

9.1а. Өгсөн эд зүйлийн хэрэглээ, мөн чанар, онцлогийг тусган харуулах замаар барааны тэмдэгийн дизайн шийдэл хийх, өөрчлөх

9.1б. Эд зүйлсийн дизайн шийдлийг төлөвлөн зурах, дизайнд дүн шинжилгээ хийх, эдлэлийн загвар бүтээх

9.1в. Бүтээгдэхүүний загварын хэрэглээний шаардлагад дүн шинжилгээ хийх замаар шинэ загвар бүтээх

9.1г. Деталийг хавтгайгаар огтолж шилжүүлсэн, давхцуулсан дүрслэлийн аргаар деталийн ортогональ проекцод огтлол хийсэн байдлаар дүрслэх

9.1д. Детальд нүүрний, хажуугийн, хэвтээ байршилтай хавтгайгаар зүсэлт хийж ортогональ проекцод дүрслэх талс биет ба деталийг изометр проекцын тэнхлэг дээр 1/4 зүсэлтээр дүрслэх

9.1е. Өгсөн эдлэлд хэрэглэх холбоосын хэрэгцээг илрүүлж онцлогийг ялган таних

9.2. БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИ

А групп

9.2а. Цардах, хэлбэршүүлэх, наах аргуудаар байгалийн ба нийлмэл материалын шинж чанарыг өөрчлөх, зохион бүтээх ажилдаа хэрэглэх

9.2б. Оёдлын машины туслах төхөөрөмж ашиглан, төрөл бүрийн оёдлуудыг оёж гүйцэтгэх

9.2в. Уран зангилаа, зүймэл урлал, уран хатгамлын арга ашиглан эдлэл зохион бүтээх

9.2г. Монгол үндэсний хувцасны эсгүүрийг уламжлалт аргачлалаар байгуулах

9.2д. Уламжлалт аргаар монгол үндэсний хувцас эсгэх, оёх, материал, багаж, технологи дараалыг схем тэмдэглэгээ ашиглан төлөвлөж бичих

9.2е. Технологийн дараалал, зааврын дагуу монгол хувцас эсгэж, оёх, чимэглэх

9.2ж. Уламжлалт аргаар тараг, аарц, ааруул бэлтгэх

9.2з. Цагаан идээ боловсруулах уламжлалт ба орчин үеийн үйлдвэрлэлийн аргын ялгааг тодруулах

Б групп

9.2и. Баруун гараар хутгыг барьж, зүүн гараар хамгаалж түлхэх аргаар цоолбор ба бүтэн сийлбэр хийх

9.2к. Сийлбэрийн төрлөөс хамаарч, үндсэн ба туслах багажийг сонгох

9.2л. Тусгай зориулалтын багаж, тоног төхөөрөмжийг ААД-ийг баримтлан зааврын дагуу ажиллах

9.2м. Гар уран хөрөө, цахилгаан уран хөрөөг зөв арга барилаар ашигласнаар муруй шугаман гадаргуутай модон эд ангийг бүтээх

9.2н. Хатаах, хат хариулах, уяраах аргуудаар байгалийн ба нийлмэл материалын шинж чанарыг өөрчлөх, зохион бүтээх ажилдаа хэрэглэх

9.2о. Дархны урлалын арга, төрөл, зориулалтыг эдлэлийн жишээн дээр тайлбарлах

9.2ө. Хөөмлийн багажийн ажлын хэсгийн хэлбэрийг хөөмлийн технологийн жишээгээр тайлбарлах, бүтээл хийхдээ сонгож хэрэглэх

9.3. ТЕХНИК (А,Б групп)

9.3а. Техникийн хөгжил, зохион бүтээлтийн түүхээс (усан онгоцны хөгжлийн түүх г.м.) хөгжлийн гол хүчин зүйлийн гаргалгаа хийх

9.3б. Машины төрлийг зориулалтаар нь ангилж жишээгээр тайлбарлах

9.3в. Энгийн болон нийлмэл цахилгаан хэлхээ бүхий, хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх техникийн бүтээл зохион бүтээх

9.3г. Эд ангийн таних тэмдэг ашиглан технологийн машины бүдүүвч унших

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

- Дизайн технологи хичээлийн агуулгыг бүтээлч эрэлхийллийн арга барилын дараах үе шатуудаар хэрэгжүүлнэ.
    - Дизайн технологийн асуудал, хэрэгцээг тодорхойлох
    - Мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх
    - Дизайны шинэ санаа, шийдэл гаргах
    - Бүтээх, хөгжүүлэх
    - Үнэлэх, үр дүнгээ танилцуулах
- Дизайн технологийн сургалтын хөтөлбөр нь дизайн зураг зүй, боловсруулах технологи, техник гэсэн агуулгын 3 хүрээтэй бөгөөд агуулгын уялдаа холбоог хангах тохирсон материал ашиглалт, төлөвлөлтийг хийнэ. Өөрөөр хэлбэл хөтөлбөрийн агуулга, чадвар түүний уялдаа холбоог чухалчлан, нөгөө талаас орон нутаг, сургуулийн онцлогийг тусган хэрэгжүүлэхэд тохиромжтой сэдвийг сонгон төлөвлөнө.
- Төлөвлөсөн сэдвийн хүрээнд тухайн ангийн хөтөлбөрийн агуулгаар хэрэгжих чадварууд эзэмшигдсэн байхыг чухалчлан авч үзнэ. Тухайлбал: Дизайн, зураг зүй бүлгийн хүрээнд тухайн агуулга, эзэмших чадваруудад нийцсэн график бүтээл, Боловсруулах технологи бүлгийн хүрээнд технологид суурилсан бүтээл, Техник бүлгийн хүрээнд техникийн бүтээл байхаар сэдвийг сонгоно.
- Дизайн технологийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэхдээ тогтвортой хөгжлийн үзэл санаа, ойлголтыг багтаан судлах, төлөвлөлтдөө тусгасан байна.
- Дизайн технологийн сургалтын үйл ажиллагааны үр дүнгээ янз бүрийн хэлбэрээр тайлагнах, хичээлээс гадуурх сургалтын ажлын зорилготой уялдуулан зохион байгуулж болно.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

- Дизайн, технологи хичээл нь тусгай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж бүхий зориулалтын кабинетэд дэд бүлгээр зохион байгуулагдах онцлогтой юм. Иймд сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд сургалтын байр, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, материалын ашиглалт, осол аюулгүй ажиллах заах арга зүйг эрүүл аюулгүйн талаас заавал тусгах шаардлагатай. Мөн сурагчийн бие даасан үйлд тулгуурласан сургалтын үйл ажиллагаа явагддагтай холбоотойгоор багшаас сурагч нэг бүрт хүрч заавар өгч ажиллах хэрэгцээ бий болдог учир нэг удаагийн хичээллэх хугацааг дараалсан 2 цаг байхаар төлөвлөх шаардлагатай.
- Сурагчид нь хүйс харгалзахгүй нэг агуулгаар судлах ба нэхмэл материал боловсруулах технологи, мод, металл боловсруулах технологи гэсэн хэсгийг 2 дэд бүлгээр сонгож суралцана. Дизайн, технологийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах хэрэглэгдэхүүнээр зайлшгүй хангагдсан байх шаардлагатай. Үүнд:
    - Оёдол эсгүүрийн гар болон цахилгаан багаж хэрэгсэл,суурь машин
    - Мод боловсруулах гар болон цахилгаан багаж хэрэгсэл, суурь машин
    - Металл боловсруулах гар болон цахилгаан багаж хэрэгсэл, суурь машин
    - Хоол хүнс боловсруулах багаж, тоног төхөөрөмж

- Уламжлалт технологийн гар багаж хэрэгслүүд
- Цахилгаан электороникийн багц хэрэглэгдэхүүнүүд
- Зургийн болон тусгай програм хангамжуудаар хангагдсан компьютер, проектор, дэлгэц, хэвлэгч, хувилагч машин, сканнер гэх мэт
- Зурагт үзүүлэн, бүдүүвч, диаграмм
- Аюулгүй ажиллагааны зааварчилга
- Ажлын хувцас

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

А. Дизайн, техник, технологийн мэдлэг ойлголт, хэрэглээ

Б. Бүтээлч эрэлхийлэл хийх арга барил, бүтээх чадвар

В*. Дизайн технологийг судлах хүсэл сонирхол, хандлага

* Сурагчийн хандлагыг ажиглалт, ярилцлага зэрэг тохиромжтой аргаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Дизайн, техник, технологийн мэдлэг ойлголт, хэрэглээ	А1. Дизайн, зураг зүй, техник, технологийн тодорхойлолт, зарчим, онол, нэр томьёо, тэмдэг, тэмдэглэгээ А2. Бүтээгдэхүүний материал, түүний төрөл, сонголт материал боловсруулах арга барил, аюулгүй ажиллагааны зааварчилга А3. Зургийн багаж хэрэгсэл болон бүтээгдэхүүний боловсруулах багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт, хэрэглээ А4. Техник, технологийн хөгжил түүний хүчин зүйлийг олон талаас баримттайгаар авч үзэх байгаль орчинд аюулгүй технологийн хэрэглээ
Б. Бүтээлч эрэлхийлэл хийх арга барил, бүтээх чадвар	Б1. Ахуй амьдрал, нийгэм дэх дизайн технологийн асуудлыг олж илрүүлэн хэрэгцээг тодорхойлох Б2. Тодорхой санаагаа товч илэрхийлж, төлөвлөх Б3. Төлөвлөсөн санаагаа хэрэгжүүлэхтэй холбогдох мэдээ, мэдээлэл, баримт цуглуулж судлан шинжлэх Б4. Дизайны анхны санаагаа хөгжүүлж, оновчтой шийдэл гаргах Б5. Дизайны санаа шийдлийг хэрэгжүүлэх материал, багаж, технологийг төлөвлөлтдөө тусгах Б6. Төлөвлөлтийн дагуу загвар зургийг (зураг зүйн дүрэм стандартын дагуу) зурах Б7. Дизайны анхны санаагаа хөгжүүлэх Б8. Дизайны оновчтой шийдэл гаргах Б9. Дизайны санаа шийдлийг хэрэгжүүлэх төлөвлөлт хийх Б10. Технологи ажилбарыг төлөвлөлтийн дагуу гүйцэтгэх Б11. Технологи ажилбарын үед аюулгүй байдлыг ханган ажиллах Б12. Гүйцэтгэх явцад гарсан асуудлыг оновчтойгоор шийдвэрлэх Б13. Дизайны санаа, үйл явц, шийдэл, үр дүнгээ үнэлэх Б14. Байгаль орчин хүний аюулгүй байдлыг авч үзэн дүгнэлт хийж, санал дэвшүүлэх
В. Дизайн технологийг судлах хүсэл сонирхол, хандлага	В1. Монголын уламжлалт технологи, бүтээлээр бахархах, хайрлах эрмэлзэл В2. Ахуй амьдрал, нийгэмд чиглэсэн дизайн технологийн асуудлыг шийдэхэд өөрийн хувь нэмрээ оруулах хүсэл сонирхол В3. Дизайны шинэ санаа гаргах, хэрэгжүүлэхдээ уламжлалт технологиос тусгах эрмэлзэл В4. Байгаль орчинд аюулгүйн талаас авч үзэх хандлага В5. Хичээлийн оролцоо, хамтран ажиллах, идэвх санаачлага

- Дизайн, техник, технологийн мэдлэг, ойлголт, хэрэглээ гэсэн зорилтын хүрээнд дизайн технологийн суурь мэдлэг ойлголт, нэр томьёо, хууль зарчим, онолыг тайлбарлаж буй байдал, тэдгээрийг ашиглах, харилцах, ахуй амьдрал, нийгэмд чиглэсэн дизайн технологийн асуудлыг шийдвэрлэх явцдаа хэрэглэж буйг үнэлнэ. Ингэснээр сурагчын дизайн технологийн болон амьдралтай холбоотой бодит асуудалд шинжлэх ухаанчаар хандах хандлагыг нэмэгдүүлэх юм.
- Бүтээлч эрэлхийлэл хийх арга барил, бүтээх чадвар гэдгийг хүрээлэн буй орчны дизайн технологийн асуудлуудаас хэрэгцээг илрүүлэх, түүнийг шийдвэрлэх шинэ санаа гаргах, холбогдох мэдээлэл цуглуулж, судлах замаар санаагаа хөгжүүлэх, хэрэгжүүлэх төлөвлөлт хийх, төлөвлөлтийн дагуу бүтээх, үнэлэх, үр дүнгээ танилцуулах чадвар, үйл ажиллагааны цогц гэж ойлгоно. Уг зорилтын хүрээнд дизайн технологийн асуудлаа олж харах түүнийг шийдвэрлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үр дүнг мэдээллийн тохиромжтой хэлбэрээр илэрхийлж дүгнэлт хийх, хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаар эргэцүүлж сайжруулах шинэ санаа дэвшүүлж буй байдал зэргийг үнэлнэ.
- Дизайн технологийг судлах хүсэл сонирхол, хандлага гэдэгт ахуй амьдрал, нийгэмд чиглэсэн дизайн технологийн асуудлыг шийдэхэд өөрийн хувь нэмэр оруулах, хийж бүтээх хүсэл эрмэлзэл, дизайны шинэ санаа гаргах, хэрэгжүүлэхдээ уламжлалт технологиос тусгах, байгаль орчинд аюулгүйн талаас авч үзэх хандлагын илэрхийллийг үнэлнэ.

Дизайн технологийн сургалтын үнэлгээний зорилт нь хөтөлбөрийн зорилго, зорилттой нийцнэ. Үнэлгээ нь сургалтын үйл ажиллагааны явцад сурагчийн ахиц амжилт, ялгаатай байдал, хоцрогдож байгаа шалтгааныг илрүүлэх, сурагчдын суралцах идэвх, оролцоог дэмжих, үүний үр дүнд багшлах арга зүй, багшлахуйн үйл явц, хичээлийн төлөвлөлтийг сайжруулах, сурагчид юу сурч мэдснээ үнэлэх, дүгнэх, эргэцүүлэх, амжилтаа ахиулах сэдэл төрүүлэхэд чиглэсэн байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх чиглэлээр:

Дизайн технологийн сургалтаар сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг улирал, жилийн эцэст үнэлнэ. хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний зорилтыг илрүүлэх нийтлэг шалгуурыг үндэслэн үнэлнэ.

- Үнэлгээний зорилт 1-ийг зурах, загварчлах бичгийн ажил, тест, бүтээлийн гүйцэтгэлийн явц болон үр дүн, асуулт хариулт, хэлэлцүүлэг, мэтгэлцээнээр илрүүлэн үнэлж болно.
- Үнэлгээний зорилт 2-ыг багшийн ажиглалт, тэмдэглэл, сурагчийн ажлын хуудас, даалгаврын гүйцэтгэлийн явц, үр дүнг харуулсан тайланг үндэслэн үнэлж болно.
- Үнэлгээний зорилт 3-ыг багшийн ажиглалт тэмдэглэл, сурагчийн ажлын хуудас, даалгаврын гүйцэтгэлийн явц, үр дүн, өөрийн болон хамт олны сэтгэгдэл, эцэг эхийн ажиглалт, санал асуулгаар үнэлнэ.

4.3. Үнэлгээний жин

Сурагчдыг үнэлэх үр дүнгийн үнэлгээний даалгавар боловсруулахдаа үнэлгээний зорилтын эзлэх хувийг дараах хүснэгтэд үзүүлсэн байдлаар хуваарилах нь тохиромжтой.

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Дизайн, техник, технологийн мэдлэг ойлголт	40%
Б. Бүтээлч эрэлхийлэл хийх арга барил, бүтээх чадвар	60%

БИЕИЙН ТАМИР

“Биеийн тамир”-ын сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч: Л.Уртнасан Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш, Ph.D, профессор

Багийн гишүүд

Г. Одбаатар	Нийслэлийн Баянзүрх дүүргийн Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагч, магистр
Б.Бат-Отгон	Монгол Улсын Боловсролын их сургууль, УБТС-ийн багш, Ph.D
Б. Дамба	Баянгол дүүргийн Спорт хорооны дарга
А. Гантулга	Нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн
Ч. Батбаяр	Нийслэлийн 33 дугаар сургуулийн биеийн тамирын багш
Ц. Ууганжаргал	Нийслэлийн 5 дугаар сургуулийн биеийн тамирын багш
Д. Мэндбаяр	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйч

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Л.Уртнасан	Монгол Улсын Боловсролын их сургууль, БТС-ийн багш, Ph.D, профессор
Б.Бат-Отгон	Монгол Улсын Боловсролын их сургууль, БТС-ийн багш, Ph.D

Хянан тохиолдуулсан (2019)

Л.Уртнасан	Монгол Улсын Боловсролын их сургууль, БТС-ийн багш, Ph.D, профессор

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь бие бялдар, эрүүл мэндээ хамгаалан хөгжүүлэх арга барилтай, эрүүл чийрэг биетэй, үндэсний спортын өв соёлоо дээдлэн, олон улсын спортын хөгжлийг дэмждэг, амьдралын зөв дадал хэвшилтэй иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Спортын тодорхой төрлүүдийн нэр томьёо, ухагдахуун, өөрийн бие бялдрыг хөгжүүлэх арга барилын ойлголттой болох;

1.2.2. Спортын дасгалын техникийг эзэмшиж, ур чадвараа сайжруулахын зэрэгцээ хурд, хүч, тэсвэр, уян хатан, хөдөлгөөний эвсэл зэрэг бие бялдрын чадавхаа хөгжүүлэн, бие махбодоо чийрэгжүүлэх;

1.2.3. Хичээл болон спортын үйл ажиллагаагаар дамжуулан шударгаар өрсөлдөх, дүрэм журмыг мөрдөх, хариуцлагатай байх эрүүл харилцааг эрхэмлэж, үндэсний спортын уламжлалаар бахархах, биеийн тамирын дасгалаар тогтмол хичээллэх хүсэл эрмэлзэл, хэвшилтэй болох.

Биеийн тамирын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сурагч дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VII анги	IX анги
Мэдрэх, төсөөлөх	- Хөдөлгөөний үйлдлийг ажиглаж, дасгалын техникийн бүтэц, дараалыг төсөөлөх - Дасгалыг гүйцэтгэхэд бие, сэтгэлээ бэлтгэх - Өөрийн бие бялдрын хөгжил, эрүүл мэндийн хэрэгцээг багшийн тусламжтай тодорхойлох	- Дасгалын техникийн дараалыг шинжилж, үе шат (бэлтгэх, үндсэн, төгсгөл)-ыг ялган таньж, үүргийг ойлгох - Дасгалыг зөв гүйцэтгэхэд бие, сэтгэлээ бэлтгэсэн байхын чухлыг ойлгох - Өөрийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн шинэ хэрэгцээг бие даан тодорхойлох
Гүйцэтгэх, харуулах	- Дасгалын техникийг дараалын дагуу дуурайх ба бие даан гүйцэтгэх - Өөрийн бие бялдрын хөгжил, хэрэгцээнд тохирсон дасгалыг багшийн тусламжтай сонгох, гүйцэтгэж харуулах	- Өмнөх туршлагадаа суурилан багшийн зааврын дагуу дасгалын техникийн бэлтгэх, үндсэн, төгсгөлийн хөдөлгөөний уялдаа холбоог хангаж, бие даан гүйцэтгэх - Өөрийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн ахицыг дэмжсэн дасгалыг бие даан сонгох, бүтээлчээр давтах
Бүтээлчээр хөгжүүлэх	- Дасгалын хүч, хурд, далайцыг нэмэгдүүлэн гүйцэтгэж, түүндээ дасан зохицох - Хөдөлгөөний үйлдлийг 1-2 нэмэлт хөдөлгөөнөөр баяжуулж, өөрчлөн хувиргах - Өөрийн хөдөлгөөний үйлдэл, дасгал, тоглоомын үр дүнг хэлэлцэх, сайжруулан гүйцэтгэх	- Дасгалыг хүндрүүлсэн нөхцөлд, тохиромжтой хүч, хурд, далайцаар нь илүү чадварлаг гүйцэтгэх - Шинэ дасгал, тоглоом зохиох, нэмэлт хэрэглэгдэхүүн ашиглан, хувиргаж гүйцэтгэх - Дасгалын техникийн алдааг засах арга зам боловсруулж, хэрэгжүүлэх
Хэвших, илэрхийлэх	- Өдөр тутам өөрт тохирсон дасгал хийж хэвших, эзэмшсэн чадвараа ашиглан тоглох - Анги, сургуулийн биеийн тамирын арга хэмжээ, тэмцээн уралдаанд оролцох	- Өөрийн бие бялдрын шинэ хэрэгцээнд тохирсон дасгалыг тогтмол хийж хэвших - Анги, сургуулийн хэмжээний биеийн тамирын арга хэмжээ, тэмцээн уралдаанд оролцох, зохион байгуулах, удирдах

ХОЁР. АГУУЛГА

VI АНГИ

6.1. БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ

6.1а. Өөрийн бие бялдрын хөгжлөө хэмжих, үнэлэх

6.1б. Бие бялдрын чийрэгжилтээ хэмжих,үнэлэх

6.2. ГИМНАСТИК

6.2а. Спортын гимнастикийн хэрэглэлийг таньж тайлбарлах,акробатикийн хосоор өнхрөлт, гар дээр зогсолт, эвлүүлгийг гүйцэтгэх, бие биедээ туслан аюулгүй орчин бүрдүүлэх

6.2б. Спортын гимнастикийн чөлөөт хөдөлгөөний хувилбар гүйцэтгэх

6.2в. Өөрийн чадварыг бодитой тодорхойлж,гимнастикийн морь, ямаан дээгүүр харайж харуулах

6.2г. Уран сайхны гимнастикийн хэрэглэлийг таньж тайлбарлах, дээстэй дасгалаар хөдөлгөөний эвслээ хөгжүүлэх

6.3. ХӨНГӨН АТЛЕТИК

6.3а. Босоо гараанаас 60 м зайд дээд хурдаар гүйх, буухиалан гүйж тоглохдоо гүйлтийн техникээ хэрэглэх, буухианы үр дүнг шүүн тунгаах

6.3б. Халхалтыг давж гүйх техникээр 40 см өндөр халхалтыг даван 20 м гүйж харуулах

6.3в. Уртад “хөл нугалж” харайх техник задлалын хэсгүүд хоорондоо хэрхэн холбогдохыг тодорхойлох, 10-12 м гүйлтээс уртад “хөл нугалж” харайх техникийг гүйцэтгэх

6.3г. Хол зайд гүйхдээ бэрхшээлийг хэрхэн даван туулснаа өөрийн үгээр тодруулах, охид 1000 м, хөвгүүд 1200 м зайд жигд гүйх аргаар ерөнхий тэсвэрээ хөгжүүлэх

6.4. САГСАН БӨМБӨГ

6.4а. Сагсан бөмбөгийн үндсэн зогсолт, шилжилт, залалтын техникийг гүйцэтгэх

6.4б. 2-3 м зайнаас сагсан бөмбөгийг бие бие рүүгээ дамжуулах, өндөрт байрлуулсан бай руу шидэх техникийг гүйцэтгэх, тоглоомын дүрмийг биелүүлэх

6.5. ХӨЛ БӨМБӨГ

6.5а. Бөмбөгийг өшиглөх, тогтоох үеийн биеийн байрлал, хөлийн хөдөлгөөнийг сэргээн санаж, өнхөрч ба ойж ирсэн бөмбөгийг хөлийн улаар тогтоох, өшиглөх аргыг хэрэглэн үзүүлэх

6.5б. Цуврууулж ба сөөлжүүлж байрлуулсан тэмдэгтийг сүлжиж бөмбөг залах техникийг гүйцэтгэх

6.5в. Өнхөрч, ойж, нисэж ирсэн бөмбөгийг хоёр гараар барих техникийг гүйцэтгэх

6.5г. Өнхөрч, ойж, нисэж ирсэн бөмбөгийг дамжуулах, заасан чиглэл рүү буцааж болон хаалга руу өшиглөх аргуудыг хөл бөмбөг тоглохдоо хэрэглэх

6.6. ВОЛЕЙБОЛ

6.6а. Волейболын үндсэн зогсолт, шилжилтийг техникийн дагуу гүйцэтгэх

6.6б. Бөмбөгийг доороос, дээрээс дамжуулах техникийг 3 м хүртэл зайнаас гүйцэтгэх

6.7. Үндэсний спорт – хурдан морины уралдаан

6.7а. Хурдан морины уралдааны онцлогийг тайлбарлах

6.7б. Хурдан морины цол, уяач, унаач хүүхдийн талаар мэдээлэл цуглуулан боловсруулах, хэлэлцэх

VII АНГИ

7.1. БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ

7.1а. Өөрийн бие бялдрын хөгжлийг хэмжих, өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх

7.1б. Бие бялдрын чийрэгжилтээ хэмжих, ахиц өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх

7.2. ГИМНАСТИК

7.2а. Өмнөх ангид эзэмшсэн акробатикийн чадвараа нэгтгэж,гар дээр зогсолтоос өнхрөлт, цагариг эргэлтэй холбон гүйцэтгэх

7.2б. Хосоор ачааг зөөхдөө янз бүрийн аргыг ашиглах

7.2в. Цагариг, бөмбөгтэй янз бүрийн дасгалыг гүйцэтгэх

7.3. ХӨНГӨН АТЛЕТИК

7.3а. Тойрог ба шулуун замд 500-800 м зайд спорт алхаагаар алхаж ерөнхий тэсвэрээ хөгжүүлэх

7.3б. Хол зайд жигд гүйх, богино зайд давтан гүйх аргыг хэрэглэн, охид 1200 м, хөвгүүд 1500 м зайд алхахгүйгээр гүйж харуулах

7.3в. Нам гараанаас 60 м зайд дээд хурдаар гүйхдээ сурагч гүйх хугацаагаа тодорхойлон, өөртөө зорилт дэвшүүлэн хэрэгжүүлэх

7.3г. 50 см өндөр халхалтыг даван 25-30 м гүйхдээ халхалттай гүйлтийн техникийг хэрэглэх

7.3д. Уртын харайлтын техникийг зураг дээр тайлбарлах, урьдчилсан гүйлтийн 15-18 м зайнаас гүйж, 20 см өргөн вандангаас түлхэн уртад “хөл нугалж” харайх техникийг гүйцэтгэх

7.4. САГСАН БӨМБӨГ

7.4а. Чиглэлээ өөрчлөн бөмбөгийг хурдтай залж гүйх, гүйлтээс дамжуулах, залалтаас зогсолтыг гүйцэтгэх

7.4б. Хоёр алхамтаас бөмбөгийг цагаригт шидэлтийг оновчтой гүйцэтгэх

7.4в. “Мини сагсан бөмбөг”-ийг багаар хамтран тоглохдоо дүрмийг мөрдөж хэрэгжүүлэх

7.5. ХӨЛ БӨМБӨГ

7.5а. Бөмбөгийг залж гүйлтээс өшиглөх, цээжин дээр тогтоох, хөлөөр хуурах, хаалгач үсэрч бөмбөгийг хаах техникийг гүйцэтгэх

7.5б. Хөл бөмбөгийн дамжуулалтын энгийн тактикийг харуулсан зураглалыг ашиглах

7.5в. Хөлийн хүч, эвслээ хөгжүүлэхдээ бөмбөгийг 1 м өргөн зурвасаар болон аль болох хол өшиглөх дасгал, тоглоомыг ашиглах

7.5г. Жижиг талбайд хөл бөмбөг тоглохдоо футзаалны тэмцээний дүрэм, шүүгчийн заалтыг хэрэгжүүлэх

7.6. ВОЛЕЙБОЛ

7.6а. Волейболын бөмбөгийг 5-6 м зайнаас тор давуулахдаа доороос давуулах техникээр гүйцэтгэх

7.6б. Тор давж ирсэн бөмбөгийг хүлээн авахдаа үндсэн зогсолт, шилжилт, дамжуулалтын техникийг ашиглах

7.7. ҮНДЭСНИЙ СПОРТ – СУР ХАРВАА

7.7а. Сур харвааны төрөл, хэрэгсэл, насны ангилал, харвах зайг тайлбарлах

7.7б. Сур харвааны цол, харваачдын талаар мэдээлэл цуглуулан боловсруулах, хэлэлцэх

VIII АНГИ

8.1. БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ

8.1а. Нараар биеэчийрэгжүүлэх аргачлалыг тайлбарлах, зөвлөгөө өгөх, биеэ чийрэгжүүлэхдээ ашиглах

8.1б. Өөрийн бие бялдрын хөгжлийг хэмжиж, өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх

8.1в. Бие бялдрын чийрэгжилтээ хэмжих, ахиц өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх

8.1г. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтээ дээшлүүлэх дасгалыг сонгох, ачааллаа өөртөө тохируулан гүйцэтгэх

8.2. АЭРОБИК

8.2а. Аэробикийн үндсэн 7 алхалтыг хөгжмийн аянд гүйцэтгэх

8.2б. Аэробикийн үндсэн алхалтыг гарын ба бусад хөдөлгөөнтэй хослуулсан зохиомжит дасгалыг хөгжмийн аянд гүйцэтгэх

8.3. БҮЖИГ

8.3а. Бүжгийн ангиллыг тайлбарлах, биелгээний үндсэн зогсолт, их бие, хөл, гарын энгийн хөдөлгөөнтэй танилцаж ахуйн зан үйлийг хөгжмийн аянд биелж харуулах

8.3б. Их бие, хөл, гарын энгийн хөдөлгөөнтэй хип хоп бүжгийг хөгжмийн аянд дэглэн гүйцэтгэх

8.4. ХӨНГӨН АТЛЕТИК

8.4а. Шулуун ба тойрог замд спортын алхаагаар 800-1000 м зайд уралдаж алхах, 2000 м зайг гүйж туулахдаа жигд гүйх ба давтан гүйлтийн аргуудыг ашиглах

8.4б. Нам гараанаас 60-80 м хүртэл янз бүрийн зайд дээд хурдтай гүйж хурдаа хөгжүүлэх

8.4в. 4х60 м буухиад уралдаж гүйхдээ буухианы модыг доороос дамжуулах техникийг ашиглах

8.4г. Бүтэн гүйлтээс өндөрт “алхаж” харайх техникийг гүйцэтгэхдээ техник задлалын хэсгүүдийг тодорхойлох, аюулгүйн дүрмийг хэрэгжүүлэх, хөлийн түлхэлтийн хүчийг хөгжүүлэх

8.4д. Гүйлтээс жижиг бөмбөг шидэлтийн тэмцээнд оролцож, 150 г жинтэй жижиг бөмбөгийг хол шидэж харуулах

8.4е. 400-500 г жинтэй хүүхдийн жадыг байрнаас шидэх техникийг гүйцэтгэх

8.5. САГСАН БӨМБӨГ

8.5а. 3х3 сагсан бөмбөг тоглохдоо залалт, дамжуулалт, шидэлтийн техникээ ашиглах

8.5б. 3х3 сагсан бөмбөгийн тоглолтын дүрэм, шүүгчийн заалтыг хэрэгжүүлэх

8.6. ВОЛЕЙБОЛ

8.6а. Мини волейбол тоглохдоо дамжуулалт, доороос давуулалтын техникээ ашиглах

8.6б. Мини волейбол тоглохдоо дүрэм, шүүгчийн заалтыг хэрэгжүүлэх

8.7. ҮНДЭСНИЙ СПОРТ – БӨХИЙН БАРИЛДААН

8.7а. Үндэсний бөхийн гараа, дэвээ, шаваа, тахим авах, өгөх ёсны утга агуулгыг тайлбарлах

8.7б. Үндэсний бөхийн барилдааны засуулын үүргийг тодорхойлох, бөхчүүдийн цолны ялгааг таних

8.7в. Үндэсний бөхийн суйлах, хавирах, этэх мэхийг таних, гүйцэтгэх

IX АНГИ

9.1. БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ

9.1а. Усаар биеэчийрэгжүүлэх аргачлалыг тайлбарлах, биеэ чийрэгжүүлэх болон бусдад зөвлөгөө өгөхдөө ашиглах

9.1б. Өөрийн бие бялдрын хөгжлийг хэмжих, өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх

9.1в. Бие бялдрын чийрэгжилтээ хэмжих, ахиц өөрчлөлтөө тодорхойлох, үнэлэх

9.2. АЭРОБИК

9.2а. Аэробик гимнастикийн төрлүүдийг тайлбарлах, туслах алхалтуудыг үндсэн 7 алхалттай харьцуулан жишиж, хөгжмийн аянд гүйцэтгэх

9.2б. Аэробикийн туслах алхалтыг гарын ба бусад хөдөлгөөнтэй хослуулсан зохиомжит дасгалыг хөгжмийн аянд гүйцэтгэх

9.3. БҮЖИГ

9.3а. Цэнгээнт бүжгийн хосуудын байрлал, зогсолт, барилтыг хүмүүн төрөлхтөн бүжиг бүжиглэхдээ ашиглах, хөгжмийн аянд бүжиглэж харуулах

9.3б. Бүжгийн спортын үндсэн хөдөлгөөнүүд, Ча ча ча бүжгийн алхалтын техникийг гүйцэтгэх

9.4. ХӨНГӨН АТЛЕТИК

9.4а. Шулуун ба тойрог замд спортын алхаагаар 1000-1500 м зайд алхах, 8-10 мин гүйхдээ жигд гүйх ба давтан гүйлтийн аргуудыг ашиглах

9.4б. Нам гараанаас 80-100 м хүртэл янз бүрийн зайд дээд хурдтай гүйж хурдаа хөгжүүлэх

9.4в. 4х80 м буухиад уралдаж гүйхдээ буухианы модыг дээрээс дамжуулах техникийг ашиглах, багийн тактик боловсруулж хэрэгжүүлэх

9.4г. Бүтэн гүйлтээс өндөрт харайх амжилтаа ахиулах

9.4д. Хөнгөн атлетикийн гүйлт, харайлт, шидэлтийн төрлөөс өөрт тохирохыг сонгох, сонгосон төрлөөрөө сургуулийн хэмжээний тэмцээнд оролцох, амжилтаа ахиулах

9.4е. Хөнгөн атлетикийн тэмцээнд үзүүлсэн өөрийнхөө амжилтад дүгнэлт хийх, бусдынхаа амжилтад үнэлгээ өгөх

9.5. САГСАН БӨМБӨГ

9.5а. Чиглэлээ өөрчлөн бөмбөг залах, оновчтой дамжуулах, хоёр алхамтаас ба дунд, холын зайнаас бөмбөгийг цагирагт шидэх техникийг үр ашигтай гүйцэтгэж харуулах

9.5б. Залалт, дамжуулалт, шидэлт хосолсон цогц дасгалын хувилбарыг бүлгээрээ хамтран зохиох, хэрэгжүүлэх

9.5в. Бүтэн талбайд 5х5 тоглогчтой сагсан бөмбөг тоглохдоо шударгаар өрсөлдөх, дүрмийг мөрдөх, ялалт ба ялагдлыг хүлээн зөвшөөрөх, буруугаа хүлээх, сэтгэлийн хөдөлгөөнөө эерэгээр илэрхийлэх

9.6. ВОЛЕЙБОЛ

9.6а. Бөмбөгний нисэлтийн өндөрт тохируулан дээрээс ба доороос хүлээн авч дамжуулах техникийг үр дүнтэй гүйцэтгэх

9.6б. 2 м өндөр торон дээгүүр бөмбөгийг охид доороос, хөвгүүд дээрээс давуулах техникийг гүйцэтгэх

9.6в. Довтлох цохилтын техникийг гүйцэтгэх

9.6г. Волейбол тоглохдоо багийн энгийн тактикийг хамтран боловсруулах, шүүгчийн заалтыг хэрэгжүүлэх

9.7. ҮНДЭСНИЙ СПОРТ – ШАГАЙН ХАРВАА

9.7а. Шагайн харвааны хэрэглэгдэхүүн, харвах зайг ялган таних

9.7б. Үндэсний шагайн харвааны түүхэн хөгжлийг тоймлох

9.7в. Ойрхон зайнаас шагай харваж тоглохдоо харвааны техникийг ашиглах

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Биеийн тамирын хичээлээр сурагч бүрт өөрийн бие бялдар, эрүүл мэндээ хамгаалан хөгжүүлэх арга барил эзэмшүүлэхийг чухалчилна. Тиймээс сурагч биеийн тамирын хичээл дээр дасгалыг зөвхөн дуурайж давтах бус үр нөлөө, сайн сайхныг нь мэдэрч, дасгалыг гүйцэтгэх аргаа хамтран боловсруулж, үр дүнгээ харуулах замаар өөрийн бие бялдар, эрүүл мэндийн хэрэгцээгээ тодорхойлон, түүнд тохирсон дасгалаар тогтмол хичээллэн, хөдөлгөөний ур чадвараа дээшлүүлж, эрүүл мэндээ хамгаалах дадал хэвшил, өөрийгөө илэрхийлж чаддаг болоход анхаарна.

Хичээлийн жил бүрийн эхэнд сурагчийн бие бялдрын чийрэгжилтийн түвшинг “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн сорил”-оор тодорхойлж, чийрэгжилтийн түвшинд тохирсон цогц дасгалыг тогтмол хийлгэж хэвшүүлэх хэрэгтэй. Сурагчийн бие бялдрын хөгжлийн үзүүлэлтийг хичээлийн жил бүрийн төгсгөлд хэмжин, ахиц өөрчлөлтийг тодорхойлно.

Спорт тоглоомын төрлүүдийн техникийг эзэмших явцад тэдгээр техникийг ашигласан тоглоом тоглуулах замаар хэрэглээнд оруулах хэрэгтэй.

8, 9 дүгээр ангийн “Бүжиг”-ийн агуулгад тухайн орон нутгийн үндэстэн ястаны ардын бүжгээс оруулах боломж нээлттэй байна.

Хүүхдийн хурдыг хөгжүүлэхдээ уралдах болон тэмцээний аргыг илүү ашиглах, тэсвэрийн гүйлтэнд жигд гүйх ба гүйлтийн темп тогтоох аргуудыг, хүчийг хөгжүүлэхдээ өөрийн биеийн жингээр хийх дасгалаас гадна 5-8 кг хүртэл жинтэй ачаа хүндрүүлэгчтэй дасгалыг ашиглах боломжтой.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ сургууль бүр биеийн тамирын гадаа талбай, заалтай байхаас гадна хичээлийн явцад сурагч дасгалыг олон удаа давтсанаар хөдөлгөөний чадвар, дадалтай болох учраас судалж буй спортын төрөл тус бүрийн хэрэглэл, хэрэгслийг хангалттай тоогоор бэлтгэнэ. Түүнчлэн гарын доорх материалаар сургалтын хэрэглэгдэхүүн хийж ашиглана.

Спортын дасгалын техникийг видео бичлэгээр үзүүлэх нь илүү үр дүнтэйг харгалзан,ялангуяа бүжиг, аэробик, өндрийн харайлт зэрэг дасгалыг цахим хэрэглэгдэхүүнээр үзүүлж, хөгжмийн аянд давтах боломж олгохын зэрэгцээ шаардлагатай хөдөлгөөнийг удаашруулж, зогсоож ярилцана.

Биеийн тамирын сургалтад сурагчийн ажлын хуудас, багшийн хяналтын дэвтэр, дасгалын зураглал, тайлбар бичиг, дасгалын өөр хувилбар зохиох даалгавар, өөрийн болон сурагч

сурагчаа үнэлэх үнэлгээний хуудас зэргийг шинээр боловсруулж хэрэглэнэ.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

А. Мэдлэг ойлголт

Б. Мэдлэгээ хэрэглэх чадвар

В*. Хандлага

* Сурагчийн хандлагыг багшийн ажиглалт ба ярилцлагаар үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Мэдлэг ойлголт	А1. Дасгалыг зөв нэрлэж хэрэглэх, ухагдахууныг тайлбарлах, дасгалын зураг дүрслэл А2. Судалж буй спортын дасгалын гүйцэтгэлийн техник ба гарч болзошгүй алдаа А3. Судалж буй спортын төрлийн тэмцээний дүрэм А4. Бие бялдрын хөгжил, чийрэгжилтээ тодорхойлох арга
Б.Мэдлэгээ хэрэглэх чадвар	Б1. Бие бялдрын хөгжлөө хэмжиж, ахиц өөрчлөлтөө тодорхойлон, өөрийн үнэлгээ өгөх, тайлбарлах Б2. Өөрийн бие бялдрын хэрэгцээнд тохируулан дасгалыг сонгох, сонгосон дасгалаа зөв гүйцэтгэх Б3. Судалж буй спортын төрлийн техникийг гүйцэтгэх Б4. Хүч, хурд, тэсвэр, хөдөлгөөний эвсэл, уян хатан, тэсвэрийн үзүүлэлт ахиулах
В*. Хандлага	В1. Төрөл бүрийн дасгалыг хичээн хийж, илүү зөв гүйцэтгэхийн төлөө зүтгэл В2. Спортоор хичээллэх хүсэл сонирхол В3. Биеийн тамирын хичээл, хичээлээс гадуурх үйл ажиллагааны оролцоо, идэвх В4. Хожих, хожигдох үед сэтгэлийн хөдөлгөөний илэрхийлэл

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
А. Мэдлэг, ойлголтыг үнэлэх даалгавар	30%
Б. Мэдлэгээ хэрэглэх чадварыг үнэлэх даалгавар	70%

ГАДААД ХЭЛ

“Гадаад хэл”-ний сургалтын цөм хөтөлбөр (2015)

Багийн ахлагч: Н.Мира Монголын англи хэлний багш нарын холбооны тэргүүн, Ph.D,

Англи хэл

Б.Батчимэг	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан
Р.Ариунаа	Нийслэлийн 84 дүгээр сургуулийн англи хэлний багш
И.Сайнгэрэл	Нийслэлийн “Шинэ Эрин” сургуулийн сургалтын менежер
Д.Бадамгарав	Монгол Улсын Боловсролын их сургууль, ГХС-ийн англи хэлний арга зүйн тэнхимийн багш
Д.Сарнай	Нийслэлийн 24 дүгээр сургуулийн англи хэлний багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Н.Мира	МАХБХ-ны тэргүүн, Ph.D, дэд профессор,
Б.Батчимэг	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан магистр,
Р.Ариунаа	Нийслэлийн 84-р дунд сургуулийн англи хэлний багш магистр

Хянан тохиолдуулсан (2019)

Б.Дэчмаа	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан магистр

Орос хэл

П. Тунгалаг	Азийн хөгжлийн банкны “Боловсролын салбарын шинэчлэл” төслийн зөвлөх, багийн ахлагч
Т.Төрбат	Хүмүүнлэгийн ухааны их сургууль, ОУХ-ны дээд сургуулийн захирал, профессор
И. Мяндас	Нийслэлийн 2 дугаар сургуулийн орос хэлний багш
Ц.Сэрээнэн	Монгол Улсын Боловсролын их сургууль, орос хэлний тэнхимийн эрхлэгч, Ph.D
У.Хонгорзул	Нийслэлийн 115 дугаар сургуулийн орос хэлний багш

Сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулсан ажлын хэсэг (2019)

Ц.Сэрээнэн	МУБИС-ийн орос хэлний тэнхимийн багш, Ph.D, дэд профессор,
И.Мяндас	Нийслэлийн 2-р дунд сургуулийн орос хэлний багш, магистр, зөвлөх багш,
У.Хонгорзул	Нийслэлийн 115-р дунд сургуулийн орос хэлний багш

Хянан тохиолдуулсан (2019)

Б.Дэчмаа	Боловсролын хүрээлэн, эрдэм шинжилгээний ажилтан магистр

НЭГ. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

1.1. Зорилго

Сурагч нь гадаад хэлээр өдөр тутмын амьдрал, ахуй, нийгэм, соёлын харилцааны хүрээнд ойлгодог, харилцан ярилцдаг, бусад үндэстний хэл, соёлыг хүндэтгэдэг, гадаад хэл эзэмших хүсэл эрмэлзэлтэй иргэн болж төлөвшинө.

1.2. Зорилт

1.2.1. Гадаад хэлээр тодорхой сэдвийн хүрээнд мэдээлэл хүлээн авах, боловсруулах, илэрхийлэх арга барилд суралцах;

1.2.2. Гадаад хэлээр тодорхой сэдвийн хүрээнд зөв сонсох, ярих, унших, бичих, харилцах чадвар эзэмших;

1.2.3. Гадаад хэл сурахын ач холбогдлыг мэдэрч, улмаар гадаад хэл сурах хүсэл эрмэлзэлтэй болох;

1.2.4. Олон үндэстний хэл, соёл болон эх хэл, соёлыг хүндэтгэдэг болно.

Англи хэлний сургалтын хөтөлбөрийг Европын холбооны нэгдсэн хүрээний англи хэлний Low A1- Low A2 түвшинг баримжаалан боловсруулсан тул VI-VII, VIII-IX ангид сурагчид мэдээлэлтэй ажиллах арга барилд суралцаж, дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VI-VII анги	VIII-IX анги
	Low A1- Mid A1	High A1- Low A2
Мэдээлэл хүлээн авах	- Анхаарал төвлөрүүлэх - Түлхүүр үг ашиглан энгийн эхийн гол ба туслах санааг таамаглах - Түлхүүр үг тэмдэглэх	- Зорилготой сонсох, уншихад анхаарлаа төвлөрүүлэх - Түлхүүр санааг тэмдэглэх - Түлхүүр өгүүлбэр ашиглан эхийн бүтэц зохион байгуулалтыг таних
Мэдээлэл боловсруулах, хөгжүүлэх	- Ажиглах, харьцуулах - Хэрэгцээт мэдээллийн талаар эрэл хайгуул хийх - Аливаа юмс үзэгдэл, үйл явдлын дэс дараалыг олох - Хам сэдвийн хүрээнд энгийн мэдлэг бүтээх - Мэдээллийг ялгах, ангилах, хэрэглэх - Тулгуур дохио болон загвар ашиглах - Үгийн нөөц баяжуулан тогтоох арга эзэмших - Ярих, бичих зүйлээ төлөвлөх, бичих	- Ажиглах, унших, загварчлах - Хэрэгцээт мэдээллийн эрэл хайгуул хийж, дүн шинжилгээ хийх - Аливаа юмс үзэгдэл, үйл явдлын уялдаа холбоо, учир шалтгааныг олох - Хам сэдвийн хүрээнд хэлний мэдлэг бүтээх, мэдээллийн төрөл бүрийн эх сурвалж хэрэглэх - Үгийн нөөц, үгийн олон утгыг ялган таних арга эзэмших, хэрэглэх - Ярих, бичих зүйлээ төлөвлөх, бичих, засан сайжруулах
Илэрхийлэх, хуваалцах	- Энгийн өгүүлбэрийн бүтцийг хэрэглэх, - Энгийн өгүүлбэрт холбоос хэрэглэн санаагаа хэрэглэх - Хэлний бус харилцааны хэрэглүүрийг ашиглах - Хосоор, багаар хялбар даалгавар гүйцэтгэх - Энгийн мэдээлэл солилцон харилцах, - Өөрийн ахицыг үнэлэх	- Энгийн болон нийлмэл өгүүлбэрийн бүтцийг хэрэглэх - Нийлмэл өгүүлбэрт холбоос хэрэглэн санаагаа зөв илэрхийлэх - Хэлний болон хэлний бус харилцааны хэрэглүүрийг ашиглах - Асуудлыг дэвшүүлэх, шийдвэрлэх - Хосоор, багаар бүтээлч даалгавар гүйцэтгэх - Дэлгэрэнгүй мэдээлэл солилцон харилцах - Өөрийн болон хамтын ахицыг үнэлэх

Орос хэлний сургалтын хөтөлбөрийг Европын Холбооны орос хэлийг судлах нэгдсэн стандарт болох ТРКИ (TOREL – Test of Russian as a Foreign Language)-ийн А1 / А1+ буюу анхан шатны түвшин (элементарный уровень)-г баримжаалан боловсруулсан тул сурагчид мэдээлэлтэй ажиллах арга барилд суралцаж, дараах чадварыг эзэмшинэ.

Чадвар	VII анги	VIII анги	IX анги
	ТРКИ –ийн А1 / А1+		
Мэдээлэл хүлээн авах	- Анхаарал төвлөрүүлэх - Түлхүүр үгийн ялган таних - Түлхүүр үгэнд тулгуурлан энгийн эхийн гол санааг ойлгох	- Хэрэгцээт мэдээлэл авахдаа анхаарлаа төвлөрүүлэ - Түлхүүр-загвар өгүүлбэрийг ялган таних - Түлхүүр үг, өгүүлбэрт тулгуурлан эхийн бүтцийг тодорхойлох	- Зорилготой сонсох, уншихад анхаарлаа төвлөрүүлэх - Түлхүүр санааг олох, - Түлхүүр өгүүлбэрт тулгуурлан эхийн гол ба туслах санааг ойлгох
Мэдээлэл боловсруулах, хөгжүүлэх	- Ажиглах, харьцуулах, - Загварын дагуу хэрэгцээт мэдээллийн талаар эрэл хайгуул хийх - Аливаа юмс үзэгдэл, үйл явдлын дэс дараалыг олох - Хам сэдвийн хүрээнд энгийн мэдлэг бүтээх - Мэдээллийг загварын дагуу танил нөхцөлд хэрэглэх - Хялбаршуулсан эхийг түлхүүр үгийн тусламжтайгаар уншиж ойлгох - Үг тогтоох, үгийн нөөцөө нэмэгдүүлэх арга барил эзэмших	- Ажиглах, харьцуулах, загварчлах - Хэрэгцээт мэдээллийн талаар эрэл хайгуул хийж, задлан шинжлэх - Аливаа юмс үзэгдэл, үйл явдлын уялдаа холбоог олох - Мэдээллийг ялгах, ангилах, хэрэглэх - Хам сэдвийн хүрээнд эрэл хайгуул хийж, мэдээллийг ангилах, задлан шинжлэх, - Хэл зүйн мэдлэгт тулгуурлан үгийн санг баяжуулах	- Ажиглах, харьцуулан жиших, задлан шинжлэх - Хэрэгцээт мэдээллийн талаар эрэл хайгуул хийж, нэгтгэн дүгнэх - Аливаа юмс үзэгдэл, үйл явдлын уялдаа холбоог олох - Мэдээллийн төрөл бүрийн эх сурвалж хэрэглэх - Хам сэдвийн хүрээнд эрэл хайгуул хийж, хэлний мэдлэгээ ашиглан мэдээллийг боловсруулах - Хам сэдвийн хүрээнд үгийн нөөц, үгийн олон утгыг ялган таних
Илэрхийлэх, хуваалцах	- Загварын дагуу энгийн өгүүлбэр зохиох - Хэлний бус харилцааны хэрэглүүрийг ашиглах - Сурах үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хосоор, багаар энгийн даалгавар хийж гүйцэтгэх, - Өөрийн үйл ажиллагааны ахицыг үнэлэх	- Энгийн болон нийлмэл өгүүлбэрийн бүтцийг хэрэглэх - Нийлмэл өгүүлбэрт холбоос хэрэглэн санаагаа зөв илэрхийлэх - Хэлний болон хэлний бус харилцааны хэрэглүүрийг ашиглах - Асуудлыг дэвшүүлэх, шийдвэрлэх - Хосоор, багаар бүтээлч даалгавар гүйцэтгэх - Дэлгэрэнгүй мэдээлэл солилцон харилцах - Өөрийн болон хамтын ахицыг үнэлэх	- Загварын дагуу хавсарсан нийлмэл өгүүлбэр зохиох - Хам сэдвийн хүрээнд хэлний ба хэлний бус харилцааны хэрэглүүрийг оновчтой ашиглах - Сурах үйл ажиллагаанд идэвхи зүтгэл, санаачлагатай оролцож, хамтран суралцах - Өөрийн болон хамтын үйл ажиллагааны ахицыг үнэлэх

ХОЁР. АГУУЛГА

Гадаад хэлний сургалтын агуулгын үндсэн хүрээг тодорхойлохдоо хэлэхүйн үйл ажиллагааны үндсэн чадваруудад суурилан ангиас ангид, энгийнээс нарийнд, хөнгөнөөс хүндэд шилжих замаар гүнзгийрүүлэн хэлний хэрэглээг (үгийн сан, хэлзүйн мэдлэг) чухалчлан үзсэн болно.

АНГЛИ ХЭЛ

VI АНГИ

СОНСОЖ ОЙЛГОХ (LOW A1)

6.L1. Ангид хэрэглэх богино, энгийн зааварчилгааг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

6.L2. Хувийн мэдээллийг лавлах асуултыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэггүйгээр сонсож ойлгох

6.L3. Энгийн асуултыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэггүйгээр сонсож ойлгох

6.L4. Өгүүлэгчийн энгийн ярианаас гол санааг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

6.L5. Өгүүлэгчийн энгийн ярианаас туслах санааг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

6.L6. Энгийн ярианаас хам сэдвийн агуулга, утгыг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэгтэйгээр таамаглах

6.L7. Богино хэмжээний хүүрнэлийг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

6.L8. Энгийн үгийн утгыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд сонсож ойлгох

6.L9. Богино дуу болон хэмнэлийг сонсож ойлгох

ЯРИХ /LOW A1/

6.S1. Хувийн мэдээллийг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд энгийн хэлбэрээр илэрхийлэх

6.S2. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд хувийн мэдээллийн талаар асуулт асуух

6.S3. Одоо болон өнгөрсөн үйл явдлыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дүрслэн ярих

6.S4. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээн дэх үгсийн сангийн энгийн үгээр ярих

6.S5. Өгүүлбэрийн түвшинд эд юмс, хүнийг товч, тодорхой дүрслэх

6.S6. Хос, бүлэг, ангиар ажиллахад тодорхой сэдвийн өргөн хүрээнд тохиромжтой үг, хэллэг, өгүүлбэрийг ашиглах

6.S7. Үндсэн, товч мэдээллийн талаар тодорхой сэдвийн өргөн хүрээнд харилцан ярилцах

6.S8. Богино үйл явдал, үлгэр, түүхтэй холбогдуулан тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд ярих

УНШИЖ ОЙЛГОХ (LOW A1)

6.R1. Эх дэх үгийг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэйгээр зөв дуудах, ялгах, таних

Англи хэлний цагаан толгойг /дармал үсгийг/ таних

6.R2. Сургалтын үйл ажиллагааны танил зааварчилгааг дэмжлэгтэйгээр унших, гүйцэтгэх

6.R3. Баримтын ба баримтын бус маш богино, энгийн эхийг дэмжлэгтэйгээр, сонирхон уншиж эхлэх

6.R4. Хам сэдвээс баримт мэдээллийг ашиглан, маш богино, энгийн эхийн гол санааг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд уншиж ойлгох

6.R5. Маш богино, энгийн эхийн зарим туслах санааг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэйгээр уншиж ойлгох

6.R6. Тодорхой сэдвээр хязгаарлагдмал хүрээнд маш богино, энгийн эхийн утгыг ойлгох

6.R7. Энгийн богино өгүүлбэрийн утгыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд уншиж ойлгох

6.R8. Өргөн хэрэглээний толь бичгийг бага зэргийн дэмжлэгтэйгээр ашиглах

БИЧИХ (LOW A1)

6.W1. Богино өгүүлбэрийг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэйгээр бичих, төлөвлөх, хянах

6.W2. Хувийн үндсэн мэдээллийн талаарх богино өгүүлбэрийг дэмжлэгтэйгээр бичих

6.W3. Танил зааварчилгыг үе тэнгийнхэндээ зориулж дэмжлэгтэй бичих

6.W4. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд бичгийн ажилд үсэг холбож бичих

6.W5. Зэрэгцүүлэн холбох холбоосыг ашиглан үг болон хэллэгийг дэмжлэгтэйгээр холбох

6.W6. Хүн, газар орны оноосон нэр бүхий богино өгүүлбэрийг багшийн зааварчилгын дагуу бичихдээ том, жижиг үсгийг хэрэглэх

6.W7. Өндөр давтамж бүхий танил үгсийн дийлэнхийг багшийн зааварчилгын дагуу зөв үсэглэн бичих

6.W8. Богино, танил өгүүлбэрүүдийг бичихдээ багшийн зааварчилгын дагуу цэг, таслал, асуултын тэмдгийг хэрэглэх

ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ (LOW A1)

6.UE1. Use singular nouns, plural nouns – including some common irregular plural forms – and uncountable nouns, genitive ‘s/ s’ to name and label things

6.UE2. Use numbers 1 – 100 to count

6.UE3. Use adjectives, including possessive adjectives, on a limited range of familiar topics to give personal information and to describe things

Use common comparative and superlative adjectives to give personal information and to describe things

6.UE4. Use determiners a, the, some, any , this, these, that to refer to familiar objects

6.UE5. Use who what and where, how many to ask questions on familiar topics Impersonal you in the question How do you spell that?

6.UE6. Use demonstrative pronouns this, these, that, those and object pronoun one in short statements and responses

6.UE7. Use there is / are to make short statements and descriptions

Use Have you... [ever]…been? to talk about experiences

6.UE8. Use imperative forms [positive and negative] to give short instructions

6.UE9. Use common simple present forms, including short answer forms and contractions, to give personal information

Use common past simple forms [regular and irregular] to describe actions and narrate simple events including short answer forms and contractions

6.UE10. Use common present continuous forms, including short answers and contractions, to talk about what is happening now on personal and familiar topics

Use –ing forms Swimming , Spelling … as nouns to describe familiar and classroom activities

6.UE11. Use personal subject and object pronouns, including possessive pronouns mine, yours to give basic personal information and describe things

6.UE12. Use prepositions of location, position and direction: at, behind, between, in, in front of, near, next to, on, to

Use prepositions of time : on, in at to talk about days and times

Use with to indicate accompaniment and instrument and for to indicate recipient on personal and familiar topics

6.UE13. Use can to make requests and ask permission and use appropriate responses here you are OK

Use must to express obligation

Use have + object + infinitive to talk about obligations

Use What/How about + noun / -ing to make suggestions

6.UE14. Use adverbs of time and place now today over there to indicate when and where

Use common –ly adverbs to describe actions

Use the adverb too to add information

6.UE15. Use *'Would you like', 'Would you like to'* for inviting and using appropriate responses yes please , no thanks

Use declarative what [a/an] + adjective + noun to show feelings

6.UE16. Use conjunctions and or but to link words and phrases

6.UE17. Use when clauses to describe simple present and past actions on personal and familiar topics

Use So do I to give short answers

VII АНГИ

СОНСОЖ ОЙЛГОХ (MID A1)

7.L1. Ангид хэрэглэх зааварчилгааны энгийн дэс дараалыг дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

7.L2. Хувийн мэдээллийг лавлах энгийн асуултыг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэггүйгээр сонсож ойлгох

7.L3. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд асуултыг дэмжлэггүйгээр сонсож ойлгох

7.L4. Өгүүлэгчийн энгийн ярианаас гол санааг ерөнхий сэдвийн хүрээнд дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

7.L5. Өгүүлэгчийн энгийн ярианаас туслах санааг ерөнхий сэдвийн хүрээнд дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

7.L6. Энгийн ярианаас хам сэдвийн агуулга, утгыг ерөнхий сэдвийн хүрээнд дэмжлэгтэйгээр таамаглах

7.L7. Богино хэмжээний хүүрнэлийг ерөнхий сэдвийн хүрээнд дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

7.L8. Энгийн ярианаас өгүүлэгчийн санаа бодлыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэйгээр сонсож ойлгох

7.L9. Авиа нийцсэн үгсийг ялгаж ойлгох

ЯРИХ (MID A1)

7.S1. Тухайн хүний хувийн мэдээллийг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд өгүүлбэрийн түвшинд илэрхийлэх

7.S2. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд ерөнхий мэдээллийн талаар асуулт асуух

7.S3. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд өгүүлбэрийн түвшинд санаа бодлоо илэрхийлэх

7.S4. Тодорхой сэдвийн өргөн хүрээн дэх үгсийн сангийн үгээр ярих

7.S5. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд өгүүлбэрийн түвшинд холбоос ашиглан ярилцлага хийх

7.S6. Хос, бүлэг, ангиар ажиллахад энгийн хэллэг, өгүүлбэрийн түвшинд ойлгосноо илэрхийлэх

7.S7. Үндсэн, товч мэдээллийн талаар тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд харилцан ярианд давамгайлан оролцох

7.S8. Үйл явдал, үлгэр, түүхтэй холбогдуулан тодорхой сэдвээр өргөн хүрээнд ярих

УНШИЖ ОЙЛГОХ (MID A1)

7.R1. Эх дэх үгийг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэгтэйгээр зөв дуудах, ялгах, таних

7.R2. Сургалтын үйл ажиллагааны танил зааварчилгааг бага зэрэг дэмжлэгтэйгээр унших, гүйцэтгэх

7.R3. Баримтын ба баримтын бус богино, энгийн эхийг тодорхой сэдвээр хязгаарлагдмал хүрээнд дэмжлэгтэйгээр, сонирхон унших

7.R4. Хам сэдвээс баримт мэдээллийг ашиглан, богино, энгийн эхийн гол санааг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд ойлгох

7.R5. Богино, энгийн эхийн зарим туслах санааг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэгтэйгээр ойлгох

7.R6. Богино эхээс баримт мэдээ болон өгүүлэгчийн санаа хоёрын ялгааг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд уншиж таних

7.R7. Богино эхээс зохиогчийн хандлага, санаа бодлыг тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд таньж ойлгох

7.R8. Сургуулийн номын сан болон ангид зорилтот ном, хэвлэмэл материалыг дэмжлэгтэйгээр ашиглах

БИЧИХ (MID A1)

7.W1. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд өгүүлбэрийг дэмжлэгтэйгээр бичих, төлөвлөх, хянах

7.W2. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд уртавтар өгүүлбэрийг дэмжлэгтэйгээр бичих

7.W3. Хүн ба юмс, газар орны талаар богино өгүүлбэрүүдийг дэмжлэгтэйгээр бичих

7.W4. Тодорхой сэдвээр өргөн хүрээнд бичгийн ажилд үсэг холбож бичих

7.W5. Зэрэгцүүлэн холбох холбоосыг ашиглан өгүүлбэрийг бага зэргийн дэмжлэгтэйгээр холбох

7.W6. Том, жижиг үсгийг хэрэглэн хүн, газар орны оноосон нэр бүхий богино өгүүлбэрийг дэмжлэггүйгээр бичих

7.W7. Өндөр давтамж бүхий танил үгсийг багшийн зааварчилгын дагуу зөв үсэглэн бичих

7.W8. Өгүүлбэрийг цэг, таслал, асуулт, хашилт зэрэг тэмдэглэгээг ашиглан дэмжлэггүйгээр алдаагүй, зөв бичих

ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ (MID A1)

7.UE1. Use nouns as direct and indirect objects in describing events and actions on a limited range of general and curricular topics

7.UE2. Use numbers 1 – 100 to count , use basic quantifiers ‘many , much, not many, a lot of’ on a limited range of general and curricular topics

7.UE3. Use common comparative and superlative adjectives to give personal information and on an increasing range of general and curricular topics

7.UE4. Use determiners ‘a, the, some, any , this, these, that , those’ to give personal information and on a limited range of general and curricular topics

7.UE5. Use who what where how many how much to ask questions on a limited range of general and curricular topics.

Use why to ask for explanations.

Use when to ask when something happens/happened.

Use What is/was the weather like? Use What's the matter?

7.UE6. Use demonstrative pronouns to ask and answer basic questions on personal and familiar topics

7.UE7. Use I think... I know... to express basic opinions on a limited range of general and curricular topics.

Use simple perfect forms…[regular and irregular] to talk about experiences on a limited range of general and curricular topics

7.UE8. Use imperative forms with direct and indirect object forms to give a short sequence of instructions

7.UE9. Use simple present forms.

Use simple past regular and irregular forms to describe actions and narrate simple events on a limited range of general and curricular topics

7.UE10. Use present continuous forms to describe events and talk about what is happening now.

Use present continuous forms to talk about future arrangements on a limited range of general and curricular topics

7.UE11. Use direct and indirect object personal pronouns in descriptions of events and actions on a limited range of general and curricular topics

7.UE12. Use common prepositions of time on, in, at, after, before to state when things happen. Common prepositions of location, position and direction: at, above, below, behind, between, in, in front of, inside, near, next to, on, opposite, outside, to, under.

Use from [origin] with / without [inclusion].

Use be good at + n. Use go for + n on a limited range of general and curricular topics

7.UE13. Use could as a past form of can. Use have (got) to/had to express obligation. Use shall [interrogative] to make offers and will to ask about future intention on a limited range of general and curricular topics

7.UE14. Use common adverbs of frequency never, a lot.

Use adverbs of sequence first next then and direction left right.

Use common comparative and superlative adverbs to describe and compare things… more quickly…best on a limited range of general and curricular topics

7.UE15. Use common verbs followed by infinitive verb / verb + ing patterns. Begin to use infinitive of purpose.

Use want/ask someone to do something. Use be called + n on a limited range of general and curricular topics

7.UE16. Use conjunction because to give reasons on a limited range of general and curricular topics

7.UE17. Use defining relative clauses with which who where to give personal

information

VIII АНГИ

СОНСОЖ ОЙЛГОХ (HIGH A1)

8.L1. Ангид хэрэглэх нийлмэл зааварчилгааны дэс дараалыг дэмжлэгтэй сонсож ойлгох

8.L2. Хувийн мэдээллийг лавлах энгийн асуултыг танил ба танил бус сэдвийн хүрээнд дэмжлэггүй сонсож ойлгох

8.L3. Танил сэдвийн хүрээнд асуултыг дэмжлэггүй сонсож ойлгох

8.L4. Өгүүлэгчийн дэлгэрэнгүй ярианаас гол санааг ерөнхий сэдвийн хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох

8.L5. Өгүүлэгчийн товч ярианаас туслах санааг ерөнхий сэдвийн хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох

8.L6. Энгийн ярианаас хам сэдвийн агуулга, утгыг танил ба танил бус сэдвийн хүрээнд дэмжлэгтэй таамаглах

8.L7. Хүүрнэлийн дэлгэрэнгүй ориаг ерөнхий сэдвийн хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох

8.L8. Энгийн ярианаас өгүүлэгчийн санаа бодлыг тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэгтэй сонсож ойлгох

8.L9. Авиа нийцсэн болон давталттай үгсийг ялгаж ойлгох

ЯРИХ (HIGH A1)

8.S1. Тухайн хүний болон бусдын хувийн мэдээллийг тодорхой сэдвийн өргөн хүрээнд өгүүлбэрийн түвшинд илэрхийлэх

8.S2. Ерөнхий мэдээллийн талаар тодорхой сэдвийн өргөн хүрээнд асуулт асуух

8.S3. Өгүүлбэрийн түвшинд санаа бодлоо тодорхой сэдвийн өргөн хүрээнд илэрхийлэх

8.S4. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд төлөвлөөгүй санаа бодлоо өгүүлбэрийн түвшинд товч илэрхийлэх

8.S5. Өгүүлбэрийн түвшинд холбоос ашиглан тодорхой сэдвийн өргөн хүрээнд ярилцлага хийх

8.S6. Хос, бүлэг, ангиар ажиллахад өгүүлбэрийн түвшинд ойлгосноо илэрхийлэх

8.S7. Үндсэн мэдээллийн талаар танил сэдвийн хүрээнд харилцан ярианд оролцох

8.S8. Үйл явдал, үлгэр, түүхтэй холбогдуулан ерөнхий сэдвийн хүрээнд ярих

УНШИЖ ОЙЛГОХ (HIGH A1)

8.R1. Ерөнхий сэдвийн хүрээнд эхийн үгийг тодорхой дэмжлэгтэйгээр зөв дуудах, ялгах, таних

8.R2. Сургалтын үйл ажиллагааны танил зааварчилгааг бага зэргийн дэмжлэгтэй унших, гүйцэтгэх

8.R3. Баримтын ба баримтын бус богино эхийг танил ба танил бус сэдвийн хүрээнд тодорхой дэмжлэгтэй сонирхон унших

8.R4. Хам сэдвээс мэдээллийг ашиглан, богино, энгийн эхийн гол санааг тодорхой сэдвийн өргөн хүрээнд уншиж ойлгох

8.R5. Энгийн эхийн туслах санааг танил сэдвийн хүрээнд богино, бага зэрэг дэмжлэгтэй, эсвэл дэмжлэггүйгээр ойлгох

8.R6. Богино эхээс баримт мэдээ болон өгүүлэгчийн санаа хоёрын ялгааг ерөнхий сэдвийн хүрээнд таних

8.R7. Богино эхээс зохиогчийн хандлага, санаа бодлыг тодорхой сэдвийн өргөн хүрээнд таньж ойлгох

8.R8. Утгыг нягтлах, ойлголтоо бататгах зорилгоор танил сэдвийн хүрээнд хэвлэмэл болон цахим эх сурвалжийг тодорхой дэмжлэгтэйгээр ашиглах

БИЧИХ (HIGH A1)

8.W1. Ерөнхий сэдвийн хүрээнд эхийн түвшинд дэмжлэгтэйгээр бичих зүйлээ төлөвлөх, бичих, засварлах

8.W2. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд цогцолбор дах богино өгүүлбэрүүдийг дараалалтай, дэмжлэгтэй бичих

8.W3. Хүн ба юмс, газар орны талаар бодит болон зохиомжилсон дүрслэлийг дэмжлэгтэйгээр бичих

8.W4. Ерөнхий сэдвийн хүрээнд бичгийн ажилд үсэг холбон тодорхой хурдтайгаар бичиж сурах

8.W5. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд зэрэгцүүлэн холбох холбоосыг ашиглан өгүүлбэрийг бага зэргийн дэмжлэгтэйгээр холбон, логик дараалал бүхий цогцолбор бичих

8.W6. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд бичгийн төрлийн эхийг бага зэргийн дэмжлэгтэйгээр зохиомжлон бичих

8.W7. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд өндөр давтамж бүхий танил үгсийн ихэнхийг дэмжлэггүйгээр зөв үсэглэн бичих

8.W8. Тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд дэмжлэггүйгээр бичихдээ эхийн түвшинд цэг, таслал, асуулт, хашилт зэрэг тэмдэглэгээг зөв хэрэглэх

ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ (HIGH A1)

8.UE1. Use an increasing range of countable and uncountable nouns, including common noun phrases describing times and location, on an increasing range of general and curricular topics

8.UE2. Use an increasing range quantifiers many, much, a lot of, on an increasing range of general and curricular topics

8.UE3. Use an increasing range of comparative and superlative adjectives [both regular and irregular] on an increasing range of general and curricular topics

8.UE4. Use determiners including ‘any, each, every’ on an increasing range of general and curricular topics

8.UE5. Use questions including tag questions to seek agreement, and questions to clarify information What time/what else/next? on a limited range of general and curricular topics

8.UE6. Use basic personal and demonstrative pronouns and quantitative pronouns some, any, something, nothing anything on a range of general and curricular topics

8.UE7. Use simple perfect forms of common verbs to express what has happened [indefinite time] on a limited range of general and curricular topics

8.UE8. Use future forms will for predictions and be going to talk about already decided plans on a limited range of general and curricular topics

8.UE9. Use simple present forms and simple past regular and irregular forms to describe routines, habits, and states on an increasing range of general and curricular topics

8.UE10. Use present continuous forms to talk about present activities and with future meaning, use past continuous forms for background, on a limited range of general and curricular topics

8.UE11. Use be/look/sound/feel/taste/smell like. Use be made of. Make somebody/something+adj on a limited range of general and curricular topics.

8.UE12. Use a limited range of prepositions to talk about time and location.

Use preposition like to describe things and about to denote topic.

Use preposition of direction to, into, out of, from, towards phrases on a limited range of general and curricular topics

8.UE13. Use might may could to express possibility.

Use shall [for suggestions] on a limited range of general and curricular topics

8.UE14. Use an increasing range of common adverbs [both regular and irregular] simple and comparative forms and adverbs of frequency.

Use adverbs of indefinite time yet ever already always.

Use adverbs of definite time last week, yesterday on a range general and curricular topics

8.UE15. Use common verbs followed by infinitive verb /verb+ ing patterns.

Use infinitive of purpose on a limited range of general and curricular topics

8.UE16. Use conjunctions so, if, when, where, before, after to link parts of sentences on a limited range of general and curricular topics

8.UE17. Use if clauses (in zero conditionals).

Use where clauses.

Use before/after clauses (with past reference).

Use defining relative clauses with which who that where to give details on a limited range of general and curricular topics

IX АНГИ

СОНСОЖ ОЙЛГОХ (LOW A2)

9.L1. Ангид хэрэглэх нийлмэл, дэлгэрэнгүй зааварчилгааны дэс дараалыг бага зэргийн дэмжлэгтэй эсвэл дэмжлэггүй сонсож ойлгох

9.L2. Хувийн мэдээллийг лавлах асуултыг нийлмэл өгүүлбэрийн түвшинд сонсож ойлгох

9.L3. Асуултыг нийлмэл өгүүлбэрийн түвшинд ерөнхий сэдвийн хүрээнд бага зэрэг дэмжлэгтэй эсвэл дэмжлэггүй сонсож ойлгох

9.L4. Өгүүлэгчийн товч болон дэлгэрэнгүй ярианаас гол санааг ерөнхий сэдвийн хүрээнд бага зэрэг дэмжлэгтэй эсвэл дэмжлэггүй сонсож ойлгох

9.L5. Өгүүлэгчийн товч болон дэлгэрэнгүй ярианаас туслах санааг ерөнхий сэдвийн хүрээнд бага зэрэг дэмжлэгтэй эсвэл дэмжлэггүй сонсож ойлгох

9.L6. Товч болон дэлгэрэнгүй ярианаас хам сэдвийн утгыг ерөнхий сэдвийн хүрээнд бага зэрэг дэмжлэгтэй эсвэл дэмжлэггүй таамаглах

9.L7. Богино болон дэлгэрэнгүй хүүрнэлийг ерөнхий сэдвийн хүрээнд бага зэрэг дэмжлэгтэй эсвэл дэмжлэггүй сонсож ойлгох

9.L8. Энгийн болон дэлгэрэнгүй ярианаас өгүүлэгчийн хандлага, санаа бодлыг ерөнхий сэдвийн хүрээнд бага зэрэг дэмжлэгтэй эсвэл дэмжлэггүй сонсож ойлгох

9.L9. Авиа нийцсэн, аялга болон хэмнэлтэй үгсийг ялган таних

ЯРИХ (LOW A2)

9.S1. Тухайн хүний болон бусдын хувийн мэдээллийг танил ба танил бус сэдвийн хүрээнд харилцааны түвшинд илэрхийлэх

9.S2. Ерөнхий сэдвийн хүрээнд утга тодруулах асуулт асуух

9.S3. Ерөнхий сэдвийн хүрээнд харилцааны түвшинд санаа бодлоо илэрхийлэх

9.S4. Ерөнхий сэдвийн хүрээнд төлөвлөөгүй санаа бодлоо өгүүлбэр, харилцааны түвшинд тодорхой илэрхийлэх

9.S5. Тодорхой сэдвээр хязгаарлагдмал хүрээнд бусдын яриаг нэгтгэн дүгнэх

9.S6. Хос, бүлэг, ангиар ажиллахад өгүүлбэрээр харилцааны түвшинд бусдын хэлсэнд өөрийн санаа бодлоо илэрхийлэх

9.S7. Танил бус сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй мэдээллийн талаар харилцан ярианд оролцох

9.S8. Танил сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй үйл явдал, үлгэр, түүхтэй холбогдуулан ярих

УНШИЖ ОЙЛГОХ (LOW A2)

9.R1. Танил сэдвийн хүрээнд эхийн доторх үгийг дэмжлэггүйгээр зөв дуудах, ялгах, таних

9.R2. Сургалтын үйл ажиллагааны танил зааварчилгааг бие даан унших, гүйцэтгэх

9.R3. Ерөнхий сэдвийн хүрээнд баримтын ба баримтын бус богино эхийг дэмжлэггүйгээр сонирхон унших

9.R4. Ерөнхий сэдвийн хүрээнд хам сэдвээс баримт мэдээллийг ашиглан, богино, энгийн эхийн гол санааг ойлгох

9.R5. Танил бус сэдвийн хүрээнд богино, энгийн эхийн туслах санааг бага зэргийн дэмжлэгтэй, дэмжлэггүйгээр ойлгох

9.R6. Ерөнхий сэдвийн хүрээнд богино эхээс баримт мэдээ болон өгүүлэгчийн санаа хоёрын ялгааг таних

9.R7. Ерөнхий сэдвийн хүрээнд богино эхээс зохиогчийн хандлага, санаа бодлыг таньж ойлгох

9.R8. Утгыг нягтлах, ойлголтоо бататгах зорилгоор танил сэдвийн хүрээнд хэвлэмэл, цахим эх сурвалжийг дэмжлэггүйгээр ашиглах

БИЧИХ (LOW A2)

9.W1. Танил сэдвийн өргөн хүрээнд эхийн түвшинд дэмжлэгтэйгээр бичих зүйлээ төлөвлөх, бичих, засварлах

9.W2. Ерөнхий сэдвийн хүрээнд бодит, зохиомжлон дүрсэлсэн, өнгөрсөн үйл явдал, туршлагын талаар тодорхой дэмжлэгтэйгээр бичих

9.W3. Хувийн үзэл бодол, мэдрэмжээ тодорхой сэдвийн хязгаарлагдмал хүрээнд бага зэргийн дэмжлэгтэйгээр бичих

9.W4. Ерөнхий сэдвийн хүрээнд бичгийн бүх төрөлд үсэг холбон, хурдтайгаар бичиж сурах

9.W5. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд үндсэн холбоосыг ашиглан өгүүлбэрийг холбон, логик дараалал бүхий эхийг дэмжлэггүйгээр бичих

9.W6. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд эхийг дэмжлэггүйгээр зохиомжлон бичих

9.W7. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд өндөр давтамж бүхий танил үгсийн ихэнхийг дэмжлэггүйгээр зөв үсэглэн бичих

9.W8. Тодорхой сэдвийн өргөн хүрээнд дэмжлэггүйгээр бичихдээ эхийн түвшинд цэг, таслал, асуулт, хашилт зэрэг тэмдэглэгээг зөв хэрэглэх

ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ (LOW A2)

9.UE1. Use a limited range of abstract nouns and compound nouns. Use double genitive structures ‘a friend of theirs’ on an increasing range of general and curricular topics

9.UE2. Use a range of quantifiers and cardinal, ordinal numbers and fractions on a range of general and curricular topics

9.UE3. Use a range of participle adjectives and a growing range of adjectives in the correct order in front of nouns on a range general and curricular topics

9.UE4. Use a range of determiners including ‘neither, both’ on an increasing range of general and curricular topics

9.UE5. Use a range of questions including how far, how many times, what + noun on a range of general and curricular topics

9.UE6. Use a range of pronouns including relative pronouns who which that whom whose on a range of general and curricular topics

9.UE7. Use simple perfect forms to express [recent, indefinite and unfinished past] on a range of general and curricular topics

9.UE8. Use a growing range of future forms including be going to [predictions based on present evidence] and will for predictions on a range of general and curricular topics

9.UE9. Use an increasing range of active and passive simple present and past forms and used to/ didn't use to for past habits/states on a range of general and curricular topics

9.UE10. Use present continuous forms with present and future meaning and past continuous forms for background, parallel and interrupted past actions on an increasing range of general and curricular topics

9.UE11. Use simple forms of reported speech to report statements and commands on a range of general and curricular topics.

9.UE12. Use a growing range of prepositions preceding nouns and adjectives in prepositional phrases.

Use dependent prepositions following adjectives on a range of general and curricular topics

9.UE13. Use a growing range of modal forms including would [polite requests] could [polite requests] needn't [lack of necessity] should, ought to [obligation] on a range of general and curricular topics

9.UE14. Use a range of adverbs [simple and comparative forms] including adverbs of manner.

Use pre-verbal, post-verbal and end-position adverbs on a range general and curricular topics

9.UE15. Use the pattern verb + object + infinitive give/take/send/bring/show + direct/ indirect object.

Use some common prepositional verbs on a range of general and curricular topics

9.UE16. Use conjunctions while, until, as soon as in relating narratives and if /unless in conditional sentences on a range of general and curricular topics

9.UE17. Use if /unless in zero and first conditional clauses. Use a range of defining and non-defining relative clauses with which who that whose whom on a range of general and curricular topics

ОРОС ХЭЛ

VII АНГИ

СОНСОЖ ОЙЛГОХ

7.А1. Өргөлтөт ба өргөлтөт бус үеийн эгшиг, гийгүүлэгч авиаг ялган сонсох

7.А2. Үгийг сонсож, даган дуурияж хэлэх

7.А3. Хүүрнэх ба асуух аялгыг ялгаж сонсох

7.А4. Өгүүлбэр болон харилцан яриа бүхий бичлэгийг сонсож ойлгох (2-4 асуулт, хариулт)

7.А5. Харилцан ярианы явцад багш болон ярилцагчийг сонсож ойлгох

ЯРИХ

7.Г1. Хэлзүйн загвар ашиглан өгүүлбэр зохиох

7.Г2. Үзүүлэн таниулах материал болон харилцааны энгийн нөхцөлд тулгуурлан 2-4 өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх

7.Г3. Эд, юмсыг нэрлэх, тоочих, загвар ашиглан зураг болон эд зүйлсийг дүрслэх

7.Г4. Уншсан эхийн утгыг тодорхой ярих

7.Г5. Харилцан ярилцагчид хэн? юу? хаана? хаашаа? ямар? гэх мэт энгийн асуулт асуух, түүний асуултад хариулах

7.Г6. Хэл ярианы хэм хэмжээг баримтлан энгийн харилцан ярианд оролцох (танилцах, мэндчилгээ дэвшүүлэх, талархал илэрхийлэх, мэндлэх, хүндлэх г.м.)

7.Г7. Сургалт болон ахуйн сэдвийн хүрээнд загварын дагуу харилцан яриа өрнүүлэх

УНШИЖ ОЙЛГОХ

7.Ч1. Үзсэн хэл зүйн хэлбэр үг, хэллэг бүхий харилцан яриа, богино эхийг зөв дуудах зүйн дүрмийг баримтлан унших

7.Ч2. Өгүүлбэр, харилцан яриаг (дүрд хувирч) дуудаж унших

7.Ч3. Сургалтын хялбаршуулсан эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгох

7.Ч4. Уншсан эхийн агуулгыг тодорхойлох, асуултад хариулах

7.Ч5. Харилцан яриа унших, ижил төстэй яриа зохиох

7.Ч6. Эхийг уншиж, агуулгыг тодорхойлох;

7.Ч7. Толь бичиг болон бусад лавлах материалыг ашиглан шинэ үгийн утгыг тайлбарлах

БИЧИХ

7.П1. Зураг болон хэлзүйн загварыг ашиглан энгийн өгүүлбэр, харилцан яриа зохиох

7.П2. Загварын дагуу ижил төстэй дан (монолог) болон харилцан яриа зохиох

7.П3. Загварын дагуу үг, хэллэгийг цээжээр бичих

7.П4. Эхээс танил бус үгсийг түүн бичиж, загварын дагуу өгүүлбэр, харилцан яриа зохиох

ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ

7.ВР1. Буквы, звуки (гласные и согласные), слоги, словосочетание

7.ВР2. Ударение и ритмика

7.ВР3. Род, число имён существительных, основные значения падежей,

7.ВР4. Одушевлённые, неодушевлённые существительных

7.ВР5. Согласование прилагательных с сущ-ми

7.ВР6. Личные местоимения (формы I, II, III лица ед.ч и мн.ч.)

7.ВР7. Вопросительные местоимения (кто, что, какой, чей,сколько, как, где,когда)

7.ВР8. Указательное местоимение (это)

7.ВР9. Притяжательные местоимения (мой, твой, его, её)

7.ВР10.

7.ВР11. Количественные числительные (1-100)

7.ВР12. Порядковые числительные (1-12)

7.ВР13. Время глагола (Я играю на гитаре. Вчера было холодно. Завтра будет дождь.)

7.ВР14. Глагольное управление) (играть во что? идти куда? смотреть что?)

7.ВР15. Спряжение глагола

7.ВР16. Глаголы движения (идти, ходить, ехать, ездить, приехать)

7.ВР17.

7.ВР18. Возвратные глаголы (учиться, заниматься, умываться)

7.ВР19. Инфинитив (неопределённая форма)

7.ВР20. Предлоги места (у, из, в, на)

7.ВР21. Наречие времени (днём, вечером, зимой)

7.ВР22. Наречие (холодно, жарко, тепло)

7.ВР23. Простое предложение. Безличное предложение (Летом жарко.)

7.ВР24.

7.ВР25. Простое предложение с однородными членами (без союза)

VIII АНГИ

СОНСОЖ ОЙЛГОХ

8.А1. Үгийн өргөлтөт ба өргөлтөт бус үеийн эгшиг (балархай эгшиг), гийгүүлэгч авиаг ялган сонсох

8.А2. Үг, хэллэгийг сонсож, даган дуурияж хэлэх

8.А3. Хүүрнэх болон асуух өгүүлбэрийн аялгыг сонсож зөв дуудах

8.А4. Салангид өгүүлбэр болон харилцан яриа бүхий бичлэгийг сонсож, гол утгыг нь ойлгох (4-6 асуулт, хариулт)

8.А5. Харилцах явцад багш, уншигч (диктор) болон ангийн нөхдийн яриаг сонсож ойлгох

ЯРИХ

8.Г1. Судалж буй сэдвийн хүрээнд зураг, түлхүүр үг ашиглан хэлзүйн загварын дагуу өгүүлбэр зохиох

8.Г2. Үзүүлэн таниулах материал, харилцааны энгийн нөхцөлд болон тулгуур дохиог (үзүүлэн таниулах материал) ашиглан, 4-6 өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх

8.Г3. Хүний тухай товч мэдээлэл өгөх, эд зүйлс, байгалийн үзэгдэл, үйл явдлыг дүрсэлж ярих

8.Г4. Уншсан эх болон харилцан яриаг дан (монолог) яриа хэлбэрээр илэрхийлэх

8.Г5. Харилцан ярилцагчид хэн? юу? ямар зорилготой (яах гэж)? хэрхэн яаж? хаана? ямар? хэзээ? хаашаа? гэх мэт энгийн асуулт асуух (лавлаж асуух), түүний асуултад хариулах

8.Г6. Харилцааны түгээмэл нөхцөлд хэл ярианы хэм хэмжээг баримтлан яриа өрнүүлэх, түүнд оролцох (бодол, санаа зорилго, хүсэлт (просьба), талархал илэрхийлэх, санал, зөвлөгөө өгөх, урилга, мэндчилгээ дэвшүүлэх, хүсэж ерөөх)

8.Г7. Харилцан яриаг зөв аялгаар эхлэх, сэдвийн дагуу санаа бодлоо илэрхийлэх

УНШИЖ ОЙЛГОХ

8.Ч1. Эхийг дуудах зүйн дүрмийн дагуу зөв унших (үгийн өргөлтийг зөв тэмдэглэх, өгүүлбэрийг зөв аялгаар унших), эхийн агуулгыг илэрхийлэх, тохирох хэлзүйн бүтцийгсонгох

8.Ч2. Нарийвчлан судалж, унших дадал чадвартай болох

8.Ч3. Сургалтын хялбаршуулсан богино эхийг уншиж, түүний хэлзүйн бүтцийгбүрэн гүйцэд ойлгох

8.Ч4. Эхийн гол ба туслах мэдээллийг ялгаж таних

8.Ч5. Мэдээллийг унших, бүтээлчээр боловсруулах, ижил төстэй эх, харилцан яриа зохиох

8.Ч6. Эхийг уншиж агуулгыг тодорхойлох, эхийн гарчиг, эхлэл хэсгээр нь агуулгыг таамаглах

8.Ч7. Толь бичиг болон бусад лавлах материалыг ашиглан шинэ үгийн утгыг тайлбарлах

БИЧИХ

8.П1. Түлхүүр үг, хэллэг, үзүүлэн таниулах материал (зураг, хүснэгт, бүдүүвч)-д тулгуурлан сэдвийн дагуу энгийн өгүүлбэр зохиох

8.П2. Уншсан болон сонссон эхийн загварыг ашиглан эх зохиох, бодол санаагаа илэрхийлэх

8.П3. Загварын дагуу үг, хэллэг цээжээр бичих; цээж бичиг хийж, хэлзүйн даалгаврыг гүйцэтгэх

8.П4. Эхээс хэрэгцээт мэдээллээ олох, өгөгдсөн сэдэв, төлөвлөгөө, уншсан эх, харилцан яриа, асуулт, түлхүүр үгс болон хэлзүйн загварт тулгуурлан зохион бичлэг хийх

ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ

8.BP1. Место ударения в словах, ритмика, редукция гласных, твёрдые и мягкие согласные, звонкие и глухие согласные, И нтонационные конструкции (ИК 1-3,4)

8.BP2. Интонационные конструкции (ИК 1-3,4)

8.BP3. Род, число имён существительных, основные значения падежей,

8.BP4. Одушевлённые , неодушевлённые существительных

8.BP5. Согласование прилагательных с сущ-ми (в роде, числе, падеже), краткая форма прилагательных

8.BP6. Склонение личных местоимений (I, II, III л. ед.ч и мн.ч.)

8.BP7. Вопросительные местоимения (кто, что, какой, чей, сколько, как, где, когда, почему, зачем)

8.BP8. Указательные местоимения (это, этот, эта)

8.BP9. Притяжательные местоимения (наш, ваш, свой, их)

8.BP10. Притяжательные местоимения (наш, ваш, свой, их)

8.BP11. Количественные числительные, сочетание числительных с существительными

8.BP12. Согласование порядковых числительных с существительными (дата)

8.BP13. Время глагола, прошедшее время глагола, сочетание с существительными (Сестра слушала музыку. Бат читал книгу. Дети играли на улице.)

8.BP14. Глагольное управление купить что? отмечать что?)

8.BP15. Спряжение глагола

8.BP16. Глаголы движения (идти, ходить, ехать, ездить, пройти, носить, бежать, плыть)

8.BP17. Императив / повелительное наклонение (читайте! пишите! говорите! напишем! пойдём! встаньте! проверьте! занимайтесь!)

8.BP18. Возвратные глаголы (родиться, питаться, веселиться)

8.BP19. Инфинитив /неопределённая форма (хочу изучать русский язык, помогаю готовить обед, пойду покупать продукты, нужно заботиться, приятно познакомиться, готов помочь)

8.BP20. Вводное слово (по-моему, кажется, конечно)

8.BP21. Предлоги места, направления, времени (в, на, за, к, по, до)

8.BP22. Наречие (сейчас, дома, весело, близко, рядом, налево, направо, нужно, надо, можно, нельзя)

8.BP23. Сложносочинённое предложение (а, но, и)

8.BP24. Сложноподчинённое предложение (поэтому, потому что, как)

8.BP25. Предложения с однородными членами (союз и)

8.BP26. Грамматические конструкции

IX АНГИ

СОНСОЖ ОЙЛГОХ

9.A1. Өргөлтөт ба өргөлтөт бус үеийн эгшиг, гийгүүлэгч авиаг ялгаж сонсох; аялгын төрлийг ялгаж сонсох; үгийн өргөлтөт үеийг зөв сонсож таних

9.A2. Үг, хэллэг, өгүүлбэрийг сонсож, даган дуурияж хэлэх

9.A3. Хүүрнэх болон асуух аялгыг ялгаж сонсох, ойлгох, хүүрнэх болон асуух өгүүлбэрийг зөв аялгаар унших

9.A4. А. Салангид өгүүлбэр болон харилцан яриа бүхий бичлэгийг сонсож, ойлгох (6-8 асуулт, хариулт)

Б. Сонссон эхээс өөрийн сонирхсон, өөрт хэрэгцээтэй мэдээллийг ялгаж ойлгох, сонгох

9.А5. Харилцах явцад багш болон ангийн нөхдийн яриаг сонсож ойлгох

ЯРИХ

9.Г1. Зураг, түлхүүр үг, хувийн сэтгэгдэлд тулгуурлан өгүүлбэр зохиох

9.Г2. Санаа бодлоо 6-8 өгүүлбэрээр илэрхийлэх (хэлзүйн мэдлэгийн хүрээнд)

9.Г3. Эд, юмсыг нэрлэх, тоочих, загвар ашиглан зураг болон эд зүйлсийг дүрслэх, тодорхойлох, тэдгээрийн талаар бодол санаагаа илэрхийлэх

9.Г4. Харилцааны янз бүрийн нөхцөл болон сэдвийн хүрээндхэл ярианы хэм хэмжээг баримтлан ярих (гэр бүл, мөрөөдөл, ирээдүйн төлөвлөгөө, ном, театр, спорт, мэргэжил г.м.)

9.Г5. Харилцан ярилцагчид хэн? юу? ямар? яагаад? хэрхэн яаж? ямар зорилготой (яах гэж)? гэх мэт энгийн асуулт асуух, түүний асуултад хариулах, бодол санаагаа илэрхийлэх

9.Г6. Тодорхой сэдэвт тохируулан, хэм хэмжээг баримтлан эх зохиох, хэн нэгэн, алив нэг зүйлд хандах хандлага, сэтгэлээ илэрхийлэх

9.Г7. Харилцааны хязгаарлагдмал нөхцөлд харилцан яриа эхлэх, өрнүүлэх, санаа бодлоо илэрхийлэх

УНШИЖ ОЙЛГОХ

9.Ч1. Үг, өгүүлбэрийн өргөлт, аялгыг баримтлан эхийг дуудаж унших; задлан шинжлэх, эхийг дагасан дасгал даалгаврыг гүйцэтгэх

9.Ч2. Нарийвчлан судалж, унших дадал чадвартай болох

9.Ч3. Сэдэв, зорилго болон харилцааны нөхцөлд нийцүүлэн тодорхойлон өгүүлэх, хүүрнэх хэлбэрээр эх зохиох

9.Ч4. Эхийн гол ба туслах мэдээллийг уншиж ойлгох, уншсан зүйлийн талаар санаа бодлоо илэрхийлэх

9.Ч5. Төрөл бүрийн эх сурвалжаас мэдээлэл олж авах, түүнийгээ уншиж ойлгох, бүтээлчээр боловсруулах

9.Ч6. Эхийг уншиж агуулгыг тодорхойлох, эхийн гарчгаар агуулгыг таамаглах, эхэд гарчиг өгөх

9.Ч7. Толь бичиг болон бусад лавлах материалыг ашиглан шинэ үгийн утгыг тайлбарлах

БИЧИХ

9.П1. Үг хэллэг, харилцааны нөхцөл, өөрийн мэдлэг туршлагад тулгуурлан энгийн ба нийлмэл өгүүлбэр зохиох

9.П2. Өөрийн мэдлэг туршлагад тулгуурлан дан (монолог) болон харилцан яриа зохиох

9.П3. Өгүүлбэрийн цэг цэглэл, үгийн өргөлтийг тэмдэглэж, цээж бичиг бичих

9.П4. Тодорхой эх сурвалжаас (источник) танил бус үг, хэллэг болон өөрт хэрэгцээт мэдээллийг түүвэрлэж бичих, боловсруулах

ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭ

9.ВР1. Место ударение в словах, подвижность ударения в словах, ритмика

9.ВР2. Интонационные конструкции (ИК 1-3,4)

9.ВР3. Имя существительное (род, число, падеж)

9.ВР4. Одушевлённые , неодушевлённые существительных

9.ВР5. Согласование прилагательных с сущ-ми (в роде, числе, падеже), краткая форма прилагательных (нужен, должен)

9.BP6. Склонение личных местоимений (I, II, III л. ед.ч и мн.ч.)
9.BP7. Вопросительные местоимения (кто, что, какой, чей,сколько, как, где,когда, почему, зачем, с какой целью)
9.BP8. Указательные местоимения (это, этот, эта, эти)
9.BP9. Притяжательные местоимения (наш, ваш, свой, их)
9.BP10. Определительные местоимения (каждый, весь, сам, самый, другой)
9.BP11. Количественные местоимения (тысяча, одна тысяча, две тысячи)
9.BP12. Согласование порядковых числительных с существительными
9.BP13. Время глагола, сочетание с существительными (Если я не поступлю в институт, я буду работать.)
9.BP14. Глагольное управление (отдыхать где? нравиться кому? должен быть каким?)
9.BP15. Спряжение глагола
9.BP16. Глаголы движения (ходить, ехать, ездить, плыть, плавать, летать, нести, носить)
9.BP17. Императив / повелительное наклонение (выбирайте, любите)
9.BP18. Возвратные глаголы (встречаться, вернуться)
9.BP19. Инфинитив /неопределённая форма глагола, вспомагательный глагол, модальное слово (мочь)
9.BP20. Вводное слово (по-моему, кажется, конечно)
9.BP21. Предлоги места, направления, времени (в, на, под, около)
9.BP22. Наречие (хорошо, надо, можно)
9.BP23. Сложносочинённое предложение (а, но, и)
9.BP24. Сложноподчинённое предложение (если, что, чтобы, когда, который, с тех пор как, потому что)
9.BP25. Предложения с однородными членами (без союза и с союзами и, или)
9.BP26. Грамматические конструкции. Обобщающие слова.

ГУРАВ. АРГА ЗҮЙ БА ОРЧИН, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

3.1. Арга зүйн онцлог

Гадаад хэлний сургалтад түгээмэл хэрэглэгдэж буй дараах хандлага, арга, техникийг гадаад хэлний сургалтын хөтөлбөрт үндсэн арга зүйгээр тодорхойлсон болно. Үүнд:

Хэл сурах, сургах коммуникатив арга зүй. Энэ арга зүй хэлний цогц чадамжийг сурагчдад төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилготой бөгөөд сурагчдад хам сэдвээс салангид үг хэллэг, хэлзүйн дүрэм, бүтцийг цээжлүүлэхээс татгалзан, харилцааны зорилго, хэрэгцээнд тулгуурлан, түүнд тохирсон дасгал, даалгаврын төрлийг сонгон хэрэглэж, сургалтын явцад багш зөвлөх, чиглүүлэх, хянах, зохион байгуулах, үнэлэх үүрэгтэй оролцоно.

Бодит даалгаварт суурилсан арга зүй. Хэлний хичээлээр судалж буй сэдвийн хүрээнд хэрэглэгдэх үг хэллэгийг жагсаан бичих, тэдгээрийг ангилах /ижил болон төстэй утгаар нь ялгах, эрэмбэлэх г.м./, харьцуулах, өөрийн санаа бодол, туршлагаас хуваалцах зэргээр бүтээлч дасгал даалгавар, төсөлт ажил гүйцэтгэнэ. Тухайн арга зүйгээр хичээлийг зохион байгуулахдаа хэлэхүйн үндсэн чадваруудыг интеграцчилан хөгжүүлэх, сурагчдын гүйцэтгэх цаг хугацааг зөв тооцох, тэдний ялгаатай байдлыг харгалзан, тохирох даалгаврыг сонгон хийлгэх, даалгавар гүйцэтгэхэд шаардлагатай эх сурвалж, хэрэглэгдэхүүнийг боловсруулна.

Гадаад хэл сурах, сургах арга барил эзэмшүүлэх арга зүй. Хэлний чадварыг хөгжүүлэх, мөн сурагч төвтэй арга зүйн тулгуур зарчмуудын нэг болох сурагчдыг багшаас хараат бус (learner autonomy), өөрсдийгөө бие даан хөгжүүлэх мэдлэг, чадвартай болгохын тулд хэл сурах

өөрийн гэсэн арга барилтай болгоно. Гадаад хэл сурах арга барилыг сурагчдад эзэмшүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хэлний даалгаврын онцлог, сурагчийн зорилго, сурах хэв маягт нийцсэн арга барилуудыг ашиглах
- Хэлний хичээлээр сурагчдад төрөл бүрийн барилуудыг туршин хэрэглэх боломж бололцоог бүрдүүлэх
- Хэл сурах арга барил эзэмшүүлэхдээ хэлний хэрэглээний бодит материалд тулгуурласан олон төрлийн дасгал даалгавар хийлгэх
- Сурагч өөрийн үйл ажиллагааг тасралтгүй хянах, үнэлэх, мөн сайжруулж байх механизм бүрдүүлэх.

Дээрх зарчмыг харгалзан багш дараах гурван чиглэлээр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

- Асуулга, ярилцлага, судалгааны бусад арга хэрэгслээр сурагчдынхаа ямар сурах барил эзэмшсэнийг тогтоох
- Сурагчдын сурах хэв шинж, онцлог, дасгал даалгаврын төрөл, зорилго зэргийг харгалзан тэдэнд бодит туслалцаа үзүүлэх, сурах үйлд нь хөтлөх
- Салангид бус, харин олон барилаас сонгон ашиглаж, сурах чадвар суулгах чиглэлээр багш практик туслалцаа, чиглүүлэг өгөх зэрэг орох юм.

Гадаад хэлний хичээлд дээрх арга зүйг хэрэглэхийн зэрэгцээ сурагчдын бүтээлч, бие даасан үйл ажиллагааг дэмжсэн асуудал шийдвэрлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадварыг хөгжүүлэх арга зүйг түлхүү хэрэглэнэ. Ингэснээр сурагчид хэл сурах үйл явцад өөрийгөө хөгжүүлнэ.

3.2. Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн

- Анги танхимд тухайн гадаад хэлээр харилцах, хэл сурах орчинг бүрдүүлнэ.
- Чөлөөтэй, өөртөө итгэлтэй, бие биеэ хүндэтгэн харилцах эерэг уур амьсгал, таатай орчинг бүрдүүлнэ.
- Сурагчдын нөхцөл байдалд болон сурах бичгийн агуулгад тохируулан хичээлд хөгжим, өсгөгч, компьютер, мэдээлэл харилцааны технологид суурилсан цахим эх сурвалж, асуулт, төрөл бүрийн эх, бичих даалгаврын жишиг загварыг багтаасан ажлын хуудас зэрэг хэрэглэгдэхүүнийг ашиглана.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

4.1. Үнэлгээний зорилт

А. Гадаад хэлний сонсох, унших чадвар болон хэлний хэрэглээ /мэдээлэл хүлээн авах/

Б. Гадаад хэлний ярих, бичих, харилцах чадвар /мэдээлэл боловсруулах/

В*. Гадаад хэл сурах хандлага (сурах арга барил)

* Сурагчдын хандлагыг ажиглалт, ярилцлага, мэтгэлцээн, илтгэл, рубрикээр үнэлнэ.

4.2. Үнэлгээний шалгуур

Гадаад хэлний сургалтаар сурагчдын эзэмшвэл зохих сонсох, ярих, унших, бичих, хэлний хэрэглээний чадварыг үнэлэхдээ үнэлгээний зорилтод нийцсэн даалгавар боловсруулж суралцахуйн зорилтыг үнэлгээний шалгуур болгон үнэлнэ.

Англи хэл

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Гадаад хэлний сонсох, унших чадвар болон хэлний хэрэглээ	А1. Хэлний хэрэглээ А2. Үг хэллэг, холбоо үг, энгийн ба нийлмэл өгүүлбэр А3. Өгүүлбэрийн гишүүд, өгүүлбэрийг холбох холбоос А4. Хувийн мэдээллийн талаар асуултыг ойлгож байгаа байдал А5. Хүлээн авч буй мэдээллийн гол ба туслах санаа, зохиогч өгүүлэгчийн хандлага санааг ялган таньж байгаа байдал А6. Хүлээн авч буй мэдээллийн агуулга, утга санааг тааварлаж байгаа байдал А7. Төрөл бүрийн эхийг /түүх, хүүрнэмж, шүлэг, дуу гэх мэт/ ойлгож байгаа байдал А8. Түлхүүр санааг тэмдэглэх А9. Түлхүүр өгүүлбэр ашиглан эхийн бүтэц зохион байгуулалтыг таних
Б. Гадаад хэлний ярих, бичих, харилцах чадвар болон	Б1. Ажиглах, загварчлах, харьцуулах Б2. Хэрэгцээт мэдээллийн эрэл хайгуул хийж, дүн шинжилгээ хийх Б3. Аливаа юмс үзэгдэл, үйл явдлын уялдаа холбоо, учир шалтгааныг олох Б4. Хам сэдвийн хүрээнд хэлний мэдлэг бүтээх, мэдээллийн төрөл бүрийн эх сурвалж хэрэглэх Б5. Энгийн түүх болон үйл явдал өгүүлэн ярих Б6. Өөрт төрсөн мэдрэмж, санаа бодол, баримт мэдээ, үйл явдал, туршлагынхаа талаар бичих Б7. Үгийн нөөц, үгийн олон утгыг ялган таних арга эзэмших, хэрэглэх Б8. Ярих, бичих зүйлээ төлөвлөх, бичих, засан сайжруулах Б9. Хувийн мэдээллийн талаар асуулт асуух болон асуултад хариулах Б10. Тодорхой сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэх
В. Гадаад хэл сурах хандлага (сурах арга барил)	В1. Хэл сурах сонирхол, арга барил, хандлага В2. Сонсох унших явцад мэдээлэл хүлээн авч, задлан шинжлэх В3. Бичих, ярих явцад мэдээллийг бүтээлчээр хэрэглэх В4. Идэвх оролцоо, бүтээлч байдал В5. Хосоор, багаар, бүлгээр хамтран ажиллах

Орос хэл

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А. Гадаад хэлний сонсох, унших чадвар болон хэлний хэрэглээ	А1. Хэлний хэрэглээ А2. Үг хэллэг, холбоо үг, энгийн ба нийлмэл өгүүлбэр А3. Өгүүлбэрийн гишүүд, өгүүлбэрийг холбох холбоос А4. Авиа, үе, үг, холбоо үг, өгүүлбэрийг сонсож ойлгож байгаа байдал А5. Үг, өгүүлбэрийн өргөлт, аялгыг зөв ялгаж сонсож буй байдал А6. Эх, харилцан яриаг сонсож, гол санааг ойлгож буй байдал А7. Тодорхой сэдвийн хүрээнд харилцан яриа болон эхийг уншиж, гол санааг ойлгож, ерөнхий мэдээлэл авч буй байдал А8. Уншсан зүйлийн гол санааг ойлгож, хам сэдвээс утгыг таамаглаж буй байдал

Б. Гадаад хэлний ярих, бичих, харилцах чадвар болон	Б1.Үгийн сан, хэлзүйн мэдлэгээ тодорхой сэдвийн хүрээнд ашиглан санаа бодлоо амаар болон бичгээр илэрхийлэх чадвар Б2. Өөрт төрсөн мэдрэмж, санаа бодол, баримт мэдээ, үйл явдал, туршлагынхаа талаар бичих Б3. Сонирхсон зүйлийн талаар асуулт асуух, мэдээлэл авах, хүн ба эд юмс, үйл явдлын талаар төлөвлөн бичих Б4. Эхээс мэдээллийг ялгаж тодорхойлох Б5. Ажиглах, харьцуулан жиших, задлан шинжлэх Б6. Хэрэгцээт мэдээллийн талаар эрэл хайгуул хийж, нэгтгэн дүгнэх Б7. Аливаа юмс үзэгдэл, үйл явдлын уялдаа холбоог олох Б8. Мэдээллийн төрөл бүрийн эх сурвалж хэрэглэх Б9. Хам сэдвийн хүрээнд эрэл хайгуул хийж, хэлний мэдлэгээ ашиглан мэдээллийг боловсруулах Б10. Хам сэдвийн хүрээнд үгийн нөөц, үгийн олон утгыг ялган таних Б11. Харилцагчийн санаа бодлыг ойлгож, үг, энгийн өгүүлбэрээр харилцах Б12. Сонссон болон уншсан эхийн гол санааг илэрхийлэн, санаа бодлоо илэрхийлэх Б13. Сонирхсон зүйлийн талаар асуулт асуух, мэдээлэл авах, хүн ба эд юмс, үйл явдлын талаар мэдээлэх Б14. Орос, монгол хэлний хэлзүйн байгууллыг харьцуулах, төсөөтэй болон ялгаатай талыг илрүүлэх
В. Гадаад хэл сурах хандлага (сурах арга барил)	В1. Хэл сурах сонирхол, арга барил, хандлага В2. Сонсох унших явцад мэдээлэл хүлээн авч, задлан шинжлэх байдал В3. Бичих, ярих явцад мэдээллийг бүтээлчээр хэрэглэх байдал В4. Идэвх оролцоо, бүтээлч байдал В5. Хосоор, багаар, бүлгээр хамтран ажиллах

4.3. Үнэлгээний жин

Үнэлгээний зорилт	Эзлэх хувийн жин
Үгийн сан, хэлний хэрэглээ	40% (сэргээн санах даалгавар 20%-иас ихгүй)
Сонсох, унших, бичих, ярих чадвар	60% (үгийн сан, хэлний хэрэглээний даалгавар 20%-иас ихгүй)

Үнэлгээний зорилтын тайлбар, тодруулга. Суурь боловсролын шатанд хэлний сургалт нь сурагчдын гадаад хэл дээрх мэдээлэлтэй ажиллах арга барилыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Сурагчдын амжилттай суралцах үндсэн нөхцөл бол гадаад хэл дээрх мэдээллийг уншиж, сонсож чаддаг, түүнийгээ ашиглан харилцдаг, аливааг ажиглан ойлгосноо тэмдэглэж, сэргээн санаж чаддаг, ангилж, нэгтгэн дүгнэж чаддаг байх явдал юм. Мэдээлэлтэй ажиллах арга барилыг дараах байдлаар ойлгоно.

- Мэдээлэл хүлээн авах. Энэ шатанд унших, сонсох чадвар чухал үүрэгтэй. Энэ хоёр чадвар нь хүлээж авч мэдээллээ өөрийн болгон ойлгож авдагт оршино.
- Мэдээлэл боловсруулах. Энэ шатанд шинээр хүлээж авсан мэдээллээ задлан шинжилж, гол ба гол бус шинжийг ялгах, харьцуулах, олон талаас харах, утгачлан тогтоох, нэгтгэн дүгнэх, үнэлгээ өгөх зэргээр судлахыг ойлгоно.
- Илэрхийлэх. Энэ нь өмнөх шатуудад бий болгосон мэдлэг туршлагадаа үндэслэн шинэ сэдэв, санаа олох, ярьж бичихийн тулд холбогдох мэдээлэл эрж хайх, ангилж бүлэглэх, төлөвлөх, бичих боловсруулах, түүнийгээ амаар болон бичгээр танилцуулахыг ойлгоно. Товчоор хэлбэл, тодорхой “бүтээгдэхүүн” гаргахад бэлтгэх болон түүнийгээ танилцуулах үйл явцыг хамтад нь ойлгоно.

Сургалтын хөтөлбөрийн үр дүнд сурагчдын унших, бичих, ярих, сонсох чадварт тодорхой ахиц гарсан байна. Хэлний үндсэн дөрвөн чадвар дараах байдлаар хөгжинө.

Сонсох чадвар:

- Энгийн үг, өгүүлбэр, харилцан яриаг сонсож ойлгох
- Өдөр тутмын энгийн яриа болон богино эх сонсоод ойлгосноо илэрхийлэх
- Судалсан сэдвийн хүрээнд энгийн яриа болон эх сонсож ойлгосноо илэрхийлэх
- Танил, танил бус сэдвийн хүрээнд яриа болон эх сонсож ойлгосноо илэрхийлэх

Унших чадвар:

- Богино эх уншиж ойлгох
- Энгийн бүтэц бүхий богино хэмжээний эх уншиж ойлгох
- Судалсан сэдвийн хүрээнд энгийн эх уншиж ойлгосноо илэрхийлэх
- Танил, танил бус сэдвийн хүрээнд яриа болон эх уншиж ойлгосноо илэрхийлэх

Ярих чадвар:

- Тодорхой сэдвийн хүрээнд загвар ашиглан энгийн танилцуулга хийх
- Энгийн сэдвээр өөрийн бүтээсэн мэдлэг болон тодорхой загвар ашиглан ярилцах
- Судалсан сэдвээр харилцан ярилцах, хүүрнэн өгүүлэх
- Тодорхой загварын дагуу өөрийг санааг илэрхийлж сурах

Бичих чадвар:

- Судалсан сэдвийн хүрээнд аливаа зүйлийг бичгээр товч танилцуулах
- Судалсан сэдвийн хүрээнд үгийн нөөц, хэлний энгийн бүтцийг ашиглан тодорхой санааг илэрхийлэх
- Тодорхой зорилгоор өөрийн санааг бичгээр илэрхийлж бичих

ЭРҮҮЛ МЭНД

“Эрүүл мэнд”-ийн сургалтын хөтөлбөр (2018)

Багийн ахлагч:	Д.Алтанцэцэг, магистр, “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн дэд зохицуулагч, магистр

Багийн гишүүд

Э.Мөнгөнтулга	Ph.D, МУБИС-ийн багш
Ч.Байгалмаа	Ph.D, МУБИС-ийн багш
Б.Жаргал	Ph.D, АШУҮИС-ийн багш
Ц.Сонинхишиг	Ph.D, Монголын хоол зүйчдийн найрамдлын холбооны тэргүүн
Г.Дарамбазар	Ph.D, АШУҮИС-ийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургуулийн захирал
В.Баярмаа	Ph.D, СЭМҮТ-ийн дэд захирал
Д.Энхмягмар	магистр, НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
С.Гэрэлмаа	магистр, НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан
В.Лхамсүрэн	магистр, МУБИС-ийн багш
Ц.Дийдэрмаа	магистр, Нийслэлийн 47-р сургуулийн багш,
О.Мөнхжаргал	магистр, Ерөнхий боловсролын Орхон Хасү сургуулийн багш

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Зорилго

Сурагч нь эрүүл мэндийн шинжлэх ухааны үндэстэй мэдлэг эзэмшиж, өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг дэвшүүлэн, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалахад хариуцлагатай ханддаг болно.

1.2. Зорилт

Сурагч дараах мэдлэг эзэмшинэ.

- Эрүүл мэндэд нөлөөлөх биологийн болон нийгмийн хүчин зүйлийн талаарх мэдлэг, ойлголт
- Эрүүл мэндэд нөлөөлөх харилцаа, орчны хүчин зүйл (эерэг, сөрөг сэтгэл хөдлөл, үерхэл нөхөрлөл, хайр сэтгэл, дарамт шахалт, хорт зуршил, орчны аюулгүй байдал)-ийн талаарх мэдлэг, ойлголт
- Эрүүл мэндийг хамгаалах амьдралын хэв маяг, нийгмийн үйлчилгээ (жендэрийн хэвшмэл ойлголт, бэлгийн боловсрол, нөхөн үржихүйн эрүүл мэнд, анхны тусламжийн аргачлал)-ний талаарх мэдлэг, ойлголт

Сурагч дараах чадвар эзэмшинэ.

- Хувийн сахилга баттай, өөрийгөө хүндэтгэх, өөрийн амьдралын үйл явцыг төлөвлөх
- Бүтээлчээр сэтгэх, хэрэглэх, эргэцүүлэх, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах
- Сэтгэлийн хөдөлгөөнөө жолоодох, бусдыг ойлгож туслах, үр дүнтэй харилцах, зохион байгуулах, хамтран ажиллах
- Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээлийн технологийг ёс зүйтэй ашиглах, зөрчил, маргааныг шийдвэрлэх, асуудлын гарцыг олох, тусламж эрэлхийлэх

Сурагчид дараах хандлага төлөвшинө.

- Эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, бие бялдрын эрүүл мэнд, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болох
- Бусдын эрүүл мэнд, сайн сайхны төлөө санаа тавьдаг байх
- Олон талт соёлыг ойлгох, бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах
- Аливаа эрсдэлтэй зан үйл, хорт зуршлаас татгалзах, даван туулах
- Нийгмийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах, багш, найз нөхөд, насанд хүрэгчдийн өмнө хариуцлага хүлээх

ХОЁР. АГУУЛГА

VI анги

ЭМ01. ХУВИЙН ЭРҮҮЛ АХУЙ БА ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД

6,01.а. Шүдний бүтэц, үүргийг хоол боловсруулах эрхтэн тогтолцоо болон гоо сайхантай холбон тайлбарлах; шүд цайруулах, пааландах үйлчилгээний давуу, сул талыг тайлбарлах

6,01.б. Түгээмэл тохиолддог гэдэсний халдварт өвчнийг нэрлэж, халдвар дамжих зам, илрэх шинж тэмдэг, урьдчилан сэргийлэх арга замыг тайлбарлах

6,01.в. Дотуур хувцсаа зөв сонгох, түүний эрүүл ахуйн (угаах, арчлах, хадгалах) талаар ярилцах; охид ариун цэврийн хэрэглэлийг зөв сонгох, хэрэглэх

ЭМ02. ХООЛЛОЛТ БА ХӨДӨЛГӨӨН

6,02.а. Хүнсний бүтээгдэхүүний илчлэг чанарыг харгалзан, аюулгүй байдлыг ханган зохистой хооллох

6,02.б. Биеийн өсөлт хөгжлөө дэмжих идэвхтэй хөдөлгөөн тогтмол хийх үед усны хэрэглээг хянаж зохицуулах

ЭМ03. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

6,03.а. Мэдрэмж, эерэг, сөрөг сэтгэл хөдлөлөө таньж мэдэх ба эергээр илэрхийлэх

6,03.б. Сэтгэл хөдлөлөө зүй бусаар илэрхийлэхээс зайлсхийх, уур бухимдлаа зохицуулах

ЭМ04. ХОРТ ЗУРШИЛ

6,04.а. Цахим хэрэгслийг хэтрүүлэн хэрэглэхээс татгалзах

6,04.б. Эмийг эмчийн зааврааар хэрэглэхийн ач холбогдол, дур мэдэн хэрэглэхийн хор уршгийг тодорхой жишээгээр харьцуулан тайлбарлах

ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

6,05.а. Эрүүл ба эрүүл бус харилцаа холбооны шинжийг ялгах, үе тэнгийнхний дарамт шахалтыг шийдвэрлэх талаар дүрийн тоглолт хийж үзүүлэх, үерхэл нөхөрлөл, хайраа илэрхийлэх арга замыг тусган харуулах

6,05.б. Гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтыг тайлбарлаж, тэдгээрийн сөрөг үр дагаврыг тодорхойлох; бүх хүн өвөрмөц бөгөөд үнэ цэнэтэй учраас хүндэтгэлтэй хандах хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрөх

6,05.в. Жендэрийн хэм хэмжээ ба хэвшмэл ойлголт, тэдгээрийн үр дагаварт дүн шинжилгээ хийх

ЭМ06. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АНХНЫ ТУСЛАМЖ

6.06.а. Гэртээ болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны үед тохиолдож болох аюул эрсдлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах

VII анги

ЭМ01. ХУВИЙН ЭРҮҮЛ АХУЙ БА ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД

7,01.а. Бэлгийн бойжилтын үеийн бэлэг эрхтний ариун цэвэр, эрүүл ахуйн дэглэм, түүнийг сахихын ач холбогдлыг тайлбарлах

7,01.б. Хувийн эрүүл ахуйг сахих талаар аав, ээж, асран хамгаалагчид болон сургуулийн багш, захирал нарт хүсэлт бичих

ЭМ02. ХООЛЛОЛТ БА ХӨДӨЛГӨӨН

7,02.а. “Гэр зөвлөмж”-ийн дагуу хооллох нэгжийг харгалзан, хоолны дэглэм зохион хэрэгжүүлэх

7.02б. Хүнсний эрүүл ахуйн шаардлагыг мэдэж, хоол, хүнсээр дамжин халдварлах өвчин болон хоолны хордлогоос сэргийлэх

7,02.в. Хөдөлгөөний хомсдлоос сэргийлж, дасгал хийхэд амин дэм, эрдсийг тохиромжтой хэмжээгээр зөвлөмжийн дагуу хэрэглэх

ЭМ03. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

7,03.а. Өөртөө итгэлтэйгээр бусадтай эерэг харилцах

7,03.б. Бусдад анхаарал халамж тавьж буйгаа үгээр болон үйлдлээр илэрхийлэх

ЭМ04. ХОРТ ЗУРШИЛ

7,04.а. Бие бялдрын өсөлт хөгжил, гоо сайханд архи, тамхи нөлөөлдөг болохыг тодорхойлох

7,04.б. Архи, тамхи хэрэглэхээс эелдгээр татгалзах

ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

7,05.а. Бэлгийн амьдрал нь хүний амьдралын салшгүй хэсэг бөгөөд хүйс, соёл, шашин нөлөөлдөг болохыг таних

7,05.б. Нөхөн үржихүйн үйл явц, жирэмслэлт нь бэлгийн хавьтлын үр дүн болохыг ойлгож, жирэмсний шинж тэмдэг болон ургийн хөгжлийн үе шатыг тайлбарлах

7,05.в. Үерхэл нөхөрлөл, дотно харилцаа хэрхэн бий болдгийг тайлбарлах; хайр, үерхэл нөхөрлөл, шохоорхолтой холбоотой сэтгэл хөдлөлийг ялгаж, түүнийг зохицуулах аргыг жишээгээр үзүүлэх

7,05.г. Хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил, хууль бус, буруу зүйл болохыг таньж мэдэх, дотно харилцаа бүхий хүмүүсийн хооронд үйлдэгддэг хүчирхийллийн хэлбэр, үр дагаврыг тодорхойлж, түүнтэй холбоотой өөрийн туршлага, үнэт зүйлийн талаар эргэцүүлэх

ЭМ06. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АНХНЫ ТУСЛАМЖ

7,06.а. Сургуулийн орчинд (туршилт хичээл, завсарлагааны үеэр) болон нийтийн тээврээр зорчих үеийн эрсдлээс сэргийлж, шаардлагатай тохиолдолд анхны тусламж үзүүлэх

VIII анги

ЭМ01. ХУВИЙН ЭРҮҮЛ АХУЙ БА ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД

8,01.а. Хувцасны төрөл, үүрэг, ач холбогдлыг мэдэх, хувцсаа төрөл зориулалтаар нь тохируулан өмсдөг байх, арчлах, хадгалах арга замыг тодорхойлох

8,01.б. Сүрьеэ өвчний үүсгэгч, илрэх шинж тэмдэг, ялгаа, халдвараас урьдчилан сэргийлэх

8,01.в. Дархлаажуулалтын ач холбогдлыг тодорхойлох, түүнд хамрагдахын ач тус, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг бусдад сурталчлах

ЭМ02. ХООЛЛОЛТ БА ХӨДӨЛГӨӨН

8,02.а. Насны бүлэг, хувийн онцлогийг харгалзан хоол хүнсний хэрэглээг хянан зохицуулах

8,02.б. Хөдөлгөөний идэвх, эрчмээ тохируулан дасгал тогтмол хийж, таргалалт, чихрийн шижин өвчнөөс сэргийлэх

ЭМ03. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

8,03.а. Асуудал, бэрхшээлийг даван туулах арга замыг тодорхойлж, хэрэглэж турших

8,03.б. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, шаардлагатай тусламж үйлчилгээг хаанаас, ямар хэлбэрээр авах талаар бусдад зөвлөх

ЭМ04. ХОРТ ЗУРШИЛ

8,04.а. Амьсгалын болон хоол боловсруулах эрхтэн тогтолцоонд архи, тамхи нөлөөлдөг болохыг туршилтаар илрүүлэх

8,04.б. Архи, тамхи хэрэглэхгүй байхыг ойр дотны хүмүүсээсээ хүсэх, бусдад нөлөөлөх

ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

8,05.а. Хувь хүний бэлгийн харилцааны талаарх шийдвэр өөрчлөгддөг болохыг ухаарч, түүнийг хүндэтгэх, эрүүл мэндээ дэмжих, хамгаалах талаар хариуцлагатай шийдвэр гаргах

8,05.б. Хүйсийн баримжаа, илэрхийллийг тайлбарлаж, өөрийн болон бусдын хүйсийн баримжаа, илэрхийллийг хүндэтгэж байгаагаа харуулах

8,05.в. Бэлгийн чиг баримжааг тайлбарлаж, хүйсийн баримжаа илэрхийллээс ялгах; буруу ташаа ойлголтыг няцаах; ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх

8,05.г. Бэлгийн харилцааны талаар харилцан зөвшилцөх нь чухал болохыг ухаарах; зөвшилцлийг ялган таних; харилцан зөвшилцөх арга замыг жишээгээр үзүүлэх

ЭМ06. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АНХНЫ ТУСЛАМЖ

8,06.а. Амьдрах орчинд болон уралдаан тэмцээний явцад тохиолдож болох гэмтэл бэртлээс сэргийлэх, хамгаалах багаж хэрэгслийг зөв хэрэглэх, шаардлагатай үед анхны тусламж үзүүлдэг болох

IX анги

ЭМ01. ХУВИЙН ЭРҮҮЛ АХУЙ БА ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД

9,01.а. Халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт зан үйлийг тодорхойлох, сэргийлэх арга замыг үзүүлэх

9,01.б. Халдвараас хамгаалах нэг удаагийн багаж хэрэгслийг зөв, зохистой хэрэглэх талаар сурталчлах

9,01.в. Гоо сайхнаа хамгаалах, өөрт тохирсон гоо сайхны бүтээгдэхүүнийг сонгохын ач холбогдлыг мэдэх

ЭМ02. ХООЛЛОЛТ БА ХӨДӨЛГӨӨН

9,02.а. Хоногийн хоолны шимт бодисын хэрэгцээ, уламжлалыг харгалзан зохистой хооллох

9,02.б. Хоолны дэглэм баримталж, биеийн жингээ зохицуулан, зүрх судас, яс сийрэгжилт, хавдар, харшил зэрэг өвчлөлөөс сэргийлэх

ЭМ03. СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД

9,03.а. Мэргэжил сонголт, түүнтэй холбоотой зөвлөгөө, мэдээлэл авах, бусадтай санал солилцох

9,03.б. Нийгмийн янз бүрийн орчинд дасан зохицох, бусадтай харилцан ойлголцох

ЭМ04. ХОРТ ЗУРШИЛ

9,04.а. Зүрх судасны үйл ажиллагаанд архи, тамхи нөлөөлдөг болохыг хэлэлцэх

9,04.б. Архи, тамхины эдийн засгийн тооцоолол хийж, сөрөг нөлөөг тайлбарлах

ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД

9,05.а. Түгээмэл тохиолддог бэлгийн замаар дамжих халдвар, дамжих зам, шинж тэмдэг, эмчлэгддэг эсэх, урьдчилан сэргийлэлт, халдвар авсан байж болзошгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тайлбарлах

9,05.б. Бэлгийн амьдрал, нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбогдох өөрийн үнэт зүйл, түүний зан үйлд үзүүлэх нөлөөг тодорхойлж, үнэт зүйл, итгэл үнэмшил, хандлагын ялгаатай байдлыг хүндэтгэхийн ач холбогдлыг ухаарах

9,05.в. Интернэт, нийгмийн сүлжээний эерэг, сөрөг нөлөөг (бусдын анхааралд өртөх, бэлгийн мөлжлөг г.м.) жишээгээр тайлбарлах, интернэт, гар утас, нийгмийн сүлжээг аюулгүй ашиглах төлөвлөгөө боловсруулж хэрэглэх

ЭМ06. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АНХНЫ ТУСЛАМЖ

9,06.а. Гэнэтийн осол гэмтлээс сэргийлэх, тохиолдсон үед гарын доорх материал, багаж хэрэгсэл ашиглан анхны тусламж үзүүлэх, яаралтай тусламж дуудах

9,06.б. Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд өөрийнхөө чадах зүйлээр туслах

ГУРАВ. АРГА ЗҮЙ

Орчин үед сурагч төвтэй сургалтын технологийн дагуу хичээлийг зохион байгуулах хандлага зонхилж байна. Сургалт нь сургах буюу багшийн үйл ажиллагаа, сурах буюу сурагчийн үйл ажиллагааны нэгдэл юм.

Сурагчийн юу хийх, юунд суралцах, яаж суралцах, хэн болох, ямар ур чадвартай болох, ямар хандлага, зан үйл төлөвшүүлэх гэх мэт асуудлыг багш төлөвлөж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд багшийн төлөвлөсний дагуу сурагчид сурах арга барил, мэдлэг ойлголт, чадвар эзэмшиж, хандлага зан үйл төлөвших болно.

3.1. Багшлах стратеги

Багш сурагчдын танин мэдэхүй, сэтгэл хөдлөл-нийгэмшил болон бие бялдрыг хөгжүүлэх, тэдгээрт харгалзах чадварыг эзэмшүүлэхийн тулд 4 алхамт арга барил, болон оролцооны аргыг төлөвлөж сургалт, үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой.

4 алхамт арга барил:

Алхам 1. Асуудлыг олж мэдэх, ойлгох (гол мэдээллийг ойлгох)

Алхам 2. Судлах, дүн шинжилгээ хийх (илүү ихийг олж мэдэх, үр дүнг танилцуулах)

Алхам 3. Үйл ажиллагаа болгох (бүтээгдэхүүн, үйлчилгээ авах, эрүүл мэндээ дэмжих, эрсдлээс зайлсхийх, үр дүнтэй харилцах, эрүүл мэндээ дэмжихийн тулд шийдвэр гаргах, зорилго тавих, эрүүл мэндийг дэмжих зан үйл, үйлдэл хийх)

Алхам 4. Үнэлж дүгнэх (Юу хийсэн, юуг сайжруулах үйл ажиллагааг хамтран хэлэлцэх)

Эрүүл мэндийн хичээлд оролцооны аргыг хэрэглэснээр бүтээлчээр сэтгэх, багаар хамтран ажиллаж шийдвэр гаргах, бусдыг сонсох, ойлгох чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ, өөрийн өдөр тутмын амьдралд тохиолдож буй асуудлыг шийдвэрлэх, эрсдэлт зан үйлээс татгалзах арга ухаанд суралцахад нь туслах болно.

4 алхамт арга барилын алхам бүрд хэрэглэж болох боломжит аргуудаас дурдвал:

Асуудлыг олж мэдэх, ойлгох	- Үзэл бодлын шугаман арга - Оюуны зураглал - Ойлголтын тойрог - Шооны арга - Мэдрэмж нээх арга - KWL арга
Судлах, дүн шинжилгээ хийх	- Булангийн арга - Инсертийн арга - Тохиолдолд шинжилгээ хийх - Дүрийн тоглолт хийх - Масктай тоглолт хийх
Үйл ажиллагаа болгох	- Жүжиг, дуугүй жүжиг тоглох - Төсөлт ажил - Үлгэр, сургамжит өгүүллэгийн хэлэлцүүлэг - Эвлүүлгийн арга
Үнэлж дүгнэх	- Мэтгэлцээн - Үгийн сүлжээ - Хөгжөөнт тоглоом - Бүтээлийн үзэсгэлэн - Мини парламент - Дүрийн тоглолт

Багш оролцооны аргаар хичээлийг зохион байгуулахад дараах зарчим баримтална.

Хэрэгцээнд тулгуурласан байх: Эрүүл мэндийн боловсролд хувь хүний болон нийгмийн хэрэгцээг тооцох, үнэлэх явдал хамгийн чухал байр суурь эзэлнэ.

Судалгаанд суурилсан, шинжлэх ухааны онолын үндэслэлтэй байх: Сурагчдад өгөх мэдлэг, мэдээлэл нь зөвхөн судалгаанд суурилсан, онолоор батлагдсан үнэн зөв мэдээлэл байх

Хувь хүний үнэт зүйл, хандлага, итгэл үнэмшилд хандсан байх: Хүн бүр өөрийн гэсэн үзэл бодол, итгэл үнэмшилтэй байдгийг хүндэтгэж үзэх, өөрийнхөө үзэл бодлыг тулган зөв, буруу гэж үнэлэхгүй байх

Суралцах стратеги, заах арга, хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгох: Багш сурагчдын нас, сэтгэхүйн хөгжлийн үе шатад тохирсон үзүүлэн таниулах материал, муляж, бодит болон зурагт үзүүлэн, мультимедиа хичээл, компьютер, проектор зэрэг орчин үеийн техник хэрэгсэл ашиглан, сургалтыг үр дүнтэй, сонирхолтой арга, хэлбэрээр зохион байуулахад анхаарна. Эрүүл мэндийн хичээлийг анги, том баг, жижиг баг, хосоор болон ганцаар ажиллуулах зэрэг хэлбэрээр зохион байгуулах нь илүү оновчтой байдаг.

Багш сургалтын аргыг үр өгөөжтэй хэрэглэх дараах нийтлэг шаардлагыг мөрдвөл зохино. Үүнд:

- Тухайн ангийн сурагчдын нас, сэтгэцийн онцлог, хөгжлийн ерөнхий түвшин, сурах чадавх, ангийн хамт олны төлөвшлийн онцлог, хэрэгцээ, сонирхол зэргийг харгалзан сургалтын аргаа сонгоно.
- Тухайн хичээлийн сэдэв, зорилго, зорилт, агуулгын багтаамж, цаг хугацаа зэргийг тооцно.
- Багш нар нэг аргыг байнга хэрэглэхээс зайлсхийж, олон янзын аргыг хослуулан хэрэглэнэ.
- Илүү бүтээлч байхын тулд багш өмнө нь хэрэглэж байсан аргыг өөр өөр нөхцөлд шилжүүлэн өөрчилж сургалтаа зохион байгуулна.

Эрүүл мэндийн хичээлийг заах багш нь дараах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

- Эрүүл мэндийн хичээлийг заах боломж, сонирхолтой байхаас гадна энэ чиглэлээр мэргэшсэн, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх,
- Эрүүл мэндийн шинжлэх ухааны үндэслэлтэй баримт мэдээ, онолын мэдээллийг баталгаат эх сурвалжаас авч ашигладаг байх,
- Хичээлд бэлтгэхдээ сурагчийн хийх үйл ажиллагаа талаас нь төлөвлөж, тухайн сэдэвтэй холбоотой гарч болох асуулт, түүний хариултыг урьдчилан бэлтгэдэг байх,
- Сурагчийн хэрэгцээ сонирхлыг төрүүлэх, сэдэлжүүлэхэд анхаарах, зарим сурагчийн ярилцахаас эмзэглэх асуудал байж болохыг анзаарах
- Сэдэв болон хичээл хоорондын залгамж уялдаа холбоог хангах,
- Сургалтын аргуудыг хослон хэрэглэж, хичээлдээ бүтээлчээр хандах, аль болох асуудлыг өөрсдөөр нь гаргуулж, шийдвэрлэх олон хувилбарыг гаргаж ярилцах
- Хичээлийн агуулгаа өдөр тутмын амьдралтай холбон зааж, хэвшүүлбэл зохих эрүүл зан үйлийг хичээлээс бусад цагаар эзэмшүүлэхэд анхаарах,
- Сурагчдаа судлан, тэдний нас, сэтгэхүйн болон орчны онцлог нөхцөл зэргийг харгалзан заах арга зүйгээ улам сайжруулахад анхаарах,
- Эрүүл мэндийн хичээлийн зарим агуулга хувь хүний нууцтай холбоотой тул тухайлан жишээ авахаас зайлсхийх, хувийн нууцыг хадгалахад анхаарах.

Эрүүл мэндийн багшийн ёс зүйг эрхэмлэсэн байх: Эрүүл мэндийн хичээл нь бусад хичээлийг бодвол хүний хувийн асуудал, эмзэг мэдрэмтгий сэдвийг хөндөх учир дараах ёс зүйн хэм хэмжээг зайлшгүй мөрдвөл зохино. Үүнд:

1. Хувийн нууцыг хадгалах
2. Үзэл бодлоо тулгахгүй байх
3. Ялгаварлан гадуурхахгүй байх
4. Хувийн, дотно харилцаа үүсгэхгүй байх
5. Хувь хүний талаар тухайлан жишээ авахгүй байх

3.2. Суралцах стратеги

Сурагчид дараах чадварт суралцана. Үүнд:

- Хувийн зохион байгуулалттай болж, амьдралаа төлөвлөх, бие даан суралцах
- Багаар хамтран ажиллах
- Мэдээлэлтэй ажиллах
- Аливаа асуудалд шүүмжлэлтэй, ул суурьтай хандах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах
- Бусдад ухуулах, сурталчлах, нийгэмд өөрийн хувь нэмрээ оруулах

Суралцах стратеги, заах арга, хэрэглэгдэхүүн зэрэг нь соёлыг харгалзсан байх: Жендэр, арьстан, угсаатан, шашин шүтлэг, нас, бие/сэтгэлийн чадвар, гадаад төрх, бэлгийн чиг баримжаа гэх мэт ялгаатай байдлыг харгалзсан байна.

3.3. Эрүүл мэндийн хичээлийн онцлог, сургалтын орчин

Эрүүл мэндийн хичээл нь сурагчдын өдөр тутмын амьдралд тохиолдох, биеийн өсөлт хөгжилтэй холбоотой олон асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг онцлогтой. Хүүхэд зөвхөн өөрийн сонирхол хэрэгцээнээс гадна найз нөхөд, харилцагчийнхаа сонирхол хэрэгцээг илүү анхаардаг онцлогтойгоос гадна охид, хөвгүүдийн хүйсийн ялгаатай байдал олон зүйл дээр ажиглагддаг болохыг багш тооцох хэрэгтэй.

Эрүүл мэндийн хичээл нь эрүүл ахуйн шаардлага хангасан, материаллаг, үйлийн болон сэтгэл зүйн таатай орчинд хэрэгжих нь зайлшгүй. Иймээс сургалтын орчинд онцгой анхаарах хэрэгтэй. Тухайлбал:

1. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь хичээл буюу танхимын сургалтаас гадна хичээлээс гадуурх үйл ажиллагаа, нийгмийн амьдралд оролцохоос ихээхэн хамаардгийг анхаарч төлөвлөх,
2. Сургууль болон анги танхимын эерэг орчин бий болгоход анхаарч, хамтран суралцах соёл, сурагчдын сайн сайхныг дэмжих үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх,
3. Сурагч-сурагч, сурагч-багш гэсэн ижил түвшинд дарамтгүйгээр нэг нэгтэйгээ харьцах боломж бүрдүүлэхэд анхаарах,
4. Эрүүл мэндийн үйлчилгээ болон биет орчин нь сурагчийн танин мэдэхүй, сэтгэл хөдлөл-нийгэмшил болон бие бялдрын хөгжилд чухал үүргийг гүйцэтгэх тул эрүүл мэндийн үйлчилгээг дэмжих, сургуулийн орчны эрүүл ахуй, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулахад анхаарах,
5. Сурагчид өөрсдийн сурах үйлийн үнэт зүйлийг үнэлэн дүгнэх, сургалтын болон сургалтын бус үйл ажиллагаанд оролцох сэдлийг өрнүүлэх,
6. Эцэг эх, сургуулийн хамт олон болон олон нийтийн төлөөлөл нь тухайн сургуулийн бодлого, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд санаачилга гарган, дэмжлэг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах,
7. Орон нутаг, сургуулийн нөөц боломж, байгаль, нийгэм, соёлын ялгаатай байдал зэргийг харгалзан үзнэ.

ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭ

3.1. Үнэлгээний зорилт

Эрүүл мэндийн боловсрол нь сурагчдад амьдрах ухааны боловсрол эзэмшүүлэхэд чиглэнэ. Хандлага, зан үйлийн үнэлгээ нь шууд утгаар хэмжигдэх боломжгүй боловч эцэг эх, сурагчдад сургалтын хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл өгөх, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэхэд хэрэглэнэ. Иймд эрүүл мэндийн сургалтын үр дүнг дараах үнэлгээний

зорилтоор үнэлнэ. Үүнд:

1. Эрүүл мэндийн мэдлэг, ойлголтыг үнэлэх
2. Эрүүл мэндээ хамгаалах чадварыг үнэлэх
3. Хандлагыг үнэлэх

3.2. Үнэлгээний шалгуур

Үнэлгээний зорилт	Үнэлгээний шалгуур
А.Эрүүл мэндийн мэдлэг, ойлголтыг үнэлэх	А1. Баримт, тохиолдол, тодорхойлолт А2. Шинжлэх ухааны үгсийн сан, нэр томьёо А3. Тэмдэг, тэмдэглэгээ, дохио А4. Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллийн сонголт, хэрэглээ А5. Эрүүл ахуйн дэглэм, дүрэм журам, стандартын хэрэгжилт, аюулгүйн дадал А6. Үүрэг, хариуцлагаа ухамсарлах байдал
Б.Эрүүл мэндээ хамгаалах чадварыг үнэлэх	Б1. Эрүүл мэндээ хамгаалахын тулд зорилго тавих, урьдчилсан таамаг, таамаглал дэвшүүлэх, асуулт болон санааг томьёолох, асуудлыг тодорхойлох, шийдвэрлэх, шүүмжлэлтэй хандах Б2. Мэдээллийг цуглуулах, нэгтгэх, боловсруулах, үнэлэлт, дүгнэлт хийх Б3. Эрүүл мэндээ хамгаалахын тулд шийдвэр гаргах Б4. Санаагаа илэрхийлэх, бусдад тайлбарлах, таниулах Б5. Бусадтай хүндэтгэлтэй, соёлч боловсон харилцах Б6. Бусдыг ойлгож, туслах, анхны тусламж үзүүлэх
В. Хандлагыг үнэлэх	В1. Эрүүл мэндийг дэмжих зан үйл, үйлдэл хийх сонирхол В2. Буруу зуршил, эрсдлээс зайлсхийх, сайжруулах алхмыг тодорхойлж, шүүн тунгаах байдал В3. Хүрээлэн буй орчиндоо хүндэтгэлтэй хандах байдал В4. Манлайлал, санаачилга болон сайн дурын үйл ажиллагаанд оролцох байдал В5. Хамт олны өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарлах байдал В6. Бусдад зөвлөн тусалдаг, нөхөрсөг, тусч, хамтач байдал

3.3. Үнэлгээний төрөл, арга, хэрэгсэл

Үнэлгээний төрөл: Өөрийн үнэлгээ, явцын үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ, үр дүнгийн үнэлгээ

Үнэлгээний арга, хэрэгсэл: Асуулт, ажиглалт, сэтгэгдэл, санал асуулга, дасгал даалгавар, бичгийн шалгалт, илтгэл, эссэ, бүтээл зэрэг байна. Мэдлэг үнэлэх тест нь үнэлгээний үндсэн хэлбэр байх боломжгүй. Харин чадвар, хандлагыг илрүүлэхэд чиглэсэн асуулга, ярилцлага, илтгэл, эссэ, реферат бичүүлэх зэрэг нь илүү бодитой бөгөөд үр дүнтэй байх болно. Гэхдээ бага ангийн сурагчдын бичих, бичгээр илэрхийлэх чадвар харьцангуй сул байх талтай. Иймээс ярилцлага хийх, тайлбарлан яриулах, зураг зуруулах зэрэг аргыг ашиглаж болохын зэрэгцээ багш өөрөө ажиглалт, тандах судалгаа хийх байдлаар сурагчдад гарч буй ахиц өөрчлөлтийг үнэлэх боломжтой.

Явцын үнэлгээ

Багш хичээлийн явцад асуулт, дасгал даалгавар болон бусад үйл ажиллагааны гүйцэтгэлээр сурагчийн мэдлэг, чадварын ахиц өөрчлөлтийг илрүүлж, заах арга зүй, орчин хэрэглэгдэхүүнийг сайжруулахын зэрэгцээ, сурагчдад зөвлөн тусална.

Үр дүнгийн үнэлгээ

Улирал, хагас жил, жилийн эцэст санал асуулга, сэтгэгдэл, бичгийн шалгалт болон бусад үйл ажиллагааны гүйцэтгэлээс сургалтын зорилт хэр зэрэг биелсэн болон сурагчдын сурах арга барил, хандлага, зан үйл төлөвшилд дүгнэлт хийнэ.

Зөвлөх:

Н.Оюунцэцэг Ph.D, дэд профессор, Боловсролын хүрээлэнгийн Боловсролын хөтөлбөрийн судалгааны секторын зөвлөх

Эмхэтгэж, хянан тохиолдуулсан:

О. Пүрэв Доктор Sc.D , Профессор, МУ-ын гавьяат багш, Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

А. Энхтогтох Боловсролын хүрээлэнгийн Боловсролын хөтөлбөрийн судалгааны секторын эрхлэгч

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

А. Мөнхмагнай Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

Хэвлэлийн хуудас: 37.25 х.х

Хэмжээ: А4

Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу-44, Засгийн газрын III байр,
strategy@mecs.dov.mn
Боловсролын хүрээлэн www.mier.mn хаягаар танилцана уу.